



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023.10.02 - 2024.01.17

ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН

2023.12.09

Улаанбаатар хот
2024 он

Улаанбаатар хот
2024 он

Үйл ажиллагааны
танилцуулга

Олон нийтэд зориулав.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023.10.02-2024.01.17

ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН

2023.12.09

(Үйл ажиллагааны танилцуулга)

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН
ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН**
(Үйл ажиллагааны танилцуулга)

Хянасан: М.Үнэнбат
Редактор: Б.Батманлай
Эмхэтгэсэн: Д.Энхболдбаатар
Эх бэлтгэсэн: Ч.Мөнхжаргал
Инфографикийг: Ч.Цогт-Очир
Гэрэл зургийг: Г.Эрдэнэтуяа
Г.Аргуужин

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх, олшруулах цехэд хэвлэв.

АГУУЛГА

Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатарын 2023 оны намрын ээлжит чуулганыг нээж хэлсэн үг..... 8

НЭГ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн тойм..... 18

Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаан...22

Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатарын хүндэтгэлийн хуралдаан дээр хэлсэн үг.....24

ХОЁР. БАЙНГЫН БОЛОН ДЭД ХОРООД

Нэг. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо.....36

Хоёр. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо.....41

Гурав. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо...48

Дөрөв. Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо.....52

Тав. Инновац, цахим бодлогын байнгын хороо.....55

Зургаа. Нийгмийн бодлогын байнгын хороо.....59

Долоо. Төрийн байгуулалтын байнгын хороо.....64

Найм. Төсвийн байнгын хороо.....68

Ес. Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо.....75

Арав. Хууль зүйн байнгын хороо.....79

Арван нэг. Эдийн засгийн байнгын хороо.....85

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Улсын Их Хурлын хяналт, шалгалт.....90

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

Нэг. Хууль тогтоох үйл ажиллагаанд үзүүлж буй дэмжлэг.....108

Хоёр. Улсын их хурлын хяналт шалгалтын үйл ажиллагаанд үзүүлж буй дэмжлэг.....110

2.1. Хууль тогтоомжоор засгийн газар болон бусад байгууллагад өгсөн үүрэг, чиглэлийн хяналт.....	110
2.2. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ.....	112
2.3. Төсвийн хяналт-шинжилгээ.....	113
2.3.1. Төсвийн хяналт.....	113
2.3.2. Макро эдийн засаг, төсвийн талаар мэдээллээр тогтмол хангасан талаар.....	119
2.3.3. Төсвийн тогтвортой байдлын зөвлөл.....	121
2.3.4. Бусад.....	122
Гурав. Улсын Их Хурлын мэдээлэл, сургалт судалгаа, олон нийтийн харилцаа.....	123
3.1. Мэдээлэл сурталчилгаа, олон нийтийн харилцаа.....	123
3.2. Иргэд, сонгогчдоос ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт.....	130
3.3. Хуралдааны цахим систем, мэдээллийн технологи.....	131
3.3.1 Хуралдааны цахим систем.....	131
3.3.2 Мэдээллийн технологи.....	132
3.3.3 Цахим парламент.....	131
3.4. Судалгаа шинжилгээ, сургалт.....	135
Дөрөв. Улсын Их Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагаа...	142
4.1. Улсын Их Хурал, түүний тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагаа.....	142
4.2. Олон улсын болон бүс нутгийн парламентын байгууллагын хамтын ажиллагаа.....	160
4.3. Гадаад харилцааны асуудлаарх зөвлөгөө, лавлагаа, мэдээ танилцуулга.....	164
4.4. Дүгнэлт.....	165

ТАВ. ХАВСРАЛТ**Хоёр.** Баталсан хууль, улсын их хурлын тогтоолын танилцуулга.....168

1.1. Бие даасан хууль.....168

2.1.1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай,
нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай,
эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай
хууль.....1682.1.2. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний
түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах
тухай хууль.....184

2.1.3. Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль.....187

2.1.4. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний
тухай хууль.....1892.1.5. Хүүхэд хамгааллын тухай хууль
/шинэчилсэн найруулга/.....1922.1.6. Органик бүтээгдэхүүний тухай хууль
/шинэчилсэн найруулга/.....197

2.2. Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.....200

2.2.1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн
хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль.....2002.2.2. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хамт
батлагдсан хууль, улсын их хурлын тогтоол.....2012.2.3. Эрүүгийн хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хууль.....2062.2.4. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай, амьтан, ургамал, тэдгээрийн
гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр
нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт
батлагдсан хуулиуд.....2082.2.5. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай
хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.....210

2.2.6. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль.....	211
2.2.7. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.....	211
2.2.8. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.....	213
2.2.9. Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль.....	214
2.2.10. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хууль.....	216
2.2.11. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль.....	219
2.3. Олон улсын гэрээ, хэлэлцээр соёрхон батлах тухай хууль.....	223
2.3.1. Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль.....	223
2.3.2. Конвенцын нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хууль.....	224
2.3.3. Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль.....	225
2.3.4. Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль.....	226
2.4. Улсын Их Хурлын тогтоол.....	227
2.4.1. “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай”	227
2.4.2. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай”	228
2.4.3. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай”	233
2.4.4. “Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай”	234

2.4.5. “Бүгд Найрамдах Узбекистан улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин Сайдын яам нээн ажиллуулах тухай”	235
2.4.6. “Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай”	236
2.4.7. “Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлого батлах тухай”	237
2.4.8. “Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос “Эрдэнэс Тавантолгой” хк, “Тавантолгой” хк-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай”	239
2.4.9. “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” ..	241
2.4.10. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай”	242
2.4.11. ““Эрдэнэс тавантолгой” хк-ийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай”	242

Монгол Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатарын 2023 оны намрын ээлжит чуулганыг хааж хэлсэн үг.....	244
--	-----

УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАРЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫГ НЭЭЖ ХЭЛСЭН ҮГ

2023.10.02



Эрхэм хүндэт Ерөнхий сайд аа,
Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,
Хатагтай, ноёд оо,

Та бүхний энэ өдрийг амар амгаланг эрж мэндчилье.

Улсын Их Хурлын энэ удаагийн бүрэн эрхийн “отгон” намрын чуулган эхэлж байна. Шударга ёс, эрүүл нийгэм, хөгжлийн зөв тогтолцоог шаардсан нийгмийн бухимдал өндөр, ирэх сонгуулийн идэвхжил эхэлсэн, өвөлжилтийн бэлтгэл, намрын их ажил ундарсан өндөр хэмнэлтэй цаг үед намрын чуулган эхэлж байна.

Эрхэм гишүүд ээ,

Монголын улс төр уламжлал-шинэчлэлийн зааг үеэ туулж байна. Монголын ардчиллын тулгуур багана болсон Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулж, сонгуулийн шинэ тогтолцоо бүрдүүлсэн, Улс төрийн намын шинэ хууль батлагдсан гээд улс төрийн цоо шинэ уур амьсгал дор Монгол хүн бүр ирээдүйдээ итгэл найдвар тавин хүлээж байна.

Тиймээс Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдийг бүрэн цогцоор нь амилуулах ёстой. Тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн үзэл санаа органик болон процессийн хууль болж хэрэгжих нь чухал. Ингэхдээ цаасан дээр үлдэх төдий биш нийгэмд, нийт тогтолцоонд бодит өөрчлөлт авчрах учиртай.

Хуучинсаг, хөшүүн, хаалттай, нууцтай, дүлий төр ард үлдэж, эсрэгээрээ нээлттэй, хурдтай, ил тод, ард түмэнтэйгээ ямагт хамт байдаг, хүчтэй төрийг төлөвшүүлэхийг иргэд дуу нэгтэй шаардаж байна. Энэ шаардлагын дагуу Улсын Их Хурал шуурхай, мэдрэмжтэй ажиллаж, иргэдийн засаглах, мэдэх, хянах, хариуцлага тооцох, оролцооны эрхүүдийг баталгаажуулсан олон хууль тогтоомжийг баталсан.



Нийслэл дэх газрын наймаа, нийтийн тээвэр, дулаан, цахилгааны тусгай зөвшөөрөл, төрийн худалдан авалтыг тойрсон авлига, хээл хахуулийн сүлжээг ил тод болгож, хариуцлага тооцох ёстой...

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр дамжуулан иргэдийн мэдэх эрхийг хангах зорилготой парламентын хяналт шалгалтын бүрэн эрхийг өргөтгөсөн. Хянан шалгах түр хороо, Нийтийн сонсгол зэрэг ард түмний хяналт, оролцооны эрхийг энэ хуулиар баталгаажуулсан. Одоо иргэдийн бухимдлыг төрүүлсэн элдэв булхай луйврыг төрийн эрх барих дээд байгууллага ард түмэнтэйгээ хамтран хянан шалгах бүрэн эрхтэй болсныг та бид тууштай хэрэгжүүлэх ёстой.

Босоо хэлбэртэй байсан хариуцлагын тогтолцоо хэвтээ болж ард иргэд, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хамтарсан хяналт, оролцоо, ардчилал, ил тод байдал дээр тулгуурладаг болсныг бүх шатанд ойлгож хэрэгжүүлбэл зохино. Ардчиллын манлайлагч С.Зоригийн “Монгол хүний саруул ухаанд би итгэдэг” гэж өгүүлсэнчлэн Улсын Их Хурлын гишүүд маань ард иргэдийнхээ чин хүсэл зоригийг мэдэрч ажиллах ёстой.

Худал хуурмаг, хулгай луйвар тав алхалгүй танигдаж, илчлэгддэг болжээ. Хууль зөрчсөн, ард түмнийхээ боломжийг хулгайлсан үйлдлүүдэд хуулийн хариуцлага тооцож, төрийн бодлого нь иргэдийнхээ хүсэлт, шаардлагад нийцэж ажиллах хэрэгтэй байна. Ингэж чадахгүй бол төр-иргэний итгэлцэл алдарна.

Монголын төр засаг авлигатай тэмцсээр байгаа ч үр дүн өргөс авах мэт түргэн гарахгүй байна. Амин хувийн эрх ашгаа бүхнээс дээгүүрт тавьсан цөөнх хэсгийн шуналт үйлдлийн үр дагавар хөгжлийг гацааж, Монгол төрийн нэр хүндийг удаанаар, “тогтвортой” унагаж, баллуурдаж байна.

Тиймээс Улсын Их Хурлын эрхэм гишүүд та бүхнийг авлигын эсрэг тэмцэлдээ сэтгэл зориг нэгтгэйгээр, тууштай зүтгэхийг хүсэж байна. Та бид өнгөрсөн хаврын чуулганыг Авлигын эсрэг чуулган гэж зарлаж, Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай зэрэг хуулийг баталсан. Авлигын эсрэг тэмцэх эрхэм зорилгоо энэ чуулганд ч үргэлжлүүлж, дараагийн алхмуудыг хийх ёстой.

Нийслэл хотод 30 жил ужгирсан, яг энэ цаг үед нийгмийн бүхимдлыг дээд цэгт нь хүргээд буй асуудлуудыг шалгаж, шийдэмгий, шуурхай арга хэмжээ авах нь чухал байна. Энэ зорилгоор Улсын Их Хурлын Хяналт шалгалтын түр хороог яаралтай зохион байгуулж, нийслэл дэх газрын наймаа, нийтийн тээвэр, дулаан, цахилгааны тусгай зөвшөөрөл, төрийн худалдан авалтыг тойрсон авлига, хээл хахуулийн сүлжээг ил тод болгож, хариуцлага тооцох ёстой гэж үзэж байна.

Эрхэм гишүүд, Улсын Их Хурал дахь Нийслэлийн хөгжлийн түр хороо, холбогдох Байнгын хороод, намын бүлгүүд үүн дээр онцгойлон анхаарч ажиллахыг үүрэг чиглэл болгож байна.

Түүнчлэн Монголын эдийн засагт үлэмж хэмжээний хохирол учруулсан “нүүрсний” гэх тодотголтой хэргийн нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг нэн тэргүүнд зохион байгуулахыг иргэд биднээс шаардаж байгааг анхааралдаа авахыг Түр хорооноос хүсье. Шүүх байгуулах тухай хуулиас эхлээд Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлын тухай зэрэг хуулиудыг баталж, эрх зүйн шинэчлэлээ гүнзгийрүүлэх шаардлагатай байна. Шүүхийн тухай хуулийн зарим заалт, тухайлбал, шүүх тогтолцооны гажуудлыг засах чиглэлээр хууль хэрэгжүүлэхгүй байгаа тайлбараа Улсын Их Хуралд ирүүлэхийг Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс шаардаж байна.

Сахилга хариуцлагыг бүх шатанд мөрдөх цогц шинэчлэлийг хийж, авлигын суурь шалтгаан болсон төрийн данхар эрх мэдлийг хумьж, эдийн засаг дахь оролцоог нь эрс багасгах бодит хэрэгцээ шаардлага хойшлуулшгүй чухал болжээ.



*Монголчууд бид
ухдаг баялгийн нөөцөө
ашиглан ургуулдаг
баялгийн салбар
буюу хөдөө аж
ахуйгаа хөгжлийн
тулгуур болгон
босох цаг иржээ...*

Энэ зорилгоор бизнес үйлдвэрлэл, баялаг бүтээгчдийг дэмжих багц хуулийг яаравчлан батлах хэрэгтэй байна. Мөн уул уурхай дагасан хэт цөөнхийн эдийн засгийн эрх мэдлийг хумих, төрийн өмчит компаниудыг нээлттэй компани болгох, аялал жуулчлал, хөдөө аж ахуйгаа хөгжүүлж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг жинхэнэ ёсоор сэргээж, олонхын оролцоог дэмжсэн, уламжлалт ахуйдаа суурилсан томоохон хөтөлбөрийг батлан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгарч байна.

Задралаас нэгдэл рүү шилжих түүхэн хийгээд бодит боломж энэ хөтөлбөрийн шийдэлд байгаа юм. Монгол Улсын мал өсөх тусам малчингүй, бэлчээргүй, үр ашиггүй, үржил шимгүй болж, хор хөнөөл нь илүү ихсэх гажуудал руу бид явж байна. Япончууд технологи бидний хөгжил гэж тодорхойлоод, түүнийгээ төрийн төлөвлөгөөт зохицуулалтаар хэрэгжүүлсэн бол, израилчууд хөдөө аж ахуйг хөгжлийн боломж гэж харж, төрийн бодлогын төвд тавьснаар хоёулаа өндөр хөгжсөний адил монголчууд бид ухдаг баялгийн нөөцөө ашиглан ургуулдаг баялгийн салбар буюу хөдөө аж ахуйгаа хөгжлийн тулгуур болгон босох цаг иржээ. Энэ бидэнд тийм ч хэцүү зорилт биш ээ. Монгол Улсын Засгийн газраас



дэвшүүлсэн Хот, Хөдөөгийн сэргэлтийн зорилттой уялдуулах замаар эрх зүйн шинэчлэлийн хүрээнд үүнийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүрэн боломж бидэнд бий.

Эрхэм гишүүд ээ,

Монголчууд бид дан саар биш, дажгүй олон сайн үйл явцын эхлэл дээр бас байна. Эдийн засаг тэлж, экспорт түүхэн дээд хэмжээндээ хүрч, валютын нөөц 4.0 тэрбум долларыг давлаа. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 5000 ам долларт хүрсэн нь авлигатай хийж буй тэмцлийн нэг бодит үр дүн мөн. Гацаа саадууд, бугшсан буруу бүхнийг оношлон зассанаар, тун ойрын жилүүдэд бид эдийн засгийн үсрэнгүй хөгжлийн гэрч болох боломж байна.

Ирэх онд бид шинэ тогтолцоогоор, анхны сонгуулиа хийнэ. Одооноос бэлтгэлийг маш сайн хангах ёстой. Энэ мэт олон шинэ сорилт шийдэл бидний өмнө байна. Алдаанаасаа суралцаж, буруугаа засаж, Шинэ сэргэлтийн төлөө тэмүүлсэн бидний хамтын зүтгэл талаар өнгөрөх ёсгүй ээ. Алдаагаа засах тусам ардчилал төгөлдөрших ёстой. Үүний үр дүнд улс төрийн цоо шинэ соёл, хандлага тогтож, тэр нь Монгол Улсын хөгжил дэвшлийн хурдасгуур болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Цар тахал, дайн самуун дараалсан он жилүүдэд манай улсын гадаад харилцааны бодлого төв, тэгш байгааг дурдах ёстой. Бид хөрш орнууд болон эх дэлхийдээ энх тайвныг баримтлагч улс гэдгээ тогтвортой тунхагласаар байна. Илт сэргэж, эрс идэвхжсэн гадаад харилцааны олон чухал айлчлал үргэлжилж, Монгол Улсад маань түүхэн боломжууд шинээр бий болсоор байгааг энд дурдах нь зүйтэй байх аа. Гадаад ертөнцөд хүйтэрсэн уур амьсгал, дотоод талдаа илүү дулаан байхыг биднээс шаардаж байгааг хүн бүр ойлгох буй за.

Намрын чуулганы нэг томоохон ажил бол Монгол Улсын 2024 оны төсвийг хэлэлцэн батлах явдал юм. Энэ жилийн төсвийг сонгуулийн жилийн төсөв болгохгүй байхад онцгойлон анхаарахыг Эрхэм гишүүд та бүхнээс хүсэж байна. Эрсдэлт нөхцөл байдал илааршаагүй энэ цаг үед болзошгүй нөхцөлд бэлэн байх нь бидний үүрэг. Ирэх оны төсөв гагцхүү үр өгөөж, хуульд заасан гарцаагүй үндэслэлд суурилах ёстой. Төсвийг үндэслэлгүйгээр тэлэх, олсныхоо хэрээр цацах үрэлгэн хандлага гаргаж яавч болохгүй. Элдэв амлалтыг хойш тавья. Сонгуулийн жилийн төсөв сонгогчдын санал цуглуулахад чиглэдэг өмнөх гажгийг засацгаая.

Үүний тулд улсын төсвийг батлах хэлэлцүүлэгт туйлын хариуцлагатай хандахыг уриалж байна. Төсвийн хэлэлцүүлгийн өмнө Ерөнхий сайд орон нутагт ажиллаж, иргэдийн оролцоотой төсвийн хэлэлцүүлгийн эхлэлийг тавилаа. Иргэдийн хүсэл сонирхол, санал шаардлагыг төсөвт тусгах төсвийн хэлэлцүүлгийг үр дүнтэй зохион байгуулах нь чухал байна.

Эцэст нь Монголын нийгэм амьд хэв шинжээр сайн тал руугаа өөрчлөгдөж байгааг тэмдэглэж хэлье. Иргэдийн оролцоо идэвхжиж, шүгэл үлээгчид олширч, нийгмээрээ буруу булхайгаа шүүн хэлэлцэж, худал хуурмагт орон зай үлдээлгүй шахаж байна. Энэ бүхэн бол хөгжин дэвжих үндэстний амьд бүтээлч, эрмэлзэл тэмүүлэл дүүрэн, сайн шинж яах аргагүй мөн. Цаашид та бидний ард түмнийхээ хяналт, оролцоотойгоор хэлэлцэн баталсан олон хууль цаг хугацааны шалгуурыг дааж, Монголын хөгжлийг тэтгэх эрх зүйн хөшүүрэг, хурдасгуур болно гэдэгт бүрэн итгэлтэй байгаа.



Нийгэмд оюун санааны хөгжил өөрчлөлт хурдацтай явагдаж, буруугаа дүгнэж, зөв зүг рүүгээ чиглэж буй энэ түүхэн цаг үед Эрхэм гишүүд та бүхний саруул ухаан, мэргэн шийдвэр, онч бодлого, зөвийн төлөөх зориг шийдэлд бүрнээ итгэж байгаагаа илэрхийлье.

Улсын Их Хурлын Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулган нээснийг мэдэгдье.



2023.10.06. “Мал аж ахуйн сэргэлт” залуу малчдын үндэсний чуулган Төрийн ордонд болж, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар оролцлоо. Энэ үеэр хэлсэн үгэндээ, Малчдын залгамж халааг бэлтгэх, шинэ залуу малчдыг дэмжин урамшуулах, орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэхгүй бол монгол мал эзэнгүй болох учир шинэчлэл хийх зайлшгүй цаг үе ирснийг тэмдэглээд, бэлчээрийн мал аж ахуйд тогтолцооны шинэчлэл хийх гол арга зам бол хоршооллын хэлбэр мөн гэж үзэж байгаагаа илэрхийлэв.



2023.10.17. Үндсэн хуулийн 3.1-т заасан ард түмний засаглах эрх мэдлээ бодитоор эдэлж, төрийн үйл хэрэгт бодитоор, шууд оролцох боломжийг нээсэн <https://petition.parliament.mn/> нийтийн өргөдөл, гомдлын системийг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын санаачилгаар нэвтрүүллээ. Тус системийн НӨАТ-ын буцаан олголтыг таван хувьд хүргэхийг дэмжих эсэх анхны өргөдөл богино хугацаанд иргэдийн дэмжлэг авснаар Улсын Их Хурлаар хэлэлцэх боломж нээгдлээ.

2023.11.14. Их эзэн Чингис хааны мэндэлсний 861 жилийн ой, “Монгол бахархлын өдөр”-ийг тохиолдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Их Эзэн Богд Чингис хаан төрийг төвшитгөж, түмэн олныг амарлиулж явахдаа стратегийн түвшинд ч, бодол оюун санааны хувьд ч асар олон өв, үнэт зүйлийг дэлхий дахинд үлдээсэн эдгийг онцолж, тэр дундаа Хууль дээдлэх ёс, Парламентат ёс, Үзэл бодол, шашин шүтлэгийн эрх чөлөө гэсэн онцлох гурван өвийн талаар санал бодлоо хуваалцав.



2023.11.25. Улсын Их Хурлын зүгээс “Өсвөрийн парламент” хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлээд гурван жил болж байна. Монгол орны өнцөг булан бүрээс үе тэнгийн найз нөхдөө төлөөлөн ирсэн хүүхдүүдээ улс тунхагласан өдрийг тохиолдуулан Үндсэн хууль, түүний ач холбогдол, тусгаар тогтнолын үнэ цэнийг тайлбарлаж, Улсын Их Хурлын дарга нээлттэй хичээл орлоо.



2023.12.04. Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын санаачилгаар “МӨНХ-Шинэ хөдөөгийн сэргэлт” сэдэвт уулзалт боллоо. Энэ үеэр Улсын Их Хурлын дарга Малчдад хөдөлмөрөөрөө хорших, нийтлэг эрх ашгийнхаа төлөө хамтран нэгдэж ажиллах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг жинхэнэ үйлдвэрлэгч-борлуулагч-нэмүү өртөг бүтээгч-ашгаа өөрсдөө хүртэгч системд шилжүүлэх зорилго бүхий “Малчин өрхүүдийн нэгдсэн холбоо” хэмээх байгууллагыг байгуулах санаачлагыг гаргасан бөгөөд өнгөрсөн зургаадугаар сард Баянхонгор, 11 дүгээр сард Хэнтий аймагт тус тус байгуулаад байна.



2023.12.05. Засгийн газраас байгуулсан татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөөг тооцох аргачлалыг боловсруулах ажлын хэсгийн судлаачид “Татвар-ашиг тусын микросимуляц”-ийн загварчлалын “МОНТАТ” моделийг хийж, гүйцэтгэсэнээ Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар болон Улсын Их Хурлын ажлын хэсгийн гишүүдэд танилцууллаа.



2023.12.09. Монгол Улс Анхдугаар Үндсэн хуулиа баталж, эрх чөлөө, тусгаар тогтнолоо баталгаажуулан Бүгд Найрамдах Улсаа тунхагласны түүхт 100 жилийн ой ойг угтан Монгол Улсын Их Хурал, “Монголын мэтгэлцээний нэгдсэн танхим” төрийн бус байгууллагатай хамтран “Үндсэн хууль - 100 жил” парламентын мэтгэлцээний үндэсний аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, Улсын Их Хурлын дарга нээлттэй хичээл орлоо.



2023.12.30. Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар өвөлжилт хүндэрсэн аймаг, сумдын малчидтай уулзаж, холбогдох арга хэмжээ авахаар орон нутагт ажиллав.



2023.12.29. Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112 жилийн ой тохиож буйтай холбогдуулан Богд хаант Монгол Улсын төрийн тугт хүндэтгэл үзүүлэх ёслол болж, уг ёслолд Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар оролцлоо.



2024.01.16. Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Архангай аймгийн Булган сумын нутагт оторлож буй малчин өрхүүдийн төлөөлөлтэй уулзлаа. Тус сумын нутагт Баянхонгор, Завхан, Хөвсгөл аймгаас малчид ирж өвөлжихөөс гадна аймаг дотроо ч отор нүүдэл хийх нь элбэгшжээ.



2024.01.23. “Монголын тэмээн соёл” улсын зөвлөгөөн Баянхонгор аймагт болж, Улсын Их хурлын дарга Г.Занданшатар оролцлоо. 1988 оноос хойш буюу 36 жилийн дараа болж буй зөвлөгөөнийг нээж Монгол Улсын Их Хурлын дарга хэлсэн үгэндээ, тэмээн сүргийнхээ үүлдэр баясааг сайжруулан, олшруулан өсгөж, Монголын “тэмээн соёл”, хоёр бөхт монгол тэмээ, түүнээс гардаг ашиг шимээр дэлхийд өрсөлдөхийн төлөө хичээн зүтгэх нь нэн чухлыг онцоллоо.



2024.02.19 Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Хөрөнгө оруулалтын тухай хуульд тусгагдсан гадаадын иргэн, аж ахуйн нэгжид газар ашиглах, эзэмшүүлэх зохицуулалт болон Газрын тухай, Ашигт малтмалын тухай хууль, тогтоомжийн хэрэгжилтийн асуудлыг Улсын Их Хурал анхааралдаа авч, хяналт шалгалт, нээлттэй сонсгол хийх Ажлын хэсэг байгуулсныг зарлалаа.

I БҮЛЭГ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ТОЙМ

2023.10.02 - 2024.01.17

75 ӨДӨР ЧУУЛАВ.

12 БИЕ
ДААСАН
ХУУЛЬ

206 НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛЬ

4 ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ,
ХЭЛЭЛЦЭЭР, КОНВЕНЦ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

2 ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ
БОЛСОНД ТООЦОХ
ТУХАЙ

62 УЛСЫН ИХ
ХУРЛЫН
ТОГТООЛ

286 НИЙТ
БАТАЛСАН ХУУЛЬ,
ТОГТООМЖ

Ээлжит чуулганы нэгдсэн хуралдаан

НИЙТ 34 УДАА ЧУУЛАВ.

151 ЦАГ 33 МИНУТ ХУРАЛДАВ.

173

АСУУДАЛ ХЭЛЭЛЦЭЖ
ЗОХИХ ШИЙДВЭРИЙГ ГАРГАСАН БАЙНА.

ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭЖ БАЙГАА ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН БУСАД ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛТЭЙ ХОЛБОГДУУЛАН УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС ХУУЛЬ САНААЧЛАГЧ, АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮДЭЭС

775
УДАА АСУУЛТ АСУУЖ

259
УДАА ҮГ ХЭЛЖЭЭ.

ХАМГИЙН ОЛОН УДАА АСУУЛТ АСУУСАН ГИШҮҮД



Ш.АДЬШАА /44/



С.ОДОНТУЯА /24/



М.ОЮУНЧИМЭГ /37/



Д.ГАНБАТ /22/



Б.БАТТӨМӨР /35/



Ж.БАТЖАРГАЛ /21/



Ж.БАТСУУРЬ /32/



Б.БАТ-ЭРДЭНЭ /21/



Н.ГАНИБАЛ /32/



Т.ДОРЖХАНД /21/



О.ЦОГТГЭРЭЛ /26/



Х.ГАНХУЯГ /21/



Б.ПҮРЭВДОРЖ /25/



Д.САРАНГЭРЭЛ /20/



2023.10.02

УЛСЫН ИХ

2023 ОНЫ НАМРЫН

АЖЛЫН 75 ӨДӨРТ

НЭГДСЭН ХУРАЛДААН

34
УДАА



151 ЦАГ
33 МИНУТ

БАЙНГЫН ХОРОО

114
УДАА



154 ЦАГ
45 МИНУТ

ДЭД ХОРОО

6
УДАА



8 ЦАГ
37 МИНУТ

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО

17
УДАА



18 ЦАГ
49 МИНУТ

ЦАХИМ ПАРЛАМЕНТ

ЦАХИМ СИСТЕМД ИДЭВХТЭЙ ТӨЛӨВТ БАЙГАА ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ:



54 боловсруулж
буй төсөл

201 өргөн
мэдүүлсэн төсөл

884.872 иргэд
удаа хандаж

7.985 нийт
санал өгсөн



ХУРЛЫН

ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024.01.17

ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТОДОРХОЙ АСУУДЛААР
ШАЛГАНСУДЛАХ,
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ
ШАЛГАЛТ ХИЙСЭН:

ХЯНАН ШАЛГАХ
ТҮР ХОРОО

2

АЖИЛЛАСАН

АЖЛЫН
ХЭСЭГ

21

АЖИЛЛАСАН

ЕРӨНХИЙ САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН
ГИШҮҮД БОЛОН УИХ-ААС
БҮРЭЛДЭХҮҮН, УДИРДЛАГЫГ НЬ
СОНГОЖ, ТОМИЛДОГ
БАЙГУУЛЛАГЫН ДАРГАД
ХАНДАН ТАВЬСАН.

АСУУЛГА

64

АСУУДЛААР

7

УДАА

АСУУЛТ

20

АСУУДЛААР

4

УДАА

 **ӨРГӨДӨЛ**

2023.10.17-НЫ ӨДӨР АЛБАН ЁСООР ХЭРЭГЛЭЭНД НЭВТРҮҮЛСЭН

148

ӨРГӨДЛИЙГ
ИРГЭД САНААЧИЛСАН

612.705

ИРГЭН
САНАЛАА ӨГСӨН

ХҮНИЙ ЭРХИЙН ТҮГЭЭМЭЛ ТУНХАГЛАЛ БАТЛАГДСАНЫ 75 ЖИЛИЙН ОЙД ЗОРИУЛСАН МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААН БОЛЛОО



Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааныг 2023 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн Бямба гарагт хуралдууллаа. Хүндэтгэлийн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Засгийн газрын гишүүд, үе үеийн Улсын Их Хурлын дарга нарын төлөөлөл, Улсын Их Хуралд ажлаа шууд тайлагнадаг байгууллагын удирдлагууд болон мөн Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүнүүд, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн болон Олон улсын байгууллагын Монгол Улс дахь суурин төлөөлөгчид, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд уригдан оролцов.

Хүндэтгэлийн хуралдаанд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн дээд комиссар, ноён Фолкер Тюрк, Ерөнхий ассамблейн 78 дугаар чуулганы дарга, ноён Деннис Фрэнсис, Монгол Улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурин зохицуулагч, ноён Тапан Мишра нар цахимаар мэндчилгээ дэвшүүллээ. Мөн “Эмнести Интернэшнл” Олон Улсын байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга, хатагтай Агнес Калламард талархлын захидал ирүүлсэн юм.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАРЫН ХҮНДЭТГЭЛИЙН ХУРАЛДААНД ХЭЛСЭН ҮГ

2023.12.09



Эрхэм хүндэт Монгол Улсын Ерөнхий сайд аа,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүндэт зочид, хатагтай, ноёд оо,

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгаж, Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейгаас Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг баталсны 75 жил, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн Дээд комиссарын алба байгуулагдсаны 30 жил, Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын Парисын зарчим батлагдсаны 30 жилийн ойн мэндчилгээг өргөн дэвшүүлье.

1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейгаас баталсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал нь дэлхийн хаана байгаа, хэн байхаас үл хамааран хүн бүр угаас заяасан үнэ цэн, нэр хүнд, нандин чанар, салшгүй эрхтэй гэдгийг хүн төрөлхтний түүхэнд анх удаа тунхаглаж, хүлээн зөвшөөрсөн түүхэн ач холбогдолтой баримт бичиг юм. Түүнчлэн Хүний эрхийг хамгаалах нь орчин үеийн парламентын нэн чухал чиг үүрэг болохыг Олон Улсын Парламентын Холбоо тунхаглаж, парламентуудыг энэ чиглэлд санаачилгатай ажиллахыг уриалсан.

Монгол Улс 1961 онд Нэгдсэн Үндэстний байгууллагын бүрэн эрхт гишүүн болсон. Тэр үеэс хойш өнөөдрийг хүртэл нийт 294 олон талт олон улсын гэрээг соёрхон баталсан. Тэдгээрээс хүний эрхийн суурь найман конвенц, тэдгээрийг дагалдах 40 гэрээнд нэгдээд байна. Эдгээр гэрээ, пакт болон Нэгдсэн Үндэстний байгууллага, олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүргээ Монгол Улс биелүүлэхийн төлөө байнгын хүч чармайлт тавьж, тайлан илтгэлүүдээ хүргүүлж, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж байна.

Тиймээс Монгол Улсын Их Хурал Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн болон бусад түүхэн ойнуудад зориулан Хүндэтгэлийн хуралдаан зарлан хуралдуулж байна.



*Агаар, орчны
бохирдол, авто замын
түгжрэл нь хүний
амьд явах эрхэд
ноцтой заналхийлэл
учруулж байна...*

Тунхаглал нь зөвлөмжийн шинжтэй баримт бичиг боловч хүний эрхийн талаарх олон улсын гэрээ, улс орнуудын Үндсэн хууль, хууль тогтоомжийн үндэс болсоор ирсэн. Энэ утгаараа Тунхаглалын үзэл санаа 1992 онд баталсан Монгол Улсын ардчилсан, шинэ Үндсэн хуульд бүрэн тусгалаа олж, хүний салшгүй эрхийг анх удаа бүрэн цогцоор нь баталгаажуулсан юм.

Монгол Улсын шинэ Үндсэн хууль “Монгол Улсын бүрэн эрхт байдал” гэсэн Нэгдүгээр бүлгээр эхэлж, “Хүний эрх, эрх чөлөө” гэсэн Хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэний эдлэх үндсэн эрх, эрх чөлөөг 18 бүлэг заалт, 60 гаруй эрхээр баталгаажуулсан юм.

Ингэснээрээ дараах Гурав, Дөрөв дэх бүлэг дэх төрийн байгууллын бүтэц, тогтолцоо, засаглалын эрх, үүрэг нь гагцхүү хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэнэ гэсэн үзэл санааг дэвшүүлсэн билээ.

Үндсэн хуулийнхаа энэхүү үзэл баримтлалд тулгуурлан Монгол Улсын Их Хурлаас “Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө”-г баталсан. Энэхүү төлөвлөгөөндөө “ард түмний засаглах эрхийг хангах, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх” нь эрхэм зорилго мөн хэмээн парламентын эрхэм зорилгыг тодорхойлсон. Энэ зорилгоо хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Их Хурлаас цахим, ардчилсан, иргэдийн оролцоотой, зөвлөлддөг “Гурван D” буюу “Digital”, “Democratic”, “Deliberative” парламент болох шинэчлэлийн зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Энэ хүрээнд хууль тогтоомжийн төсөлд хүний эрхийн талаас нь үнэлгээ хийдэг аргачлалыг хэвшүүлж, “Хүний эрхийг дээдлэгч” парламент байхаа зарласан. Улсын Их Хурал, Олон Улсын Парламентын Холбоотой хамтран Хүний эрх, жендэрийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээг өнгөрсөн сард хийлээ. Хүний эрхийн өөрийн үнэлгээг Олон Улсын Парламентын Холбооноос баталсан аргачлалын дагуу анх удаа хийсэн парламент нь Монгол Улсын Их Хурал боллоо. Цахим шилжилтийн хүрээнд бид “D-parliament”, “D-petition” программуудыг нэвтрүүлж, ард түмний засаглах эрхийг хангаж, парламентын ардчиллыг төлөвшүүлж байна.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Ажлын хэсэг байгуулж, олон улсын гэрээний хэрэгжилтийн тайланг Нэгдсэн Үндэстний байгууллагын Гэрээний хороонд хүргүүлж буй байдал, Гэрээний хорооноос ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, санал, дүгнэлт боловсруулахаар ажиллаж байна.

Манай улс хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний анхдугаар илтгэлээ 2010 онд, II илтгэлээ 2015 онд, III илтгэлээ 2021 онд Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөр хэлэлцүүлээ. Гурав дахь илтгэлийг хэлэлцээд тус Зөвлөлөөс ирүүлсэн 190 зөвлөмжийг 2023-2025 онд хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газар батлан хэрэгжүүлж байна.

Хүний эрхийг хамгаалах тогтолцооны асуудлыг авч үзэхдээ хэн зөрчих боломжтой вэ гэдэгт илүү анхаарах ёстой. Тэгвэл хүний эрхийг зөрчих, хязгаарлах гол субъект нь Төр өөрөө байдаг байна. Тиймээс төрийн эрх мэдлийг хуваарилах, хуулийн засаглалыг бэхжүүлэхэд онцгой ач холбогдол өгч байна.

Францын агуу сэтгэгч Шарль дө Монтескье "Хэрэв хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг нэг гарт төвлөрүүлбэл эрх чөлөө хэрэгжихгүй. Шүүх эрх мэдэл нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс тусгаарлагдаагүй тохиолдолд эрх чөлөө үл оршино. Хэрэв шүүх эрх мэдэл хууль тогтоох эрх мэдэлтэй нэгдвэл иргэдийн амьдрал, эрх чөлөө дур зоргын золиос болно. Шүүх эрх мэдлийг гүйцэтгэх эрх мэдэлтэй нэгтгэвэл шүүгчид дарангуйлагчид болох үүд хаалга нээгдэнэ" гэсэн билээ. Тиймээс засаглалын харилцан хяналт-тэнцлийг хангах чиглэлээр 2019, 2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаад байна.

Төр бол ердөө л хүний эрхийг хангах тогтолцоо юм. Төр гагцхүү хуулиар зөвшөөрсөн хүрээнд ажиллаж, шийдвэр гаргах үүрэгтэй, харин иргэн хуулиар хориглоогүйг хийх эрхтэй гэдгийг бид ямагт санаж байх учиртай.

Хүн бүхэнд амьдралын зорилго, хүсэл мөрөөдөл байдаг. Зорилгоддоо хүрэхийн тулд авьяас чадвараа нээн хөгжүүлэх, мэдлэг боловсрол эзэмших, хөдөлмөрлөх, өмч эзэмших, баялаг хуримтлуулах, айдас хүйдэсгүй амьдрах гээд хүний жам ёсны эрхийг эдлэх бүхий л нөхцөлөөр хангагдах ёстой.

Энэ үүднээс Улсын Их Хурал хүний эрхийг хамгаалах тогтолцоог эрх зүйн шинэчлэлээр дэмжих чухал алхмууд хийсэн. Тухайлбал,

Нэгдүгээрт, "Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Парисын зарчим"-д нийцүүлэн Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2020 онд баталлаа.

Хоёрдугаарт, Монгол Улсад анх удаа нээлттэй, ил тод сонгон шалгаруулалтаар Комиссын гишүүдийг томилж, хараат бус, бие даасан байдлаар ажиллах боломжийг бүрдүүлсэн.



Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн мэдлэг олгох, сургах, чадавхжуулах Ази, Номхон далайн бүсийн төвийг Монгол Улсад байгуулах санаачилгыг дэвшүүлж байна.

Гуравдугаарт, Комисс үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн хэмжээг 2021 оныхоос бараг дөрөв дахин нэмэгдүүллээ.

Дөрөвдүгээрт, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэлийг зөвхөн Байнгын хороогоор хэлэлцдэг байсан уламжлалыг өөрчилж, 2020 оноос Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцдэг болж, Улсын Их Хурлын гурван тогтоол гаргаад байна.

Тавдугаарт, Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийг 2021 онд баталж, Ази тивдээ хүний эрх хамгаалагчийг хамгаалах тогтолцоо бий болгосон анхны улс боллоо. Үүнийг маань Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн Дээд комиссарын алба онцлон сайшаасан. “Эмнести интернэшнл” байгууллагаас энэхүү Хүндэтгэлийн хуралдаанд ирүүлсэн мэндчилгээндээ мөн баяр хүргэж, онцлон тэмдэглэсэн байна.

Зургадугаарт, Улсын Их Хурлын тогтоолоор Комиссын Хүний эрх хамгаалагчийн болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүдийг томилсноор Хүний эрхийн Үндэсний комиссын дэргэд хараат бус, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм, Хүний эрх хамгаалагчийн хороо байгуулагдлаа.

Долдугаарт, Монгол Улсын Шүүхийн тухай, Хууль зүйн туслалцааны тухай хуулиудыг шинэчлэн баталлаа. Иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах зорилгоор Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, хүний хувийн мэдээллийг ашиглах, аюулгүй байдлыг хангах харилцааг зохицуулсан Хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийг баталсан.

Наймдугаарт, Төр, хувийн хэвшлийн аль алинд хүний эрх, эрх чөлөөг зөрчиж, улсын болон иргэний боломжийг хулгайлж буй хорт үзэгдэл бол авлига хэмээн үзэж, 2023 оны хаврын чуулганаа “Авлигын эсрэг чуулган” болгохоо зарлаж, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг шинэчлэн баталсан. Түүнчлэн Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, төрийн өндөр албан тушаалтнууд гэмт хэрэгт холбогдвол хөөн хэлэлцэх хугацааг зогсоох, авлига, албан тушаалын гэмт хэрэгт оногдуулах ялын бодлогыг чангатгах, өршөөл, уучлал үзүүлэхгүй байх, хялбаршуулсан журмаар шийдвэрлэдэггүй байх зэрэг зохицуулалтыг тусгалаа.

Есдүгээрт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг шинэчилж, нэр дэвшигчдийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийнх байх зохицуулалтыг 2024 оноос, 40-өөс доошгүй хувь байхыг 2028 оноос мөрдөхөөр болж жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн дэвшил гаргалаа. Мөн нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчдийн хүйсийн харьцаа 1:1 байх зохицуулалтыг тусгалаа.



Хүний эрхийн түгээмэл тунхаглалын үзэл санаа 1992 онд баталсан Монгол Улсын ардчилсан, шинэ Үндсэн хуульд бүрэн тусгалаа олж, хүний салшгүй эрхийг анх удаа бүрэн цогцоор нь баталгаажуулсан юм...



Хүний эрхийг хамгаалах эдгээр хүч чармайлтыг дэмжиж, хамтран ажиллаж, сайн үйлсийг түгээж яваа хүний эрхийг хамгаалагч байгууллага, хүмүүс манайд цөөнгүй бий. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг олон нийтэд таниулж, хамгаалах үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулсан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ажилтан Буянжаргалын Болороог Европын Холбооноос “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн төлөө тэмцэгч”-ээр өргөмжилсөн. Мөн Төв Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны хөтөлбөрөөс жендэрийн тэгш байдлыг бэхжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, Монгол Улсын Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийг шилдгээр шалгаруулсан.

Эдгээр хүмүүс, байгууллагын төлөөлөл өнөөдрийн хуралдаанд хүндэт зочноор оролцож байна. Та бүхэнд болон хүний эрхийг хамгаалагч, тэмцэгч бүх хүмүүст баяр хүргэе.

Эрхэм гишүүд ээ,

Манай улсад хүний эрх зөрчигдөх явдал арилаагүй, гарсаар байна. Нэгдсэн Үндэстний байгууллагын хүний эрхийн механизмуудаас гаргаж буй удаа дараагийн дүгнэлт, зөвлөмжүүдэд ч энэ талаар дурдсаар байгаа.

Хот, хөдөөгийн нийтлэг асуудал болсон агаар, орчны бохирдол, авто замын түгжрэл нь хүний амьд явах эрхэд ноцтой заналхийлэл учруулж байна. Ийм учраас “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн бодлогыг Засгийн газар дэвшүүлсэн нь хүний эрхийг хангахын төлөө хийж буй чухал санаачилга юм.

Хувийн өмч бол хүн эрх, эрх чөлөөтэй байх, түүнийгээ бодитоор эдлэх гол нөхцөл мөн. Гэтэл хувийн өмчийг хамгаалах баталгааг зөрчих явдал гарсаар

байна. Хувийн өмч гэдэгт гадаадын хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах асуудал ч мөн хамаарна гэдгийг онцлон тэмдэглэе. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах асуудлыг хүний эрхийн хүрээнд онцгойлон авч үзэх ёстой.

Авлигын сүлжээ илчлэгдэж, баялгийн хуваарилалт, орлогын тэгш бус байдал нийгэмд бухимдал үүсгэж, энэ хэрээр хүний эрхийн зөрчил нэмэгдэх хандлагатай боллоо. Өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах иргэний эрх бүрэн хангагдахгүй байна. Эрүү шүүлт тулгаж, хүнлэг бусаар доромжлон харилцаж, хууль бусаар мөрдөх ажиллагаа явуулж, ял шийтгэсэн баримт олон нийтэд дэлгэгдэж байсан. Гэхдээ энэ сүүдэр одоо болтол арилаагүй байна.

Хүүхэд, эмэгтэйчүүдийг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах хууль тогтоомж шинэчлэгдсээр байгаа боловч хэрэг зөрчил буурахгүй, хүнлэг бус, ёс бус үйлдэл, доромжлол үйлдэгдсээр байгааг нийгмээрээ шүүмжилж, бухимдаж байна.

Олон нийтийн цахим мэдээллийн сүлжээ хурдацтай хөгжиж, тэндээс иргэд мэдээлэл олж авахын зэрэгцээ, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжууд нэмэгдсэн. Гэсэн хэдий ч хиймэл оюун ухаан, цахим орчинд хүний эрх, аюулгүй байдлыг хангах асуудал тулгамдаж байна.

Хотын алслагдсан хороололд амьдардаг иргэд, хөдөөгийн малчин өрхүүдийн хувьд интернэтийн хурд, сүлжээний хүртээмж хангалтгүй байгаа. Өндөр настан, үндэстний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд цахим үйлчилгээг тэр бүр авч чадахгүй байгаа нь судалгаагаар тогтоогдсон. Энэ нь нийгэмд цахим хуваагдлыг бий болгож байна.

Дэлхийн улс орнууд хиймэл оюун ухааны чатбот технологийн программуудыг ашиглаж худал, захиалгат мэдээлэл тараах, хүний эрх, нэр төрд халдах байдалд тодорхой цензур тогтоохыг эрмэлзэж байгаа ч бүрэн хяналт тавьж чадахгүй байна. Үүнтэй холбогдуулан АНУ болон Европын 40 гаруй оронд өндөр хандалттай зарим вэбсайтын үйл ажиллагааг хязгаарлахад хүрчээ.



Энэ дашрамд хүний эрхийг хуулиар хязгаарлаж болох боловч тэр нь зөвхөн бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах зайлшгүй шаардлагаар л хийгддэг болохыг анхааруулъя. Аливаа хэлмэгдүүлэлтээс хүн бүр ангид байх ёстой. Үүний нөгөө талд ял завших байдал хэрхэвч байж болохгүй.

Та бүхэнд “World Justice Project”-ээс дэлхийн улс орнууд хууль дээдлэх ёсыг хэрхэн хангаж буй талаар гаргадаг индексээр Монгол Улс хаахна явааг таван жилийн өмнөх болон дараах байдлаар харьцуулан үзүүлье.

Тухайлбал, Хүний үндсэн эрхийн үзүүлэлтээр 2017 онд 113 орноос 56-д орж байсан бол 2023 онд 142 орноос 69-д, авлигын үзүүлэлтээр 2017 онд 113 орноос 70-д эрэмбэлэгдсэн бол, 2023 онд 142 орноос 86-д, эрүүгийн эрх зүйн хэрэгжилтээр 2017 онд 113 орноос 50-д орсон бол 2023 онд 142 орноос 66-д, Нээлттэй засаглалын байдлаар 2017 онд 113 орноос 61-д жагсаж байснаа 2023 онд 142 орноос 74-д орсон байх жишээтэй.

Эндээс бид чухам ямар асуудалд илүү анхаарах ёстой вэ гэдэгт дүгнэлт хийх ёстой.

Эрх зүйн онолч, сэтгэгч Жон Локк “Хүн бүр өөрийн шинж чанараар эрх чөлөөтэй бөгөөд тухайн хүн өөрөө л зөвшөөрөөгүй тохиолдолд түүнийг өөр хэн ч, юу ч энэ газар дээрх аливаа эрх мэдлийн захиргаанд оруулж чадахгүй” гэжээ. Мөн “Хуулийн зорилго бол эрх чөлөөг устгах буюу хавчин гадуурхах явдал биш, харин түүнийг хамгаалж, өргөжүүлэх явдал мөн” гэсэн байдаг.

Тиймээс Монгол Улс хүн засагладаг биш, хууль засагладаг, хууль нь хүний эрх, эрх чөлөөг тууштай хамгаалдаг, хангадаг тогтолцоо бүрдүүлэхийг эрхэм зорилго болгож байна. Хууль дээдэлдэг, хууль нэг мөр үйлчилдэг нийгэмд л хүн эрх чөлөөтэй амьдардаг. Тиймээс эрх чөлөөнийхөө эзэн байх эрхийг иргэддээ



эдлүүлэх үүрэг, хариуцлага Монгол төрийнх юм. Хүний эрх бол төрийн аливаа байгууллага, тэнд алба хаагчдын заавал эзэмшсэн байх соёл мөн гэдгийг онцлон тэмдэглэе.

Эрхэм гишүүд ээ,

Монгол Улс Хүний эрхийн түгээмэл тунхаглалын үзэл санаанд үнэнч байж, тууштай сахисаар ирсэн, цаашид ч хэлбэрэлтгүй мөрдөж, хүний эрхийг хамгаалах дэлхий нийтийн үйлсэд хувь нэмрээ оруулах эрмэлзэл төгс байгаагаа нотолж;

Монгол Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдааны энэхүү индрээс:

1) төрөөс хүний эрхэнд халдах ямар нэгэн боломж, нөхцөл үүсгэхээс байнга сэргийлж, хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад нэн чухал хууль тогтоомжуудыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих;

2) Хүний эрхийн конвенц, гэрээ, пактуудаар хүлээсэн үүргээ биелүүлж, Хүний эрхийн төлөв байдлын талаар Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн хороо, бүтцийн бусад байгууллагуудад тайлагнах механизм бүрдүүлж, парламентаас манлайлж ажиллах;

3) гэрээ, конвенцуудад дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, олон улсын гэрээний заалтыг шүүн таслах үйл ажиллагаанд хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, олон улсын гэрээний үүрэг, зөвлөмжийн биелэлтийн явцыг Улсын Их Хуралд тогтмол тайлагнадаг журамд шилжиж, нээлттэй сонсголоор хянан хэлэлцэх;

4) хүний эрхийн боловсролыг иргэд, хүүхэд залууст олгох, тэдэнд зориулсан сурах бичиг хэвлэх, эрх эдлэгч, үүрэг хүлээгчийг чадавхжуулах сургалт зохион байгуулах, мэдлэгжүүлэх, чадавхжуулах, төрийн албан хаагчдад зориулан хүний эрхийн гарын авлага гаргах, тэдний хүний эрхийн мэдлэг, мэдрэмжийг шалган аттестатчилах эрх зүйн зохицуулалт бий болгох;

5) Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейгаас гаргасан тогтоолын хүрээнд Ахмадын эрхийн асуудлаар тусгайлсан эрхийн баримт бичиг боловсруулан батлах санаачилгыг дэмжиж, уг санаачилгад нэгдэх;

6) “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр-2”-ыг батлан хэрэгжүүлэх;

7) 2025 онд болох Нэгдсэн Үндэстний байгууллагын 80 жилийн ойг угтаж, 2025 оныг Нэгдсэн Үндэстний байгууллагын дүрмийн жил болгох;

8) Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн мэдлэг олгох, сургах, чадавхжуулах Ази, Номхон далайн бүсийн төвийг Монгол Улсад байгуулах санаачилгыг дэвшүүлж байгааг Улсын Их Хурал, Засгийн газрын эрхэм гишүүд Та бүхэн дэмжиж, ажил хэрэг болгохыг уриалж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Монгол Улсын нийт иргэд, Улсын Их Хурлын эрхэм гишүүд, Хүндэт зочид Та бүхэндээ маргааш тохиох Олон улсын Хүний эрхийн өдрийн мэндчилгээ дэвшүүлж, хамгийн сайн сайхныг хүсье.

II БҮЛЭГ

БАЙНГЫН БОЛОН ДЭД ХОРООД

БАЙНГЫН БОЛОН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААН

Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Байнгын хороод 114 удаагийн хуралдаанаар 271, дэд хороод зургаан удаагийн хуралдаанаар 12, хянан шалгах түр хороод 17 удаагийн хуралдаанаар 41 асуудал хэлэлцэн шийдвэрлэлээ.

БАЙНГЫН ХОРООДЫН ХУРАЛДААН

114
УДАА



АЖЛЫН ХЭСЭГ
107 | **271**
УДАА ХУРАЛДАЖ | АСУУДАЛ ХЭЛЭЛЦСЭН

295 хуулийн
төсөл

62 Улсын Их Хурлын
тогтоолын төсөл

71 Байнгын хорооны
тогтоолын төсөл

7 Зөвшилцөх
асуудал

3 Хяналт шалгалтын
тайлан

21 Яам, агентлаг, харьяа байгууллагын
тайлан, илтгэл, мэдээлэл

23 Албан тушаалтныг томилох,
чөлөөлөх асуудал

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН

31 Хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийн
санал, дүгнэлт

49 Анхны хэлэлцүүлгийн
санал, дүгнэлт

25 Эцсийн хэлэлцүүлгийн
танилцуулга

4 Олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцын
зөвшилцөх асуудлаарх санал, дүгнэлт

4 Соёрхон батлах
асуудлаарх санал, дүгнэлт

34 Бусад асуудлаарх
санал, дүгнэлт

29 Ажлын хэсгийн
танилцуулга

ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

Анхны хэлэлцүүлгийн шатанд **471**

Эцсийн хэлэлцүүлгийн шатанд **34**

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, АЛБАН БИЧИГ

85 Хариу өгч шийдвэрлэсэн / **124** Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол

420 Аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн албан бичиг / **88** Хянаж хариу өгсөн

ДЭД ХОРООДЫН ХУРАЛДААН

6
УДАА



Нэг. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

АГААРЫН БОХИРДЛЫГ
БУУРУУЛАХ АСУУДЛЫН
ДЭД ХОРОО
1 удаа хуралдсан

хэлэлцсэн асуудал

- Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны мэдээлэл
-“Таван толгой түлш” үйлдвэрийн мэдээлэл

СОНГОГЧИЙН НЭРСИЙН
ЖАГСААЛТ, БҮРТГЭЛИЙН
ХЯНАЛТЫН ДЭД ХОРОО
1 удаа хуралдсан

хэлэлцсэн асуудал

- Дэд хорооны даргыг сонгох тухай

ТӨСВИЙН
ЗАРЛАГЫН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРОО
1 удаа хуралдсан

хэлэлцсэн асуудал

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиуд

ТУСГАЙ ХЯНАЛТЫН
ДЭД ХОРОО
2 удаа хуралдсан

хэлэлцсэн асуудал

- Хаалттай

ХҮНИЙ ЭРХИЙН
ДЭД ХОРОО
1 удаа хуралдсан

хэлэлцсэн асуудал

- Улсын Их Хурал, түүний Тамгын газарт хийсэн хүний эрх, жэндэрийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээний санал, зөвлөмж

Байнгын болон дэд хороодоос зохион байгуулсан

6 НИЙТИЙН СОНГОЛ / **14** ХУРАЛ, ЗӨВЛӨГӨӨН / **91** УУЛЗАЛТ, ЯРИЛЦЛАГА
23 ХЭЛЭЛЦҮҮЛЭГ / **2** СУРГАЛТ, СЕМИНАР / **17** ХУУЛЬ ТОГТООМЖ
СУРТАЛЧЛАХ АЖИЛ

НЭГ. АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

Ээлжит чуулганы хугацаанд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо есөн удаа, ажлын хэсэг зургаан удаа хуралдаж, нийт 22 асуудлын хүрээнд таван хуулийн төсөл, Улсын Их Хурлын гурван тогтоолын төсөл, Байнгын хорооны таван тогтоолын төсөл, дөрвөн зөвшилцөх асуудал, хяналт шалгалтын хоёр тайлан, албан тушаалтныг томилох, чөлөөлөх тухай хоёр асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД

БАЙНГЫН ХОРОО

9 УДАА
ХУРАЛДСАН

АЖЛЫН ХЭСЭГ

6 УДАА
ХУРАЛДСАН

4 ХУУЛИЙН ТӨСӨЛ
ХЭЛЭЛЦҮҮЛЭН БАТЛУУЛСАН

3 УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ
ХЭЛЭЛЦҮҮЛЭН БАТЛУУЛСАН

5 БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ БАТАЛСАН

4 ЗӨВШИЛЦӨХ
АСУУДАЛ

2 ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТАЙЛАН

2 АЛБАН ТУШААЛТНЫГ
ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ

ТҮС ТҮС АСУУДЛУУДЫГ ХЭЛЭЛЦСЭН.

БАЙНГЫН ХОРООНООС

18 САНАЛ, ДҮГНЭЛТ ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТЭН
ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦҮҮЛСЭН.

Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар төслийн эцэслэн батлах бэлтгэлийг хангаж, нэгдсэн хуралдаанаар хуулийн дөрвөн төсөл, Улсын Их Хурлын гурван тогтоолын төслийг хэлэлцүүлэн батлуулсан.



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Б.ЭНХ-АМГАЛАН

БҮРЭЛДЭХҮҮН:



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.АМАРТҮВШИН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.БАДЕЛХАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ГАНБАТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ЦОГТБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.АЛТАНХУЯГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.БАТБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ДЭЛГЭРСАЙХАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
П.АНУЖИН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Э.БАТ-АМГАЛАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.НАРАНБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ЭРДЭНЭБАТ



Т.АЮУРСАЙХАН
/БҮРЭН ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН/



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БАТ-ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ОДОНТУЯА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БАТТӨМӨР



Д.БАТ-ЭРДЭНЭ
/БҮРЭН ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН/



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.СЭРГЭЛЭН

19
ГИШҮҮНТЭЙ

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар

Байнгын хороо хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн батлах үе шатанд дараах санал, дүгнэлт, танилцуулгыг бэлтгэн төслийг эцэслэн батлах бэлтгэл ханган ажиллалаа. Үүнд:

- хэлэлцэх эсэх асуудлаарх нэг санал, дүгнэлт;
- анхны хэлэлцүүлгийн нэг санал, дүгнэлт;
- эцсийн хэлэлцүүлгийн нэг танилцуулга;
- олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенц, Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох асуудлыг зөвшилцсөн талаарх таван санал, дүгнэлт;
- соёрхон батлах асуудлаар дөрвөн санал, дүгнэлт;
- бусад асуудлаар дөрвөн санал, дүгнэлт.

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах дөрвөн хууль, Улсын Их Хурлын гурван тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, Байнгын болон дэд хорооны долоон тогтоолыг баталж, олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцын зөвшилцөх дөрвөн асуудлыг шийдвэрлэж, Элчин сайд нарыг эгүүлэн татах, томилох нэг асуудлыг хэлэлцэн, чуулганы нэгдсэн хуралдааны дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчид хүргүүлснээс гадна холбогдох байгууллагуудад хуралдааны дөрвөн тэмдэглэлээр үүрэг даалгавар өгч, батлагдсан хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг нэг удаа холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулсан.

Байнгын хорооны тогтоолоор хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий нэг, хяналт, шалгалтын хоёр ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаагаас хоёр ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж байна.

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсэг:

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
2023.12.12, №09	“Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ахлагч: Б.Энх-Амгалан Гишүүд: Д.Ганбат Н.Энхболд

Бусад Байнгын хороонд хүргүүлсэн санал, дүгнэлт:

Байнгын хорооны хуралдаанаар Засгийн газраас 2023 оны есдүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн болно.

Хяналт, шалгалтын ажлын талаар

Байнгын хорооны хаалттай хуралдаанаар дараах мэдээллийг сонссон. Үүнд:

- 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, хар тамхины талаарх мэдээлэл;
- 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Усны нөөцийг хамгаалах, хомсдолоос сэргийлэх, ундны усны эх үүсвэр, усны чанар, аюулгүй байдлын талаарх мэдээлэл.

Бусад ажлын талаар

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан дараах байгууллагын дарга, удирдлагуудыг хүлээн авч уулзан, санал солилцож, тодорхой асуудлуудаар үүрэг, чиглэл өгөв. Үүнд:

- 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Алексей Николаевич Евсиков болон Оросын Холбооны Улсын Элчин сайдын яамны нэгдүгээр нарийн бичгийн дарга Максим Владимирович Кравцов, тус яамны атташе Татьяна Михайловна Сятчихина болон албаны бусад хүмүүсийг хүлээн авч уулзав;





- 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар нар Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, ноён Ричард Буанган болон холбогдох хүмүүстэй уулзаж, санал солилцов;

- 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Холбооны Бүгд Найрамдах Герман Улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хельмут Рудольф Кулитцийг хүлээн авч уулзав;

- Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2023 оны 11 дүгээр сарын 01-05-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад хийсэн төрийн айлчлалын бүрэлдэхүүнд орж ажиллав;

- 2023 оны 12 дугаар сарын 03-07-ны өдрүүдэд Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан тэргүүтэй тус Байнгын хорооны гишүүд Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (БХАТИХ)-ын Гадаад хэргийн хорооны урилгаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсад ажлын айлчлал хийж, БХАТИХ-ын Байнгын хорооны дэд дарга Луосан Жанцун, БХАТИХ-ын Гадаад хэргийн хорооны дэд дарга Фү Зиин болон холбогдох албаны хүмүүстэй уулзалт хийсэн.



ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО

Ээлжит чуулганы хугацаанд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 11 удаа, Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо нэг удаа, ажлын хэсэг есөн удаа, ажлын дэд хэсэг 21 удаа тус тус хуралдаж, нийт 22 асуудлын хүрээнд 34 хуулийн төсөл, Улсын Их Хурлын тогтоолын нэг төсөл, Байнгын хорооны зургаан тогтоолын төслийг хэлэлцэн, яам, агентлаг, харьяа байгууллагын тайлан, мэдээлэл тавыг хэлэлцэн шийдвэрлэсэн болно.

Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар төслийн эцэслэн батлах бэлтгэлийг хангаж, нэгдсэн хуралдаанаар 24 хуулийн төслийг хэлэлцүүлэн батлуулсан.



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРОО

2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД

БАЙНГЫН ХОРОО

11 УДАА
ХУРАЛДСАН

ДЭД ХОРОО

1 УДАА
ХУРАЛДСАН

АЖЛЫН ХЭСЭГ

9 УДАА
ХУРАЛДСАН

ДЭД ХЭСЭГ

21 УДАА
ХУРАЛДСАН

НИЙТ

24 АСУУДАЛ
ХЭЛЭЛЦСЭН

23 ХУУЛИЙН ТӨСӨЛ
ХЭЛЭЛЦҮҮЛЭН БАТЛУУЛСАН

5 АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН
САНАЛ, ДҮГНЭЛТ

4 БУСАД АСУУДААР
САНАЛ ДҮГНЭЛТ

6 БАЙНГЫН ХОРООНООС
ЗОХИОН БАЙГУУЛСАН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

5 ҮҮЛЗЛЭГ,
ЯРИЛЦЛАГА

Хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн талаар

Байнгын хороо хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн батлах үе шатанд дараах санал, дүгнэлт, танилцуулгыг бэлтгэн төслийг эцэслэн батлах бэлтгэл ханган ажиллаа. Үүнд:

- хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийн нэг санал, дүгнэлт;
- анхны хэлэлцүүлгийн таван санал, дүгнэлт;
- эцсийн хэлэлцүүлгийн гурван танилцуулга;
- бусад асуудлаар дөрвөн санал, дүгнэлт.



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ж.БАТЖАРГАЛ

БҮРЭЛДЭХҮҮН:



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.АНАНДБААЗАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ГАНБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.НАРАНБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.ЦОГТГЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.АУБАКИР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.ГАНИБАЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ӨНӨРБОЛОР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.ЦЭРЭНПУНЦАГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.БАТ-ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ДАМДИННЯМ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.САРАНЧИМЭГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.ЭНХТҮВШИН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.БОЛОРЧУЛУУН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.ИДЭРБАТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ТЭМҮҮЛЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БЕЙСЕН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.МӨНХЦЭЦЭГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.ТУВААН

19
ГИШҮҮНТЭЙ

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий нэг Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

Хяналт, шалгалтын ажлын талаар

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалтын чиглэлээр Байнгын хорооны тогтоолоор байгуулсан дараах ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж байна.

Байнгын хорооны 2023 оны 10 дугаар тогтоолоор Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт, шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболороор ахлуулж, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Н.Ганибал, Ц.Идэрбат, Ц.Туваан нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан. Ажлын дэд хэсгийг холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан байгуулсан.

Ажлын хэсгээс баталсан төлөвлөгөөний дагуу дэд ажлын хэсэг холбогдох байгууллагуудаас хуулийн хэрэгжилтийн талаар тайлан, мэдээлэл авахаар үүрэг чиглэл өгөн ажиллаж байна.

Байнгын хороонд хүргүүлсэн санал, дүгнэлт:

- Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.10.31-ний өдөр Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлсэн/;

- “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.10.31-ний өдөр Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлсэн/;

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн/.

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсэг:

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
2024.01.03, №02	Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий	Ахлагч: Н.Наранбаатар Гишүүд: Г.Ганболд Н.Ганибал Ц.Идэрбат Б.Саранчимэг Ц.Туваан Т.Энхтүвшин
2023.04.18, №05	Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий	Ахлагч: Д.Цогтбаатар Гишүүд: Т.Аубакир Э.Батшугар Г.Дамдинням Ц.Туваан
2023.05.03, №06	Органик бүтээгдэхүүний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий	Ахлагч: Б.Баттөмөр Гишүүд: С.Ганбаатар Х.Ганхуяг Ц.Идэрбат Ц.Цэрэнпунцаг
2023.06.28, №10	Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий	Ахлагч: Р.Өнөрболор Гишүүд: Ж.Батжаргал Н.Ганибал Ц.Идэрбат Ц.Туваан
2023.07.04, №11	Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 22 гишүүнээс 2023 оны зургадугаар сарын 20-ны өдөр өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр нарын таван гишүүнээс 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэх үүрэг бүхий	Ахлагч: Г.Тэмүүлэн Гишүүд: Ж.Батжаргал С.Ганбаатар Н.Ганибал Ц.Идэрбат Ц.Мөнх-Оргил Ц.Сандаг-Очир Б.Жаргалмаа

<p>2023.07.04, №12</p>	<p>Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэх үүрэг бүхий</p>	<p>Ахлагч: Ж.Бат-Эрдэнэ</p> <p>Гишүүд: Т.Аубакир Б.Бейсен Ц.Идэрбат Ц.Туваан</p>
----------------------------	--	--

Бусад ажлын талаар

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах, мэдээлэл солилцох зорилгоор хууль тогтоомжийн төслийн талаарх олон нийтийн зургаан хэлэлцүүлэг, таван уулзалт, ярилцлагыг зохион байгуулж ажиллалаа.

Байнгын хорооноос зохион байгуулсан хэлэлцүүлэг:

- 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Говьсүмбэр аймгийн сум, орон нутгийн иргэд болон аймгийн төрийн албан хаагчдын 70 гаруй төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг;

- 2023 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Их дээд сургууль, мэргэжлийн байгууллагын 80 гаруй төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг Туушин зочид буудлын “Сүлд” танхимд;



- 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Увс аймгийн сум, орон нутгийн иргэд болон аймгийн төрийн албан хаагчдын 60 гаруй төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг;
- 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр Баян-Өлгий аймгийн сум, орон нутгийн иргэд болон аймгийн төрийн албан хаагчдын 60 гаруй төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг;
- 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Өвөрхангай аймгийн сум, орон нутгийн иргэд болон аймгийн төрийн албан хаагчдын 70 гаруй төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг;
- 2024 оны нэгдүгээр сарын 03-ны өдөр “Мөнх-Шинэ хөдөө сэргэлт” сэдэвт хэлэлцүүлгийг Төрийн ордны “Их Эзэн Чингис хаан” танхимд.



Байнгын хорооноос зохион байгуулсан уулзалт:

- 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Байнгын хорооны дарга, ажлын алба, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга болон яамны холбогдох газар, хэлтсийн дарга нартай 2024 онд Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээ, өвөлжилтийн нөхцөл байдал, мах бэлтгэл, гурилын нөөц, хангамж зэрэг асуудлуудаар санал солилцсон.
- 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Байнгын хорооны дарга, ажлын алба Хөдөө аж ахуйн салбарын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэн гүйцэтгэдэг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, Ургамал, газар тариалангийн хүрээлэн, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн болон Боловсрол, шинжлэх ухааны яамны холбогдох газрын төлөөлөлтэй хүрээлэнгүүдийн судалгааны үр өгөөж, шинжлэх ухааны салбарын санхүүжилт, бэлчээр, газар тариалангийн талаар хэрэгжүүлж байгаа судалгааны ажлын талаар болон хүрээлэнгүүдийн танилцуулгатай танилцаж санал солилцсон.

• 2024 оны нэгдүгээр сарын 08-ны өдөр Байнгын хорооны дарга Ж.Батжаргал болон тус байнгын хорооны гишүүд, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Г.Дамдинням, Г.Мөнхцэцэг, Ц.Туваан, Б.Бейсен, Т.Аубакир, Н.Ганибал нар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны үйл ажиллагаатай танилцаж, Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоол, Байнгын хорооноос чиглэл өгсөн тогтоолын хэрэгжилтийн талаар уулзалт зохион байгуулсан;

• 2024 оны нэгдүгээр сарын 15-ны өдөр Байнгын хорооны дарга, ажлын алба Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газар, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хөдөө аж ахуйн корпораци ТӨХХК-ийн төлөөлөлтэй 2024 оны хаврын тариалалтын бэлтгэл ажил, яамнаас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцож, Байнгын хорооны даргаас тодорхой асуудлаар үүрэг чиглэл өгсөн.



• 2024 оны нэгдүгээр сарын 16-ны өдөр Байнгын хорооны дарга, ажлын алба Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын төлөөлөлтэй ноос, ноолуурын талаар баримтлах бодлого болон мал, махны экспорт, малын тэжээл, уг салбарт үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих бодлого арга хэмжээний талаар санал солилцож, үүрэг чиглэл өгсөн.

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээс санал авах зорилгоор Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, тогтоолын 12 төсөл, Байнгын хорооны есөн санал, дүгнэлт, танилцуулга, 12 мэдээ мэдээлэл иргэд, олон нийтээс санал авах D.Parliament.mn цахим системд байршуулсан.

ГУРАВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРОО

Ээлжит чуулганы хугацаанд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо таван удаа, ажлын хэсэг хоёр удаа, ажлын дэд хэсэг долоон удаа тус тус хуралдаж, нийт найман асуудлын хүрээнд нэг хуулийн төсөл, Байнгын хорооны дөрвөн тогтоолын төслийг хэлэлцэн, яам, агентлаг, харьяа байгууллагын тайлан, мэдээлэл хоёрыг хэлэлцэн шийдвэрлэсэн болно.



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРОО

2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД

БАЙНГЫН ХОРОО

7 УДАА
ХУРАЛДСАН

НИЙТ

8 АСУУДАЛ
ХЭЛЭЛЦСЭН

НИЙТ

4 БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛЫН ТӨСӨЛ БАТЛАВ

2 ЯАМ, АГЕНТЛАГ, ХАРЬАА БАЙГУУЛЛАГЫН
ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

"МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН АСУУДАЛ, ШИЙДЭЛ"
ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН:

"МОНГОЛ ХЭЛ, БИЧГИЙН ҮНЭЛЭМЖ, ХЭРЭГЛЭЭ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛААР
ЗӨВЛӨМЖ, САНАЛ, ДҮГНЭЛТ ГАРГАЖ, ЦААШИД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААРХ
ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ": АЖЛЫН ХЭСЭГ

БОЛОВСРОЛЫН БАГЦ ХУУЛИЙГ БАЯНХОНГОР, ӨВӨРХАНГАЙ, ДАРХАН-УУЛ, ГОВЬСҮМБЭР, ДҮНДГОВЬ АЙМАГТ СУРТАЛЧЛАН АЖИЛЛАВ.

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ ҮЙЛДВЭРЭЛИЙГ ДЭМЖИХ ТҮХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ОРГОН МЭДГҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛӨДИЙГ ХЭЛЭЛЦҮҮЛЭХЭЭР БЭЛТЭЖ БАЙНА.

Хяналт, шалгалтын ажлын талаар

Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалтын чиглэлээр Байнгын хорооны тогтоолоор хоёр Ажлын хэсэг байгуулан ажилласан.



БАЙНГИН ХОРООНЫ ДАРГА
Б.БАЯРСАЙХАН

БҮРЭЛДЭХҮҮН:



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
А.АДЪЯАСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Э.БАТШУГАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.МӨНХЦЭЦЭГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.УЧРАЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
П.АНУЖИН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.ГАНХУЯГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.МӨНХЦЭЦЭГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ЧИНЗОРИГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.АУБАКИР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ДАМДИННЯМ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ЧИНБҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Л.ЭНХ-АМГАЛАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ё.БААТАРБИЛЭГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ЖАРГАЛМАА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ч.УНДРАМ

16
ГИШҮҮНТЭЙ

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсэг:

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
2023.10.18, №04	Монгол хэл, бичгийн үнэлэмж, хэрэглээ, эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар зөвлөмж, санал, дүгнэлт гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ахлагч: Г.Мөнхцэцэг Гишүүд: П.Анужин Б.Баярсайхан Б.Жаргалмаа Ц.Мөнхцэцэг Ж.Чинбүрэн
2023.10.15, №01	Монгол Улсын Засгийн газраас 2023 оны дөрөвдүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий	Ахлагч: Ч.Ундрэм Гишүүд: А.Адъяасүрэн П.Анужин Т.Аубакир Э.Батшугар Г.Дамдинням Б.Жаргалмаа Г.Мөнхцэцэг

Бусад Байнгын хороонд хүргүүлсэн санал, дүгнэлт:

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг бэлтгэн Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн.

Бусад ажлын талаар

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах, мэдээлэл солилцох зорилгоор хууль тогтоомжийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг нэг, уулзалт, ярилцлага дөрвийг зохион байгуулж ажиллалаа.

Байнгын хорооноос зохион байгуулсан хэлэлцүүлэг:

- 2024 оны нэгдүгээр сарын 15-ны өдөр Байнгын хороо, Боловсрол, шинжлэх ухааны яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Соёлын яам, Боловсролын ерөнхий газар, ШУА-ийн Хэл зохиолын үндэсний хүрээлэн, Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Монгол Улсын Их сургууль, Монгол Улсын багшийн их сургуультай хамтран 500 гаруй төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг Соёлын төв өргөөнд зохион байгуулсан.

• 2024 оны нэгдүгээр сарын 15-ны өдөр Байнгын хороо, Боловсрол, шинжлэх ухааны яам, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Соёлын яам, Боловсролын ерөнхий газар, ШУА-ийн Хэл зохиолын үндэсний хүрээлэн, Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Монгол Улсын Их сургууль, Монгол Улсын багшийн их сургуультай хамтран “Монгол хэл, бичгийн асуудал, шийдэл” Үндэсний чуулганыг зохион байгуулсан.

Байнгын хорооноос зохион байгуулсан уулзалт:



• 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Байнгын хорооны дарга, ажлын албаны хамтаар Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон яамны холбогдох газар, хэлтсийн удирдлагуудтай 2024 онд боловсролын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээ, нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудын талаар санал солилцсон.

• 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Байнгын хорооны дарга, ажлын албаны хамтаар Соёлын сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон яамны холбогдох газар, нэгжийн удирдлагуудтай 2024 онд Соёлын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээ, нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудын талаар санал солилцсон.

• 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Байнгын хорооны дарга, ажлын албаны хамтаар Олимп, нийтийн биеийн тамир спортын Үндэсний хорооны дарга болон холбогдох бусад удирдлагуудтай 2024 онд Олимп, нийтийн биеийн тамир, спортын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээ, нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудын талаар санал солилцсон.

• 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Соёлын яамны албан тушаалтнууд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлал, хуулийн төслийн талаар танилцуулав.

ДӨРӨВ. ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРОО

Ээлжит чуулганы хугацаанд Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд таван удаа хуралдаж, нийт долоон асуудлын хүрээнд Байнгын хорооны зургаан тогтоол баталж, ажлын хэсгийг найман удаа хуралдуулж, харьяа байгууллагын нэг тайлан, илтгэл, мэдээллийг хэлэлцэн шийдвэрлүүлсэн байна.



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН БАЙНГЫН ХОРОО

2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД

БАЙНГЫН ХОРОО

5 УДАА
ХУРАЛДСАН

АЖЛЫН ХЭСЭГ

8 УДАА
ХУРАЛДСАН

НИЙТ

6 АСУУДАЛ
ХЭЛЭЛЦСЭН

БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ **6**

5 УДАА
ТӨРИЙН АЛБАН ХААГЧДАД СУРГАЛТ

1 ХАРЬАА БАЙГУУЛЛАГЫН
ТАЙЛАН, МЭДЭЭГЭЛ

2 САНАЛ
ДҮГНЭЛТ

3 ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙГ НИЙТЭД
ТАНИУЛАН СУРТАЛЧЛАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

2 ХУУЛИЙН ТӨСӨЛД САНАЛ АВАХ,
НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ҮҮЛЭЛТ

“ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ”

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙГ БАЙГУУЛАВ.

Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Байнгын хороо хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн батлах үе шатанд дараах санал, дүгнэлт, танилцуулгыг бэлтгэн төслийг эцэслэн батлах бэлтгэл ханган ажиллалаа.

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд Байнгын хорооны зургаан тогтоол баталж, нэг хэлэлцүүлэг, батлагдсан хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг нэг удаа тус тус зохион байгууллаа.

Улсын Их Хурлын даргын захирамжаар хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий нэг Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Б.БАТТӨМӨР

БҮРЭЛДЭХҮҮН:



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ш.АДЬШАА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БАТ-ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Л.ЭНХ-АМГАЛАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.БАДЕЛХАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БЕЙСЕН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.БЯМБАЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.ЭНХБОЛД

10
ГИШҮҮНТЭЙ

<https://www.facebook.com/StandingCommitteeOnEthicsaAndDiscipline>

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг:

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
2023.12.15, №209	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах үүрэг бүхий	Ахлагч: Б.Баттөмөр Гишүүд: Х.Баделхан Б.Баярсайхан Б.Бейсен Н.Энхболд

Бусад ажлын талаар

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах гурван, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах, мэдээлэл солилцох нэг, хууль тогтоомжийн төслийн талаарх олон нийтийн нэг уулзалт, хэлэлцүүлэг, төрийн байгууллагын ахлах ажилтнуудыг хамруулсан сургалт, семинарыг таван удаа тус тус зохион байгуулж ажиллалаа.



ТАВ. ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

Ээлжит чуулганы хугацаанд Инновац, цахим бодлогын байнгын хороо дөрвөн удаа, нийт зургаан асуудлын хүрээнд 109 хууль, Улсын Их Хурлын гурван тогтоолын төсөл, Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал нэг удаа, Байнгын хорооны хоёр тогтоолын төслийг хэлэлцэж шийдвэрлэв.



Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Засгийн газраас 2023 оны тавдугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нийт 109 хууль, Улсын Их Хурлын нэг тогтоолын төслийг тус Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хурлын чуулганы 2024 оны нэгдүгээр сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар батлуулсан. Үүнд:

- ажлын хэсгийн хоёр танилцуулга;
- анхны хэлэлцүүлгийн нэг санал, дүгнэлт;
- эцсийн хэлэлцүүлгийн нэг танилцуулга.



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Э.БАТШУГАР

БҮРЭЛДЭХҮҮН:



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Э.БАТ-АМГАЛАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.ДОРЖХАНД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.САРАНЧИМЭГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ЧИНБҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.ГАНИБАЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.ИДЭРБАТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ч.УНДРАМ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.ГАНХУЯГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.СЭРГЭЛЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.УЧРАЛ

11
ГИШҮҮНТЭЙ

<https://www.facebook.com/StandingCommitteeOfInnovationAndEPolicy>

Тус Байнгын хорооны 2023 оны 03 дугаар тогтоолоор байгуулагдсан хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг таван удаа хуралдаж, ажлын хэсгийн танилцуулга, саналын томъёоллоо Байнгын хорооны хуралдаанд танилцуулсан байна.

Бусад Байнгын хороонд хүргүүлсэн санал, дүгнэлт:

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн/;

Хяналт, шалгалтын ажлын талаар

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугар 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Төрийн албаны зөвлөл, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын удирдлагууд, нийслэл, аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын холбогдох албан хаагчидтай Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлгийг Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд зохион байгуулж, хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох байгууллагын удирдлагад үүрэг чиглэл өгч ажилласан.

Бусад ажлын талаар

• Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023 оны нэгдүгээр тогтоолоор батлагдсан “Цахим систем ашиглан иргэдийн оролцоог хангах, санал авах журам”-аар иргэний гаргасан нийтийн өргөдлийг хүлээн авах харилцааг зохицуулсан бөгөөд 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн Улсын Их Хурлын D-Өргөдөл буюу “Нийтийн өргөдөл, гомдлын систем”-ээр иргэн нийтийн өргөдөл санаачлах болон нийтийн өргөдлийг дэмжиж санал өгөх эрхийг бодитой хэрэгжүүлэх боломжтой болсон.



• Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, гишүүд цахим хөгжлийг дэмжих чиглэлээр баталсан хууль тогтоомжийг сурталчлах, мэдээлэл солилцох зорилгоор дараах дөрвөн уулзалтыг зохион байгууллаа. Үүнд:

• 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Байнгын хорооны дарга Э.Батшугар тус Байнгын хорооны 2022 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилттэй танилцах ажлын хүрээнд “Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн төв” Улсын үйлдвэрийн газрын захирал, менежер нартай уулзалт хийсэн.

• 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Байнгын хорооны дарга Э.Батшугар Улаанбаатар инновацын төв /Hub innovation center/-ийн үйл ажиллагаа болон “Metaforce”, “Өнгө нэмье”, “ROCO”, “Tetgeleg”, “Diverse solution”, “Cloud Bridge”, “Clubi”, “Social Bot”, “Grado”, “AI Rookies”, “Chipmo”, “Carpool Mongolia” ХХК-ийн инновацын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцаж, санал солилцлоо.



• 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Байнгын хорооны дарга Э.Батшугар Төрийн ордонд зохион байгуулагдсан төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн “Админ-2023” чуулга уулзалтад үг хэлж, мэдээллийн технологийн хөгжлийг төрийн байгууллагын үйлчилгээ, үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, аюулгүй байдлыг бэхжүүлэх, технологийн шинэ шийдлийн талаар мэдээлэл солилцсон.

• 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Байнгын хорооны дарга Э.Батшугар Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагаатай танилцаж, монгол эрдэмтдийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, өрсөлдөх чадвартай, импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжихэд төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах, технологи, инновацын салбарын гарааны бизнесийг дэмжих, улсын төсвийн санхүүжилтээр хийгдсэн эрдэм шинжилгээний бүтээлүүдэд оюуны өмчийн үнэлгээ хийлгэх зэргээр Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хороо бодлогын түвшинд дэмжиж, хамтран ажиллахаа илэрхийлсэн.

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээс санал авах зорилгоор Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 120 хууль, Улсын Их Хурлын нэг тогтоолын төсөл, Байнгын хорооны хоёр санал, дүгнэлт, нэг танилцуулга, 70 зарчмын зөрүүтэй саналын томьёолол, есөн мэдээ, мэдээллийг D.Parliament.mn цахим системд байршуулсан.

ЗУРГАА. НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

Ээлжит чуулганы хугацаанд Нийгмийн бодлогын байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд найман удаа хуралдаж, нийт 23 асуудлын хүрээнд 25 хуулийн төсөл, Улсын Их Хурлын нэг тогтоолын төсөл, Байнгын хорооны долоон тогтоолын төсөл, яам, агентлаг, харьяа байгууллагын тайлан, илтгэл, мэдээлэл хоёр удаа, албан тушаалтныг томилох, чөлөөлөх асуудлыг нэг удаа хэлэлцэн шийдвэрлүүлж, Улсын Их Хурлын гишүүд болон Байнгын хорооны гишүүдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.



Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийн хоёр санал, дүгнэлт, анхны хэлэлцүүлгийн долоон санал, дүгнэлт, эцсийн хэлэлцүүлгийн гурван танилцуулга, бусад асуудлаарх гурван санал, дүгнэлт бэлтгэж холбогдох Байнгын, дэд хороонд хүргүүлж, ажлын хэсгийн дөрвөн танилцуулгыг бэлтгэж, Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгийн шатанд зарчмын зөрүүтэй 109 саналын томьёолол, эцсийн хэлэлцүүлгийн шатанд зарчмын зөрүүтэй 11 саналын томьёоллыг тус тус бэлтгэн төслийг эцэслэн батлах бэлтгэл ханган ажиллалаа.

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах 22 хууль, Улсын Их Хурлын гурван тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ханган, Байнгын хорооны долоон тогтоолыг баталж, 12 хэлэлцүүлэг зохион байгуулж, батлагдсан хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан ажиллалаа.



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
П.АНУЖИН

17
ГИШҮҮНТЭЙ

БҮРЭЛДЭХҮҮН:



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.БАТЛУТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ГАНБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.САРАНГЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ЖАРГАЛМАА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БАЯРСАЙХАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.ИДЭРБАТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.САРАНЧИМЭГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.ТУВААН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БЕЙСЕН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
М.ОЮУНЧИМЭГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.МӨНХ-ОРГИЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ЧИНЗОРИГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.БУЛГАНТУЯА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.САНДАГ-ОЧИР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ОДОНТУЯА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ЧИНБҮРЭН



<https://www.facebook.com/StandingCommitteeOnSocialPolicy>

Улсын Их Хурлын даргын захирамжаар нэг, Байнгын хорооны тогтоолоор хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий хоёр ажлын хэсэг байгуулан ажилласнаас нийт хоёр ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж байна.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг.

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
2023.02.06, №27 2023.06.19, №108	Монгол Улсын Засгийн газраас 2023 оны нэгдүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал нарын таван гишүүнээс 2020 оны тавдугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэх, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий	Ахлагч: П.Анужин Гишүүд: Ж.Батжаргал С.Ганбаатар Т.Доржханд Б.Жаргалмаа Ц.Идэрбат Ц.Мөнх-Оргил М.Оюунчимэг Ц.Сандаг-Очир Б.Саранчимэг Ц.Туваан С.Чинзориг

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсэг

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
2023.04.04, №08	Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, А.Адъяасүрэн, П.Анужин, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Б.Саранчимэг, Ч.Ундрам нараас 2022 оны наймдугаар сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ахлагч: Ж.Чинбүрэн Гишүүд: Б.Бейсен Б.Жаргалмаа Ц.Сандаг-Очир Ц.Туваан

2023.10.10, №12	Монгол Улсын Засгийн газраас 2023 оны зургадугаар сарын 28-ны өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал дүгнэлийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ахлагч: Д.Сарангэрэл Гишүүд: П.Анужин Б.Жаргалмаа М.Оюунчимэг Ж.Чинбүрэн
2023.11.07, №14	Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн таслууд, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, А.Адьяасүрэн, П.Анужин, Х.Булгантуяа, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Д.Өнөрболор, Д.Сарангэрэл, Б.Саранчимэг, Ч.Ундрам нарын гишүүдээс 2023 оны гуравдугаар сарын 05-ны өдөр Улсын их хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг нэгтгэн Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх үүрэг бүхий	Ахлагч: Ц.Идэрбат Гишүүд: П.Анужин Б.Баярсайхан Б.Бейсен Б.Жаргалмаа

Хяналт, шалгалтын ажлын талаар

Байнгын хорооны 2022 оны 19 дүгээр тогтоолоор байгуулагдсан Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох, санг зайлшгүй эрсдэлээс хамгаалах эрүүл мэндийн салбарны цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг 2023 оны 11 сарын 23-ны өдөр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар дээр ажиллалаа.

Бусад ажлын талаар

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах, мэдээлэл солилцох зорилгоор хууль тогтоомжийн гурван төслийн талаар олон нийтийн 12 хэлэлцүүлэг зохион байгуулж ажиллалаа.

- 2023 оны наймдугаар сарын 21-22-ны өдрүүдэд Олон улсын Парламентчдын Эрүүл мэндийн асуудлаарх 7-р чуулган;
- 2023 оны есдүгээр сарын 12-ны өдөр Мансууруулах бодисын хор хөнөөлтэй тэмцэх бодлого хэлэлцүүлэг;
- 2023 оны есдүгээр сарын 13-ны өдөр Баянхонгор аймгийн иргэд, албан хаагчдын төлөөлөлтэй хийсэн Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга;
- 2023 оны есдүгээр сарын 14-ны өдөр Өвөрхангай аймгийн иргэд, албан хаагчдын төлөөлөлтэй хийсэн Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга;
- 2023 оны есдүгээр сарын 18-ны өдөр Дархан-Уул аймгийн иргэд, албан хаагчдын төлөөлөлтэй хийсэн Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга;
- 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн жишиг төвийн үйл ажиллагаа, бүтэц зохион

байгуулалттай танилцаж ажилтан албан хаагчид, иргэдтэй Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийн уулзалт-хэлэлцүүлэг;

- 2023 оны 10 дугаар сарын 05-07-ны өдөр Сэлэнгэ, Дархан аймгийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн жишиг төвийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалттай танилцаж ажилтан албан хаагчид, иргэдтэй Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийн уулзалт-хэлэлцүүлэг;

- 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдөр “Жирэмсэн болон хөхүүл үеийн хооллолт” сэдэвт цахим хэлэлцүүлэг;

- 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр “Хүүхдийн эрүүл мэнд ба чихрийн хэрэглээ” хэлэлцүүлэг;

- 2023 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилт, түүний чанар үр дүн, тулгамдаж буй асуудал, эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн үр дүнгийн талаар Увс аймгийн эрүүл мэндийн салбарын ажиллагсадтай уулзалт хэлэлцүүлэг;

- 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилт, түүний чанар үр дүн, тулгамдаж буй асуудал, эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн үр дүнгийн талаар Архангай аймгийн эрүүл мэндийн салбарын ажиллагсадтай уулзалт хэлэлцүүлэг;

- 2024 оны нэгдүгээр сарын 18-ны өдөр Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилт, түүний чанар үр дүн, тулгамдаж буй асуудал, эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн үр дүнгийн талаар Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн салбарын ажиллагсадтай уулзалт хэлэлцүүлэг.



Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээс санал авах зорилгоор Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 25 хууль, тогтоолын төслийг Улсын Их Хурлын цахим хуудас болох forum.parliament.mn болон иргэд, олон нийтээс санал авах D.Parliament.mn-д тус тус байршуулсан бөгөөд хуулийн төслүүдийг 11796 иргэн үзэж танилцан 94 санал өгсөн байна.

ДОЛОО. ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

Ээлжит чуулганы хугацаанд Төрийн байгуулалтын байнгын хороо 15 удаа, нийт 35 асуудлын хүрээнд 27 хуулийн төсөл, 17 Улсын Их Хурлын тогтоолын төсөл, нэр дэвшигчийн сонсголын гурван тайлан, Байнгын хорооны найман тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэв.



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО

2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД

БАЙНГЫН ХОРОО

15 УДАА
ХУРАЛДСАН

23 ХУУЛИЙН ТӨСӨЛ
ХЭЛЭЛЦҮҮЛЭН БАТЛУУЛСАН

22 УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ
ХЭЛЭЛЦҮҮЛЭН БАТЛУУЛСАН

8 БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛЫН ТӨСӨЛ БАТАЛСАН

28 БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ, ТАНИЛЦУУЛГА

69 БАЙНГЫН ХОРООНЫ БОЛОН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ АНХНЫ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ШАТАНД ЗАРЧМЫН ЗОРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

3 НЭР ДЭВШИГЧИЙН
СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛЖЭЭ

5 ЭЦСИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ШАТАНД ЗАРЧМЫН ЗОРҮҮТЭЙ САНАЛЫН
ТОМЬЁОЛЛЫГ ТҮС ТҮС БЭЛТГЭН ТӨСЛИЙГ ЭЦЭСЛЭН БАТЛАХ БЭЛТГЭЛ
ХАНГАН АЖИЛЛАВ.

Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Байнгын хороо хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэлэцэн батлах үе шатанд дараах санал, дүгнэлт, танилцуулгыг бэлтгэн төслийг эцэслэн батлах бэлтгэл ханган ажиллалаа. Үүнд:

- хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийн гурван санал, дүгнэлт;
- анхны хэлэлцүүлгийн таван санал, дүгнэлт;
- эцсийн хэлэлцүүлгийн хоёр танилцуулга;
- бусад асуудлаар 14 санал, дүгнэлт;
- ажлын хэсгийн таван танилцуулга.



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Н.ЭНХБОЛД

БҮРЭЛДЭХҮҮН:



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.АМАРСАЙХАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ГАНБОЛД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.МӨНХЦЭЦЭГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.СҮХБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
А.АДЪЯАСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.ДОРЖХАНД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
М.ОЮУНЧИМЭГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ТОГТОХСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ё.БААТАРБИЛЭГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ЖАРГАЛМАА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Л.ОЮУН-ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ЭРДЭНЭБАТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.БАТСУУРЬ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ПҮРЭВДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.БЯМБАЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.МӨНХ-ОРГИЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.САРАНГЭРЭЛ

19
ГИШҮҮНТЭЙ

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах 24 хууль, Улсын Их Хурлын 21 тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ханган эцэслэн батлуулж, Байнгын хорооны найман тогтоолыг баталж, холбогдох байгууллагуудад хуралдааны тэмдэглэлээр нэг үүрэг даалгавар өгч, нэг хэлэлцүүлэг, нэр дэвшигчийн гурван сонголт, батлагдсан хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг хоёр удаа зохион байгуулав.

Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын даргын захирамж болон Байнгын хорооны тогтоолоор хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий гурван Ажлын хэсгийг байгуулан ажилласнаас хоёр Ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж байна.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
2023.11.06, №174	Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий	Ахлагч: Г.Амартүвшин Гишүүд: Э.Бат-Амгалан Ж.Бат-Эрдэнэ Х.Ганхуяг Ц.Мөнх-Оргил С.Одонтуяа М.Оюунчимэг Д.Сарангэрэл Д.Цогтбаатар

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсэг:

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
2022.01.17, №02	Монгол Улсын Засгийн газраас 2022 оны нэгдүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлаар иргэдийн санал авах журам”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг сонгогчдын саналаар эгүүлэн татах журам”, “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлийн ажиллах журам” батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий	Ахлагч: Г.Ганболд Гишүүд: Ё.Баатарбилэг Ж.Сүхбаатар
2024.01.16, №03	Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлантай танилцаж, шаардлагатай бол хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий	Ахлагч: М.Оюунчимэг Гишүүд: Б.Баттөмөр Ж.Батсуурь Г.Ганболд

Бусад ажлын талаар

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах, мэдээлэл солилцох зорилгоор хууль тогтоомжийн төслийн талаарх олон нийтийн нэг хэлэлцүүлэг, дөрвөн уулзалт, ярилцлага, нэр дэвшигчийн талаарх нийтийн гурван сонголыг зохион байгуулж ажиллалаа. Үүнд,

- 2024 оны нэгдүгээр сарын 02-ны өдөр Байнгын хорооны 2023 оны 10 дугаар тогтоолын дагуу “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонголыг;

- 2024 оны нэгдүгээр сарын 16-ны өдөр Байнгын хорооны 2024 оны 01 дүгээр тогтоолын дагуу Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонголыг;

- 2024 оны нэгдүгээр сарын 16-ны өдөр Байнгын хорооны 2024 оны 02 дугаар тогтоолын дагуу “Төрийн албаны зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонголыг;

- 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр хуулийн төсөл боловсруулсан ажлын хэсэг болон эрдэмтэн судлаач, улс төрийн намуудын төлөөллийг оролцуулан “Эмэгтэй парламентчдын чуулган-2023” хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан.



Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээр санал авах зорилгоор Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, тогтоолын таван төсөл, Байнгын хорооны 27 санал, дүгнэлт, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулга гурвыг болон 15 мэдээ, мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудас болох forum.parliament.mn болон иргэд, олон нийтээр санал авах D.Parliament.mn-д тус тус байршуулсан.

НАЙМ. ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

Ээлжит чуулганы хугацаанд Төсвийн байнгын хороо 18 удаа хуралдаж, нийт 52 асуудлын хүрээнд 31 хуулийн төсөл, Улсын Их Хурлын 17 тогтоол, Байнгын хорооны 11 тогтоолын төсөл, зөвшилцөх асуудлаар нэг, албан тушаалтныг томилох, чөлөөлөх асуудлаар гурав, яам, харьяа байгууллагын таван тайланг хэлэлцэн шийдвэрлэлээ.



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД

БАЙНГЫН ХОРОО

18 УДАА
ХУРАЛДСАН

ДЭД ХОРОО

1 УДАА
ХУРАЛДСАН

АЖЛЫН ХЭСЭГ

8 УДАА
ХУРАЛДСАН

ДЭД ХЭСЭГ

6 УДАА
ХУРАЛДСАН

НИЙТ

52 АСУУДАЛ
ХЭЛЭЛЦСЭН

29 ХУУЛИЙН ТӨСӨЛ
ХЭЛЭЛЦҮҮЛЭН БАТЛУУЛСАН

16 УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСӨЛ

11 БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛЫН ТӨСӨЛ

2 ЗӨВШИЛЦӨХ
АСУУДАЛ

2 АЛБАН ТУШААЛТНЫГ
ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ

5 ХАРЬАА
БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН

6 ХЭЛЭЛЦЭХ ЭСЭГИЙН
САНАЛ, ДҮГНЭЛТ

19 АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН
САНАЛ, ДҮГНЭЛТ

8 ТАНИЛЦУУЛГА

Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Байнгын хороо хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн батлах үе шатанд дараах санал, дүгнэлт, танилцуулгыг боловсруулж, төслийг эцэслэн батлах бэлтгэл ханган ажиллалаа. Үүнд:

- хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийн зургаан санал, дүгнэлт;
- анхны хэлэлцүүлгийн 19 санал, дүгнэлт;
- эцсийн хэлэлцүүлгийн найман танилцуулга;

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах 29 хууль, Улсын Их Хурлын 16 тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ханган эцэслэн батлуулж, Байнгын хорооны 11 тогтоол баталсан.

Улсын Их Хурлын даргын захирамжаар болон Байнгын хорооны тогтоолоор хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий таван Ажлын хэсгийг байгуулан ажилласнаас гурван ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж байна.



БҮРЭЛДЭХҮҮН:



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ГАМАРТУВШИН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.БАТСУУРЬ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ОДОНТУЯА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ТОГТОХСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.АНАНДБАЗАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ГАНБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ӨНӨРБОЛОР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ч.ХҮРЭЛБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.БУЛГАНТУЯА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.ДАВААСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ПҮРЭВДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б. ЧОЙЖИЛСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.БАТЖАРГАЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ЖАВХЛАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ш.РАДНААСЭД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.БАДЕЛХАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Л.МӨНХБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.САНДАГ-ОЧИР

19
ГИШҮҮНТЭЙ

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг:

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
2023.02.17, № 37	Татварын орчинд дүн шинжилгээ хийх, нийгэм, эдийн засагт үүсээд байгаа эргэлзээтэй асуудлыг судалж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол татварын суурь шинэчлэлт хийх шийдвэрийн төсөл болвсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ахлагч: Г.Тэмүүлэн Гишүүд: Б.Баттөмөр Ц.Цэрэнпунцаг Ж.Батжаргал Ж.Батсуурь

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсэг:

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
2023.11.01, №10	Хууль тогтоомжийн шаардлагыг ханган 100,000 гаруй иргэдээс ирүүлсэн “Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын 2.0 хувийг 5.0 хувь болгож нэмэгдүүлэх талаарх нийтийн өргөдлийн дагуу уг асуудлаар болон татварын орчныг сайжруулах талаар холбогдох тооцоо, судалгаа, дүн шинжилгээ хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ахлагч: Г.Тэмүүлэн Гишүүд: Г.Амартүвшин Ж.Батжаргал Ж.Батсуурь Б.Жавхлан Д.Өнөрболор Ц.Сандаг-Очир
2023.12.19, №18	Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ахлагч: Ц.Сандаг-Очир Гишүүд: Х.Булгантуяа Г.Тэмүүлэн

Бусад Байнгын хороонд хүргүүлсэн санал, дүгнэлт:

- “Онцгой байдлын ерөнхий газарт гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төсөл, “Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн төслийн талаарх санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

- Нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

- Органик бүтээгдэхүүний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлтийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд тус тус хүргүүлсэн.

Хяналт, шалгалтын ажлын талаар

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тайлан, мэдээлэл сонсохтой холбогдуулан дараах ажлыг гүйцэтгэсэн:

- 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр “Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэл”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэв;
- 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр “Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэв;
- 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдөр “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэв;
- 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр “Хөдөө аж ахуйн салбарын зээл тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж”-нд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцэв;
- 2024 оны нэгдүгээр сарын 01-ний өдөр Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бчгийн хэрэгжилтийн талаарх тайланг тус тус хэлэлцсэн.

Бусад ажлын талаар

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээр хэлэлцүүлэх, санал авах, мэдээлэл солилцох зорилгоор хууль тогтоомжийн төслийн талаарх нэр дэвшигчийн сонсгол 1, уулзалт, ярилцлагыг 12 удаа зохион байгууллаа.

- “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг тогтоох тухай” Төсвийн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 19 дүгээр тогтоолын дагуу 2024 оны нэгдүгээр сарын 10-ны өдөр нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулсан.

• 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Байнгын хорооны 10 дугаар тогтоолоор байгуулагдсан Хууль, тогтоолын шаардлагыг ханган 100,000 гаруй иргэдээс ирүүлсэн Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын 2.0 хувийг 5.0 хувь болгож нэмэгдүүлэх талаар нийтийн өргөдлийн дагуу уг асуудлаар болон татварын орчныг сайжруулах талаар холбогдох тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж, санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Батсуурь, Ц.Сандаг-Очир нар татварын шинэчлэл, татварын хууль эрх зүйн орчныг сайжруулах талаар Сангийн яам, Татварын ерөнхий газрын удирдлагуудтай санал солилцсон.



• 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Татварын суурь орчинд дүн шинжилгээ хийх, нийгэм, эдийн засагт үүсээд байгаа эргэлзээтэй асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол татварын суурь шинэчлэлт хийх шийдвэрийн төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ нар Монголын ноос, ноолуурын холбооны төлөөлөл, үндэсний үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудыг хүлээн авч уулзаж, татварын орлогын зонхилох хувийг бүрдүүлдэг ноос, ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг сайжруулахад татварын нэгдсэн бодлогоор хэрхэн дэмжих талаар нээлттэй ярилцаж, баялаг бүтээгч, үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдэд ногдуулж буй татварын төрөл зүйл, хувь хэмжээ хэр оновчтой эсэх асуудлаар харилцан санал солилцсон болно.

• 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Татварын суурь орчинд дүн шинжилгээ хийх, нийгэм, эдийн засагт үүсээд байгаа эргэлзээтэй асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол татварын суурь шинэчлэлт хийх шийдвэрийн төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Батсуурь

нар татварын хуулийн эрх зүйн орчныг сайжруулах, татварын шинэчлэлийн хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо болон даатгал, үнэт цаасны салбарт үйл ажиллагаа явуулж буй 40 гаруй аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзан, татварын орчны талаар санал солилцов.

• 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга, ажлын хэсгийн ахлагч Г.Тэмүүлэн дотоодын үйлдвэрлэгчдээ татварын зөв бодлого, хөшүүргээр дэмжих нь ажлын байрыг нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх үйл ажиллагааны хүрээнд “Баялаг тахиа” ХХК-ний үйл ажиллагаатай танилцсан.



• 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Татварын суурь орчинд дүн шинжилгээ хийх, нийгэм, эдийн засагт үүсээд байгаа эргэлзээтэй асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол татварын суурь шинэчлэлт хийх шийдвэрийн төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр нар “Монголын хүнд үйлдвэрийн салбарын эрдэс холбоо” ГҮТББ болон төмрийн хүдэр, нүүрс, жонш боловсруулах үйлдвэрийн төлөөллийг хүлээн авч уулзан, дотоодын аж ахуйн нэгжүүдэд тулгарч байгаа татварын ачаалал, дарамт, тэдний үйл ажиллагааны талаар санал солилцсон.



• 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Татварын суурь орчинд дүн шинжилгээ хийх, нийгэм, эдийн засагт үүсээд байгаа эргэлзээтэй асуудлыг судалж, санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол татварын суурь шинэчлэлт хийх шийдвэрийн төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Б.Баттөмөр, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Батсуурь нар хувьцаат компаниудын төлөөллийг хүлээн авч уулзан, татварын орчны эрх зүйн шинэчлэлийн бодлого, чиглэлийг танилцуулж, хөрөнгийн зах зээл дээр үнэт цаас гаргагчдыг дэмжих боломж, санаачлагын талаар ярилцсан.

• 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Нэгдсэн Үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөрийн орлогч, суурин төлөөлөгч Лин Цао, төслийн менежер Б.Нинжин нарыг хүлээн авч уулзан, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Нэгдсэн Үндэстний байгууллага хоорондын хамтын ажиллагаа, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлын явц, цаашдын зорилтын талаар санал солилцсон.

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээс саналавах зорилгоор Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, тогтоолын 52 төсөл, Байнгын хорооны 32 санал, дүгнэлт, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн 10 танилцуулга, есөн мэдээ мэдээлэл, долоон байгууллагын тайланг иргэд, олон нийтээс санал авах D.Parliament.mn цахим системд байршуулсан.

ЕС. ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

Ээлжит чуулганы хугацаанд Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд долоон удаа хуралдаж, нийт 17 асуудлыг хэлэлцсэнээс хуулийн нэг төсөл, Байнгын хорооны таван тогтоолын төсөл, яам, агентлагийн дөрвөн мэдээлэл, хяналт шалгалтын зургаан тайлан, албан тушаалтныг томилох нэг асуудал хэлэлцэн шийдвэрлэлээ.



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРОО

2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД

БАЙНГЫН ХОРОО

8 УДАА
ХУРАЛДСАН

НИЙТ

17 АСУУДАЛ
ХЭЛЭЛЦСЭН

1 ХУУЛИЙН ТӨСӨЛ
ХЭЛЭЛЦҮҮЛЭН БАТЛУУЛСАН

5 БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛЫН ТӨСӨЛ

4 ЯАМ, АГЕНТЛАГИЙН
МЭДЭЭЛЭЛ

6 ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТАЙЛАН

1 АЛБАН ТУШААЛТНЫГ
ТОМИЛОХ АСУУДАЛ

Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх хүрээнд хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн нэг санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг санал, дүгнэлтийг бэлтгэж ажилласан.

Байнгын хорооны таван тогтоолын төслийг хэлэлцэн баталж, 15 удаагийн уулзалтыг зохион байгууллаа.

Улсын Их Хурлын даргын захирамжаар 2021 онд байгуулагдсан нэг ажлын хэсэг үргэлжлүүлэн ажиллаж байна.



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Г.ГАНБОЛД

БҮРЭЛДЭХҮҮН:



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
А. АДЪЯАСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.БАТЖАРГАЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.НАРАНБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.ТУВААН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.АНАНДБАЗАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.БАТЛУТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.ЦОГТГЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ЭРДЭНЭБАТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.АУБАКИР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ГАНБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ш.РАДНААСЭД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.ЭНХТҮВШИН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.БАТ-ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ДАМДИННЯМ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ТЭМҮҮЛЭН

16
ГИШҮҮНТЭЙ

Хяналт, шалгалтын ажлын талаар

• Байнгын хорооны 2023 оны 05 дугаар тогтоолоор ноос, ноолуурын боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор Улаанбаатар хот, орон нутагт хялгас ялгахаас дээш боловсруулалт хийх үйлдвэрүүдийн хүчин чадал, суурилагдсан тоног төхөөрөмжийн талаар хяналт, шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд тус ажлын хэсгийн тайланг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцээд “Засгийн газарт чиглэл” өгөх тухай Байнгын хорооны 2023 оны 07 дугаар тогтоолыг баталсан. Уг тогтоолоор дэлхийн зах зээл дээр ноос, ноолуурын салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, ноос, ноолуурын боловсруулах салбарын технологи хөгжүүлэлт, хүний нөөцийг бэлтгэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх талаар Засгийн газарт чиглэл өгсөн.

• Байнгын хорооны хуралдаанаар “Тавантолгой–Гашуунсухайт, Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнгийн талаарх Үндэсний аудитын газрын тайлан”-г хэлэлцээд “Засгийн газарт чиглэл” өгөх тухай Байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолыг баталсан.

Уг тогтоолоор төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогыг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулж, Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган хил холболтын ажлыг эрчимжүүлэх, төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцсон аж ахуйн нэгжүүдийн өр, төлбөрийг барагдуулах талаар Засгийн газарт чиглэл өгсөн.





- Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг олон нийтэд нээлттэй худалдах ажлыг эрчимжүүлэх, мөн Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонссон.

- Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэхтэй холбоотой Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонссон.

- Дархан арьс ширний цогцолбор, Эмээлт эко аж үйлдвэрийн парк болон Шинэ Ховд үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлын эрчимжүүлэх талаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны 08 дугаар, 2023 оны 01 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонссон.

- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төрийн санхүүгийн бүтцийг оновчтой болгох, зах зээлийг тэлэх, борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл сонссон.

- Дотоодын сүү, сүүний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, борлуулалтын тогтолцоог төлөвшүүлэх, сүүний урамшуулал олгох хугацааг сунгах талаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны 07 дугаар тогтоолын хэрэгжилт болон Жижиг, дунд үйлдвэрийн газрын үйл ажиллагааны талаарх тайланг хэлэлцлээ.

Бусад ажлын талаар

Байнгын хорооны хоёр санал, дүгнэлт, дөрвөн тайлан, мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудсанд байршуулсан.

АРАВ. ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРОО

Ээлжит чуулганы хугацаанд Хууль зүйн байнгын хороо 15 удаа хуралдаж, нийт 42 асуудлын хүрээнд 31 хуулийн төсөл, Улсын Их Хурлын 11, Байнгын хорооны найман тогтоолын төслийг хэлэлцэж, Хууль зүйн байнгын хорооны тогтоолоор хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий таван Ажлын хэсэг, Улсын Их Хурлын даргын захирамжаар нэг Ажлын хэсэг байгуулав. Ажлын хэсгүүд 23 удаа хуралдаж, 11 танилцуулгыг бэлтгэн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлсэн.

Байнгын хорооны хуралдаанаар албан тушаалтныг томилох, чөлөөлөхтэй холбоотой таван асуудлыг хэлэлцэж, холбогдох шийдвэр, санал, дүгнэлтийг гаргасан болно.



Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх хүрээнд дараах санал, дүгнэлт, танилцуулгыг бэлтгэж ажиллалаа. Үүнд:

- хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийн 11 санал, дүгнэлт;
- анхны хэлэлцүүлгийн таван санал, дүгнэлт;
- эцсийн хэлэлцүүлгийн таван танилцуулга;
- бусад асуудлаар таван санал, дүгнэлт;
- холбогдох Байнгын, дэд хороонд таван санал, дүгнэлт.



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Д.ЦОГТБААТАР

БҮРЭЛДЭХҮҮН:



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ш. АДШАА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д. ГАНБАТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б. ПҮРЭВДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н. УЧРАЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н. АЛТАНХУЯГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б. ДЭЛГЭРСАЙХАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ш. РАДНААСЭД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ЭНХ-АМГАЛАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г. АМАРТҮВШИН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц. МӨНХЦЭЦЭГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц. САНДАГ-ОЧИР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Э. БАТ-АМГАЛАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц. МӨНХ-ОРГИЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж. СҮХБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С. БЯМБАЦОГТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Л. МӨНХБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц. СЭРГЭЛЭН

19
ГИШҮҮНТЭЙ



<https://www.facebook.com/StandingCommitteeOnLegalAffairs>

Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгийн шатанд зарчмын зөрүүтэй 53 саналын томьёолол, эцсийн хэлэлцүүлгийн шатанд зарчмын зөрүүтэй зургаан саналын томьёоллыг тус тус бэлтгэн төслийг эцэслэн батлах бэлтгэл ханган ажиллалаа.

Байнгын хорооны эрхлэх асуудлынхаа хүрээнд хамаарах есөн хууль, Улсын Их Хурлын 11 тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ханган эцэслэн батлуулж, Байнгын хорооны найман тогтоол, Дэд хорооны хоёр тогтоолыг баталж, хяналтын сонсгол нэг удаа, батлагдсан хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлах ажлыг хоёр удаа зохион байгууллаа.

Улсын Их Хурлын даргын захирамжаар болон Байнгын хорооны тогтоолоор хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий зургаан ажлын хэсгийг байгуулснаас гурав нь үргэлжлүүлэн ажиллаж байна.

Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг:

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
2023.12.11, №205	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ахлагч: Ц.Мөнхцэцэг Гишүүд: Ш.Адъяаа Г.Амартүвшин Б.Жаргалмаа М.Оюунчимэг Ц.Сандаг-Очир Д.Сарангэрэл Ж.Чинбүрэн

Байнгын хорооны тогтоолоор байгуулсан ажлын хэсэг:

Шийдвэр	Ажлын хэсгийн нэр	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
2023.10.25, №12	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ахлагч: Ц.Сандаг-Очир Гишүүд: Ш.Адъяаа Г.Амартүвшин Ц.Мөнхцэцэг Б.Пүрэвдорж Ж.Сүхбаатар Б.Энх-Амгалан

2023.10.31, №13	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ахлагч: Б.Энх-Амгалан Гишүүд: Ц.Мөнх-Оргил Ц.Мөнхцэцэг Б.Пүрэвдорж Ц.Сандаг-Очир
2023.10.31, №14	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ахлагч: Ц.Мөнх-Оргил Гишүүд: Н.Алтанхуяг Ц.Мөнхцэцэг Б.Пүрэвдорж Ш.Раднаасэд
2023.10.31, №15	Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ахлагч: Л.Мөнхбаатар Гишүүд: Г.Амартүвшин Э.Бат-Амгалан Д.Ганбат Б.Энх-Амгалан
2024.01.09, №02	Шүүх байгуулах тухай хуулийн /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий	Ахлагч: Ш.Раднаасэд Гишүүд: Г.Амартүвшин Д.Ганбат Ц.Мөнх-Оргил Ц.Мөнхцэцэг Ц.Сандаг-Очир

Бусад Байнгын хороонд хүргүүлсэн санал, дүгнэлт:

- Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

- Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтийг Инновац, цахим бодлогын байнгын хороонд;

• Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд тус тус хүргүүлсэн.

Хяналт, шалгалтын ажлын талаар

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгээс “Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын асуудлаар ерөнхий хяналтын сонсгол явуулах санал гаргах тухай” 2023 оны УИХ-03/7749 дугаар албан бичиг, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы ахалсан Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны есдүгээр тогтоолоор байгуулагдсан Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны явцад хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн хэрэгжилтийн асуудлаар сонсгол явуулах хүсэлт гаргаж байсныг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа, Ж.Батжаргал, Б.Баттөмөр, Б.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, С.Бямбацогт, Д.Ганбат, Ц.Даваасүрэн, Б.Дэлгэрсайхан, Ц.Идэрбат, Н.Наранбаатар, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Д.Тогтохсүрэн, Ц.Цэрэнпунцаг, Т.Энхтүвшин нарын гишүүдээс Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт хандан УИХ-03/7750 дугаар албан бичгээр тус тус хяналтын сонсгол зохион байгуулах тухай хүсэлт хүргүүлсэн.

Энэхүү хүсэлтийг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд “Хяналтын сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” 11 дүгээр тогтоолоор хяналтын сонсголыг зохион байгуулах, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэгийг сонгож томилсон.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос зохион байгуулж байгаа Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан.

Хяналтын сонсголд Улсын Их Хурлын гишүүдээс гадна холбогдох төрийн байгууллагын төлөөлөл, төрийн бус байгууллага, иргэд, хуулийн этгээдийн төлөөлөл бүхий нийт 106 оролцогч бүртгүүлсэн бөгөөд ажиглагчаар 12, төрийн байгууллагын төлөөлөл 54, Төрийн бус байгууллага болон иргэдийн төлөөлөл 40 иргэн оролцсон.

Байнгын хороо “Хүүхдийн эрхийг хамгаалах, хангахтай холбоотой асуудлаар явуулсан Улсын Их Хурлын хяналтын сонсгол”-ын тайланг хэлэлцсэн.

Бусад ажлын талаар



Холбогдох байгууллагын үйл ажиллагаатай танилцах ажлын хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, дүүргийн шүүхүүдийн үйл ажиллагаатай танилцлаа.

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээс санал авах зорилгоор Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 22 хууль, тогтоолын төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Байнгын хорооны есөн санал, дүгнэлт, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх зургаан танилцуулгыг Улсын Их Хурлын цахим хуудас болох forum.parliament.mn болон иргэд, олон нийтээс санал авах D.Parliament.mn-д тус тус байршуулсан.

АРВАН НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРОО

Ээлжит чуулганы хугацаанд тус Байнгын хороо 15 удаа, ажлын хэсэг 17 удаа, давхардсан тоогоор нийт 35 асуудлыг хэлэлцэж, 20 хуулийн төсөл, Улсын Их Хурлын найман тогтоолын төсөл, Байнгын хорооны 10 тогтоол, зээлийн хоёр хэлэлцээрийг зөвшилцөх, албан тушаалтныг томилох, чөлөөлөх тухай хоёр асуудлын төслийг хэлэлцэн шийдвэрлэлээ.



Хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлгийн талаар

Байнгын хороо хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийг хэлэлцэн батлах үе шатанд дараах санал, дүгнэлт, танилцуулгыг бэлтгэн төслийг эцэслэн батлах бэлтгэл ханган ажиллалаа. Үүнд:

- хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийн долоон санал, дүгнэлт;
- анхны хэлэлцүүлгийн 26 санал, дүгнэлт;
- эцсийн хэлэлцүүлгийн хоёр танилцуулга;
- ажлын хэсгийн гурван танилцуулга.

Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд гурван хууль, Улсын Их Хурлын дөрвөн тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ханган эцэслэн батлуулж, Байнгын хорооны 10 тогтоолыг баталсан.



БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ц.ЦЭРЭНПУНЦАГ

БҮРЭЛДЭХҮҮН:



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.БАТЛУТ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Н.ГАНИБАЛ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
М.ОЮУНЧИМЭГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.ЧИНЗОРИГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БАТТӨМӨР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Х.ГАНХУЯГ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Д.ӨНӨРБОЛОР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ЭНХБАЯР



Д.БАТ-ЭРДЭНЭ
/БҮРЭН ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛСЭН/



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ц.ДАВААСҮРЭН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ч.УНДРАМ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.ЭНХТҮВШИН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.БАТ-ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Т.ДОРЖХАНД



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ч.ХҮРЭЛБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Ж.ГАНБААТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.ЖАВХЛАН



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.ЦОГТГЭРЭЛ

19
ГИШҮҮНТЭЙ

Хяналт, шалгалтын ажлын талаар



"Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэх бэлтгэл хангах ажлын хэсгийн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 17,18-ны өдрүүдэд Монголбанканд ажиллаж, АмЧам Монголиа АНУ-ын худалдааны танхимын төлөөлөгчид, Монголын бизнесийн зөвлөл, МҮХАҮТ-ын төлөөлөгчдийг оролцуулан уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулав.

Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэлээс "Ковид-19" цар тахлын үеийн төсвийн зарцуулалтын асуудлаар ерөнхий хяналтын сонсгол явуулах санал ирүүлсний дагуу Эдийн засгийн байнгын хороо 2023 оны зургадугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа ерөнхий хяналтын сонсгол явуулах тухай тогтоолыг баталж, сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлийг томилсон бөгөөд сонсголыг 2023 оны 10 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан.

Бусад ажлын талаар

Байнгын хороо найман хурал, зөвлөгөөн, 38 уулзалт, ярилцлага, гадаадын зочид төлөөлөгчтэй уулзах 15 уулзалтыг зохион байгуулж ажиллалаа.

Хууль тогтоомжийн төслийг олон нийтэд сурталчлан таниулах, олон нийтээс санал авах зорилгоор Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах долоон хууль, тогтоолын төсөл, Байнгын хорооны 32 санал, дүгнэлт, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хоёр танилцуулгыг иргэд, олон нийтээс санал авахаар D.Parliament.mn цахим системд байршуулсан.

III БҮЛЭГ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Намрын ээлжит чуулганы хугацаанд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлуудыг хянан шалгах үүрэг бүхий Хянан шалгах хоёр түр хороо байгуулагдан ажиллав.

Хянан шалгах түр хороод

Нэр	Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий	Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий
Байгуулагдсан шийдвэр	Улсын Их Хурлын 2023 оны 60 дугаар тогтоол	Улсын Их Хурлын 2023 оны 63 дугаар тогтоол
Байгуулагдсан огноо	2023.06.30	2023.07.06
Дарга, бүрэлдэхүүн	Ж.Чинбүрэн Улсын Их Хурлын долоон гишүүн	Б.Энхбаяр Улсын Их Хурлын 11 гишүүн
Намрын ээлжит чуулганы хугацаанд явуулсан үйл ажиллагаа	Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд долоон удаа хуралдсан. Үйл ажиллагаа үргэлжилж байна.	10 удаа хуралдаж, Улсын Их Хуралд тайлангаа танилцуулснаар татан буугдсан.

Улсын Их Хурлын 2023 оны 60 дугаар тогтоолоор байгуулагдаж, долдугаар сараас үйл ажиллагаагаа эхлүүлсэн Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Түр хорооны үйл ажиллагааг Улсын Их Хурлын 2023 оны 115 дугаар тогтоолоор зургаан сараар сунгасан.

Хянан шалгах түр хороо таван хянан шалгагч, долоон шинжээчийг томилон ажиллуулж, зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг батлах шийдвэрийн

хэрэгжилт, эмийн чанар, аюулгүй байдал, чанарын баталгаажуулалтын нөхцөл байдал зэрэгтэй газар дээр очиж танилцаж, нотлох баримт, мэдээлэл цуглуулан ажиллаж байна. Мөн эмийн чанарыг хянах тогтолцоо, эмийн чанарыг үнэлэх биологийн сорил, эмнэл зүйн судалгааны байдал, зах зээлд худалдаалагдаж байгаа зайлшгүй шаардлагатай эмийн үнийн өсөлтийн бодит шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, ялангуяа, тендер шалгаруулалт, татвар гэх мэт асуудлыг авч үзэж, дүн шинжилгээ хийж байна.



Тус түр хороо Эм, эмнэлгийн хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүний үнэ бүрдэлт, чанарын өнөөгийн байдалд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Засгийн газрын Ажлын хэсгийн мэдээллийг сонсож, холбогдох байгууллагуудаас нотлох баримт гаргуулахаас гадна Хавдрын хяналтын олон улсын холбооны /UICC/ хорт хавдрын эмийн хүртээмжийг нэмэгдүүлэх АТОМ хөтөлбөртэй хамтран ажиллаж байна. Түр хорооноос Монгол Улсын хүн амын дунд өндөр хэрэглээтэй, зайлшгүй шаардлагатай эмийн 10 дугаар жагсаалт болон Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгох эмийн жагсаалтад орсон, хатуу зохицуулалттай орноос бусад улсад үйлдвэрлэсэн 52 нэр төрлийн эмийн дээжийг зах зээлээс түүвэрлэн худалдан авч чанарыг шалгуулахаар эмийн хяналтын лабораторийн шинжилгээнд өгчээ.

Түр хороо эмийн үнэ, чанар болон бусад асуудлаарх мэдээллийг иргэдээс утсаар болон www.emiinsonsgol.mn, <https://d.parliament.mn/> цахим хуудас, emiin-turhoroog@parliament.mn цахим шуудангаар 2024 оны гуравдугаар сарын 01-ний өдөр хүртэл хүлээн авч байна.

Улсын Их Хурлын 2023 оны 63 дугаар тогтоолоор байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий түр хороо Нотлох баримтыг шинжлэн судлах хяналтын сонсголыг 2023 оны 12 дугаар сарын 04-22-нд хоёр үе шаттайгаар зохион байгуулсан. Сонсголд 16 хянан шалгагч, шинжээч болон ажиглагчаар Нээлттэй нийгэм форум, Цогц хөгжлийн үндэсний төв ТББ-ын төлөөлөл, сонсгол даргалагчийн урилгаар УЕПГ, Нийслэлийн прокурорын газар, Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газар зэрэг төрийн байгууллагын төлөөлөл ажилласан. Нийт 574 гэрчийг сонсголд оролцуулахаар мэдэгдэх хуудас хүргүүлснээс 412 буюу 71.8 хувь нь хүрэлцэн ирж оролцсон байна. Нээлттэй сонсголыг Монголын үндэсний олон нийтийн телевизийн нэг, хоёрдугаар суваг, ТВ8, ТВ9, Тэнгэр телевизээр шууд дамжуулсан бөгөөд нийт 60 сэдвийн хүрээнд нотлох баримтыг шинжлэн судалсан шинжээчдийн дүгнэлт, хянан шалгагчдын тайланг сонсон, шаардлагатай бичмэл нотлох баримтуудыг танилцуулсан.

Хянан шалгах түр хороо нь 2024 оны нэгдүгээр сарын 16-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд тайлан, санал, дүгнэлтээ танилцуулсан бөгөөд Улсын Их Хурлаас тус түр хорооны санал, дүгнэлтэд үндэслэн “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа, бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтад хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолыг батлан гаргав.



Хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгүүд

Ээлжит чуулганы хугацаанд тодорхой асуудлаар шалган судлах, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий нийт 21 ажлын хэсэгт давхардсан тоогоор Улсын Их Хурлын 123 гишүүн ажилласан. Ажлын хэсгүүдийн гурав нь Улсын Их Хурлын даргын захирамжаар, 17 нь Байнгын хорооны тогтоолоор, нэг нь Дэд хорооны тогтоолоор тус тус байгуулагдсан бөгөөд эдгээрээс дөрвөн ажлын хэсэг үйл ажиллагаагаа дуусгавар болгон тайлан, санал, дүгнэлтээ танилцуулжээ. Үйл ажиллагаагаа дуусгавар болгосон Ажлын хэсгүүдийн тайлантай холбогдуулан боловсруулсан шийдвэрийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж Байнгын хорооны хоёр тогтоолоор үүрэг, чиглэл өгсөн байна.



Ажлын хэсэг **21**



Улсын Их Хурлын даргын захирамжаар **3**



Байнгын хорооны тогтоолоор **17**



Дэд хорооны тогтоолоор **1**



Ажлын хэсгүүдэд ажилласан гишүүд **123**



Үйл ажиллагаагаа дуусгавар болгосон **4**

Үргэлжлэн ажиллаж байгаа Ажлын хэсгүүд

Шийдвэр	Ажлын явц
<p>Улсын Их Хурлын даргын захирамж 2021.03.11 №18</p> <p>Концессын тухай хууль тогтоомж, гэрээний хэрэгжилтийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрт хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгах, санал, дүгнэлт гарган, шийдвэрийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>2014 онд байгуулсан Концессын гэрээ, 2019 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлт болон “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХК-аас 2021.05.05-нд ирүүлсэн тайлбар, 2014-2020 оны төмрийн хүдрийн экспортын мэдээлэл, татварын өглөгийн дэлгэрэнгүй мэдээлэл зэрэгт зэрэгцүүлсэн судалгаа хийж, санал, дүгнэлт боловсруулж байна.</p>

<p>Хууль зүйн байнгын хорооны тогтоол 2020.12.24 №09</p> <p>Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хариуцан хэрэгжилтийг тайлагнадаг олон улсын гэрээ, конвенцийн хэрэгжилтийн талаар Ажлын хэсгийн ахлагч Ц.Мөнх-Оргил Нийгмийн бодлогын байнгын хороо болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаанд танилцуулсан.</p> <p>Ажлын хэсэг болон ажлын дэд хэсгийн хуралдаануудаар Засгийн газарт Байнгын хорооны тогтоолоор чиглэл өгөх тухай асуудлыг хэлэлцээд дахин боловсруулахаар тогтсон.</p> <p>Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.</p>
<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны тогтоол 2021.01.13, №01</p> <p>Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 39 дүгээр тогтоолын 1.5 дахь дэд заалт “төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэж заасны хэрэгжилтийг хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Засгийн газраас тус төслийг 2024 оны эхний хагас жилд багтаан дуусгахад шаардагдах үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэхтэй холбоотой 2023.07.05-ны өдрийн 266 дугаар тогтоол баталсан.</p> <p>2023.09.08-ны өдрийн байдлаарх ажлын гүйцэтгэлийн явцын товч мэдээлэл болон аймаг бүрээр нэгтгэн гаргасан нэгдсэн танилцуулга, бүсчилсэн төлөвлөгөөг ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн.</p> <p>2024.01.16-ны өдрийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хуралдаанд ажлын хэсгийн үйл ажиллагааны явцын талаарх мэдээллийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан танилцуулав.</p>
<p>Төсвийн байнгын хорооны тогтоол 2021.01.20 №01</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яамнаас холбогдох мэдээллийг авч, тооцоо, судалгаа хийж байна.</p> <p>Ажлын хэсгийн үйл ажиллагаа түр зогссон.</p>
<p>Хууль зүйн байнгын хорооны тогтоол 2021.03.15 №07</p> <p>Монгол Улсын Их Хурлаас 2021 оны нэгдүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Шүүхийн Ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны ажлын явцын талаарх мэдээлэл, мөн Монгол Улсын шүүхийн төсвийн төслийн талаар Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга болон Улсын Дээд Шүүхийн Тамгын газрын даргын танилцуулга, мэдээллийг тус тус сонссон.</p> <p>Байнгын хорооны хуралдаанд ажлын хэсэг танилцуулга хийж, “Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах тухай” Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 13 дугаар тогтоолоор Засгийн газарт үүрэг өгсөн.</p> <p>Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.</p>

<p>Эдийн засгийн байнгын хорооны тогтоол 2021.10.27 №13</p> <p>Дархан-Улаанбаатар хот хоорондын авто зам барих, ажлын явцыг эрчимжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тодорхой асуудлаар үүрэг, чиглэл өгөх үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Дархан-Улаанбаатар хот хоорондын автозамын ажлын явцын талаар холбогдох байгууллагуудын мэдээллийг сонсож, ЗТХЯ-нд автозамын өнөөгийн нөхцөл байдал болон хурлаар хэлэлцсэн асуудалтай холбогдуулан чиглэл өгч, цементийн зөрүүтэй мэдээллийг шалгахыг Эрүүгийн цагдаагийн газарт үүрэг болгосон. Үүний дагуу холбогдох байгууллагууд ажиллаж байгаа талаар Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас 2023.06.06-нд мэдээлсэн. Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.</p>
<p>Эдийн засгийн байнгын хорооны тогтоол 2021.11.30 №17</p> <p>Монгол Улсын Их Хурлаас 2021 оны нэгдүгээр сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиудын хэрэгжилтийг хянан шалгаж, арилжааны банкуудад байршиж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн мөнгөн хөрөнгийг эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Монголбанк болон холбогдох байгууллагаас мэдээллүүдийг цуглуулж, тэдгээрийг боловсруулан, дүн шинжилгээ хийж байна. Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.</p>
<p>Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны тогтоол 2021.12.24 №03</p> <p>Газрын тосны салбарын хөрөнгө оруулалт, экспорт, эрэл хайгуул, ашиглалт, олборлолт, байгалийн нөхөн сэргээлтийн асуудлаар газар дээр нь ажиллаж мэдээлэл авах, тулгамдаж буй асуудлыг судлан шийдвэрлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх зорилгоор Дорнод аймгийн Тамсагбулагийн сав газарт ажиллах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Байнгын хорооны хуралдаанд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Тамсагийн сав газрын Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд үйл ажиллагаа явуулж байгаа “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг танилцуулав. Холбогдох газруудын мэдээллийг боловсруулж Ажлын хэсэг Байнгын хорооны хуралдаанд тайлангаа 2022.05.24-нд танилцуулсан бөгөөд Байнгын хорооноос “Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээнээс Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх тухай” 2022 оны 03 дугаар тогтоолоор Засгийн газарт чиглэл өгсөн. Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.</p>

<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны тогтоол 2022.01.17 №03</p> <p>Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг “Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна” гэж заасны хэрэгжилтийг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг /2002 оны тавдугаар сарын 03-ны өдөр баталсан/</p>	<p>Цэцэрлэг, ясли, дунд болон дээд боловсролын байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуус, багш, ажилтнуудын тусгай хэрэгцээг хэрхэн хангаж байгаа талаар танилцаж, Ажлын хэсгийн тайлангийн төслийг боловсруулаад байна.</p> <p>Ажлын хэсгийн тайланд нэмэлтээр оруулах статистик мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч, дүн шинжилгээ хийж байна.</p> <p>Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.</p>
<p>Байгаль орчин, Хүнс, Хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоол 2022.04.13 №05</p> <p>Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт болон ус ашиглалтын талаар хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх БОАЖЯ болон Ажлын дэд хэсгийн мэдээллийг сонсож, Ажлын хэсгийн тайлангийн төслийг боловсруулж байна.</p> <p>Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.</p>
<p>Нийгмийн бодлогын байнгын хорооны тогтоол 2022.05.10, №12</p> <p>Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд эх, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>2023.10.09-ний өдөр ажлын хэсэг Нийгмийн бодлогын байнгын хороо, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүн амын сантай хамтран 2023 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Жирэмсэн болон төрсөн эхчүүдэд тодорхой хэмжээний дэмжлэг үзүүлэхтэй холбоотой асуудлаар цахим хэлэлцүүлэг зохион байгуулсан.</p> <p>Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.</p>
<p>Нийгмийн бодлогын байнгын хорооны тогтоол 2022.06.15 №17</p> <p>Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн харилцааны бүх шатанд олон талт түншлэлийг оновчтой, үр дүнтэй нэвтрүүлж, гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж оролцдог оновчтой тогтолцоог бүрдүүлсэн эсэхийг хянан шалгах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Холбогдох долоон яамны мэдээлэлтэй танилцаж, ажлын дэд хэсгийн үйл ажиллагааны хүрээнд “Нийгэм, эдийн засаг, бизнес, улс төрийн асуудлуудыг олон талуудын оролцоотой /түншлэлээр/ шийдвэрлэх арга зам, туршлага” сэдвээр сургалт, хэлэлцүүлгийг 2023.03.20-нд зохион байгуулсан.</p> <p>Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.</p>

<p>Нийгмийн бодлогын байнгын хорооны тогтоол 2022.11.15, №19</p> <p>Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох, санг болзошгүй эрсдэлээс хамгаалах, эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>2023.10.30-ны өдөр ажлын хэсгийн гишүүд Эрүүл мэндийн яаманд ажиллаж, эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилт түүний хэрэгжилт, одоогийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар мэдээлэл сонсож, санал солилцсон.</p> <p>Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 15 дугаар тогтоолоор ажлын хэсгийн удирдамжийг баталсан.</p> <p>2023.11.17-ны өдөр ажлын хэсгийн гишүүд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагаатай танилцаж ажилласан.</p>
<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны тогтоол 2022.12.19 №09</p> <p>Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт, 38 дугаар зүйлд заасны дагуу уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт болон уул уурхай, аялал жуулчлалын зэрэг нөлөөнд өртөн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдалд ноцтой хохирол учирч болзошгүй соёлын биет өвийг бүсчилсэн байдлаар тодорхойлох, хамгаалах талаар санал, дүгнэлтийн төсөл боловсруулах, хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.</p>
<p>Эдийн засгийн байнгын хорооны тогтоол 2023.04.18 №7</p> <p>Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, эдгээр сангуудад байршиж байгаа мөнгөн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, эрсдэлээс хамгаалах талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Ажлын хэсэг 2023 онд зургаан удаа хуралдаж, Засгийн газрын тусгай сангуудын мэдээллийг сонсон Байнгын хорооны 2023.11.15-ны хуралдаанд санал, дүгнэлтээ танилцуулсан бөгөөд тус хуралдаанаар Ажлын хэсгийн ажиллах хугацааг сунгасан. Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.</p>
<p>Байгаль орчин, Хүнс, Хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоол 2023.06.28 №10</p> <p>Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хяналт шалгалт хийж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Хуулийн хэрэгжилт, үр дагаврын үнэлгээг Сангийн ямаар хийлгэж байна. Аймгуудаас холбогдох мэдээллийг цуглуулж, нэгтгэн дүгнэх ажил хийгдэж байна. Ажлын хэсгийн үйл ажиллагаа үргэлжилж байна.</p>
<p>Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны тогтоол 2020.10.26 №01</p> <p>Уурын болон усан халаалтын зуухтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, "Таван Толгой түлш" ХХК-ийн тайлан, мэдээлэлтэй танилцсан. Ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.</p>

Үйл ажиллагаа нь дуусгавар болсон Ажлын хэсүүд

Шийдвэр	Үйл ажиллагаа
<p>Улсын Их Хурлын даргын захирамж 2021.03.02, №16</p> <p>Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>2023.11.20-ны өдөр Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаарх мэдээллийг нэгтгэн ажлын хэсгийн гишүүдэд танилцуулснаар ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.</p>
<p>Улсын Их Хурлын даргын захирамж 2023.06.16, №107</p> <p>“Нүүрсний хулгай”-н асуудлыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу үр дүнтэй хянан шалгах, ард иргэд, иргэний нийгмийн байгууллагын хүсэлт, шаардлагын хүрээнд олон нийтийг ил тод, бодитой мэдээллээр хангах, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор нүүрсний худалдан авалт, тээвэрлэлт, гаалийн бүрдүүлэлт, экспорт, холбогдох зөвшөөрөл, хяналтын асуудлаар Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулах бэлтгэл хангах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Ажлын хэсгээс “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан, танилцуулга, үзэл баримтлалын хамт 2023.06.23-ны өдөр Улсын Их Хурлын даргад Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар өргөн барьсан.</p> <p>Улсын Их Хурлаас 2023.07.06-ны өдрийн 63 дугаар тогтоолоор хянан шалгах түр хороог байгуулсан.</p> <p>Түр хорооноос Улсын Их Хурлын хяналтын сонсголыг хоёр үе шаттайгаар 2023.12.04-08, 18-22-ны өдрүүдэд зохион байгуулснаар ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.</p>
<p>Эдийн засгийн байнгын хорооны тогтоол 2023.06.27, №14</p> <p>Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын онцгой байдлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн төлөвлөгөө, төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн зарцуулалт, гадаадын орнуудаас авсан зээл, тусламж, иргэн, аж ахуйн нэгжүүдийн хандив, тусламж болон тэдгээрийн орлого, зарлагыг нийтэд ил болгох тухай асуудлаар Ерөнхий хяналтын сонсголыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>Ерөнхий хяналтын сонсголд төрийн байгууллагаас 62, иргэн, хуулийн этгээд 52, ажиглагч иргэн 10, хэвлэл мэдээллийн 17 байгууллага, нийт 141 оролцогч бүртгүүлснээс 2023.10.23-ны өдөр зохион байгуулагдсан тус сонсголд 46 төрийн байгууллагын төлөөлөл, 15 иргэн хуулийн этгээд, хэвлэл мэдээллийн гурван байгууллага, гурван ажиглагч буюу нийт 67 оролцогч хүрэлцэн ирсэн. Сонсголын үйл ажиллагаа зохион байгуулагдсан тул ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсонд тооцсон.</p>
<p>Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны тогтоол 2023.10.17, №05</p> <p>Монгол Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилт болон ноос, ноолуурын боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор Улаанбаатар хот, орон нутагт хялгас ялгахаас дээш боловсруулалт хийх үйлдвэрүүдийн хүчин чадал, суурилагдсан тоног төхөөрөмжийн талаар хяналт, шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>	<p>2023.11.29-ний өдрийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанд ажлын хэсэг тайлан, санал, дүгнэлтээ танилцуулсан. Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан Байнгын хорооноос Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023 оны 07 дугаар тогтоол баталсан. Ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.</p>

Улсын Их Хурлын гишүүний асуулга

Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын даргад хандан 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын зургаан гишүүн 64 асуудлаар долоон удаа асуулга тавьсан байна.

Асуулга тавьсан гишүүн	Хандсан байгууллага, албан тушаалтан	Асуулгын агуулга	Асуулга тавьсан огноо	Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн огноо
О.Цогтгэрэл	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Улаанбаатар хотын утаа болон сайжруулсан шахмал түлшний талаар	2023.08.15	2023.11.24
Б.Баттөмөр	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар	2023.08.29	2023.10.27
Ш.Адьяшаа	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Хуулийн хэрэгжилтийн талаар мэдээлэл ирүүлэх тухай	2023.09.06	-
Ж.Батсуурь	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Эрчим хүчний шинэ эх үүсвэрийн талаар	2023.10.27	-
Н.Алтанхуяг	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар	2023.11.16	-
Н.Алтанхуяг	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Төсвийн тогтвортой байдлын тухай болон Ирээдүйн өв сангийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар	2023.11.20	-
Х.Ганхуяг	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар	Дизель түлш болон АИ92 шатахууны хүрэлцээ муу байгаа талаар	2023.12.08	-

Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар өмнөх чуулганы хугацаанд Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан зарим асуулгыг хэлэлцэв.

Асуулга тавьсан гишүүн	Хандсан байгууллага, албан тушаалтан	Асуулгын агуулга	Асуулга тавьсан огноо	Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн огноо
Г.Тэмүүлэн Ж.Бат-Эрдэнэ Л.Мөнхбаатар	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар төлөвлөж буй бодлого, арга хэмжээний талаар	2021.03.24	2023.12.08
М.Оюунчимэг	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбоотой бүтээн байгуулалтын ажлын талаар	2022.05.20	2023.12.22
Б.Баярсайхан	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун	Малчдын өмнө тулгамдаж буй асуудлын талаар	2023.05.26	2023.10.13



Улсын Их Хурлын гишүүний асуулт

Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын даргад хандан 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын хоёр гишүүн 20 асуудлаар дөрвөн удаа асуулт тавьсан байна.

Асуулт тавьсан гишүүн	Хандсан байгууллага, албан тушаалтан	Асуултын агуулга	Асуулт тавьсан огноо	Хариу ирүүлсэн огноо
О.Цогтгэрэл	Монголбанкны ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн	Мэдээлэл авах тухай	2023.09.04	2023.10.04
О.Цогтгэрэл	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа	Коронавируст халдвар "КОВИД-19" цар тахлын үед Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар	2023.09.05	2023.09.21
Н.Ганибал	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Төрийн худалдан авах үйл ажиллагааны талаар	2023.10.04	2023.10.23
Н.Ганибал	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ	Метро барих төслийн санхүүжилтийн талаар	2024.01.10	-

Ерөнхий сайдын мэдээлэл

Ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Засгийн газраас нийт зургаан удаа мэдээлэл хийв. Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан давхардсан тоогоор Улсын Их Хурлын 43 гишүүн 187 асуулт асууж, үг хэлжээ.

- Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт "“Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар”;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалах, оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар”;
- Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр “Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шинэтгэлийн бодлогын талаар”;
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ “Монгол орны ойн сангийн төлөв байдал, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний явц, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар”;

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа “Хүүхдийн хөгжил, хамгааллын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар” (Цаг үеийн мэдээлэл);

- Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан “Өвөлжилтийн нөхцөл байдал, бэлтгэх хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар” (Цаг үеийн мэдээлэл).



Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд 2022.07.05-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах, хуулийн хэрэгжилтийн талаарх өргөдөл, гомдол хүлээн авах “D.Parliament” цахим системээр дамжуулан иргэд Ерөнхий сайдын хийх мэдээлэлтэй холбогдуулан Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс асуулт асуух, хариулт авах боломжийг бүрдүүлсэн. Үүний хүрээнд Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Ерөнхий сайдын хийсэн дөрвөн удаагийн мэдээллийг D.Parliament цахим системд байршуулан нийт 23 иргэнээс ирүүлсэн 41 асуултыг Улсын Их Хурал дахь намын бүлгүүдэд ангилан багцалж хүргүүлсэн бөгөөд чуулганы нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдээс эдгээр асуултыг асууж, хариулт авсан байна.

Байнгын хороодын хуралдаанд сонссон Засгийн газрын тайлан, мэдээлэл, илтгэл

Намрын ээлжит чуулганы хугацаанд Байнгын болон дэд хороодын хуралдаанаар Засгийн газрын гишүүд болон холбогдох бусад байгууллагын нийт 14 удаагийн мэдээлэл, тайлан, илтгэлийг хэлэлцсэн бөгөөд давхардсан тоогоор Улсын Их Хурлын 112 гишүүн 335 асуулт асууж, үг хэлжээ.

Байнгын хорооны нэр, огноо	Мэдээлэл хийсэн байгууллага, албан тушаалтан	Мэдээллийн сэдэв
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2023.10.16	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг	“Ноос, ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилт
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2023.10.16	Таван Толгой түлш ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Даваацэрэн	“Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэлийн хүчин чадал, техникийн шинэчлэл, тоног төхөөрөмжийн элэгдэл, түүхий эдийн хангамжийн асуудлаарх мэдээлэл
Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо 2023.10.16	Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн	Агаарын чанарын асуудлаарх Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны мэдээлэл
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2023.10.18	Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан	Боловсролын салбарын үйл ажиллагаа, үнэлгээ, хөрөнгө оруулалтын талаар
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023.11.15	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар	Усны нөөцийг хамгаалах, хомсдолоос сэргийлэх, ундны усны эх үүсвэр, усны чанар, аюулгүй байдлын талаар
Хууль зүйн байнгын хороо 2023.11.21	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан	Хүний эрхийн Үндэсний Комиссын мэдээлэл
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2023.11.22	Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг	Тавантолгой–Гашуунсухайт, Тавантолгой–Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүнгийн талаарх Үндэсний аудитын газрын тайлан
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2023.12.13	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга М.Мэндбаяр	Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 03 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2023.12.13	Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга	Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2023 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар
Төсвийн байнгын хороо 2023.12.20	Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Ц.Наранчимэг	“Хөдөө аж ахуйн салбарын зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр өгөөж” сэдэвт аудитын тайлан
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2024.01.09	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг	Шинэ сэргэлтийн бодлого, аж үйлдвэрийн сэргэлт / Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны 05, 08 дугаар, 2023 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилт/
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2024.01.09	Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулах талаар
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2024.01.09	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайд М.Ганхүлэг	Дотоодын сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх /Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2022 оны 07 дугаар тогтоолын хэрэгжилт/
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2024.01.16	Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан	Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явц, үр дүнгийн талаар





IV БҮЛЭГ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

Нэг. ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГ

Улсын Их хурлын хууль тогтоох үйл ажиллагаанд Тамгын газраас мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын бүхий л дэмжлэгийг үзүүлж ажиллав. Үүний хүрээнд хууль санаачлагчаас өргөн мэдүүлэх хууль, тогтоолын төслийн бүрдүүлбэрийг хянаж, тов тогтоох, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх, шаардлагатай зохицуулалтууд бүрэн туссан эсэх талаар дүн шинжилгээ, эрх зүйн дүгнэлт хийх, Үндсэн хуулийн цэцэд гаргах тайлбарын төслийг бэлтгэх, батлагдсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг хянах, лавлагаа судалгаа, хуулийн төсөлтэй холбоотой санал, зөвлөгөөг өгөх зэргээр дэмжлэг туслалцаа үзүүлсэн байна. Мөн Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн нэгдсэн сан бүрдүүлэх, ангилах ажлыг гүйцэтгэлээ.

ХУУЛЬ ТОГТООХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛЖ БУЙ ДЭМЖЛЭГ



Эрх зүйн
дүгнэлт **1**



Үндсэн хуулийн цэцэд
гаргах тайлбар **5**



Зөвлөмж **15**



Цахим болон цаасан хяналт
гүйцэтгэсэн **286**



Буцаасан
төсөл **3**



Эцсийн найруулга
хянасан **286**



Эрх зүйн мэдээллийн
санд бүртгэсэн **437**



Хууль тогтоомжийн сангаас
үйлчилгээ үзүүлсэн **55**



Бүрдүүлбэр хянасан
төсөл **26**

Төсвийн байнгын хорооны шийдвэрээр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, төслийн зохицуулалтын хэрэгжих боломжийн талаар эрх зүйн дүгнэлт гаргаж Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн.

Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн мэдээлэл, албан тушаалтнаас гаргасан хүсэлттэй холбогдуулан итгэмжлэгдсэн төлөөлөгчид мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, урьдчилсан тайлбар нэг, их суудлын хуралдаанд нэг, нэмэлт гурван тайлбар боловсруулж, албан бичгээр хариу өгсөн.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн нийт 15 хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх, хууль хоорондын зөрчил байгаа эсэх, шаардлагатай бүх хууль, зүйл, хэсэг, заалт тусгасан эсэх талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч хуулийн эх барих зөвлөхтэй хамтран ажилласан.

Ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоолгохоор ирүүлсэн 26 хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн бүрдүүлбэрийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянаж, Тамгын газрын удирдлагад танилцуулсан бөгөөд хууль, Улсын Их Хурлын тогтоолын гурван төслийг хуульд заасан шаардлагыг хангуулахаар хууль санаачлагчид нь албан бичгээр буцаасан.

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулга хянах журмын дагуу 224 хууль, Улсын Их Хурлын 62 тогтоолын эцсийн найруулгыг хянан, тухайн хууль, тогтоолын агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр нэр томьёо, үг хэллэгийг жигдлэх, найруулгын болон дэс дараалал, бүтцийн зэрэг хууль зүйн техникийн шинжтэй засварыг хийж чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан болно.

Ээлжит чуулганы хугацаанд есөн хууль, Олон улсын гэрээ соёрхон батлах тухай дөрвөн хууль, нэмэлт, өөрчлөлт оруулсан 211 хууль, Улсын Их Хурлын 62 тогтоолыг цахим болон цаасан хяналтын хувьд өөрчлөлт, хөдөлгөөн бүрэн хийж гүйцэтгэсэн.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 53 зарлиг, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, тогтоол тус бүр нэг, “Төрийн мэдээлэл” эмхэтгэл 35, Засгийн газрын 347 тогтоолыг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж авсан болно.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн санд байгаа хууль тогтоомж, бусад эрх зүйн актаар Улсын Их Хурлын гишүүд, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн хүсэлт, түүнчлэн Тамгын газрын удирдлага, байнгын хорооны ажлын алба, Тамгын газрын ахлах, зөвлөх, референт, нарийн бичгийн дарга нарт 55 лавлагаа, мэдээллээр үйлчилжээ.

Хоёр. УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮЗҮҮЛЖ БҮЙ ДЭМЖЛЭГ

Монгол Улсын Их Хурал хяналт, шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд Тамгын газраас дэмжлэг үзүүлж, Засгийн газар болон бусад байгууллагад өгсөн үүрэг, чиглэлийг хянах, хууль тогтоомж болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, үр дүнг холбогдох Байнгын хороодод танилцууллаа. Мөн Улсын төсвийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байна.

2.1. Хууль тогтоомжоор Засгийн газар болон бусад байгууллагад өгсөн үүрэг, чиглэлийн хяналт

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн санд Засгийн газарт үүрэг, чиглэл болгосон нийт 137 хуулийн 610 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 109 тогтоолын 525 заалт, Байнгын болон дэд, түр хорооны 95 тогтоолын 728 заалтыг тус тус бүртгэн, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй, хяналтад байгаа хууль тогтоомж

Он	Монгол Улсын хууль		Улсын Их Хурлын тогтоол		Байнгын хорооны тогтоол	
	Хяналтад байгаа хууль	Хэсэг, заалт	Хяналтад байгаа тогтоол	Заалт	Хяналтад байгаа тогтоол	Заалт
2020	103	391	84	314	76	408
2021	126	516	94	296	96	535
2022	159	651	106	486	109	677
2023	137	610	109	525	95	728

Монгол Улсын хууль

Хуулиар нийт 139 хуулийн 616 зүйл, хэсэг, заалтыг мэдээллийн санд бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Үүнээс 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг нийт 17 хуулийн 160 хэсэг, заалтыг нэмж хяналтад авлаа.

Улсын Их Хурлын тогтоол

Улсын Их Хурлын нийт 109 тогтоолын 525 заалтыг мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Үүнээс Улсын Их Хурлын гурван тогтоолын 26 заалтыг 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд хяналтад нэмж авсан.

Ээлжит чуулганы хугацаанд хяналтад авсан Улсын Их Хурлын тогтоол

№	Улсын Их Хурлын тогтоолын огноо, дугаар	Тогтоолын агуулга
1.	2023.11.10, №93	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай
2.	2023.11.23, №99	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай
3.	2023.11.23, №100	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Байнгын хорооны тогтоол

Улсын Их Хурлын Байнгын, дэд, түр хорооны тогтоолоор Засгийн газар, холбогдох байгууллагад үүрэг, чиглэл болгосон нийт 95 тогтоолын 728 заалтыг мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Үүнээс 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Байнгын хороодын зургаан тогтоолын 48 заалтыг нэмж хяналтад авсан.

Ээлжит чуулганы хугацаанд хяналтад авсан Байнгын хорооны тогтоол

№	Байнгын хорооны тогтоолын огноо, дугаар	Тогтоолын агуулга
1.	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны тогтоол 2023.11.15, №07	Байнгын хорооны 2023.11.15-ны өдрийн хуралдаанаар “Усны нөөцийг хамгаалах, хомсдолоос сэргийлэх, ундны усны эх үүсвэр, усны чанар, аюулгүй байдал” сэдвийн хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсоод Монгол Улсын ундны усны чанар, аюулгүй байдлыг хангах, усны нөөцийг зүй зохистой ашиглах, нөөцийг нэмэгдүүлэх, усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эхийг хамгаалах, хаягдал бохир усыг эргүүлэн ашиглах, цэвэрлэх дэвшилтэт технологи нэвтрүүлэхтэй холбогдуулан “Чиглэл өгөх тухай”
2.	Байгаль орчин, Хүнс, Хөдөө аж ахуйн байнгын хорооны тогтоол 2023.12.19, №17	Мал аж ахуйн өвөлжилтийн өнөөгийн байдал, зохион байгуулж байгаа ажлыг эрчимжүүлэх хүрээнд “Өвөлжилтийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор Засгийн газарт чиглэл;
3.	Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны тогтоол 2023.11.01, №10	Байнгын хорооноос санаачилж Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэн, Монгол Улсын Их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн Философи, шашин судлалын тэнхимтэй хамтран зохион байгуулсан “Өнөөгийн монголын нийгмийн ёс суртахууны өөрчлөлт, хандлага” сэдэвт хэлэлцүүлгээс төрийн байгууллага, олон нийтэд хандан гаргасан зөвлөмж, уриалгыг үндэслэн “Засгийн газарт чиглэл өгөх тухай”;

4.	Эдийн засгийн байнгын хорооны тогтоол 2023.12.13, №21	Байнгын хорооны 2023.12.13-ны өдрийн хуралдаанаар банкны хувьцаа эзэмшигчийн төвлөрлийг бууруулах хууль тогтоомжийн хэрэгжилт болон инфляцын нөхцөл байдал, инфляцад нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх Монголбанкны мэдээлэлтэй танилцаад Монголбанканд даалгасан “Банкны хувьцаа эзэмшигчийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах болон инфляцын өсөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авах арга хэмжээний тухай”;
5.	Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны тогтоол 2023.11.29, №07	Байнгын хорооны 2023 оны 05 дугаар тогтоолоор байгуулсан Улсын Их Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилт болон ноос, ноолуурын боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор Улаанбаатар хот, орон нутагт хялгас ялгахгаас дээш боловсруулалт хийх үйлдвэрүүдийн хүчин чадал, суурилагдсан тоног төхөөрөмжийн талаар хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн тайланг хэлэлцээд “Засгийн газарт чиглэл өгөх тухай”;
6.	Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны тогтоол 2023.11.29, №08	Үндэсний аудитын газрын “Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтад зарцуулсан хөрөнгө, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг хэлэлцээд “Засгийн газарт чиглэл өгөх тухай”.

2.2. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ

Намрын ээлжит чуулганы хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын цаглаварт тусгасан дөрөв, төлөвлөгөөт бус хоёр хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, тайланг холбогдох Байнгын хороодод хүргүүллээ.

Төлөвлөгөөт:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ
2. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ
3. Монгол Улсын нэгдсэн төсвийн сүүлийн 10 жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хууль болон түүнд өөрчлөлт оруулах тухай хуулиудын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ
4. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ (“Олон нийтийг дэмжих үндэсний төв” ТББ-аар гүйцэтгүүлсэн).

Төлөвлөгөөт бус:

1. Ахуйн зориулалтаар саарал чоно агнахтай холбоотой харилцааг зохицуулж буй хуулиудын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ /Ховд аймгийн хүрээнд/;
2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ

худалдан авах тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ /Ховд аймгийн хүрээнд/

2.3. Төсвийн хяналт-шинжилгээ

2.3.1. Төсвийн хяналт

Төсвийн төлөвлөлтийн хяналт: Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн цаглаврын эхэнд боловсруулж, тухайн жилийн нэгдсэн төсвийн төсөлд тусгагдах үзүүлэлтүүдийн хүрээ, хязгаарыг тодорхойлдог. Монгол Улсын Засгийн газраас 2023 оны есдүгээр сарын 29-нд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл” нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.1-6.1.4-д заасан тусгай шаардлагыг хангасан эсэх, “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд заасан төсөл, арга хэмжээг тусгасан эсэх зэрэгт Тамгын газраас шинжилгээ хийж, холбогдох дүгнэлтүүдийг гаргав. Хийгдсэн гол дүгнэлтүүдийг дурдвал дараах байдалтай байна.

- 2023 оны тавдугаар сарын 31-ний өдөр Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль”-ийг өргөн мэдүүлсэн хуулийн төсөлтэй харьцуулахад бүх үзүүлэлтүүд өссөн.

- Төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах болсон нь дараах үндэслэлтэй гэж төсөлд дурдсан байна. Үүнд:

- Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний олборлолт, экспортын биет хэмжээг¹ нэмэгдүүлснээр тээвэр логистик, худалдаа үйлчилгээний салбарт өсөлт гарч, эдийн засгийн бодит өсөлт батлагдсан дүнгээс 0.5 нэгж хувиар нэмэгдэж, 7.0 хувьд хүрэх боломжтой гэж тооцоолсон;

- Эдийн засгийн бодит өсөлт нэмэгдэж, төсөвт төвлөрүүлэх орлого өсөх боломжтой гэж үзсэнээр “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих, иргэдийн бодит орлогыг хамгаалах, хөдөө, орон нутгийн хөгжлийг дэмжсэн бүтээн байгуулалтуудыг хийх замаар төсвийн орлогыг зарцуулна гэж төлөвлөсөн.

Засгийн газар 2024 оны эдийн засгийн өсөлтийг Олон улсын санхүүгийн байгууллагуудын дунджаас 1.4 нэгж хувиар өндрөөр төсөөлснийг доорх хүснэгтээс харж болно.

¹Нүүрсний экспортын биет хэмжээ 50.0 сая.тн байсныг 60.0 сая.тн, зэсийн баяжмалын экспортын хэмжээг 1.5 сая тн-д тус тус хүргэхээр төлөвлөсөн.

Монгол Улсын 2024 оны эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

№	Төсөөлөл хийсэн институт	Төсөөлөл хийсэн хугацаа	2024 оны эдийн засгийн өсөлтийн төсөөлөл /хувь/
1	Олон улсын валютын сан	2023.10*	4.5
2	Дэлхийн банк	2023.04**	6.3
3	Азийн хөгжлийн банк	2023.09***	5.9
4	Монголбанк	2023.09	6.0
5	Сангийн яам	2023.09	7.0

*2023 оны 06-07 дугаар сард Олон улсын валютын сангаас
Монгол Улсад ирж ажилласан ажлын хэсгийн тайлан

**Монголын эдийн засгийн тойм, 2023.04

***Азийн хөгжлийн төлөв, 2023.09

• Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 25,289.2 тэрбум төгрөг (дотоодын нийт бүтээгдэхүүний 34.2 хувь), нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээ 27,360.5 тэрбум төгрөг (дотоодын нийт бүтээгдэхүүний 37.0 хувь) байхаар тооцож, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2,070.8 тэрбум төгрөг (дотоодын нийт бүтээгдэхүүний 2.8 хувь)-тэй тэнцэх хэмжээний төсвийн алдагдалтай байхаар дунд хугацааны Төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгасан.

Хүснэгт 2. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн харьцуулалт

№	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2024 оны Төсвийн хүрээний мэдэгдэл		Зөрүү	Төсвийн төсөөлөл	
		Батлагдсан Төсвийн хүрээний мэдэгдэл 2023.05.31	Төсөл 2023.09.29		2025 он	2026 он
		1	2	3=2-1	4	5
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	6.5	7.0	0.5	6.5	5.4
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин / хувь/	8.0	8.5	0.5	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ / тэрбум төгрөг/	21,163.2	25,289.8	4,126.6	27,757.3	29,155.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.3	34.2	1.9	33.4	32.4

4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	22,996.1	27,360.5	4,364.4	29,417.3	30,955.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	35.1	37.0	1.9	35.4	34.4
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	2,520.8	4,989.2	2,468.4	2,056.7	1,538.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.9	6.7	2.8	2.5	1.7
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,832.9	-2,070.8	- 237.8	-1,660.0	-1,800.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-2.8	-2.8	0.0	-2.0	-2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	5,850.4	6,170.4	320.0	6,620.8	6,971.7
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	8.9	8.3	- 0.6	8.0	7.7
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	39,276.0	44,400.0	5,124.0	49,800.0	54,000.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	60.0	60.0	0.0	60.0	60.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	2,153.8	2,389.6	235.8	2,437.7	2,461.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	3.3	3.2	- 0.1	2.9	2.7

Эх сурвалж: Батлагдсан Төсвийн хүрээний мэдэгдэл², Төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл³

Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ болон эдийн засгийн бодит өсөлт төлөвлөснөөс нэмэгдэхээр байгаа нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон зардлыг өсөхөд нөлөөлсөн байна.

• Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзүүлэлтүүдийг батлагдсан нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлтүүдтэй харьцуулан шинжлэхэд дараах үр дүн гарсан. Үүнд:

- Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт 6.5 байсныг 7.0 хувь болгож, 0.5 нэгж хувиар нэмэгдүүлэхээр тусгасан. Уул уурхай, ялангуяа нүүрсний экспортын бие хэмжээг 10.0 сая.тн, зэсийн баяжмалыг 120.0 мян.тн, төмрийн хүдрийг 1.3 сая.тн-оор тус тус нэмэгдүүлснээр тээвэр, худалдаа, үйлчилгээний салбарт эерэг өөрчлөлт гарна гэж тооцоолсон нь эдийн засгийг өсгөх үндэс болж байна. Батлагдсан Төсвийн хүрээний мэдэгдэлд тухайн оны дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээг 60,193.0 тэрбум төгрөг байхаар тооцоолж байсан бол өргөн мэдүүлсэн төсөлд 74,000.0 тэрбум төгрөгт хүргэж, 13,807.0 тэрбум төгрөг буюу 22.9 хувиар нэмэгдүүлэхээр тооцоолсон.

- Батлагдсан Төсвийн хүрээний мэдэгдэлтэй харьцуулахад төсвийн төсөлд дотоодын нийт бүтээгдэхүүний нэрлэсэн болон бодит өсөлт нэмэгдсэнээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 4,126.6 тэрбум төгрөг, зарлагын дээд хэмжээг 4,364.4 тэрбум төгрөгөөр тус тус өсгөж, тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг 237.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр тооцоолсон.

- Тухайн оны дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээний өсөлттэй уялдуулан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон дээд хязгаарт багтааж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл болон Засгийн газрын өрийн үлдэгдэл (өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн)-ийн хэмжээг нэмэгдүүлсэн.

- Төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд Засгийн газрын өрийн үлдэгдэл (өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн)-ийн хэмжээ 44.4 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувьтай тэнцүү байхаар тусгасан. Батлагдсан Төсвийн хүрээний мэдэгдэлтэй харьцуулахад Засгийн газрын өрийн үлдэгдэл (өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн)-ийн хэмжээ 5.1 их наяд төгрөгөөр нэмэгдэхээр байна. Төсвийн төсөлд Засгийн газрын өрийн үлдэгдэл (өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн)-ийн хэмжээ 30.0 их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 40.5 хувь байна.

- Төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын зардлын хэмжээ 5,850.4 тэрбум төгрөг байсныг 320.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 6,170.4 тэрбум төгрөг, мөн Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 235.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, 2,389.6 тэрбум төгрөг байхаар тус тус өөрчлөхөөр тусгасан.

²2023 оны тавдугаар сарын 31-ний өдөр баталсан “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай” хууль

³2023 оны есдүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”

Төсвийн төслийн хэлэлцүүлэгт бэлтгэх үе шатны хяналт

Улсын Их Хурлын Тамгын газраас 2023 оны наймдугаар сарын 15-наас 2023 оны есдүгээр сарын 29-ний өдрийг хүртэл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5-д заасан хугацаанд ирүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2024 оны төсвийн саналтай танилцаж, “Төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу 38 төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн төслийн саналыг батлагдсан төсвийн хязгаартай харьцуулан зардлын зүйлээр дүн шинжилгээ хийсэн. Түүнчлэн 2022, 2023 оны батлагдсан төсөвтэй харьцуулалт хийж, Төсвийн ерөнхийлөн захирагч нарын зардлын өөрчлөлтийг тодорхойлсон.

Төсвийн тухай хуулийн 14.2 дахь хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 14.2.1 дэх заалтад “жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах”, 31.1 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан байна:”, 31.1.3 дахь заалтад “жилийн төсвийн хязгаарт багтаасан байх;”, 27 дугаар зүйлд “Төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага”, 27.1.4 дэх заалтад жилийн төсвийн хязгаарт үндэслэсэн байх;” гэж тус тус заасан.

Ирүүлсэн төсвийн саналыг 2024 оны Засгийн газрын 245 дугаар тогтоолоор баталсан төсвийн хязгаартай харьцуулж үзэхэд нийт дүнгээрээ 13.3 их наяд төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байсан.

Хүснэгт 3. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн хязгаар болон төсвийн саналын зөрүү /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын баталсан 2024 оны төсвийн хязгаар	Төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн 2024 оны төсвийн санал	Зөрүү
Нийт зарлагын дүн	15,705.0	29,003.4	-13,298.4
Урсгал зардал	12,977.7	18,845.0	-5,867.3
Хөрөнгийн зардал	3,015.9	10,149.7	-7,133.9
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-288.6	8.6	-297.2

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагч нараас ирүүлсэн 2024 оны төсвийн хязгаарын санал, Хязгаар батлах тухай Засгийн газрын 245 дугаар тогтоол

Улсын Их Хурлын даргын 2023 оны аравдугаар сарын 17-ны өдрийн 162 дугаар захирамжаар байгуулсан Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Байнгын хороо, нэгдсэн хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын

хэсэг ажилласан. Ажлын хэсгийн шийдвэрээр дараах дөрвөн чиглэлээр Ажлын дэд хэсэг байгуулан ажиллуулсан:

- төсвийн нийт орлоготой танилцаж, санал, дүгнэлт гаргах, гишүүдийг мэдээллээр хангах үүрэг бүхий ажлын дэд хэсэг;
- урсгал зардлыг бууруулах, түүний өөрчлөлт, хөдөлгөөнийг бүртгэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах ажлын дэд хэсэг;
- дагалдах, хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдтэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, гишүүдийг мэдээллээр хангах ажлын дэд хэсэг;
- хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний талаар санал, дүгнэлтийн төсөл боловсруулах ажлын дэд хэсэг.

Ажлын дэд хэсгийн үйл ажиллагааны онцлох үр дүнг хураангуйлан авч үзвэл дараах байдалтай байна:

- Төсвийн нийт орлоготой танилцаж, санал, дүгнэлт гаргах, гишүүдийг мэдээллээр хангах үүрэг бүхий ажлын дэд хэсэг ажиллаж, орлого нэмэгдүүлэх боломжийн талаар судалж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 590.8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 565.4 тэрбум төгрөгөөр сайжруулах санал боловсруулж, хүргүүлснийг Ажлын хэсэг хүлээж авч, улмаар Улсын Их Хурлаас дэмжин 2024 оны төсвийг алдагдалгүй баталсан.

Төсвийн төслийн хэлэлцүүлгийн үе шатны хяналт

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлага хангасан эсэх талаарх Тамгын газраас хийсэн дүн шинжилгээтэй танилцаж, төсвийг хэлэлцсэн.

Дүн шинжилгээнд төсвийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу “Улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлого”-д нийцсэн эсэх, Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх, Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагыг хангасан эсэх, Төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуульд нийцсэн байдал зэргийг шинжилж дүгнэлт гаргасан. Түүнчлэн төсвийн төслийн тоон үзүүлэлтүүдийг төсвийн хязгаар, өргөн мэдүүлсэн төсөв, өмнөх онуудын төсвийн холбогдох үзүүлэлтүүдтэй харьцуулан мэдээлэл бэлтгэж, танилцуулгад тусгасан. Төсвийн төслийн танилцуулгад тусгасан зарим онцлох дүгнэлтүүдийг дурдвал дараах байдалтай байна:

- “Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолын хавсралтын Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгийг хангасан эсэхийг хянах, үнэлэх шалгуур үзүүлэлт, арга зам тодорхой хуульчлагдаагүй байх тул өргөн

мэдүүлсэн төсвийн төсөл нь төсөв, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн эсэхийг тодорхойлохтой холбоотойгоор зургаан шалгуур үзүүлэлтэд шинжилгээ хийсэн.

- Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн тухайн жил бүрийн төсвийн төслийг төлөвлөн хэрэгжүүлэхгүй байсаар ирсэн нь төсвийн тогтвортой байдал, хариуцлага, сахилга бат алдагдах, улмаар төсвийн зардал нэмэгдэх, алдагдал буурахгүй байх нөхцөл болж байна.

- Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд 184 төсөл, арга хэмжээ тусгагдсанаас санхүүжүүлэх шаардлагатай 153 төсөл, арга хэмжээний санхүүжилтэд нийт 13,429.4 тэрбум төгрөгийг төлөвлөсөн. Нийт санхүүжилтийн 16.0 хувь (2,149.5 тэрбум.төг)-ийг улсын төсөв, 9.8 хувь (1,311.7 тэрбум.төг)-ийг гадаад, зээл тусламж эзэлж байна. Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх 25 арга хэмжээний 981.8 тэрбум төгрөг, гадаад зээл, тусламжаар санхүүжүүлэх найман арга хэмжээний 241.9 тэрбум төгрөгийг Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгагдсан байна. Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг улсын төсөв болон гадаад, зээл тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт санхүүжилтийн 35.4 хувийг Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгасан.

Түүнчлэн 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Төсвийн байнгын хорооны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн санал нь тус хуулийн 70.7.2, 70.7.3-т заасан шаардлагыг хангасан эсэх талаар дүн шинжилгээг Тамгын газар хийж, нэгдсэн чуулганд танилцуулсан.

2.3.2. Макро эдийн засаг, төсвийн талаар мэдээллээр тогтмол хангасан талаар

Монгол Улсын нэгдсэн төсвийн сар, улирлын гүйцэтгэлийн мэдээ

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн урьдчилсан гүйцэтгэл болон 2023 оны 09-11 дүгээр сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд шинжилгээ хийж, нэгдсэн төсвийн орлого, зарлагын тооцооллыг боловсруулж, тэнцвэржүүлсэн тэнцэл, улсын төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн гүйцэтгэлийн мэдээ бүхий танилцуулгыг гурван удаа бэлтгэн www.parliament.mn, www.m-office.parliament.mn цахим хуудсанд байршуулсан.

Танилцуулгад Монгол Улсын Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр гаргаж тусгасан нь төсөвт тавих хяналтыг сайжруулахад хэрэгцээтэй мэдээлэл болсон.

Гадаад худалдааны сарын мэдээ

Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл, гол нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнэ болон татварын орлого бүрдэлтийн 2023 оны 09-11 сарын гүйцэтгэлийн танилцуулгыг бэлтгэн боловсруулж, нийт гурван удаа Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хорооны гишүүдийг мэдээллээр хангаж ажилласан. Танилцуулгыг бэлтгэхдээ Татварын Ерөнхий газар, Гаалийн Ерөнхий газраас авсан улсын болон орон нутгийн гадаад үйл ажиллагаатай холбоотой татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээ, татварын өр, дутуу төвлөрсөн орлогын тайлбар, холбогдох тооцооллын талаарх мэдээллийг тус тус ашигласан. Тус танилцуулга www.parliament.mn, www.m-office.parliament.mn цахим хуудсанд олон нийт танилцах боломжтой байршдаг.


Макро эдийн засгийн улирлын мэдээ

Монгол Улсын макро эдийн засгийн 2023 оны гуравдугаар улирлын тойм судалгаа бүхий танилцуулгыг дараах үзүүлэлтүүдийн хүрээнд боловсруулж, мэдээллээр хангаж ажилласан. Үүнд:

- Бодит секторын үзүүлэлт, /Дотоодын нийт бүтээгдэхүүн, нэг ажилтанд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн/;
- Монгол Улсын нэгдсэн төсвийн үзүүлэлт, /Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого, зарлага/;
- Гадаад худалдаа, /Гадаад худалдааны эргэлт, экспорт, импорт/;
- Мөнгө санхүүгийн үзүүлэлт, /Мөнгөний нийлүүлэлт, гадаад валютын албан нөөц, төлбөрийн тэнцэл/;
- Хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлт /Хүн ам, ажил эрхлэлт, ажилгүйдлийн түвшин/.

Бэлтгэсэн мэдээллийг www.parliament.mn, www.m-office.parliament.mn цахим хуудсанд байршуулсан.

Эдийн засгийн өсөлт, 2016-2023 оны гуравдугаар улирал /хувь/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Мөн макро эдийн засгийн 2014-2022 оны үндсэн үзүүлэлтүүдээр инфо хэлбэрээр танилцуулга бэлтгэн Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр ханган ажилласан.

2.3.3.Төсвийн тогтвортой байдлын зөвлөл

Зөвлөлийн хуралдаан

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл 2023 оны хоёр дахь хагас жилийн байдлаар нэг удаа хуралдсан бөгөөд хурлаар Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд өгөх зөвлөмжийн талаар хэлэлцсэн.

Хурал зөвлөгөөн, сургалт, хамтын ажиллагаа

Олон улсын валютын сангийн Төсвийн газраас улсын хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээг (public investment management assessment-PIMA) хийх зорилгоор техник туслалцааны ажлын хэсэг зургадугаар сарын 19-нөөс долдугаар сарын 04-ний хооронд Улаанбаатар хотод ирж ажилласан. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн төлөөлөл ажлын хэсэгтэй зургадугаар сарын 21-ний өдөр уулзаж, улсын хөрөнгө оруулалт, өрийн менежмент, төсвийн дүрмийн хэрэгжилт болон холбогдох бусад асуудлаар ярилцаж, үнэлгээг хийхэд хамтран оролцсон.

Үндэсний статистикийн хорооноос Нэгдсэн Үндэстний байгууллагын Ази Номхон далайн эдийн засаг нийгмийн комисстой хамтран Монгол Улсын Үндэсний статистикийн системд олон улсын цогц үнэлгээ хийх ажлын үнэлгээний баг /Ази, Номхон далайн бүсийн зөвлөх, Комиссын эдийн засаг, байгаль орчны нэгжийн дарга, Нэгдсэн Үндэстний байгууллагын Европ талыг хариуцсан зөвлөх, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан дарга/-тай 2023 оны есдүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан төрийн байгууллага хэрэглэгчдийн төлөөллийг оролцуулсан уулзалт хэлэлцүүлэгт оролцож, үнэлгээний багаас асуусан асуултад хариулж, тодруулсан асуудлуудаар саналаа өгсөн.



Түүнчлэн Олон улсын валютын сангийн Кавказ, Монгол, Төв азийн орнуудын бүс нутгийн чадавхыг хөгжүүлэх төв, Сингапур дахь сургалтын институт болон Олон улсын валютын сангаас зохион байгуулагддаг цахим сургалтын мэдээллүүдийг тогтмол зөвлөлийн гишүүдэд хүргүүлж байгаа бөгөөд зөвлөлийн гишүүд холбогдох сургалтуудад тухай бүр хамрагдсан.

2.3.4. Бусад

- Монгол Улсын 2024 оны батлагдсан төсвийн танилцуулгад 2024 оны төсвийн онцлог арга хэмжээ, Нэгдсэн төсвийн зарлага, Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Орон нутгийн төсөв, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын дэлгэрэнгүй мэдээллийг тусгаж, танилцуулга бэлтгэн Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангасан. Бэлтгэсэн мэдээлэл www.parliament.mn, www.m-office.parliament.mn цахим хуудсанд тавигдсан.

- Европын Холбооны санхүүжилттэй Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад тогтвортой хөгжлийн зорилготой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь” төслийн хүрээнд үр дүнд суурилсан төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн төслийн зарлага, үр нөлөөний шинжилгээ хийх, бодлогын өртөг тооцох, бодлогын баримт бичиг, тайлан, илтгэл, мэдээлэлд шинжилгээ хийх, төсөв, санхүүтэй холбоотой судалгаа, шинжилгээний танилцуулга сонсох, мэдээлэл солилцох зэрэг чиглэлүүдээр хамтран ажилласан.

- Улсын Их Хурлын Тамгын газраас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундестагт туршлага судлах ажлын айлчлал хийхтэй холбогдуулан Герман улсын Берлин хотод зохион байгуулагдах уулзалт, арга хэмжээний үеэр төсвийн хяналтын чиглэлээр асуух асуултуудыг боловсруулсан. Түүнчлэн ХБНГУ-ын Бундестагийн төсөвт тавих хяналтын онцлог, Тамгын газрын бүтэц зохион байгуулалттай холбоотой мэдээлэл, Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн танилцуулга зэргийг бэлтгэсний зэрэгцээ туршлага судлах арга хэмжээний хөтөлбөр, ажил үүргийн хуваарийг боловсруулахад оролцсон.

- 2023 оны 10 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Ассамблейн Төсвийн алба болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага хамтран зохион байгуулсан Азийн орнуудын Парламентын төсвийн албадын анхдугаар чуулга уулзалтад оролцож, Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн зорилго, чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, хийгдэж буй дэвшилттэй ажлууд болон сорилтуудын талаар илтгэл тавьж, хэлэлцүүлсэн.

Гурав. УЛСЫН ИХ ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ СУДАЛГАА, ОЛОН НИЙТИЙН ХАРИЛЦАА

Улсын Их Хурлын Тамгын газраас хууль тогтоох болон Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, мэдээ мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, цахим хуудас, олон нийтийн сүлжээгээр шуурхай түгээж, иргэд, олон нийтээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуульд заасан хугацаанд шийдвэрлэх, хариу өгөх болон хуралдааны цахим систем, мэдээллийн технологийг хөгжүүлэх, сургалт, судалгаагаар Улсын Их Хурлын гишүүд болон холбогдох нэгж, ажилтан, албан хаагчдыг хангах замаар парламентын чадавхыг нэмэгдүүлэхэд анхаарал хандуулж ажиллалаа.

3.1. Мэдээлэл сурталчилгаа, олон нийтийн харилцаа



Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээлэл, нэгдсэн хуралдаан, Байнгын, дэд, түр хороо, хянан шалгах түр хороо болон ажлын хэсгийн хуралдааны тойм, Улсын Их Хурлын дарга, гишүүд, Байнгын хороод, Улсын Их Хурлын Тамгын газраас зохион байгуулсан хэвлэлийн бага хурал, гадаад додоод уулзалт, хэлэлцүүлэг, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Тамгын газрын үйл ажиллагааны талаарх нийт 435 текст мэдээг 3756 гэрэл зургийн хамт Улсын Их Хурлын цахим хуудас (www.parliament.mn)-д байршуулав.

Хянан шалгах түр хороо нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг хоёр үе шаттайгаар, нийт есөн өдрийн турш зохион байгуулсан бөгөөд тус сонсголын нээлттэй, ил тод байдлыг ханган нийгмийн сүлжээний шууд дамжуулалтыг тасралтгүй явуулж, мэдээ мэдээллийг олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд шуурхай дамжуулахын зэрэгцээ 702 гэрэл зургийг бэлтгэн хэвлэл мэдээллийн байгууллагуудад түгээлээ.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ,



435

Албан мэдээ



3756

Гэрэл зураг



20

7 хоногийн тойм



19

Шууд дамжуулалт



176

Видео мэдээ,
богино контент

15 дугаар

“Төрийн мэдээлэл” эмхэтгэл



ОЛОН НИЙТИЙН ХАРИЛЦАА



2

Аудио хууль



776

Төрийн ордонтой
танилцах аялал



21465

Төрийн ордонтой танилцах аялалд
хамрагдсан иргэд

“Парламентын боловсрол”
хөтөлбөрт хамрагдсан сургууль

52

“Парламентын боловсрол”
хөтөлбөрт хамрагдсан сурагч

1892

Хууль тогтоомж сурталчлах
төвийн үйл ажиллагаа

3

Ээлжит чуулганы хугацаанд Видео контентын алба нь Улсын Их Хурлын долоо хоног тутмын үйл ажиллагааг тоймлон 20 нэвтрүүлэг бэлтгэж, телевизүүдийн эфир, олон нийтийн сүлжээгээр иргэдэд хүргэв. Монгол Улсын Үндсэн хуулийн ойн өдөр, “Нүүрсний” сонсгол, Монгол Улсын 2024 оны улсын төсөв, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулж, нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтыг 5.0 хувиас доошгүй байхаар тогтоох санал, D-petition буюу Нийтийн цахим өргөдөл, гомдлын системийг танилцуулга, Улсын Их Хурлын дарга өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн аймгуудад ажиллаж байгаа талаарх нэвтрүүлгүүдийг бэлтгэсэн. Тамгын газар, Байнгын, дэд, түр хороо, хянан шалгах түр хорооноос зохион байгуулж байгаа сонсгол, хэлэлцүүлэг, тэмдэглэлт ойн өдрүүдийн талаарх 15 шторк бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, цахим хуудас, нийгмийн сүлжээнд нийтлэн олон нийтэд түгээлээ.

- ТЕКСТ МЭДЭЭ, НИЙТЛЭЛ, ЯРИЛЦЛАГА, ТОЙМ БЭЛТГЭХ,

- СЭТГҮҮЛ, ГАРЫН АВЛАГА БОЛОВСРУУЛАХ,

- 28' НЭВТРҮҮЛЭГ БЭЛТГЭХ,

- ПАРЛАМЕНТЫН БОЛОВСРОЛ ХӨТӨЛБӨРТ ХАМРУУЛАХ,

- ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ НИЙТЛЭХ,

- ӨСВӨРИЙН ПАРЛАМЕНТ ДЭД ХӨТӨЛБӨРТ ХАМРУУЛАХ,

- ГЭРЭЛ ЗУРАГ САН БҮРДҮҮЛЭХ,

- ХУУЛЬ ТОГТООМЖ СУРТАЛЧЛАХ ТӨВ АРГА ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ,

- ПОСТЕР, ИНФОГРАФИК, ШТОРК БЭЛТГЭХ,

- FACEBOOK, TWITTER, YOUTUBE ХӨТЛӨХ,

- ХАВАР, НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН ЭМХЭТГЭЛ БОЛОВСРУУЛАХ,

- ТАМГЫН ГАЗРААС ЭРХЛЭН ГАРГАСАН НОМ, ЭМХЭТГЭЛИЙГ ОРОН НУТАГТ ХҮРГҮҮЛЭХ ХАРИУЦАХ

- ТӨРИЙН ОРДОНТОЙ ТАНИЛЦАХ АЯЛАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ,

- ГЭРЭЭТ 13 ТВ, 15 САЙТ, 4 СОНИН, 2 РАДИО ХАМТРАН АЖИЛЛАХ,

- ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ,

Түүнчлэн Улсын Их Хурал, түүний Тамгын газрын албан ёсны мэдээ мэдээллийг түгээх сувгийг өргөжүүлэх зорилгоор дээрх нэвтрүүлгүүд, видео контентуудыг Тамгын газрын дотоод сүлжээний “Parliament TV”-ээр өдөр тутам түгээж байна.



Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслүүд, Улсын Их Хурлын дарга болон гишүүдийн уулзалтын талаарх 41 видео мэдээ, нийгмийн сүлжээний богино хэмжээний 120 контент бэлтгэж Улсын Их Хурлын цахим хуудас (www.parliament.mn)-т байршуулахын зэрэгцээ youtube.com, twitter.com, facebook.com сүлжээ дэх Улсын Их Хурлын албан ёсны хуудсаар дамжуулан олон нийтэд түгээв.

Монголын үндэсний олон нийтийн радио, Дэлхийн монголчуудын 88.3 радио сувгаар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, баталсан хууль тогтоомжийн талаар мэдээ мэдээлэл бэлтгэж тогтмол нэвтрүүлсэн.

Улсын Их Хурлын Байнгын, дэд, түр, хянан шалгах түр хороод, Улсын Их Хурлын Тамгын газраас зохион байгуулсан нээлттэй сонсгол, хэлэлцүүлэг, уулзалт, семинар хэвлэлийн хуралд сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг өргөнөөр оролцуулах ажлыг тухай бүрд нь зохион байгуулж ажилласан бөгөөд 19 хэвлэлийн бага хурлын шууд дамжуулалтыг хийсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.10 дахь хэсэгт “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд хэвлэн нийтлэх бөгөөд түүнийг албан ёсны эх гэж үзнэ” хэмээн заасан байдаг. Ээлжит чуулганы хугацаанд “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 15 дугаарыг хэвлэж захиалагч, уншигчдад хүргүүлэв. Эмхэтгэлийн дээрх дугааруудын тойм, танилцуулгыг бэлтгэн Улсын Их Хурлын цахим хуудас (www.parliament.mn) болон олон нийтийн сүлжээнд байршуулав. Үүний зэрэгцээ дугаар бүрийн PDF хувилбарыг тухай бүр Улсын Их Хурлын цахим хуудас (www.parliament.mn)-д нийтлэн, хууль тогтоомжийн албан ёсны эхийг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй хэлбэрээр шуурхай түгээлээ. Эмхэтгэлийн дугаарт Монгол Улсын хууль 59, Улсын Их Хурлын тогтоол 39, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг 17, Засгийн газрын тогтоол 30, Үндсэн хуулийн цэцийн хоёр тогтоол, нэг дүгнэлт, Монгол Улс нэгдэн орсон олон улсын гурван гэрээ, Монгол Улсын дээд шүүхийн нэг тайлбарыг тус тус нийтэлжээ. Мөн Засгийн газраас баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдэх хууль тогтоомжуудыг үндэсний монгол бичгээр хэвлэн, нийтэлж байна.





2022.10.02- 2024.01.17

21,465
ИРГЭН

Ээлжит чуулганы хугацаанд иргэд, зочдыг Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцуулах 776 удаагийн аяллыг зохион байгуулж 21,465 дотоод, гадаадын иргэн хамрагдав. Түүнчлэн энэ аялалд хамрагдах иргэдийн хүсэлтийг цахим хэлбэрээр бүртгэх модулийг боловсруулж, Азийн сангийн дэмжлэгтэйгээр хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болоод байна.

Мөн “Парламентын боловсрол” хөтөлбөртөрөнхий боловсролын 52 сургуулийн 1892 сурагч хамрагдав. Сурагчдыг парламентын боловсролын талаар мэдлэг олгох сургалтад хамруулж, Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцууллаа. Түүнчлэн “Парламентын боловсрол” хөтөлбөрийн edu.parliament.mn цахим хуудсыг мэдээ, мэдээллээр баяжуулж, сурталчлан ажиллав.

Улсын Их Хурлын цахим хуудсын хайлтын системийг сайжруулж, англи хэл дээрх хувилбарыг хөгжүүлж, “Тамгын газар” цэс шинээр үүсгэн, мэдээ, мэдээллийг англи хэлээр хөрвүүлэн parliament.mn цахим хуудаст байршуулж байна.

Улсын Их Хурлын Тамгын газар, Азийн сангийн хамтын ажиллагааны хүрээнд “Аудио хууль” төслийг хэрэгжүүлж, “Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай”, “Нийтийн сонсголын тухай” хуулиудыг аудио хувилбарт шилжүүлэн, parliament.mn цахим хуудаст байршуулж, нийгмийн сүлжээгээр олон нийтэд түгээв. Түүнчлэн “Улсын Их Хурал-Энэ долоо хоногт” товч тоймыг 7 хоног бүр бэлтгэн намрын ээлжит чуулганы хугацаанд нийт 17 тойм бэлтгэн parliament.mn цахим хуудаст нийтэлж, фэйсбүүк пэйж хуудас, твиттер хуудсаар дамжуулан олон нийтэд түгээлээ.

Улсын Их Хурал, түүний Тамгын газрын Стратеги төлөвлөгөөнд тусгагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэд Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурталчлах төв байгуулах зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Дархан-Уул, Говьсүмбэр аймагт Хууль тогтоомж сурталчлах төв байгуулж, ажилтнуудыг сургалтад хамруулан, төвүүдийг Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргадаг 400 гаруй ширхэг ном товхимол, гарын авлага, эмхэтгэл, эрдэм шинжилгээний сэтгүүл зэргээр хангав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газар 2023 оны есдүгээр сарын 13, 14, 18-ны өдрүүдэд Баянхонгор, Өвөрхангай, Дархан-Уул аймаг дахь Хууль тогтоомж сурталчлах төвтэй хамтран Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганаар батлагдсан хууль тогтоомжийг дээрх аймгуудын иргэд, төрийн албан хаагчдад танилцуулах арга хэмжээг зохион байгуулав.



3.2. Иргэд, сонгогчдоос ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт

Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд 917 иргэнээс 3337 хуудас бүхий нийт 917 өргөдлийг Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороодод хандаж ирүүлэв. Эдгээрийн 173 өргөдөл (18.9 хувь)-ийг Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороо бүрэн шийдвэрлэж, 85 өргөдөл (9.3 хувь)-ийг судалж, шийдвэрлэхээр ажиллаж байна. Үлдэх 659 өргөдөл (71.9 хувь)-тэй Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороо, ажлын алба танилцаж байна.

№	Өргөдлийн агуулга	Ирсэн өргөдлийн тоо	Нийт өргөдөлд эзлэх хувийн жин	
I	Иргэдээс ирүүлсэн нийт өргөдөл	917	100%	
I.1	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын асуудал	0	0.0%	
I.2	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын асуудал	1	0.1%	
I.3	Санхүү, төсвийн асуудал	2	0.2%	
I.4	Хууль зүйн асуудал	4	0.4%	
I.5	Барилга, хот байгуулалтын асуудал	18	2.0%	
I.6	Боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал	8	0.9%	
I.7	Хүнс, хөдөө аж ахуйн асуудал	1	0.1%	
I.8	Хөдөлмөрийн асуудал	3	0.3%	
I.9	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын асуудал	12	1.3%	
	Үүнд:			
	I.9.1	нийгмийн халамжийн бодлого, бусад	7	0.8%
	I.9.2	нийгмийн даатгалын бодлого	2	0.2%
	I.9.3	орон байр, гэр хүссэн	3	0.3%
I.10	Эрүүл мэндийн асуудал	8	0.9%	
I.11	Шагналын асуудал	49	5.3%	
I.12	Төрийн байгуулалтын асуудал	6	0.7%	
I.13	Эдийн засгийн асуудал	87	9.5%	
I.14	Бусад асуудал	686	74.8%	
I.15	Нүүрсний сонгогч	32	3.5%	

Ээлжит чуулганы хугацаанд ирүүлсэн 917 өргөдлөөс 168 (18.3 хувь) нь хөдөө орон нутгийн иргэдээс, 749 (81.7 хувь) нь нийслэлийн иргэдээс ирүүлсэн байна.

Мөн энэ хугацаанд Улсын Их Хуралд нийт 1758 албан бичиг ирсэн бол Улсын Их Хурлаас нийт 5058 албан бичгийг төлөвлөн холбогдох байгууллагад хүргүүлжээ. Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороо, намын бүлэг, Тамгын газарт болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудад хандан 266

иргэнээс санал, хүсэлт, гомдол, шүүмжлэл, талархал ирүүлснийг холбогдох байгууллагуудад уламжилж, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна. Улсын Их Хурлын Иргэдийг хүлээн авах байрны 51-261526 дугаарын утсаар нийт 36 иргэнээс санал, хүсэлт, гомдол ирүүлснийг Улсын Их Хурал болон Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог, ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагуудад уламжлав.

Санал, хүсэлт, гомдлын шийдвэрлэлтийн явц, үе шатны үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар ханган ажиллаж байна.

3.3. Хуралдааны цахим систем, мэдээллийн технологи

3.3.1 Хуралдааны цахим систем

Программ хангамж

Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд 35 удаагийн нэгдсэн хуралдаан, Байнгын хорооны 114 удаагийн хуралдаан, дэд хорооны зургаан удаагийн хуралдаан, түр хорооны 17 удаагийн хуралдаан буюу нийт 172 удаагийн хуралдаанд хуралдааны цахим системийн тасралтгүй, хэвийн ажиллагааг ханган ажиллаж, 2360 гаруй санал хураалт явуулж, 1100 гаруй саналын томъёоллыг мэдээллийн санд оруулан холбогдох нэгжид хэвлэж өгсөн байна. Мөн хуралдааны цахим системийн программ хангамжийн операторын үйлчилгээг 528 удаа үзүүлж, чуулганы нэгдсэн хуралдааны ирцийн мэдээллийг 35 удаа боловсруулан холбогдох нэгжид хүлээлгэн өгөв.

Хуралдааны санал хураалтын үр дүн, хуралдааны талаарх тоон мэдээллийг нэг удаа нэгтгэн боловсруулж холбогдох нэгж, албан тушаалтанд хүлээлгэн өгсөн.

Хуралдааны дуу, дүрсний систем

Ээлжит чуулганы хугацаанд 35 удаагийн нэгдсэн хуралдаан, Байнгын хорооны 114 удаагийн хуралдаан, дэд хорооны зургаан удаагийн хуралдаан, түр хорооны 17 удаагийн хуралдаан, ажлын хэсгийн 125 удаагийн хурал, бусад байгууллагаас зохион байгуулсан 44 удаагийн арга хэмжээний нийт 302 ширхэг дүрс бичлэгийг хийж, дүрсний операторын үйлчилгээг 320 гаруй, дууны операторын үйлчилгээг 620 гаруй удаа үзүүлсэн.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг Монголын Үндэсний Олон нийтийн телевиз, Парламент телевиз, Юнивишн, Скаймедиа, дотоод сүлжээний IPTV болон Улсын Их Хурлын цахим хуудас (www.parliament.mn), iptv.parliament.mn), Parliament.MN, [D.Parliament facebook](https://www.facebook.com/Parliament.MN) хуудсаар Байнгын (түр, дэд) хороодын хуралдаан, намын бүлгийн мэдээллүүдийг дотоод сүлжээний IPTV-ээр тус тус шууд дамжуулсан байна. Парламентын сэтгүүлчдийн өрөөнд холболт хийж 200 гаруй удаагийн арга хэмжээний дүрсийг шууд дамжуулсан.

Хуралдааны танхимуудад зохион байгуулагдсан хэлэлцүүлэг, ажлын хэсгийн хуралдаан болон Улсын Их Хурлын удирдлага, гишүүдийн оролцсон хурал, уулзалт зэрэг 10 арга хэмжээнд орчуулгын систем, 29 арга хэмжээнд цахим хуралдааны ZOOM программ, хуралдааны дуу, дүрсний зөөврийн системийг найман удаа тус тус ашигласан.

Улсын Их Хурал дахь намын бүлгүүдийн 30 гаруй удаагийн хуралдаан болон арга хэмжээний техникийн бэлтгэлийг хангасан байна.

"Хүний эрх, жендерийн мэдрэмжтэй парламент" хэлэлцүүлэг, "Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол", Шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээн болон бусад сонсгол, хурал, уулзалт, арга хэмжээний техникийн шийдлийг боловсруулан амжилттай хэрэгжүүллээ.

Дотоод сувгийн IPTV-ний цахим хуудас (<http://iptv.parliament.mn/>), хуралдааны тайлан, бүртгэлийн программ хангамж (<http://10.10.200.21/employer>)-ийн хөгжүүлэлтийг хийж, дараагийн хувилбараар шинэчилсэн.

3.3.2 Мэдээллийн технологи

Хэрэглэгчдэд программ хангамжийн 260, компьютерийн сүлжээний 120, дотоод сүлжээний IPTV-ийн 21, хувилах, хэвлэх төхөөрөмжийн 220 удаагийн засвар үйлчилгээ, 250 гаруй мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, нийт 12 ширхэг техник хэрэгслийн гэмтлийг оношлон засварлаж хүлээлгэн өгөв.

Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудас болон дэд цахим хуудаснуудад шинээр орсон 942 мэдээ мэдээлэлд форматын хяналт тавьж, дэд цахим хуудас хариуцсан ажилтнуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

"MyParliament" хөдөлгөөнт оффисийн системийн мэдээллийн санд системийн хандалт 279, үйл ажиллагаа 1223, хуулийн төсөл, хэлэлцэх асуудал 271, дагалдах файлууд 336, үйл явдал, хуралдаан 537 шинээр нэмж бүртгэгдсэн.

Улсын Их Хурлын бүх цахим хуудсыг cloudflare программ хангамжийн сүлжээнд холбож, аюулгүй байдлыг ханган ажилласан.

3.3.3 Цахим парламент

"D-Parliament" цахим платформ

Парламентын цахим шилжилтийн үндсэн суурь систем болох "D-Parliament" платформ хэрэглээнд нэвтэрснээс хойш 2024 оны нэгдүгээр сарын 18-ны байдлаар нийт 13,542 иргэн хэрэглэгчээр бүртгүүлэн 7555 иргэн танилт нэвтрэлтийн ДАН системийн баталгаажуулалт хийж, нийт 884,872 удаагийн хандалт хийгдсэн байна. Мөн тус платформоор дамжуулан идэвхтэй төлөвт байгаа боловсруулж буй 54, өргөн мэдүүлсэн 201 хуулийн төсөлд иргэдийн саналыг авч байна. Өнгөрсөн хугацаанд боловсруулж буй нийт 93, өргөн

мэдүүлсэн 327 хуулийн төслийг цахим системд байршуулж иргэдээс санал авсан байна. Платформд байршуулсан төслүүдийг иргэд үзэж танилцан дэмжих эсэхээ нийт 82,248 удаа /like – 69.827, dislike – 12.421/ илэрхийлж, нийт 7985 саналыг ирүүлээд байна.



Иргэд дараах хуулийн төслүүдийг хамгийн олон удаа үзэж танилцан санал өгсөн байна:


- Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 23,167 удаа үзэж 1.216 санал;
- Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн төслийг боловсруулалтын шатанд 11,981 удаа, өргөн мэдүүлэгдсэнээс хойш 8623 удаа, нийт 20,604 үзэж 228 санал;
- Боловсролын ерөнхий хуулийн төслийг 14,976 удаа үзэж 839 санал;
- Хөрөнгө оруулалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг 14,508 удаа үзэж 110 санал;
- Газрын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн төслийг 12,955 удаа үзэж 789 санал.

Уг платформын мобайл аппликейшний iOS хувилбарыг 10.025, Android хувилбарыг 15,054 хэрэглэгч гар утас, хөдөлгөөнт төхөөрөмжид суулган ашиглаж байна. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайдын хийх 18 удаагийн мэдээлэлтэй холбогдуулан иргэдийн 138 асуултыг хүлээн авч нэгтгэсэн.

Нийтийн өргөдлийн “D-Өргөдөл” цахим систем

“D-Parliament” цахим платформыг өргөтгөн сайжруулах ажлын даалгаврыг Инновац, цахим бодлогын байнгын хорооны тогтоолоор батлагдсан “Цахим систем ашиглан иргэдийн оролцоог хангах, санал авах журам”-д нийцүүлэн

боловсруулж, нийтийн өргөдлийн “D-Өргөдөл” системийн хөгжүүлэлт хийгдэн 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдөр албан ёсоор хэрэглээнд нэвтрүүлсэн.



2024 оны нэгдүгээр сарын 18-ны өдрийн байдлаар иргэд нийт 738 нийтийн өргөдөл санаачлан шаардлага хангасан 148 өргөдөл нь цахим системд нийтлэгдэн иргэдийн саналыг авсан байна. Мөн иргэд цахим системд нийтлэгдсэн саналуудыг давхардсан тоогоор 612,705 удаа дэмжиж санал өгсөн бөгөөд иргэний баталгаажуулалтад танилт нэвтрэлтийн “ДАН” систем 543,646 удаа, “E-Mongolia” аппликейшн 63,389 удаа, иргэний тооны гарын үсгийн “G-Sign” аппликейшн 5670 удаа ашиглагдсан байна.



Нийтийн өргөдлийн “D-Өргөдөл” цахим системийг ашиглан санал өгсөн иргэдийг хүйсээр авч үзвэл эрэгтэй 179,285, эмэгтэй 433,420 байгаа бөгөөд насны хувьд 18-93 насны иргэд оролцсон бол дундаж нас 32.23 байна. Харин оршин суугаа хаягийн хувьд нийслэл Улаанбаатар хотын иргэд 66.34 хувийг эзэлж байна.

Нийтийн өргөдлийг дэмжиж санал өгсөн иргэдийн тоо

№	Аймаг, нийслэл	Тоо	Хувь
1	Архангай	9030	1.47
2	Баян-Өлгий	3407	0.56
3	Баянхонгор	8875	1.45
4	Булган	6770	1.10
5	Говь-Алтай	5812	0.95
6	Говьсүмбэр	2979	0.49
7	Дархан-Уул	19,061	3.11
8	Дорноговь	10,591	1.73
9	Дорнод	11,051	1.80
10	Дундговь	6065	0.99
11	Завхан	8373	1.37
12	Орхон	19,561	3.19
13	Өвөрхангай	12,243	2.00
14	Өмнөговь	9731	1.59
15	Сүхбаатар	5554	0.91
16	Сэлэнгэ	15,508	2.53
17	Төв	10,992	1.79
18	Увс	8226	1.34
19	Ховд	8090	1.32
20	Хөвсгөл	14,272	2.33
21	Хэнтий	10,054	1.64
22	Улаанбаатар	406,810	66.34
23	Хаяг тодорхойгүй	123	0.02
Нийт		613,178	100

3.4. Судалгаа шинжилгээ, сургалт

Судалгаа, мэдээлэл, лавлагаа

Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Тамгын газрын Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгээс хуулийн төсөл болон Улсын Их Хурлаар хэлэлцэн баталж буй хууль, тогтоолын төсөлд холбогдох 24 судалгааны захиалгыг Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороод болон Тамгын газрын удирдлагын захиалгаар гүйцэтгэлээ. Үүнд:

Гүйцэтгэсэн нийт судалгааны ажил – 24	
Судалгааны ангилал (захиалагчаар) • Улсын Их Хурлын гишүүдийн захиалгаар – 15 • Байнгын хорооны захиалгаар – 1 • Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлага, • Ажлын хэсгийн захиалгаар – 6 • Хүрээлэнгийн санаачилгаар – 2	Судалгааны ангилал (төрлөөр) • Тусгай захиалгат судалгаа - 2 • Харьцуулсан судалгаа - 10 • Мэдээлэл лавлагаа – 8 • Тойм судалгаа - 4

Ном товхимол, гарын авлага

Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгээс Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэдээллийн дэмжлэг үзүүлэх хүрээнд “Парламент” судалгааны цуврал эмхэтгэлийн 44, 45 дахь дугаар, “Судалгааны мэдээллийн сангийн лавлагаа” цуврал товхимлын 31 дэх дугаар, “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга”, “Парламентын судалгаа, шинжилгээ” эрдэм шинжилгээний сэтгүүлийн 7 дахь дугаар, “Мэдээлэл судалгаа” сэдэвчилсэн тойм сэтгүүлийн 7 дахь дугаар, Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын лавлагааны 2 дахь дугаарыг тус тус эмхэтгэн гаргаж Улсын Их Хурал, түүний Тамгын газрын албан хэрэгцээнд хүргүүлээ.

Ном, гарын авлага - 13		Тоо
1.	“Парламент” судалгааны эмхэтгэл №44-45	2
2.	Судалгааны мэдээллийн сангийн лавлагаа №31	1
3.	“Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы үйл ажиллагааны танилцуулга”	1
4.	“Парламентын судалгаа, шинжилгээ” эрдэм шинжилгээний сэтгүүл №7	1
5.	“Мэдээлэл, судалгаа” аналитик тойм сэтгүүл №52-58	7
6.	Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын лавлагаа №2	1

“Мэдээлэл судалгаа” сэдэвчилсэн тойм сэтгүүл - 4		Дугаар
1.	Төрийн албаны сонгон шалгаруулалтын тогтолцоо	52
2.	Байгалийн хий хайх, олборлох үйл ажиллагаа	53
3.	Засгийн газрын тусгай сан	54
4.	Нийтийн бие засах байгууламж	55
5.	Хөрөнгө оруулалтын бодлого, чиг хандлага	56
6.	Хөдөө аж ахуйн хоршоолол	57
7.	Парламентын ордон	58

Мөн Парламентын номын сангаас Улсын Их Хурлын гишүүдийн хууль хэлэлцэн батлах үйл ажиллагаанд мэдээллийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудалд холбогдох тогтмол хэвлэлийн ном зүйн лавлагаа болон Парламентын номын санд буй ном товхимлын ном зүйн лавлагааг гаргаж, Улсын Их Хурлын гишүүдийн “MyParliament” хөдөлгөөнт оффисын системд байршуулсан.

Ном зүйн лавлагаа - 2		
1.	Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлаарх тогтмол хэвлэлийн ном зүйн лавлагаа	6
2.	Парламентын номын санд буй ном товхимлын ном зүйн лавлагаа	6

Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгээс Монгол Улсын Их Хурлын 2020-2024 оны үйл ажиллагааны тайланг эмхэтгэн 300 хувь хэвлүүлж Улсын Их Хурлын гишүүдэд тараах ажлыг зохион байгуулав.

Чуулга уулзалт, арга хэмжээ

	Арга хэмжээ	Огноо	Тайлбар
1.	“Номын баяр-2023” арга хэмжээ	2023.05.26-28 2023.09.17-19	“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2023”-ийн хүрээнд Тамгын газрын холбогдох газар, хэлтэс, төслийн багтай хамтран “Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн хэвлүүлсэн ном товхимол”, “Парламентын номын санд хадгалагдаж буй Монгол Улсын Үндсэн хуультай холбогдолтой номын үзэсгэлэн”-г дэглэж, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулсан.
2.	“Алтай дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээ: Жендэрийн эрх тэгш байдал ба Тогтвортой хөгжил” чуулга уулзалт	2023.06.12-14	Монгол Улсын Их Хурал, Стэнфордын их сургууль, Бан Ги Мун сан, Эвэ Эмэгтэйчүүдийн их сургуультай хамтран зохион байгуулав. Чуулга уулзалтад эмэгтэйчүүдийн эрх мэдэл ба манлайлал, жендэрийн тэгш байдал, жендэрт суурилсан хүчирхийлэл, хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш байдал зэрэг сэдэвт хэлэлцүүлгүүдээс гадна Алтай судлалын олон улсын чиг хандлагын талаарх салбар хуралдаан хуралдсан.
3.	“Хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй парламент” өөрийн үнэлгээ	2023.11.22-23	Монгол Улсын Их Хурал, Олон Улсын Парламентын Холбоотой хамтран зохион байгуулсан “Хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй парламент” өөрийн үнэлгээний нэгдсэн хэлэлцүүлгийн бэлтгэл ажлыг хангаж зохион байгуулав. Хүрээлэнгээс үнэлгээнд оролцогчдод зориулсан мэдээллийн гарын авлага, эмхэтгэл боловсруулав.

Сургалт

Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнгийн Сургалтын албанаас ээлжит чуулганы хугацаанд нийт 20 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын гишүүд, тэдний ажлын албаны ажилтнууд болон Улсын Их Хурлын Тамгын газрын нийт ажилтнуудад зориулж зохион байгуулсан бөгөөд, холбогдох ном, эмхэтгэл, гарын авлагаар хангах чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллав. Энэ хугацаанд Улсын Их Хурлын гишүүд, олон улсын байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачид, Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд оролцсон “Парламентын ардчиллын тулгамдсан асуудлууд” сэдэвт хэлэлцүүлэг, Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслах, бие-төлөөлөгч туслахын чиглүүлэх сургалт, Салбар дундын мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийн хүрээнд “Цахим засаглалын хөгжлийн чиг хандлага” сэдэвт сургалт”, Хувь хүний хөгжлийн сургалтын хөтөлбөрийн “Монгол хэл, бичиг, найруулга зүй” сургалтын дэд хөтөлбөрийн хүрээнд Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөлтэй хамтран Монгол бичгийн анхан болон дунд түвшний 14 удаагийн сургалтыг 2023 оны 10 дугаар сарын 09-нөөс

12 дугаар сарын 25-ны өдрийн хооронд зохион байгуулж, сургалтын хөтөлбөрийг бүрэн судалсан 81 оролцогчдоод “Батламж” олгосон.

Мөн Хуулийн төсөл боловсруулагчийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд Монголын хуульчдын холбоо, “Монгол Улсад парламентын ардчиллыг бэхжүүлэх нь” төсөлтэй хамтран “Хуулийн төсөл боловсруулагчийн сургалт”-ыг зохион байгуулж Улсын Их Хурлын Тамгын газар болон Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог, ажлаа тайлагнадаг байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагаас хамрагдсан 64 оролцогчдоод “Гэрчилгээ” олгосон.

Ээлжит чуулганы хугацаанд зохион байгуулсан 20 удаагийн сургалтад нийт 900 гаруй оролцогч (давхардсан тоогоор) хамрагдсан байна.

Зохион байгуулсан нийт сургалт, хэлэлцүүлэг		
1.	Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнууд, Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүний ажлын албаны ажилтнуудад зориулсан сургалт	19
1.1.	Мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтын хөтөлбөрийн хүрээнд: 2023.11.06. “Эрсдэлийг удирдах үйл явцыг хэрэгжүүлэх нь”	1
1.2.	Хувь хүний хөгжлийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд: 2023.10.09-2023.12.25. “Монгол бичиг” 2023.12.15. “Мэдээллийн аюулгүй байдал”	15
1.3.	Салбар дундын мэдлэг олгох сургалтын хөтөлбөрийн хүрээнд: 2023.11.17. “Цахим засаглалын хөгжлийн чиг хандлага”	1
1.4.	Хуулийн төсөл боловсруулагчийг бэлтгэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд: 2023.12.11-13. “Хуулийн төсөл боловсруулах техник I”	1
1.5.	Чиглүүлэх сургалт хүрээнд: 2023.11.28. Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслах, бие-төлөөлөгч туслахын чиглүүлэх сургалт	1
2.	Улсын Их Хурлын даргын санаачилгаар болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан хэлэлцүүлэг: 2023.10.25. “Парламентын ардчиллын тулгамдсан асуудлууд”	1
Нийт		20

Сургалтын цогц хөтөлбөр

Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх ажлыг тогтмолжуулах, бодлогын бичиг баримтад тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхээр зургаан үндсэн, 25 дэд хөтөлбөр бүхий “Парламентын сургалтын цогц хөтөлбөр” Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны гуравдугаар сарын 03-ны өдрийн 164 дүгээр захирамжаар батлагдсан. Намрын чуулганы хугацаанд Парламентын сургалтын цогц хөтөлбөрт тусгагдсан дараах дэд хөтөлбөрийг батлуулав. Үүнд:

№	Цогц хөтөлбөр	Дэд хөтөлбөр	Батлагдсан захирамжийн дугаар
1.	Хувь хүний хөгжлийн сургалтын хөтөлбөр	Менежмент	Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2023 оны 869 дугаар захирамж

2024 онд дараах хөтөлбөрүүдийг батлуулахаар ажиллаж байна. Үүнд:

1. “Бодлогын судалгааны арга зүй (PD-01)”;
2. “Эрсдэлийн менежмент (PS-02/06)”;
3. “Эдийн засаг, дэд бүтэц, үйлдвэржилт (ID-06)”;
4. Эрх зүйн тогтолцоо, хөгжлийн чиг хандлага (PS-02/01);
5. Хууль зүйн дүн шинжилгээ хийх арга зүй (PS-02/02);
6. Ногоон хөгжил (ID-02);
7. Нийгмийн бодлого (ID-04);
8. Төсөв (ID-05);
9. Сэтгэлгээний хөгжил (PD-07).

Парламентын боловсрол олгох хөтөлбөр

Парламентын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, оюутан, залууст парламентын боловсрол, мэдлэг олгох, хууль тогтоох дээд байгууллагын ил тод, нээлттэй байдлын талаарх шинэ чиг хандлага, үзэл санааг түгээн дэлгэрүүлэх зорилготой “Парламентын боловсрол олгох хөтөлбөр”-ийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн мөн чанар, үзэл баримтлал, хэм хэмжээг хүүхэд, залуучуудад ойлгуулан мэдүүлэх зорилгоор их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургуулийн оюутнууд болон ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад “Монгол Улсын Үндсэн хууль” сэдэвт цахим хичээлийн агуулгыг “Парламентын боловсрол” хөтөлбөрийн гарын авлагын хүрээнд боловсруулж, “Үндсэн хууль гэж юу вэ?”, “Яагаад хүний эрх, эрх чөлөөг Үндсэн хуулиар баталгаажуулдаг вэ?” зэрэг асуултын хүрээнд сурагчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлж, Үндсэн хуулийн мөн чанар, үзэл баримтлал, хэм хэмжээг хүүхэд, залуучуудад ойлгуулан мэдүүлж, 400 гаруй сурагчдад хичээлийг цахим болон танхимын хэлбэрээр хослуулан зохион байгуулсан.

2. Их, дээд сургуулийн оюутан залуусын дунд “Парламентын мэтгэлцээний аварга шалгаруулах тэмцээн”-ийг Монголын мэтгэлцээний нэгдсэн танхимтай хамтран 2023 оны 12 дугаар сарын 09-өөс 10-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт есөн их, дээд сургуулийн 15 клубийн 48 баг оролцсоноос дөрвөн баг шагналт байр эзэлсэн. Тэмцээний нээлтийн арга хэмжээг Төрийн ордны “Их Монгол” танхимд, тэмцээнийг Герман-Монголын хамтарсан технологийн сургууль дээр зохион байгуулсан.

3. Дотоодын их, дээд сургуулиудын оюутнуудын дунд “Миний мэдэх парламент” эссэ бичлэгийн уралдааныг 2023 оны 12 дугаар сарын 06-наас 26-ны өдрийн хооронд зохион байгуулж, нийт 46 эссэ ирүүлснээс шилдэг дөрвөн эссэ шалгаруулж, шагналыг 2024 оны нэгдүгээр сарын 11-ний өдөр Төрийн ордонд гардуулсан.

4. 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Баянхонгор, Өвөрхангай аймгийн хууль сурталчлах төвийн ажилтнуудад зориулсан сургалтад “Парламентын боловсрол” сэдвээр танилцуулга хийсэн.

“Өсвөрийн парламент” хөтөлбөр



“Өсвөрийн парламент” хөтөлбөрийг Улсын Их Хурлын даргын санаачилгаар Улсын Их Хурлын Тамгын газар, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сан, Монголын скаутын холбоотой хамтран 2021 оноос эхлэн хэрэгжүүлж, гурав дахь жилдээ зохион байгуулж байна.

Энэхүү хөтөлбөрөөр өсвөр үеийнхэнд ардчилал, хүний эрх, эрх чөлөө, хууль тогтоох, шийдвэр гаргах үйл ажиллагааны талаар ойлголт өгч, тогтвортой хөгжлийн зорилго, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг мэдээллээр

дамжуулан шийдвэр гаргах түвшинд өсвөр үеийнхний оролцоог дэмжих зорилгоор үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна.

Хөтөлбөрийн шалгаруулалт 2023 оны 10 дугаар сарын 25-наас 11 дүгээр сарын 12-ны өдрийн хооронд явагдаж 21 аймаг, есөн дүүргээс нийт 760 өргөдөл ирүүлснээс 150 хүүхэд шалгарсан.

- 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр Найрамдал зусланд хөтөлбөрт шалгарсан оролцогч 150 сурагчдад Парламентын боловсрол болон Улсын Их Хурлын үйл ажиллагаа сэдвээр танилцуулга хичээл зохион байгуулсан.

- Мөн оны 11 дүгээр сарын 25-ны өдөр “Өсвөрийн Парламент 2023” хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагааг Төрийн ордонд зохион байгуулсан. Нээлтэд Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Хөтөлмөр, нийгэм хамгааллын сайд Х.Булгантуяа, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат болон холбогдох бусад албан тушаалтнууд болон хөтөлбөрийн 150 сурагчид оролцсон.

“Өсвөрийн Парламентын 2023” хөтөлбөрийн сурагч болон сургагч багш нарт сургалт зохион байгуулах ажлын хүрээнд дараах сургалтыг зохион байгуулсан. Үүнд:

- 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр “Өсвөрийн Парламентын 2023” хөтөлбөрийн сурагчдад Парламентын боловсролын, Улсын Их Хурал түүний үйл ажиллагаа сургалт;

- Мөн оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Өсвөрийн Парламент үндэсний хөтөлбөрийн сургагч багш нарын чиглүүлэх мэдээлэл сургалт;

- Мөн оны 12 дугаар сарын 01-нээс 29-ний өдрүүдэд Өсвөрийн Парламент үндэсний хөтөлбөрийн сургагчдад зориулсан таван удаагийн цахим хичээлийг зохион байгуулав.

“Парламентын сургалтын цахим систем”

- EdX, Harvard их сургуулиас санал болгож буй Кибер аюулгүй байдлын энгийн ойлголтууд, Алсын зайнаас ажиллах хувьсгал, Манлайлалд суралцах нь, Гэрээний эрх зүй, Нийгэм, эдийн засаг ба гадаад бодлого сэдэвт сургалтуудын холбоосуудыг;

- “Парламентын сургалтын цогц хөтөлбөр”-ийн Нийгмийн мэдрэмж олгох сургалтын хөтөлбөрийн танилцуулгыг; танхимаар зохион байгуулагдсан Жендэрийн талаарх шинэ ойлголт, Эрсдэлийг удирдах үйл явцыг хэрэгжүүлэх нь сургалт, Хүний эрхэд суурилсан бодлого төлөвлөлт зэрэг гурван сургалтын бичлэгийг тус тус байршуулж ажилласан.



Дөрөв. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Улсын Их Хурлын Тамгын газраас намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын удирдлага, гишүүдэд гадаад бодлого, парламент хоорондын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах, айлчлал, хурал, уулзалт, арга хэмжээг тухай бүр амжилттай зохион байгуулав.

4.1. Улсын Их Хурал, түүний Тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагаа

“Монгол Улсын Их Хурал, Монголын Парламентын Бүлгэм, Тамгын газрын гадаад харилцаа, хамтын ажиллагааг зохион байгуулах” хүрээнд Улсын Их Хурлын дэд дарга, гишүүд, Ерөнхий нарийн бичгийн даргын Шведийн Хаант Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Япон Улсад тус тус хийсэн айлчлал, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Оросын Холбооны Улс, Европын Парламент, Австри Улсын парламентын дарга, бүлгийн дарга, гишүүдийн Монгол Улсад хийсэн айлчлалуудыг хэрэгжүүллээ. Мөн Улсын Их Хурал дахь Монгол-Мексикийн парламентын бүлгийн уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулав.



Гадаад айлчлал**Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар
Бүгд Найрамдах Киргиз Улсад айлчлав**

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Бүгд Найрамдах Киргиз Улсын парламент Жогорку Кенешийн дарга Нурланбек Тургунбекович Шакиевийн урилгаар 2024 оны 02 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд тус улсад албан ёсны айлчлал хийлээ.

Айлчлалын үеэр Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Киргиз Улсын Жогорку Кенеш-ийн дарга Н.Шакиев нар албан ёсны хэлэлцээ хийж, хоёр талын харилцаа, парламент хоорондын хамтын ажиллагаа болон харилцан сонирхсон бусад асуудлаар санал солилцов. Түүнчлэн, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч С.Жапаров-т бараалхаж, Сайд нарын танхимын дарга бөгөөд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга А.Жапаровтай хоёр талын уулзалт хийлээ.

Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс хоорондын дээд, өндөр түвшний яриа хэлэлцээний давтамжийг хадгалах, харилцан итгэлцлийг гүнзгийрүүлэх, хууль тогтоох байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх, харилцааны эрх зүйн үндсийг бататгах, парламент дахь найрамдлын бүлэг, Тамгын газар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд энэхүү айлчлал чухал ач холбогдолтой боллоо.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар тэргүүтэй төлөөлөгчдийн Шведийн Хаант Улсад хийсэн айлчлал



Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар тэргүүтэй төлөөлөгчид Шведийн Хаант Улсын Риксдагийн Тэргүүн дэд даргын урилгаар 2023 оны 10 дугаар сарын 16-21-ний өдрүүдэд тус улсад албан ёсны айлчлал хийв.

Айлчлалын үеэр Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар тэргүүтэй төлөөлөгчид Шведийн Хаант Улсын хууль тогтоох дээд байгууллага Риксдагийн дарга Андреас Норлейнд бараалхаж, Риксдагийн Тэргүүн дэд дарга Кеннет Г.Форшлунд, Гадаад хэргийн дэд сайд Ян Кнутссон болон Стокхолм хотын зөвлөлийн дарга Олле Буррел нартай албан уулзалт хийв.

Бараалхалт, уулзалтын үеэр талууд хууль тогтоох байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлж, харилцан туршлага солилцох, парламентын Тамгын газар хоорондын харилцаа хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах, хоёр орны харилцаа хамтын ажиллагааг худалдаа, хөрөнгө оруулалт, соёл, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, ногоон технологи болон бусад бүхий л салбарт харилцан үр ашигтай өргөжүүлэн хөгжүүлэх, 2024 онд тохиох Монгол-Шведийн дипломат харилцааны 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, иргэдийн эрх ашгийг хамгаалах зэрэг асуудлаар ярилцаж, санал нэгдэв. Түүнчлэн, айлчлалын үеэр манай тал Швед Улсаас Монгол Улсад Дипломат төлөөлөгчийн газраа нээх нь харилцаа, хамтын ажиллагаанд ач холбогдолтойг онцолж, энэ асуудлыг бүх шатанд хөндөж тавьсан нь чухал алхам болов.

Энэхүү айлчлалын үеэр Риксдагт Швед-Монголын парламентын бүлэг албан ёсоор байгуулагдсан нь айлчлалын онцлох үйл явдал байв. Мөн Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Риксдагийн дарга А.Норлейнийг хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойгоор Монгол Улсад айлчлахыг урьсан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын урилгыг гардуулан өгөв.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар тэргүүтэй төлөөлөгчдийн Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад хийсэн айлчлал



Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар тэргүүтэй төлөөлөгчид 2023 оны 11 дүгээр сарын 13-14-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад ажлын айлчлал хийв.

Энэхүү айлчлалын үеэр Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар БНАЛАУ-ын Үндэсний Ассамблейн дарга Сайсумпон Фумвиханд бараалхаж, Үндэсний Ассамблейн дэд дарга хатагтай Сунтон Сайяжактай уулзав. Уулзалтаар талууд Монгол-Лаосын харилцаа, тэр дундаа хууль тогтоох байгууллага хоорондын хамтын ажиллагаа идэвхтэй хөгжиж байгааг онцолж, Монгол Улсын Их Хурал, БНАЛАУ-ын Үндэсний Ассамблей хооронд байгуулагдсан хамтын ажиллагааны санамж бичгийн хэрэгжилтийг хангах чиглэлд хамтран ажиллахаа харилцан илэрхийлэв. Түүнчлэн, хоёр орны хууль тогтоох байгууллага хоорондын уламжлалт найрсаг харилцаа, хамтын ажиллагааны бэлгэ тэмдэг болгон Монгол Улсын Их Хурлаас БНАЛАУ-ын Үндэсний Ассамблейн ордонд зориулж бэлэглэсэн дэвсгэр хивсийг Лаосын талд албан ёсоор гардуулав.


Монгол Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан тэргүүтэй төлөөлөгчдийн Бүгд Найрамдах Турк Улсад хийсэн айлчлал



Монгол Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан тэргүүтэй төлөөлөгчид Бүгд Найрамдах Турк Улс (БНТУ)-ын Үндэсний Их Хурлын Гадаад бодлогын хорооны дарга Фуат Октай-н урилгаар 2023 оны есдүгээр сарын 19-нөөс 23-ны өдрүүдэд тус улсад айлчлав.

Айлчлалын хүрээнд Байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан тэргүүтэй төлөөлөгчид БНТУ-ын Үндэсний Их Хурлын гишүүн, Гадаад бодлогын байнгын хорооны дарга Ф.Октай, Үндэсний Их Хурлын гишүүн, Үндэсний батлан хамгаалах хорооны дарга Хулуси Акар, Үндэсний Их Хурлын гишүүн, Үндэсний Их Хурал дахь Турк-Монголын парламентын бүлгийн дарга Ибрахим Уфук Каянак нартай уулзав. Уулзалтаар талууд хоёр улсын улс төр, эдийн засаг, эрүүл мэнд, соёл, боловсрол, батлан хамгаалах, зам тээвэр, худалдаа, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг улам өргөжүүлэн хөгжүүлэх асуудлаар ярилцаж, санал солилцсоны зэрэгцээ 2024 онд тохиох хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойг угтуулан дээд, өндөр түвшний харилцан айлчлалын давтамжийг тогтмолжуулах, ойн хүрээнд хоёр улсын харилцааны түвшинг шат ахиулан стратегийн түншлэлд хүргэх, харилцаа, хамтын ажиллагааг цаашид эдийн засгийн агуулгаар баяжуулж, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх нь чухал болохыг санал нэгтэй тэмдэглэв.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан тэргүүтэй төлөөлөгчдийн Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийсэн айлчлал



Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан тэргүүтэй төлөөлөгчид БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал (БХАТИХ)-ын Гадаад хэргийн хорооны урилгаар 2023 оны 12 дугаар сарын 03-08-ны өдрүүдэд БНХАУ-д ажлын айлчлал хийв.

Айлчлалын үеэр байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан БХАТИХ-ын Байнгын хорооны дэд дарга Луосан Жанцун, БХАТИХ-ын Гадаад хэргийн хорооны дэд дарга Фү Зыин болон БНХАУ-ын Зам, тээврийн дэд сайд Ли Яан нартай тус тус албан уулзалт хийв.

Уулзалтаар талууд Монгол-Хятадын найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгааг онцлоод хоёр улсын худалдаа, эдийн засгийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, дунд хугацааны хөтөлбөрийг шинэчлэх, эдийн засгийн бодит хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, худалдааны бүтцийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, зам тээвэр, боомт, дэд бүтэц, боловсрол, цахим худалдаа, хиймэл оюун ухааны хөгжил, тэр дундаа цахим худалдааны платформын дэд бүтцийг хөгжүүлж, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх зэрэг асуудлаар санал солилцоод дээрх үйл ажиллагаанд парламент хоорондын хамтын ажиллагаа чухал гэдэгт санал нэгдэв.

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан тэргүүтэй төлөөлөгчид Румын Улсад айлчлав



Монгол Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан тэргүүтэй төлөөлөгчид Румын Улсын Парламентын Сенатын танхимын Гадаад бодлогын байнгын хорооны урилгаар тус улсад 2024 оны 02 дугаар сарын 20-25-ны өдрүүдэд албан айлчлал хийв. Айлчлалын бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүн Х.Баделхан, Д.Ганбат, Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Л.Саянаа (Румын Улсад хавсран суугаа) болон албаны бусад хүмүүс ажиллалаа.

Айлчлалын үеэр Улсын Их Хурлын гишүүд Румын Улсын парламентын Сенатын танхимын Ерөнхийлөгч Эрхэмсэг ноён Николае-Ионел Чука-д бараалхан Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын мэндчилгээг уламжилж, парламент хоорондын харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх, улмаар бусад салбар хоорондын харилцан ойлголцсон, нийтлэг ашиг сонирхол бүхий хамтын ажиллагааны хөгжилд түлхэц үзүүлэх зорилго, эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлэв.

Айлчлалын хүрээнд Монгол Улсын Их Хурлын төлөөлөгчид тус улсын парламентын Дээд танхимын Гадаад бодлогын байнгын хорооны дарга ноён Сенатор Титус Корласеан болон Төлөөлөгчдийн танхимын Гадаад бодлогын байнгын хорооны дарга хатагтай Розалия Биро, Сенат дахь Румын-Монголын парламентын найрамдлын бүлгийн дарга Сорин Лаврич, Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ноён Траян-Христя нартай тус тус албан уулзалт хийв. Мөн тус улсын эрдэмтэн, академич Константин Барбуг хүлээн авч уулзлаа. Академич Константин Барбу Монголын эрт үеийн түүхийн холбогдолтой судалгааны эх сурвалжуудыг цуглуулан, "Monumenta Mongoliae historica" хэмээх түүхэн эх сурвалжийн цувралынхаа эхний 10 боть номыг өөрийн зардлаар хэвлүүлсэн байна. Тэрбээр уг 10 ботио 10 газрын зургийн хамт Монгол Улсын Их Хурлын төлөөлөгчдөд гардуулав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд тэргүүтэй Улсын Их Хуралд суудалтай намуудын төлөөллөөс бүрдсэн төлөөлөгчдийн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад хийсэн айлчлал



Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболдоор ахлуулж Улсын Их Хурлын гишүүн, Монгол Ардын Намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Ардчилсан Намын бүлгийн дарга О.Цогтгэрэл зэрэг Улсын Их Хуралд суудалтай намуудын төлөөллөөс бүрдсэн төлөөлөгчид 2023 оны есдүгээр сарын 24-29-ний өдрүүдэд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад ажиллав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар байгуулагдах дараагийн парламент 126 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулахтай холбогдуулан Улсын Их Хурлын өдөр тутмын үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт болон хуралдааны дэгийг шинэчлэн боловсруулахад парламентын соёл өндөр хөгжсөн улс орнуудын туршлагыг судалж, олон улсын сайн жишигт нийцүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Уг зорилтын хүрээнд төлөөлөгчид Бундестагт ажиллах хугацаандаа парламентын бүтэц, байнгын болон түр хороодын чиг үүрэг, бүрэн эрх, бүрэлдэхүүний тоо, тусгай хороодын эрхлэх асуудлын зааг ялгаа, хүрээ хязгаар, сонгуулийн дараа нам, эвслийн бүлэг байгуулах журам, нам, эвслийн бүлэг байгуулах гишүүдийн тооны дээд, доод хязгаар, нам, эвслийн бүлгийн эрх, үүрэг, сахилга, хариуцлага, бүлэгт харьяалалгүй гишүүдийн эрх, үүргийн онцлог зэрэг асуудлуудын талаар холбогдох эрх бүхий албан тушаалтнуудтай уулзаж, нарийвчилсан мэдээлэл авав. Мөн парламентын мэтгэлцээний сонгодог зарчим, түүнийг хэрхэн явуулдаг талаарх зохицуулалт, парламентын мөрдөн шалгах чиг үүрэг, хяналт шалгалтын түр хорооны зохион байгуулалт, нийтийн сонсгол, парламентын хэвлэлийн эрх зүйн орчин зэрэг асуудлуудыг цогцоор нь судлан ажиллав.

Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд, Улсын Их Хурал дахь Монгол-Японы парламентын бүлгийн дарга Ц.Даваасүрэн тэргүүтэй төлөөлөгчдийн Япон Улсад хийсэн айлчлал

Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд, Улсын Их Хурал дахь Монгол-Японы парламентын бүлгийн дарга Ц.Даваасүрэн Япон Улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын гишүүн, Япон-Монголын парламентын бүлгийн дарга М.Хаяшигийн урилгаар 2024 оны нэгдүгээр сарын 13-17-ны өдрүүдэд тус улсад айлчлав.

Айлчлалын үеэр төлөөлөгчид Япон Улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Ф.Нүкага, Зөвлөхүүдийн танхимын дэд дарга Х.Нагахана нарт бараалхаж, Төлөөлөгчдийн танхимын гишүүн, Япон-Монголын парламентын бүлгийн дарга М.Хаяши, Япон Улсын Ерөнхий сайд асан, Төлөөлөгчдийн танхимын гишүүн Ё.Сүга, Хууль зүйн сайд, Төлөөлөгчдийн танхимын гишүүн Р.Коизүм, Газар, дэд бүтэц, зам тээвэр, аялал жуулчлалын дэд сайд Ш.Доко нартай тус тус албан уулзалт хийв.

Монгол-Японы парламентын бүлгийн төлөөлөгчдийн Япон Улсад хийсэн энэ удаагийн айлчлал нь хоёр улсын “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн харилцааг гүнзгийрүүлэх, улс төрийн итгэлцлийг бэхжүүлэх, парламент хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд томоохон түлхэц болов.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан тэргүүтэй төлөөлөгчдийн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад хийсэн туршлага судлах айлчлал



Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу 2024 оноос Улсын Их Хурлын бүтэц, бүрэлдэхүүн өргөжиж, сонгуулийн холимог тогтолцоогоор парламент 126 гишүүнээс бүрдэхтэй холбогдуулан шинэчлэлтийн талаар судалж, туршлага солилцох зорилгоор Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан тэргүүтэй төлөөлөгчид 2023 оны есдүгээр сарын 11-14-ний өдрүүдэд ХБНГУ-ын Бундестагийн Тамгын газарт ажиллав.

Төлөөлөгчид энэхүү туршлага судлах айлчлалын үеэр Бундестагийн Тамгын газрын холбогдох хэлтэс, албадын удирдлагатай уулзаж, ХБНГУ-ын төрийн тогтолцоон дахь парламентын үүрэг, бүтэц, үйл ажиллагаа, гишүүдийн санхүүжилт, ёс зүйн дүрэм, халдашгүй байдлын хэрэгжилт, төсвийн дүн шинжилгээ, улс төрийн нам болон намын бүлгийн санхүүжилт зэрэг олон асуудлаар ярилцаж, мэдээлэл солилцов. Тухайлбал, Бундестагийн Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч, Парламент болон гишүүдийн асуудал эрхэлсэн дэд дарга, хатагтай Рут Лангтай албан ёсны уулзалт хийж, Холбооны төсөв, санхүүгийн эрх зүй, хяналтын тогтолцоо болон парламентын гишүүний бүрэн эрх, ёс зүйн хэм хэмжээ, хязгаарлалт зэрэг асуудлыг эрхэлсэн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцав.

Энэ удаагийн туршлага судлах айлчлалын зорилго нь улсын төсөв, төлөвлөгөө хийгээд санхүүгийн салбарын хууль тогтоомжийг боловсруулах, батлах аргачлал, үе шат болон тэдгээрт тавих хяналт, дүн шинжилгээний арга зүй, хамрах хүрээ, мөнхүү улс төрийн санхүүжилтийн шийдлийг судлахад оршив.

Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат ИБУИНВУ-ын Нийтийн танхимын туршлагаас судлав



Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат тэргүүтэй төлөөлөгчид 2024 оны нэгдүгээр сарын 29-ноос хоёрдугаар сарын 03-нд Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын парламентын тогтолцоо, үйл ажиллагааны талаар туршлага судаллаа. Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу Монгол Улсын Их Хурлын бүрэлдэхүүн өргөжиж, 126 гишүүнтэй ажиллах болсонтой холбогдуулан олон гишүүн бүхий парламентууд, тэдгээрийн хуралдааны дэг, парламентын ажлын албаны зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар судалж, сайн туршлагыг нэвтрүүлэхэд Тамгын газар анхаарал хандуулж буй юм.

Энэ хүрээнд тэрбээр Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын парламент буюу Нийтийн танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга Том Гоулдсмиттэй уулзав. Ерөнхий нарийн бичгийн дарга Том Гоулдсмит Нийтийн танхим, түүний Тамгын газрын үйл ажиллагааны талаар танилцуулсан юм. Нийтийн танхим нь 650 гишүүнтэй бөгөөд сонгуулийг нэг мандаттай 650 тойрогт мажоритар системээр явуулдаг байна. Англи 529, Уэльс 40, Шотланд 72, Умард Ирланд 18 сонгуулийн тойрогтой. Парламентын бүх нийтийн сонгууль 5 жил тутамд болж, сонгуульд дийлэнхийн санал авсан улс төрийн нам засгийн газрыг эмхлэн байгуулдаг аж.

Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат туршлага судлах ажлынхаа хүрээнд хуулийн төсөл боловсруулах, батлах үйл явц, E-petition буюу өргөдөл гомдлын цахим системийн үйл ажиллагаа, парламентын судалгаа, олон нийтийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн ажилтай танилцсан юм.

Хоёр улсын парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн боломж байгааг Ерөнхий нарийн бичгийн дарга нар ярилцаж, парламентат ёсны хөгжил, Тамгын газруудын туршлага, ур чадварыг харилцан солилцох, мэргэжилтнүүдийн дадлагажуулах, тус тусын болон бусад улсын туршлагыг судлахад хамтран ажиллахаар тохиролцлоо.

Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат БНЭУ-ын парламентын Лок Сабха (Доод танхим)-д ажиллалаа



Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат тэргүүтэй төлөөлөгчид 2024 оны хоёрдугаар сарын 26-29-нд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын парламентын Лок Сабха (Доод танхим)-ын бүтэц, зохион байгуулалт, хуулийн төсөл боловсруулах, батлах үйл явц, хуралдааны дэг, хуулийн төсөл боловсруулагчдыг бэлтгэх, чадавхжуулах тогтолцоо, парламентын судалгаа, парламентын боловсрол хэрхэн олгож буй талаар туршлага судалж ажиллалаа. Айлчлалынхаа эхэнд тэрбээр БНЭУ-ын парламентын Лок Сабхагийн Ерөнхий нарийн бичгийн дарга Утпал Кумар Сингхтэй уулзлаа.

Монгол Улсад хийгдэж буй парламентын шинэтгэлийн түүхэн үйл явдлын өмнө хоёр парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагааны протоколын хүрээнд хийж буй чухал ач холбогдолтой айлчлал болохыг талууд илэрхийлэв.

Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Энхбат манай хоёр улсын хууль тогтоох дээд байгууллагын хуулийн төсөл боловсруулагчдыг бэлтгэх, чадавхжуулах болон парламентын ажлын албаны ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, орчин цагийн шаардлагад нийцүүлэх чиглэлээр сургалт, хэлэлцүүлэгт оролцох мэдлэг, туршлагаа хуваалцах бодитой боломж гарна гэдэгт итгэлтэй байна гэлээ.

БНЭУ-ын парламентын Лок Сабхагийн Ерөнхий нарийн бичгийн дарга Утпал Кумар Сингх Монгол, Энэтхэгийн парламент хоорондын үйл ажиллагаа өргөжин тэлж байгааг онцлон тэмдэглэж, тус Тамгын газраас хэрэгжүүлдэг дэлхийн 50-60 орны парламентын ажлын албаны ажилтнуудыг оролцуулсан хуулийн төсөл боловсруулагчдын сургалтын хөтөлбөр болон парламентын үйл ажиллагаанд нэвтрүүлж буй цахим технологийн талаар танилцуулав.

Дотоодод хэрэгжүүлсэн арга хэмжээ**Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ХБНГУ-ын Ерөнхийлөгч Франк-Вальтер Штайнмайэрт бараалхав**

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн урилгаар манай улсад төрийн айлчлал хийсэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ерөнхийлөгч Франк-Вальтер Штайнмайэрт (2024.02.08) бараалхав. ХБНГУ нь Европын орнуудаас Стратегийн түншлэл байгуулсан анхны улс болж байгаа нь хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны цар хүрээ, харилцан итгэлцлийг илтгэж буй талаар Улсын Их Хурлын дарга тэмдэглээд, уг Стратегийн түншлэлийн харилцааг цаашид улам төгөлдөржүүлэн хөгжүүлэхэд хууль тогтоох байгууллагуудын улс төрийн манлайлал, тэр дундаа парламент дахь найрамдлын бүлэг хоорондын нягт хамтын ажиллагаа чухал үүрэгтэй гэв.

Тэрбээр, ХБНГУ-ын Бундестаг дахь Герман-Төв Азийн найрамдлын бүлгийг өргөжүүлж, шинээр Герман-Монголын парламентын найрамдлын бүлгийг байгуулахад дэмжлэг үзүүлэхийг Ерөнхийлөгч Франк-Вальтер Штайнмайэрээс хүсээд, Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу Монгол Улсын Их Хурлын гишүүдийн тоо 2024 оны сонгуулиар 126 болох бөгөөд үүгээр парламентын төлөөлөх чадавх, эмэгтэйчүүдийн квот нэмэгдэж байгаа талаар ярилаа.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ерөнхийлөгч Франк-Вальтер Штайнмайэр Монгол, Германы харилцаа улс төр, эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалт, соёл, боловсрол, шинжлэх ухаан, зам тээвэр, археологи, хүмүүнлэг болон бусад салбарт тасралтгүй өргөжиж байгааг онцолж, цаашид хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар өргөжүүлэх олон боломж бийг тэмдэглэлээ.

Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Үндэсний Ассамблейн дарга Сайсумпон Фумвиханы Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал



Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын урилгаар Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Үндэсний Ассамблейн дарга Сайсумпон Фумвихан тэргүүтэй төлөөлөгчид 2023 оны есдүгээр сарын 07-10-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв.


Айлчлалын хүрээнд Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Лаосын Үндэсний Ассамблейн дарга С.Фумвихан-тай албан ёсны хэлэлцээ хийж, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхэд Үндэсний Ассамблейн дарга С.Фумвихан бараалхав. Яриа хэлэлцээний үеэр талууд Монгол-Лаосын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа, түүний дотор парламент хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлж, олон улсын тавцан дахь хамтын ажиллагааг бэхжүүлэх, олон улс, бүс нутгийн харилцан сонирхсон асуудлуудаар санал солилцов. Тухайлбал, дэд бүтэц, тээвэр логистик, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, мал аж ахуй, боловсрол, нийгмийн эрүүл мэнд зэрэг эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг түлхүү хөгжүүлэх талаар санал солилцож, хэлэлцэн тохиролцсон ажлууд, хамтын ажиллагааны санал санаачилгуудыг бодит ажил хэрэг болгохын төлөө хоёр тал эрчимтэй ажиллахаар тохиролцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Үндэсний Ассамблейн дарга С.Фумвихан нар албан ёсны хэлэлцээ хийсний дараа Монгол Улсын Их Хурал, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Үндэсний Ассамблейн хоорондын хамтын ажиллагааны Санамж бичгийг үзэглэв. Түүнчлэн, Үндэсний Ассамблейн дарга С.Фумвихан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд зочилж, 2003 онд Лаосын талаас чуулганы танхимд зориулан бэлэглэсэн улаан модон тавилгыг өнөөг хүртэл ашиглаж буйтай танилцав. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу 2024 оноос Улсын Их Хурал 126 гишүүнтэй болохтой холбоотойгоор Лаос Улсаас улаан модон тавилга нэмж авах манай талын хүсэлтийг Үндэсний Ассамблейн дарга С.Фумвихан шийдвэрлэхээ илэрхийлэв.



Айлчлалын хүрээнд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан БНАЛАУ-ын Үндэсний Ассамблейн гишүүн, Үндэсний Ассамблейн Нарийн бичгийн дарга Пингкам Ласасимматай уулзаж, парламентын Тамгын газруудын хооронд байгуулагдсан хамтын ажиллагааны баримт бичгийн дагуу уламжлалт найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа улам бүр өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө ажиллахаа харилцан илэрхийлэв.

Энэхүү айлчлал нь Лаос Улсын Үндэсний Ассамблейн даргын түвшинд 11 жилийн дараа Монгол Улсад хэрэгжиж буй айлчлал бөгөөд Монгол Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын харилцаа, хамтын ажиллагааны шинэ жарны эхлэлд хэрэгжиж буйгаараа онцлог болов. Түүнчлэн Монгол Улс АСЕАН-ы Яриа хэлэлцээний түнш болох, АПЕК зэрэг бүс нутгийн үйл явцад нэгдэн ороход Лаосын талын дэмжлэгийг үргэлжлүүлэн авахад чухал ач холбогдолтой болов.



Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Төрийн Думын дарга Вячеслав Викторович Володины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлал



Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын урилгаар Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Төрийн Думын дарга Вячеслав Викторович Володин 2023 оны есдүгээр сарын 23-25-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв.

Айлчлалын үеэр Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын дарга В.В.Володин нар албан ёсны хэлэлцээ хийж, Төрийн Думын дарга В.В.Володин Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхэд бараалхаж, Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэтэй уулзав. Уулзалт, хэлэлцээний үеэр Монгол-Оросын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг бэхжүүлэхэд чиглэсэн парламент хоорондын хамтын ажиллагааг идэвхжүүлэх, хоёр улсын худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, эрчим хүч, зам тээвэр, аялал жуулчлал, хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудлаар талууд дэлгэрэнгүй санал солилцов.



Энэ удаагийн айлчлалын хүрээнд Монгол Улсын Их Хурал, ОХУ-ын Холбооны Хурал хоорондын хамтын ажиллагааны Комиссын анхдугаар хуралдааныг зохион байгуулж, хамтарсан комиссын анхдугаар хуралдааныг нээж хоёр улсын парламентын дарга нар үг хэлэв. Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар, Төрийн Думын дэд дарга Алексей Васильевич Гордеев нарын удирдан явуулсан комиссын анхдугаар хуралдаанаар талууд худалдаа, эдийн засаг, газрын тос, эрчим хүч, байгаль орчин, зам тээвэр, боловсрол, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, хил орчмын бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, тэр дундаа шатахууны тогтвортой нийлүүлэлт, хангамж, үнийн асуудлаарх яриа, хэлэлцээг үргэлжлүүлэх, ноос ноолуур, арьс шир, мах махан бүтээгдэхүүнийг ОХУ-д татваргүй болон татварын хөнгөлөлттэй нөхцөлөөр нийлүүлэхийн тулд хориг саадыг арилгах зэрэг асуудлаар хэлэлцсэн нь ихээхэн үр дүнтэй болов. Яриа хэлэлцээрийн энэхүү шинэлэг механизм нь мөнхийн хөрш ОХУ-тай найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх, парламент хоорондын хамтын ажиллагааг шинэ түвшинд хүргэх, улс төрийн төдийгүй цаг үеийн тулгамдсан асуудлыг авч хэлэлцэж, цаашдын хөгжлийн чиг баримжааг зөв тодорхойлоход чухал талбар болохыг онцлов.

***Бүгд Найрамдах Австри Улсын Үндэсний зөвлөлийн гишүүн,
Австри-Монголын найрамдлын бүлгийн дарга Эва Эрнст-Жиеджич тэргүүтэй
төлөөлөгчдийн Монгол Улсад хийсэн айлчлал***



Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Австрийн парламентын бүлгийн дарга Э.Бат-Амгалангийн урилгаар Бүгд Найрамдах Австри Улсын Үндэсний зөвлөлийн гишүүн, тус зөвлөл дэх Австри-Монголын найрамдлын бүлгийн дарга, хатагтай Эва Эрнст-Жиеджич тэргүүтэй төлөөлөгчид 2023 оны наймдугаар сарын 29-нөөс есдүгээр сарын 02-ны өдрүүдэд Монгол Улсад айлчлав.

Айлчлалын үеэр төлөөлөгчид Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт бараалхаж, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Австрийн парламентын бүлгийн дарга Э.Бат-Амгалан тэргүүтэй бүлгийн гишүүдтэй уулзав. Бараалхалт, уулзалтаар талууд Монгол-Австрийн харилцаа, хамтын ажиллагаа нийгэм, улс төр, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарт идэвхтэй өрнөж байгааг тэмдэглээд цаашид байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, ногоон хөгжил, хүнсний аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуй, сэргээгдэх эрчим хүч, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлд хамтран ажиллах боломжийн талаар санал солилцов.

Монгол-Австрийн дипломат харилцааны 60 жилийн ойн хүрээнд хэрэгжсэн энэхүү айлчлал нь хоёр улсын хууль тогтоох байгууллага хоорондын харилцан айлчлалын давтамжийг тогтмолжуулах, харилцан ойлголцол, итгэлцлийг бэхжүүлж, харилцаа хамтын ажиллагааг шинэ шатанд гаргахад чухал ач холбогдолтой болов.

Монгол Улсын Их Хурал, Европын Парламент хоорондын Зөвлөлдөх уулзалт



Монгол Улсын Их Хурал, Европын Парламент хоорондын ээлжит 16 дугаар Зөвлөлдөх уулзалтыг 2023 оны 10 дугаар сарын 28-наас 11 дүгээр сарын 02-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Европын Парламенттай харилцах бүлгийн дарга Ц.Мөнхцэцэг, Европын Парламентын гишүүн, Европын Парламент дахь Төв Ази, Монголтой харилцах бүлгийн дарга Томаш Здоховски нарын ахлан явуулсан энэ удаагийн зөвлөлдөх уулзалтаар Монгол Улс, Европын Холбооны сүүлийн үеийн өөрчлөлт, үйл явдлууд, улс төрийн нөхцөл байдал, парламент хоорондын цаашдын хамтын ажиллагаа, эрчим хүч, ногоон хөгжил, иргэний нийгэм, хүний эрх, иргэдийн харилцан зорчих нөхцөлийг хөнгөвчлөх, олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааны чиг хандлага зэрэг асуудлаар өргөн хүрээнд ярилцаж, санал солилцов.



Уулзалтын хүрээнд Европын Парламентын төлөөлөгчид Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт бараалхан, Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Улсын Их Хурлын эмэгтэй гишүүдийн төлөөлөл болон холбогдох албан тушаалтнуудтай уулзаж, харилцаа, хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Энэ удаагийн уулзалт Монгол Улс, Европын Холбооны хооронд тогтоосон түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэх, хоёр талын харилцан ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэх, хууль тогтоох байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх, иргэдийн визийн нөхцөлийг хөнгөлөх санаачилгыг цаашид үргэлжлүүлэхэд зохих хувь нэмэр оруулав.

Цахим арга хэмжээ

Монгол, Мексикийн парламент дахь найрамдлын бүлгийн дарга нарын цахим уулзалт



Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол-Мексикийн парламентын бүлгийн дарга Т.Доржханд 2023 оны есдүгээр сарын 14-ний өдөр Мексикийн Нэгдсэн Улсын Конгресс дахь Мексик-Монголын парламентын бүлгийн дарга Мануэль Гулермо Чапман Моренотой цахимаар уулзаж, хамтын ажиллагааны талаар санал солилцов.

Цахим уулзалтаар талууд Монгол-Мексикийн дипломат харилцаа идэвхжин хөгжиж байгааг тэмдэглээд цаашид парламент хоорондын хамтын ажиллагааг улам өргөжүүлэх, эдийн засаг, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх өргөн боломж байгаатай санал нэгдэж, хууль тогтоогчдын зүгээс бүхий л хэлбэрээр дэмжин ажиллахаа харилцан илэрхийлэв.

4.2. Олон Улсын болон Бүс нутгийн Парламентын байгууллагын хамтын ажиллагаа

“Олон улсын болон бүс нутгийн парламентын байгууллагын үйл ажиллагаанд оролцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх” хүрээнд олон улс, бүс нутгийн хурал, чуулга уулзалтад Улсын Их Хурлын дарга, гишүүд, Ерөнхий нарийн бичгийн даргыг оролцуулахаас гадна бүс нутгийн чанартай томоохон арга хэмжээг Монгол Улсад хүлээн авч, амжилттай зохион байгуулав.

Гадаад арга хэмжээ

“Номхон далай дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээ-2023: Эрчим хүчний аюулгүй байдал” олон улсын чуулга уулзалт



Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар тэргүүтэй төлөөлөгчид 2023 оны есдүгээр сарын 12-14-ний өдрүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотноо зохион байгуулагдсан “Номхон далай дамнасан тогтвортой байдлын яриа хэлэлцээ-2023: Эрчим хүчний аюулгүй байдал” олон улсын чуулга уулзалтад оролцов.

БНСУ-ын “Бан Ги Мүн” сан болон Стэнфордын их сургуулиас хамтран зохион байгуулсан энэ удаагийн олон улсын чуулга уулзалтад Нэгдсэн Үндэстний байгууллагын найм дахь Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүн, БНСУ-ын Гадаад хэргийн сайд Парк Жин, БНСУ-ын Үндэсний Ассамблейн дарга Ким Жин Пёо, Физикийн Нобелийн шагналтан Стивэн Чү, Токио Их сургуулийн Ерөнхийлөгч Тэрүо Фүжи, БНСУ-ын Эвха Эмэгтэйчүүдийн их сургуулийн Ерөнхийлөгч Еүн Мии Ким зэрэг долоон улсын 160 гаруй хүндэт төлөөлөгчид оролцсон юм.

Эрчим хүчний аюулгүй байдлын олон улсын зураглал, Геополитик, эрчим хүчний тогтвортой байдал, Цэвэр эрчим хүчний шийдлүүдээр дамжуулан Ази, Номхон далай дахь эрчим хүчний аюулгүй байдлыг дэмжих, Цэвэр эрчим хүч, хамтын ажиллагаа гэсэн сэдвүүдийн дор зохион байгуулагдсан чуулга уулзалтын Нэгдүгээр хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үндсэн илтгэгчээр оролцож, үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар энэхүү чуулга уулзалтад оролцохоор Сүүл хотод ажиллах үеэрээ БНСУ-ын Үндэсний Ассамблейд зочилж, Үндэсний Ассамблейн дэд дарга хатагтай Ким Ён Жү, Үндэсний Ассамблейн гишүүн, Үндэсний Ассамблей дахь Ард Түмний Хүч Намын бүлгийн дарга Юн Жэ Уг, Үндэсний Ассамблейн гишүүн, Үндэсний Ассамблей дахь Ардчилсан Намын бүлгийн дарга Паг Гуан Ун нартай уулзан Монгол Улс, БНСУ-ын “Стратегийн түншлэл”-ийн харилцаа, хамтын ажиллагааг нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт өргөжүүлэн хөгжүүлэх асуудлаар санал солилцож, харилцан ашигтай, бие биеэ нөхсөн эдийн засгийн харилцааг хөгжүүлэхийн тулд хамтын ажиллагааны эрх зүйн үндэс суурийг бэхжүүлэх нь зүйтэй хэмээн санал нэгдэв.

Монгол Улсын Их Хурлаас парламентын ардчиллыг бэхжүүлэх, ардчиллын төлөөллийг хангах зорилтын хүрээнд эрх зүйн шинэчлэл хийж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу Улсын Их Хурлын хуралдааны дэг, мэтгэлцээний зарчим, парламентын хяналт шалгалтын процессыг шинэчлэхээр ажиллаж буйтай холбогдуулан төлөөлөгчид БНСУ-ын Үндэсний Ассамблейн сайн туршлагыг судлав.

Түүнчлэн, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар тэргүүтэй төлөөлөгчид “БНСУ дахь гадаад иргэдийн хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн халамж ба тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх нь” хэлэлцүүлэгт оролцов. Уг хэлэлцүүлгийн зорилго нь БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа гадаад иргэд, тэр дундаа Монгол Улсын иргэдийн хүүхдэд сургууль, цэцэрлэг, бусад нийгмийн болоод эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх асуудлыг хялбарчлах, эрх зүйн зохицуулалтыг шинэчлэхэд чиглэв.

Олон Улсын Парламентын Холбооны дэргэдэх Парламентын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын нийгэмлэгийн хурал



Бүгд Найрамдах Ангол Улсад 2023 оны 10 дугаар сард болсон Олон улсын Парламентын холбооны 147 дугаар Ассамблейн үеэр зохион байгуулагдсан Парламентын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын нийгэмлэгийн ээлжит хуралд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, доктор Л.Өлзийсайхан оролцов.

Ангол Улсын нийслэл Луанда хотноо зохион байгуулагдсан 147 дугаар Ассамблейн үеэр “Хиймэл оюун ухааныг зохицуулах, ашиглах, Парламентын Тамгын газрын ур чадвар”, “Парламентын Тамгын газар хоорондын хамтын ажиллагаа”, “Байгууллагын харилцааг сайжруулах замаар парламентын ил тод, хариуцлагатай байдлыг дэмжих нь”, “Хямралын үе дэх төлөөллийн ардчиллын шинэчлэл: Сорилт ба боломж” болон “Парламентын Тамгын газар болон Парламентын гишүүдийн харилцаа” гэсэн сэдвээр төлөөлөгчид илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлэв.

Ассамблейн үеэр Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан Олон улсын Парламентын холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Мартин Чунгон болон Их Британи, Герман Улсын парламентын Ерөнхий нарийн бичгийн дарга нартай уулзаж, Тамгын газрын харилцааг өргөжүүлэх боломжийн талаар ярилцаж, нэн ялангуяа хамтын ажиллагааг цахим парламент, хиймэл оюун ухааны чиглэлээр хөгжүүлэхээр тохиролцов.

Олон улсын Парламентын холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга Мартин Чунгонтой хийсэн албан уулзалтын үеэр талууд Монгол Улсын Их Хурал болон Олон улсын Парламентын холбоо хоорондын хамтын ажиллагаа, тухайлбал, парламентын ардчиллыг бэхжүүлэх, парламент дахь хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хамтран ажиллаж, Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газар нь хүний эрх болон жендэрийн асуудлаарх парламентын өөрийн үнэлгээг Олон улсын Парламентын холбооны боловсруулсан аргачлалын дагуу хийхээр төлөвлөж, бэлтгэлээ хангаж буй нь Монгол Улсын Их Хурлын үйл ажиллагааг улам боловсронгуй болгоход чухал хувь нэмэр оруулаад зогсохгүй дэлхийн бусад улс орнуудын парламентад сайн туршлага болохыг онцлов.

Дотоодод хэрэгжүүлсэн арга хэмжээ

Дэлхийн эрүүл мэндийн асуудлаарх Ази, Номхон далайн орнуудын парламентчдын чуулган



Монгол Улсын Их Хурал, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Эрүүл мэндийн яам хамтран Дэлхийн эрүүл мэндийн асуудлаарх Ази, Номхон далайн орнуудын парламентчдын VII чуулганыг “Ирээдүйн төлөө анхан шатны тусламж үйлчилгээг бүтээе” сэдвийн дор 2023 оны наймдугаар сарын 21-23-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав.

Энэхүү бүс нутгийн парламентчдын чуулганд Бүгд Найрамдах Вануату Улс, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Камбожийн Хаант Улс, Күүкийн Арлууд, Бүгд Найрамдах Кирибати Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Монгол Улс, Ниуэ Улс, Папуа Шинэ Гвиней Улс, Тусгаар Тогтносон Самоа Улс, Соломоны Арлууд Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Тонгагийн Вант Улс, Тувалу Улс, Бүгд Найрамдах Фижи Улс гэсэн 15 улсын парламентын гишүүд, Эрүүл мэндийн сайд болон Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас нийт 70 гаруй төлөөлөгч оролцов.

Дэлхийн эрүүл мэндийн асуудлаарх Ази, Номхон далайн орнуудын парламентчдын чуулганы энэ удаагийн хуралдааныг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар даргалан явуулж, чуулганы салбар хуралдаанууд “Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ яагаад чухал вэ?”, “Ази Номхон далайн бүс нутгийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ: Бид хаана байна вэ? Шинэчлэлийг хаанаас хэрхэн эхлэх вэ?”, “Эрүүл мэндийн инновацаар дамжуулан эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний шинэчлэлийг эрчимжүүлэх нь”, “Парламентын үйл ажиллагаагаар дамжуулан эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг шинэчлэх, шинэчлэлийн арга зам” гэсэн дөрвөн сэдвийн хүрээнд болов.

Дэлхийн эрүүл мэндийн асуудлаарх Ази, Номхон далайн орнуудын парламентчдын VII чуулганы оролцогчид “Номхон далайн баруун бүс дэх анхан шатны тусламж үйлчилгээний ирээдүй” стратегийн баримт бичгийн хүрээнд анхан шатны тусламж үйлчилгээний цаашдын бодлогыг бэхжүүлэх, орчин үеийн шинжлэх ухааны судалгаанд үндэслэсэн шийдвэрлэх арга замыг тодорхойлох; Орон нутгийн боломжуудыг ашиглах өөрсдийн үндсэн чиг үүргээр дамжуулан анхан шатны тусламж үйлчилгээний шинэчлэлийг манлайлан дэмжих асуудлаар улс орнуудын парламентын туршлагаудаас хуваалцах; Технологи, санхүүжилтийн загварууд болон анхан шатны тусламж үйлчилгээнд тулгарч буй бэрхшээлийг түншлэлээр хэрхэн шийдэх, анхан шатны тусламж үйлчилгээг дэмжих инновацыг танилцуулж, санал солилцох; Парламентчдын зүгээс эрүүл мэндийн салбар цаашлаад дэлхий дахин, бүс нутаг, үндэсний болон орон нутгийн түвшинд түншлэлээр дамжуулан анхан шатны тусламж үйлчилгээг дэмжих талаар анхаарч ажиллах боломжуудыг хуваалцах зэрэг асуудлуудыг хөндөж, Тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх шийдлийг олох хэлэлцүүлгийг өрнүүлэв. Түүнчлэн, төлөөлөгчид Төв аймгийн Алтанбулаг, Сэргэлэн сумдад ажиллаж, сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай танилцаж, төвөөс алслагдсан малчин өрхийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг мобайл технологийг ашиглан хэрхэн үзүүлж байгаа болон хөдөө орон нутагт эрүүл мэндийн анхан шатны цогц тусламж үйлчилгээ, санхүүжилтийн загвар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн ажлуудтай танилцав.

Энэхүү чуулганы төгсгөлд улс орнуудын парламентчдыг эрүүл мэндийн одоогийн болон ирээдүйн хэрэгцээг хангах анхан шатны тусламж үйлчилгээний хүчирхэг тогтолцоог бий болгохын төлөө өөрсдийн боломжуудыг бүрэн ашиглахыг уриалсан “Улаанбаатарын хамтарсан мэдэгдэл”-ийг батлан гаргав.

БНСУ-ын Үндэсний Ассамблейн санаачилгаар 2015 оноос эхлэн жил бүр бүс нутгийн хэмжээнд төдийгүй дэлхий нийтэд тулгамдаж буй эрүүл мэндийн нийтлэг асуудлаарх Ази, Номхон далайн орнуудын парламентчдын форум нь эдүгээ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон Далайн Баруун Бүс болон Зүүн Өмнөд Азийн бүсэд харьяалагдах нийт 30 улсын парламентыг эгнээндээ нэгтгэж, эрүүл мэндийн асуудалд парламентчдын зүгээс улс төрийн дэмжлэг үзүүлэх явцыг нэмэгдүүлэх, улмаар олон улсын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах замаар Тогтвортой хөгжлийн зорилгод хүрэхэд хууль эрх зүй, бодлогын дэмжлэгт орчин бий болгоход чиглэсэн олон талт хамтын ажиллагааны нэгэн чухал платформ юм.

Олон улс, бүс нутгийн байгууллагын хурал, чуулганд Улсын Их Хурлын удирдлага, гишүүд идэвхтэй оролцсон нь олон талт харилцааг тасралтгүй үргэлжлүүлэх, тухайн асуудлаар манай улсын төр, засгаас авч хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээг мэдээлэх, бусад улс орнуудтай хамтран ажиллаж, туршлага, мэдээлэл солилцоход үр дүнтэй арга хэрэгсэл болов.

4.3. Гадаад харилцааны асуудлаарх зөвлөгөө, лавлагаа, мэдээ танилцуулга

“Гадаад бодлого, парламент хоорондын харилцааны асуудлаар зөвлөгөө өгөх, лавлагаа, мэдээ, танилцуулгаар хангах” ажлын хүрээнд харилцааны асуудлаар баримт бичиг боловсруулах, орчуулах, уулзалт зохион байгуулах, хэлмэрчлэх, шаардлагатай мэдээллээр хангах болон байгууллагын дотоод үйл ажиллагаатай холбоотой бусад ажлуудыг тухай бүр хийж гүйцэтгэв.

Улсын Их Хурал болон Тамгын газрын удирдлагад ирүүлсэн захидал болон бусад баримт бичгүүдийг орчуулж танилцуулах, хариу бичгийн төсөл боловсруулж, албажуулан хүргүүлэх, Улсын Их Хурлын намрын болон хүндэтгэлийн чуулганы нээлтэд Улсын Их Хурлын даргын хэлэх үгийг орчуулах, хэлмэрчлэх, Улсын Их Хурлын дарга, гишүүдийн олон улсын хуралд хэлэх үгийг боловсруулж орчуулах, Улсын Их Хурлын удирдлага, Байнгын хорооны дарга болон Улсын Их Хурлын гишүүд хоёр талын уулзалт хийхэд уулзалт ярианы сэдэвт тусгах саналыг бэлдэж эцэслэх, шаардлагатай мэдээлэл, танилцуулга, лавлагаа бэлтгэн өгөх, уулзалтын үеэр хэлмэрчлэх, уулзалтын дараа ярианы тэмдэглэл гаргах зэрэг ажлуудыг тухай бүр хийж гүйцэтгэв.

Олон улсын Парламентын холбоо, Ази, Номхон далайн орнуудын парламентын чуулган зэрэг олон улс, бүс нутгийн байгууллагуудаас ирүүлсэн захидал, хурлын урилга, үзэл баримтлал, ерөнхий мэдээлэл, хөтөлбөр, хэвлэлийн мэдээ болон холбогдох бусад баримт бичгийн монголоос англи, англиас монгол хэлний орчуулгыг хийж гүйцэтгэв.

Улаанбаатар дахь Нэгдсэн Үндэстний байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагууд, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Азийн сан, Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, ЖАЙКА зэрэг олон улс, бүс нутгийн байгууллагууд болон Дипломат төлөөлөгчийн газруудтай тодорхой асуудлуудаар уялдаа холбоотой ажиллаж, харилцан мэдээлэл солилцов. Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганы нээлт, “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-ын 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын Хүндэтгэлийн хуралдаанд гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн болон Олон улсын байгууллагын Суурин төлөөлөгч нарыг урьж оролцуулав.

Улсын Их Хурлын дарга, дэд дарга, Байнгын хороодын дарга нар, Улсын Их Хурлын гишүүд болон Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Монгол Улсад суугаа гадаад улсын Элчин сайд нар, Олон улсын байгууллагын тэргүүн болон гадаадын дээд, өндөр хэмжээний зочид төлөөлөгчидтэй хоёр талын харилцааны болон цаг үеийн бусад асуудлаар хийсэн уулзалтыг тухай бүр зохион байгуулсан байна.

Улсын Их Хурлын дарга, гишүүдээс гадаад улсын парламентын дарга, гишүүдэд илгээлт, захидал, Улсын Их Хурлын Тамгын газрын удирдлагаас гадаад харилцаа, арга хэмжээтэй холбоотой захидал, албан бичиг, Гадаад харилцааны хэлтсээс Гадаад харилцааны яам, Элчин сайдын яамд болон холбогдох бусад байгууллага, газарт албан бичиг, цахим шууданг тухай бүр илгээсэн байна.

4.4. Дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу хууль тогтоох, төрийн эрх барих дээд байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг өргөжүүлж, төлөөлөх чадамж, үйл ажиллагааны цар хүрээг тэлэх, Монгол Улсын төрийн байгуулалд оруулж буй томоохон өөрчлөлтийг зөв зүйтэй хэрэгжүүлэх, бэлтгэл ажлыг хангах зорилгод нийцүүлэн Улсын Их Хурлын удирдлага, гишүүд парламентын ардчилал, парламентат ёс өндөр хөгжсөн улс орнуудын хууль тогтоох байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан нь үр дүнтэй боллоо.

Улсын Их Хурлын дарга Бүгд Найрамдах Солонгос Улсад, Улсын Их Хурлын дэд дарга, гишүүд Швейцарийн Холбооны Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Япон Улсад, мөн Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс, Европын Парламент, Австри Улсын парламентын төлөөлөгчид Монгол Улсад тус тус айлчилсан нь хамтын ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэхэд чухал ач холбогдолтой байв.

Олон улс, бүс нутгийн байгууллагуудын ээлжит хурал, чуулган, хэлэлцүүлэгт Улсын Их Хурлын дарга, гишүүд, Ерөнхий нарийн бичгийн дарга оролцож, олон талт хамтын ажиллагааг идэвхтэй өрнүүлсний зэрэгцээ эдгээр арга хэмжээний үеэр бусад орны парламентын төлөөлөгчидтэй хоёр талын уулзалтуудыг хийсэн нь хууль тогтоох байгууллагууд, тэдгээрийн Тамгын газар хоорондын итгэлцлийг бэхжүүлэх, уламжлалт найрсаг харилцааг үргэлжлүүлэн хөгжүүлэх зорилтоо амжилттай биелүүлээ.

Парламент хоорондын харилцаанд хоёр талын найрамдлын бүлгүүд онцгой чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд Улсын Их Хурал дахь найрамдлын бүлгийн дарга нар энэ чиглэлээр идэвх чармайлт гарган ажиллалаа. Бүлгийн дарга, гишүүд өөрсдийн санаачилгаар бусад улс орнуудын парламентын гишүүд, Элчин сайд нартай уулзаж, хоёр улсын харилцааны өнөөгийн асуудлууд болон цаг үеийн бусад асуудлаар ярилцаж, тодорхой санал, санаачилга дэвшүүлж ажилласан нь улс төрийн томоохон дэмжлэг болов.

Ээлжит чуулганы үеэр Улсын Их Хурлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлд хийгдсэн бүх айлчлал, уулзалт, арга хэмжээ Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөний холбогдох зорилтод бүрэн нийцэж буй юм.

V БҮЛЭГ

ХАВСРАЛТ

Нэг. БАТАЛСАН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ЖАГСААЛТ

1.1. Бие даасан хууль

1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай /2023.11.10/;
2. Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай /2023.11.10/;
3. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай /2023.11.10/;
4. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай /2023.12.07/;
5. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай /2023.12.07/;
6. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2023.12.08/;
7. Гэрийн тэжээвэр амьтны тухай /2023.12.08/;
8. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2023.12.08/;
9. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай /2024.01.12/;
10. Хүүхэд хамгааллын тухай /Шинэчилсэн найруулга/ /2024.01.17/;
11. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /2024.01.17/;
12. Органик бүтээгдэхүүний тухай /2024.01.17/.

1.2. Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

1. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.10.27/;
2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
3. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
4. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
5. Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
6. Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
7. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.11.10/;
8. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
9. Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
10. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
11. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
12. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.11.10/;
13. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.11.10/;

14. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.11.10/;
15. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
16. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
17. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
18. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
19. Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
20. Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
21. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
22. Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай /2023.11.10/;
23. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.11.10/;
24. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
25. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
26. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
27. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.12.07/;
28. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
29. Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
30. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
31. Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
32. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.12.07/;
33. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.12.07/;
34. Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
35. Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
36. Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
37. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.12.07/;
38. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
39. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
40. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
41. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын

- тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
42. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
 43. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
 44. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.12.07/;
 45. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.12.07/;
 46. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.12.07/;
 47. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
 48. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.12.07/;
 49. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
 50. Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.07/;
 51. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.08/;
 52. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.08/;
 53. Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.12.08/;
 54. Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.08/;
 55. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.12.08/;
 56. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.08/;
 57. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2023.12.08/;
 58. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.12.08/;
 59. Статистикийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.12.08/;
 60. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.12.08/;
 61. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.12.08/;
 62. Татварын ерөнхий тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2023.12.08/;
 63. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2023.12.08/;
 64. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2023.12.08/;
 65. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.12.08/;
 66. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2023.12.08/;
 67. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 68. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 69. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
-

70. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
71. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
72. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
73. Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
74. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
75. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
76. Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
77. Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
78. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
79. Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
80. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
81. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
82. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
83. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
84. Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
85. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
86. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
87. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
88. Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
89. Векселийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
90. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
91. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
92. Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
93. Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
94. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
95. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
96. Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
97. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
98. Далай ашиглах тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;

99. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
100. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
101. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
102. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
103. Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
104. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
105. Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
106. Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
107. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
108. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
109. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
110. Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
111. Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
112. Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
113. Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
114. Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
115. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
116. Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
117. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
118. Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
119. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
120. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
121. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд оруулах тухай /2024.01.12/;
122. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд оруулах тухай /2024.01.12/;
123. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
124. Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
125. Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
126. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
127. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;

128. Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 129. Нөхөрлөлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 130. Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 131. Органик хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 132. Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 133. Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 134. Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 135. Патентын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 136. Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 137. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 138. Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 139. Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 140. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 141. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 142. Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 143. Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 144. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 145. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 146. Төрийн бус байгууллагын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 147. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 148. Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 149. Усан замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 150. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 151. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 152. Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 153. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 154. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 155. Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 156. Хог хаягдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 157. Хоршооны тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 158. Хувийн хамгаалалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
-

159. Хувиргасан амьд организмын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 160. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 161. Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 162. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 163. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 164. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 165. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 166. Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 167. Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 168. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 169. Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 170. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 171. Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 172. Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 173. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 174. Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 175. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 176. Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 177. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.12/;
 178. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 179. Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.12/;
 180. Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
 181. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
 182. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
 183. Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
 184. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.17/;
 185. Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
 186. Хууль зүйн туслалцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
-

187. Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.17/;
188. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.17/;
189. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.17/;
190. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
191. Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
192. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
193. Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
194. Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
195. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.17/;
196. Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
197. Төмөр замын тээврийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
198. Иргэний нисэхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
199. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
200. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.17/;
201. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.17/;
202. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
203. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай /2024.01.17/;
204. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
205. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/;
206. Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /2024.01.17/.

1.3. Олон улсын гэрээ, хэлэлцээр соёрхон батлах тухай хууль

1. Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай /2023.12.15/;
2. Конвенцын нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай /2023.12.15/;
3. Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай /2024.01.11/;
4. Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай /2024.01.11/.

1.4. Хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль

1. Хүүхэд хамгааллын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай /2024.01.17/;
2. Органик хүнсний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай /2024.01.17/.

1.5. Улсын Их Хурлын тогтоол

1. Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийн тухай /2023.10.15, дугаар 78/;
 2. Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай /2023.10.12, дугаар 79/;
 3. Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөх тухай /2023.10.12, дугаар 80/;
 4. Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай /2023.10.12, дугаар 81/;
 5. Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоох тухай /2023.10.19, дугаар 82/;
 6. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай /2023.10.19, дугаар 83/;
 7. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.10.19, дугаар 84/;
 8. Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай /2023.10.20, дугаар 85/;
 9. Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай /2023.10.26, дугаар 86/;
 10. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай /2023.11.10, дугаар 87/;
 11. Тогтоолд нэмэлт оруулах тухай /2023.11.10, дугаар 88/;
 12. Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай /2023.11.10, дугаар 89/;
 13. Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай /2023.11.10, дугаар 90/;
 14. Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /2023.11.10, дугаар 91/;
 15. Авлигатай тэмцэх газрын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай /2023.11.10, дугаар 92/;
 16. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай /2023.11.10, дугаар 93/;
 17. Нийтийн өргөдлийн талаар авах арга хэмжээний тухай /2023.11.10, дугаар 94/;
 18. Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай /2023.11.16, дугаар 95/;
 19. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай /2023.11.16, дугаар 96/;
 20. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох, Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай /2023.11.16, дугаар 97/;
 21. Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилох тухай /2023.11.16, дугаар 98/;
 22. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай /2023.11.23, дугаар 99/;
 23. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2023.11.23, дугаар 100/;
 24. Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох /2023.11.23, дугаар 101/;
 25. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай /2023.11.30, дугаар 102/;
 26. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх тухай /2023.11.30, дугаар 103/;
-

27. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын даргаар томилох тухай /2023.11.30, дугаар 104/;
28. Хуулийн төсөл буцаах тухай /2023.11.30, дугаар 105/;
29. Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай /2023.12.01, дугаар 106/;
30. Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай /2023.12.07, дугаар 107/;
31. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай /2023.12.07, дугаар 108/;
32. Хуулийн төсөл буцаах тухай /2023.12.07, дугаар 109/;
33. Хуулийн төсөл буцаах тухай /2023.12.08, дугаар 110/;
34. Хуулийн төсөл буцаах тухай /2023.12.14, дугаар 111/;
35. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай /2023.12.21, дугаар 112/;
36. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай /2023.12.21, дугаар 113/;
37. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай /2023.12.22, дугаар 114/;
38. Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай /2023.12.22, дугаар 115/;
39. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай /2023.12.28, дугаар 116/;
40. Зарим байгууллагын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох /2023.12.28, дугаар 117/;
41. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай /2023.12.28, дугаар 118/;
42. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай /2023.12.28, дугаар 119/;
43. Монгол Улсын Ерөнхий аудиторыг үүрэгт ажлаас чөлөөлөх тухай /2023.12.28, дугаар 120/;
44. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, гишүүний цалингийн хэмжээг тогтоох тухай /2023.12.28, дугаар 121/;
45. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай /2024.01.04, дугаар 01/;
46. Хуулийн төсөл буцаах тухай /2024.01.04, дугаар 02/;
47. Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай /2024.01.11, дугаар 03/;
48. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнийг томилох тухай /2024.01.11, дугаар 04/;
49. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай /2024.01.12, дугаар 05/;
50. Бүгд Найрамдах Узбекистан Улсын нийслэл Ташкент хотод Монгол Улсын Элчин сайдын яам нээн ажиллуулах тухай /2024.01.12, дугаар 06/;
51. Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай /2024.01.12, дугаар 07/;
52. Зэвсэгт хүчний зэвсэг техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг батлах тухай /2024.01.16, дугаар 08/;

53. Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа, бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтад хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай /2024.01.16, дугаар 09/;
 54. “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компанийн хувьцааны талаар авах зарим арга хэмжээний тухай /2024.01.17, дугаар 10/;
 55. Засгийн газарт чиглэл өгөх тухай /2024.01.17, дугаар 11/;
 56. Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай /2024.01.17, дугаар 12/;
 57. Хянан шалгах түр хороо байгуулах тухай /2024.01.17, дугаар 13/;
 58. Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай /2024.01.17, дугаар 14/;
 59. Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүнийг томилох, гишүүнээс чөлөөлөх тухай /2024.01.17, дугаар 15/;
 60. Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай /2024.01.17, дугаар 16/;
 61. Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай /2024.01.17, дугаар 17/;
 62. Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2024.01.17, дугаар 18/.
-

Хоёр. БАТАЛСАН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТАНИЛЦУУЛГА

2.1. Бие даасан хууль

2.1.1. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ

БАТАЛСАН ОГНОО 2023.11.10	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.01.01
---------------------------------	--	---------------------------------------

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн талаар:

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 25,855,147.4 сая төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 34.9 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 27,360,535.7 сая төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 37.0 хувь болж, нэгдсэн төсвийн алдагдал 1,505,388.3 сая төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2.0 хувьтай тэнцүү байхаар батлагдлаа.

Төсвийн орлого:

Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 27,722,165.7 сая төгрөгөөр тооцож баталлаа.

Ирэх онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 7,386.6 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 182.5 ам.доллар байхаар тооцов. 2024 онд зэсийн баяжмалын орлогоос 441.9 тэрбум төгрөг, нүүрсний орлогоос 71.8 тэрбум төгрөг, нийт 513.7 тэрбум төгрөгийн орлогыг Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлэхээр тооцсон.

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1.2-т заасан Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.27-д зааснаас бусад орд ашигласнаас төсөвт төвлөрсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад үлдэх хэсгээс Ирээдүйн өв санд хуваарилах хувь 2024 онд 20, 2025 оноос 65 байхаар тусгасан.

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад үлдэх хэсгийн 20 хувийг 2024 онд, 65 хувийг 2025 оноос Ирээдүйн өв санд төвлөрүүлэхээр тусгасан. Ингэснээр ирэх 2024 онд Ирээдүйн өв санд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс 833.2 тэрбум төгрөг, ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болон төрийн өмчийн үйлдвэрийн газрын төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгаас 520.1 тэрбум төгрөгийг хуваарилж, нийт 1,353.3 тэрбум төгрөгийг тус санд төвлөрүүлэхээр тооцсон.

Төсвийн орлого бүрдүүлэлтийг татварын төрлөөр ангилбал:

/сая төгрөгөөр/

№	Татварын төрөл	2022 Гүйцэтгэл	2023 Батлагдсан	2024 Батлагдсан
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	2,556,218.7	2,972,554.3	4,130,973.4
2	Хувь хүний орлогын албан татвар	1,362,765.4	1,448,934.9	1,798,875.0
3	Онцгой албан татвар	847,805.1	972,000.0	991,000.0
4	Нэмэгдсэн өртгийн албан татвар	3,946,188.2	4,771,910.0	6,183,549.3
5	Гаалийн албан татвар	1,255,537.1	1,644,000.0	1,928,712.9
6	Хөрөнгийн албан татвар	237,587.1	197,326.0	237,467.0

1) Ирэх онд эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд сэргэж уул уурхайн экспорт өсөх хандлагатай байна гэж тооцон уул уурхайн салбарын аж ахуйн нэгжийн албан татварын орлогыг өнгөрсөн оноос 31.0 хувь өснө гэж тооцсон.

2) Засгийн газраас цалин хөдөлмөрийн хөлсийг инфляцын түвшинтэй уялдуулан цогцоор нь нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тооцож хувь хүний орлогын албан татварын орлогыг өнгөрсөн оноос 23.8 хувиар өснө гэж тооцсон.

3) 2024 оны төсвийн жилд эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, цахим төлбөрийн баримтын системийн хамрагдалтын түвшин, татварын суурийг тэлэх арга хэмжээ, өмнөх жилүүдийн гүйцэтгэл зэргийг харгалзан 2024 онд нэмэгдсэн өртгийн албан татварын орлогыг 2023 оны гүйцэтгэлээс 30 хувиар нэмэгдүүлэхээр тооцлоо.

4) Засгийн газрын өргөн мэдүүлсэн төслөөс олон жил хуримтлагдсан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрийн өрийг үе шаттай барагдуулах, төсвийн тогтвортой байдлыг хангах хүрээнд 2022 оноос өмнө хуримтлагдсан аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулахаар тооцож улсын төсвийн орлогыг 2.0 хувиар нэмэгдүүлсэн болно.

Төсвийн зарлага:

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 27,360,535.7 сая төгрөгөөр, үүнээс урсгал зарлагыг 21,221,866.4 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 6,273,326.8 сая төгрөгөөр, эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүнг 134,657.5 сая төгрөгөөр тус тус баталлаа.

№	Зарлагын төрөл	2021 Гүйцэтгэл	2022 Гүйцэтгэл	2023 Батлагдсан	2024 Батлагдсан
1	Цалин, хөлс	2,531,733.2	1,666,291.0	1,890,710.1	5,516,866.1
2	Бараа, үйлчилгээний бусад зардал				
2.1	Томилолт, зочны зардал	19,998.5	28,720.9	31,848.5	53,877.4
2.2	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	271,275.2	318,184.6	397,699.9	547,255.4
2.3	Хангамж, бараа материалын зардал	187,517.9	182,277.1	89,776.7	200,223.9
2.4	Нормативт зардал	262,287.3	229,320.8	204,974.9	311,361.4
2.5	Эд хогшил, урсгал засварын зардал	119,023.6	121,255.7	63,020.6	121,816.5
2.6	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	805,600.9	784,786.8	1,094,521.8	1,360,668.3
2.7	Бараа үйлчилгээний бусад зардал	504,543.5	475,135.6	416,297.1	771,881.0
3	Татаас ба урсгал шилжүүлэг				
3.1	Татаас	453,698.2	537,068.2	634,281.3	622,848.5
3.2	Урсгал шилжүүлэг	6,812,580.5	9,088,492.0	9,243,778.5	10,541,447.8
4	Хөрөнгийн зардал				
4.1	Барилга байгууламж	1,941,065.6	2,923,510.2	3,702,101.9	4,262,636.1
4.2	Их засвар	128,506.7	142,886.3	168,693.8	172,709.7
4.3	Тоног төхөөрөмж	409,369.0	239,778.5	512,851.6	540,473.3
4.4	Бусад хөрөнгө	487,880.4	489,149.8	967,180.1	1,287,127.9
4.5	Стратегийн нөөц хөрөнгө	1,019,416.8	8,079.7	8,879.7	10,379.7
5	Эргэж төлөгдөх зээл	-311,651.5	-155,771.7	-131,950.3	-134,657.5

Нэгдсэн төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төслийн нийт зарлагын зээлийн хүүгийн төлбөр, үйл ажиллагааны орлогоос бүрэн санхүүждэг зардлаас бусад урсгал зардлыг 1.88 хувиар буюу 320,416.0 сая төгрөгөөр бууруулж, мөн Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог татан буулгасантай холбогдуулан Эрчим хүчний сайдын төсвийн багцын урсгал зардлыг 25,738.2 сая төгрөгөөр бууруулсан.

Харин хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх шаардлагатай зарим урсгал зардлын төлөвлөсөн төсөв хүрэлцэхгүй, үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж болзошгүй гэж үзэж Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсөлд тусгагдсан зарим төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлыг нэмэгдүүлэн баталлаа. Тухайлбал:

1) Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны ажлын албаны үйл ажиллагааны урсгал зардлыг 1,000.0 сая төгрөгөөр;

2) Улсын төсвөөс Говьсүмбэр аймагт олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг 1,000.0 сая төгрөгөөр;

3) Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороог татан буулгасантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын орчны бохирдлыг бууруулах үйл ажиллагааны зардлыг 26,238.2 сая төгрөгөөр;

4) Орон нутаг, хөдөөгийн багуудын хөгжил, үйл ажиллагааг дэмжих зорилгоор хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд зориулж Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын сум, багийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зардлыг Төв аймагт 300.0 сая төгрөг, Ховд аймагт 300.0 сая төгрөгөөр тус тус;

5) Аймгийн номын сангийн номын фондыг баяжуулах зорилгоор Соёлын сайдын төсвийн багцын номын зардлыг Төв аймагт 100.0 сая төгрөгөөр;

6) Сэлэнгэ аймгийн ерөнхий боловсролын сургуулийн номын сангийн фондыг баяжуулах зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын номын зардлыг 175.0 сая төгрөгөөр;

7) Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын 2016 оноос хойш нэмэгдүүлээгүй цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн багцын цалингийн санг 233.0 сая төгрөгөөр, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн төсвийн багцын цалингийн санг 640.5 сая төгрөгөөр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын цалингийн санг 11,100.1 сая төгрөгөөр, Шүүхийн сахилгын хорооны даргын төсвийн багцын цалингийн санг 198.1 сая төгрөгөөр, Улсын ерөнхий прокурорын төсвийн багцын цалингийн санг 17,506.1 сая төгрөгөөр тус тус, нийт 29,677.8 сая төгрөгөөр;

8) Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг 800.0 сая төгрөгөөр;

9) Удирдлагын академид төрийн албан хаагчдыг сургах, хөгжүүлэх, чадавхжуулах үйл ажиллагаатай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын төсвийн багцын урсгал зардлыг 3,561.7 сая төгрөгөөр;

10) Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн урвалж бодисын зардалд зориулан Шадар сайдын төсвийн багцын урсгал зардлыг 500.0 сая төгрөгөөр;

11) Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын төсвийн багцын урсгал зардлыг 8,108.0 сая төгрөгөөр;

12) 2024 онд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын төсвийн багцын Нийгмийн даатгалын санд олгох татаасыг 140,661.6 сая төгрөгөөр;

13) Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тогтмол зардлыг санхүүжүүлэхтэй холбоотойгоор аймгуудын тогтмол зардлыг 14,200.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталлаа.

Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн талаар:

Улсын Их Хурлаас 2023 оны долдугаар сарын 07-ны өдөр Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулиудыг шинэчлэн баталсан. Тус хуулиудын хэрэгжилтийг хангах, тэтгэврийн хэмжээг 2024 оны дөрөвдүгээр сараас 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг төсөвт тусгасан.

Нийгмийн даатгалын санд нийт 5,893.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрөхөөр баталлаа. Энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад 1,718.1 тэрбум төгрөгөөр нэмэгдэж байна. Ирэх онд нийгмийн даатгалын тухай хуулиудын шинэчлэлийн хүрээнд нийгмийн даатгалын хамрах хүрээ нэмэгдэх, төрийн албан хаагчийн цалин хөлс болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой дундаж цалин өсөх, орлогын боломжит бусад эх үүсвэр нэмэгдэх төсөөлөлтэй байна. Уг санд улсын төсвөөс 1,175.0 тэрбум төгрөг олгоно.

Нийгмийн даатгалын сангийн зарлагыг 5,188.4 тэрбум төгрөгөөр баталлаа. Энэ нь иргэдийн тэтгэвэр, тэтгэмжид зарцуулах хөрөнгийг 2023 онтой харьцуулахад 1,035.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн тооцсон дүн юм. Энэ нь 2023 оны төсвийн тодотголоор хэрэгжүүлсэн арга хэмжээг 2024 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, тэтгэвэр инфляцын түвшинтэй уялдуулан дахин нэмэгдүүлэх болон шинэчлэн батлагдсан хуулийн хэрэгжилтийг хангахад зориулсан болно.

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн талаар:

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн орлогыг 1,964.8 тэрбум төгрөг байхаар баталлаа. Үүний 1,070.9 тэрбум төгрөгийг улсын төсвөөс олгоно.

Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад нэг иргэнээр тооцон олгох санхүүжилтийг нэмэгдүүлж 359.4 тэрбум төгрөг тусгасан.

Эмийн үнийн хөнгөлөлтөд олгох санхүүжилтийг 47.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 137.3 тэрбум төгрөгөөр баталлаа.

2.1.2. НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ, ГЭР ХОРООЛЛЫГ ОРОН СУУЦЖУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

**БАТАЛСАН
ОГНОО**
2023.12.07

ТӨСӨЛ САНААЧИЛСАН

Засгийн газраас 2023.10.31-ний өдөр өргөн
мэдүүлсэн.

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**
2024.12.15

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах нийгэм болон хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүднээс Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд дараах зохицуулалтыг тусгасан. Үүнд:

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨН X ГЭР ХОРООЛЛЫГ ОРОН СУУЦЖУУЛАХ

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний эрчмийг нэмэгдүүлэх, гэр хорооллыг орон сууцжуулахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тусгалаа.

1



“ЗАМЫН
ХӨДӨЛГӨӨНИЙ
ТҮГЖРЭЛ”



“НИЙГМИЙН
ЗАЙЛШГҮЙ
ХЭРЭГЦЭЭ”



ЗОГСООЛЫН МЕНЕЖМЕНТ

авто зогсоолын төрөл, нийтлэг шаардлагыг хотын стандартаар тогтоох, авто зогсоолын менежментийг сайжруулах, нэгдсэн системтэй болгох зохицуулалтыг тодорхой болголоо.

2

зэрэг нэр томъёог тодорхой болгож, хуулийн үйлчлэх хүрээг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэр байхаар тогтоож өгсөн.

3



ДУГААРЫГ ХЯЗГААРТАЙГААР ОЛГОХ

нийслэл хотод олгох тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дээд хязгаарыг нийслэлийн ЗД-ын саналыг үндэслэн НИТХ-аас тогтоож байх зохицуулалтыг тусгалаа.



70-ААС ДООШГҮЙ ХУВИЙН ДЭМЖЛЭГ

газар чөлөөлөх үндэслэлийг тодорхойлж, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч иргэн, хуулийн этгээдийн 70-аас доошгүй хувийн дэмжлэгийг авсан байхаар хуульчиллаа.

4

5



1) Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн төрөл хүртээмжийг нэмэгдүүлж, авто зогсоолын ашиглалтыг сайжруулах замаар замын хөдөлгөөний эрчмийг нэмэгдүүлэх, агаарын болон хөрсний бохирдлоос үүсэх нийгэм, эдийн засгийн нөлөөллийг бууруулахад анхаарч гэр хорооллыг орон сууцжуулахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тусгалаа.

2) “Замын хөдөлгөөний түгжрэл”, “Нийгмийн зайлшгүй хэрэгцээ” зэрэг нэр томъёог тодорхой болгож, хуулийн үйлчлэх хүрээг Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэр байхаар тогтоож өгсөн.

3) Нийслэлийн замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах зорилгоор авто зогсоолын төрөл, тэдгээрт тавигдах нийтлэг шаардлагыг хотын стандартаар тогтоох, авто зогсоолын менежментийг сайжруулах, нэгдсэн системтэй болгох зохицуулалтыг тодорхой болголоо.

Авто зогсоолын менежментийг зөв зохистой хэрэгжүүлснээр иргэд авто замын зорчих хэсгийн дагуу хөдөлгөөнд саад учруулж олон цагаар үнэ төлбөргүй автомашинаа байршуулах явдлыг цэгцэлж, авто зогсоолыг төв замд бус замын хөдөлгөөний эрчим багатай холбоос замд байршуулах ажлыг төлөвлөх боломжтой болохоос гадна хяналтын төхөөрөмжийн тусламжтайгаар зогсоолын дүүргэлт, багтаамж, хүчин чадлыг харгалзан ойролцоох зогсоолыг санал болгох мэдээллийн тогтолцоо бий болох нөхцөл бүрдэх юм.

4) Авто замын түгжрэлийг зохицуулах дараагийн арга хэмжээ нь нийслэл Улаанбаатар хотод олгох тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарыг хязгаартайгаар олгох зохицуулалт бөгөөд тээврийн хэрэгслийн өсөлт, авто замын сүлжээний нягтрал, замын хөдөлгөөний түгжрэлийг харгалзан нийслэл хотод олгох тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дээд хязгаарыг нийслэлийн Засаг даргын саналыг үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоож байх зохицуулалтыг тусгалаа.

5) Мөн нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх үндэслэлийг тодорхойлж, уг шийдвэрийг гаргахад иргэдийн оролцоог ханган тухайн төсөл, арга хэмжээний нөлөөлөлд өртөж байгаа газар өмчлөгч, газар эзэмших эрхтэй этгээд, улсын бүртгэлд бүртгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч иргэн, хуулийн этгээдийн 70-аас доошгүй хувийн дэмжлэгийг авсан байхаар, түүнчлэн хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан байршилд заасан гэр хорооллыг нэн түрүүнд орон сууцжуулах, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд заасан хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх, тус үйл ажиллагааг нийслэлийн өмчит гэр хорооллыг орон сууцжуулах байгууллага хэрэгжүүлэхээр хуульчилсан.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуультай хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийслэл хотын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг баталсан болно.

Мөн “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсан бөгөөд тогтоолоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан. Үүнд:

1) Улсын Их Хурлын 1995 оны 26 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 3-т заасан Богдхан уулын дархан цаазат газрын хилийн заагийн хэмжээг бууруулахгүйгээр хилийн цэст өөрчлөлт оруулах асуудлыг судлан шийдвэрлүүлэх, уг нутаг дэвсгэрт үүссэн суурьшлын бүсийг нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн иргэдийн хотын нийтийн аж ахуйн үйлчилгээ авах эрхийг хангах арга хэмжээ авах;

2) Улсын хэмжээнд нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар албадан чөлөөлөхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг бий болгох зорилгоор хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх;

3) Нийслэл Улаанбаатар хотын орон сууцны байшингийн цахилгаан шатны болон дулааны техникийн шинэчлэл /фасад, дээвэр, босоо шугам, хаяавч, узель/-д шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлэх;

4) Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг 2023 оны 12 дугаар сард багтаан боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5) Зөвшөөрөлгүй нийтийн тээвэр, таксины үйлчилгээ эрхэлсэн бол Зөрчлийн тухай хуулийн дагуу торгох шийтгэл нь цахим платформд бүртгэлтэй зорчигч тээвэрлэдэг иргэнд хамаарахгүй байхаар зохицуулах зэрэг болно.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул хууль санаачлагчид буцаасан болно.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуулийг 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр баталсан.

Хамт батлагдсан Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг 2024 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс, бусад хуулийг Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, баталгаажуулах үндсэн эрх хангагдах боломж бүрдэх юм.

2.1.3. ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬ

<p>БАТАЛСАН ОГНОО</p> <p>2023.12.08</p>	<p>ТӨСӨЛ САНААЧИЛСАН</p> <p>Их Хурлын гишүүдээс 2022.09.26-ны өдөр өргөн мэдүүлсэн.</p>	<p>ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА</p> <p>2024.01.01</p>
---	--	---



Гэрийн тэжээвэр амьтны
тухай анхдагч хууль нь 9 бүлэг
41 зүйлтэй бөгөөд уг хуулиар

**ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТАН БУЮУ
НОХОЙ, МУУР, ТЭДГЭЭРТЭЙ АДИЛТГАХ
БУСАД АМЬТАНТАЙ ХОЛБОГДОХ
ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛНА.**

Гэрийн тэжээвэр амьтны тухай хуульд дараах онцлог зохицуулалтыг тусгасан. Үүнд:

Асран хамгаалагчид тавигдах шаардлага,
Асран хамгаалагчийн эрх, үүрэг, хариуцлага



Гэрийн тэжээвэр
нохой, муурыг
бүртгэлд хамруулах



Бичил чип
суулгах,



Нохой муурын
асран хамгаалагчийн
сургалт



Засаг дарга
харьяа нутаг дэвсгэртээ
нохой, муурын асран
хамгаалагчийн бүртгэл
хөтлөх



Цагдаагийн
байгууллага нь
алдагдсан гэрийн
тэжээвэр амьтны
талаарх бүртгэл



Нохой, муур үржүүлэх
үйл ажиллагаа эрхлэх,
гэрийн тэжээвэр
амьтныг хүчирхийллээс
хамгаалах



Гэрийн тэжээвэр
амьтны талаарх төрийн
байгууллагын чиг
үүрэг



Гэрийн тэжээвэр
амьтны тухай хуультай
хамт холбогдох
хуулиудыг баталлаа.

Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль батлагдсанаар гэрийн тэжээвэр амьтны асран хамгаалагчийн үүрэг хариуцлага нэмэгдэж, нийтийн эрүүл мэнд, иргэдийн аюулгүй байдал хамгаалагдахаас гадна нохой, муурын хяналтгүй үржүүлэг багасч, эзэнгүй амьтны тоо толгой буурах, нохой, мууртай харгис хэрцгий хандсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэдэг болох эрх зүйн орчин бүрдсэн.

2.1.4. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ

<p>БАТАЛСАН ОГНОО</p> <p>2024.01.12</p>	<p>ТӨСӨЛ САНААЧИЛСАН</p> <p>Засгийн газраас 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн.</p>	<p>ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА</p> <p>2024.04.01</p>
---	--	---

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН АНХАН ШАТНЫ НЭГЖЭЭС ЭХЛЭН

**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ**

**ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ
БОЛГОН ХЭРЭГЖҮҮЛНЭ.**



**ЭРҮҮЛ МЭНДИЙН
БОЛОВСРОЛ ОЛГОХ ХӨТӨЛБӨР**



**МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БОДЛОГОД ТУСГАЖ,
ХЭРЭГЖҮҮЛНЭ.**

Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт зааснаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эмнэлгийн тусламж, үйлчилгээ гэсэн хоёр төрөлтэй байх бөгөөд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгож төрөөс хүн амд үзүүлэх эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэхээр хуульчилсан байдаг. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль 2016 онд батлагдан хэрэгжиж байгаа ч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэргүүлэх чиглэл болгосон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэрэгжүүлэх нарийвчилсан зохицуулалт бүхий бие даасан хууль, эрх зүйн орчин шаардлагатай байсан юм.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар дараах харилцааг зохицуулна. Үүнд:

1) Эрүүл мэндийн байгууллагын анхан шатны нэгжээс эхлэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хэрэгжүүлнэ.

2) Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох хөтөлбөр, баримт бичгийн төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу боловсруулж, Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгаж, хэрэгжүүлнэ.

3)

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭГ ДАРААХ ТӨРЛӨӨР ҮЗҮҮЛНЭ.

- ХАЛДВАРТ БОЛОН ХАЛДВАРТ
БУС ӨВЧНИЙ ХЯНАЛТ;

- ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД;

- ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД;

- ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ШИМ СУДЛАЛ;

- НИЙГЭМ, СЭТГЭЦ - ЗАН ҮЙЛ;

- НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД;

- НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ЛАБОРАТОРИ;

- НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НОЦТОЙ
БАЙДЛЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ.

4) Нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан эрүүл мэндийн мэргэжилтний эрх, нийгмийн баталгааг эдэлнэ.

5)



НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ОРОН ТООНЫ БУС ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ



ЕРӨНХИЙ САЙДЫН
ДЭРГЭД АЖИЛЛАНА.

6) Төрийн захиргааны төв байгууллага бүр нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний асуудлыг бодлого, үйл ажиллагаандаа тусгаж, хэрэгжүүлэх бөгөөд жил бүрийн хэрэгжилтийн тайланг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгтгэн, Нийгмийн эрүүл мэндийн орон тооны бус үндэсний зөвлөлд хүргүүлж, хэлэлцүүлнэ.

7) Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах асуудлаар хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

8)

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА НЬ ДАРААХ ТӨРӨЛТЭЙ

- НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ҮНДЭСНИЙ ТӨВ;

- АЙМАГ, ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ;

- ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ;

- ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭГЖ, АЛБА;

- АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА.

9) Нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан үндэсний төвийн дүрмийг Засгийн газар, бүтцийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Аймаг, дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц, дүрмийг хүн амын төвлөрөл, газар нутгийн байршлыг харгалзан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, удирдлагыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга томилж, чөлөөлнө. Эрүүл мэндийн тухай хуулийн 15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.11, 15.1.12, 15.1.13-т заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн нэгж, албатай байна. Харин хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, боловсролын сургалтын байгууллага нь нийгмийн эрүүл мэндийн нэгж, алба, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнийг ажиллуулж болно.

10) Эрүүл мэндийн ноцтой байдал үүссэн тохиолдолд Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв тохиолдлын удирдлагын тогтолцоонд шилжиж ажиллах бөгөөд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн байгууллагыг арга зүйгээр хангаж ажиллана.

11) Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ нь ил тод байх бөгөөд түүнд олон нийтийн оролцоог хангах, хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байна.

12) Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн даатгалын болон Эрүүл мэндийг дэмжих сан, хандив, тусламж, дэмжлэг, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлж болох бөгөөд бусад бүх тохиолдолд нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль хэрэгжиж эхэлснээр эрүүл мэндийн байгууллага иргэдэд өвчилсөн хойно нь эрүүл

мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэхээс илүүтэйгээр тэдэнд өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндээ хамгаалах, эрүүл дадал хэвшилтэй, эрүүл мэндийн боловсролтой байх асуудлаар тусламж, үйлчилгээ үзүүлж, үүний үр дүнд хүн амын дундаж наслалт дээшлэх, өвчлөл, нас баралтын тоог буурах, улмаар эрүүл мэндийн салбарт төрөөс зарцуулах санхүүжилт багасах эерэг үр дүн гарах ач холбогдолтой юм.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай болон хамт баталсан хуулиудыг 2024 оны дөрөвдүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2.1.5. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/

БАТАЛСАН ОГНОО 2024.01.17	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.09.01
---	--	---

Хуулийн зорилго нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, хүүхэд хамгаалалд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн хамгаалуулах эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад оршино.

Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д дараах онцлог зохицуулалтыг нэмж тусгалаа. Үүнд:

1) Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдийг үл хайхарсны улмаас хүүхэд бие махбод, сэтгэл санаа, бэлгийн дарамт, бэлгийн хүчирхийлэлд өртөх, гэмт хэргийн улмаас хохирсон, нас барсан хүүхдийн тоо жил бүр нэмэгдэж, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн иргэдийн 68 хувийг хүүхэд эзэлж байна. Хүүхэд хамгааллын үйлчилгээг эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд бүрд чанартай, хүртээмжтэй хүргэх, эцэг, эх хүүхдээ үл хайхрахыг хориглосон заалтыг тусгасан.

ТҮР ХАМГААЛАХ БАЙР,
НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВӨӨР
ҮЙЛЧЛҮҮЛСЭН ИРГЭДИЙН

68%-ийг
ХҮҮХЭД ЭЗЭЛЖ БАЙНА.

2) Эцэг, эхийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, хүүхдийн дэргэд согтууруулах ундаа хэрэглэх, эсхүл хэрэглэсэн үедээ хүүхдийн амьдарч, суралцаж байгаа орчин, орон байранд нэвтэрснийг хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсантай адилтгаж үзэхээр болов.



3) Боловсролын орчин дахь хүүхэд хамгааллын хүрээг өргөжүүлж, боловсролын сургалтын байгууллага, сүм хийдийн дэргэдэх шашны сургуульд суралцаж байгаа хүүхдийн эрхийг хамгаалах асуудлыг тусгасан. Хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, зөвлөгөө өгөх, хүүхэд бүрийн нийгэм, сэтгэл зүйн асуудлыг илрүүлэх, тандан судлах, хүүхэд тодорхойгүй шалтгаанаар хичээлдээ ирээгүй тохиолдолд гэр бүл, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид даруй мэдэгдэхийг боловсролын сургалтын байгууллагын холбогдох ажилтанд үүрэг болголоо.

Боловсролын сургалтын байгууллага үе тэнгийн дээрэлхэлт үйлдсэн болон хохирогч хүүхэдтэй хэрхэн харилцах, сургуулийн удирдлагын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээний хэлбэрийг өөрчилсөн. Үе тэнгийн дээрэлхэлт үйлдсэн хүүхэдтэй ганцаарчилсан уулзалт хийж, түүнд зөвлөгөө өгөх, хохирогч суралцагчаас уучлалт гуйлгуулах, сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүлэх, хүүхдийн төлөвшилд нөлөөлөх сургалт, үйл ажиллагаанд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт хамруулах зохицуулалтыг тусгасан.

Мөн боловсролын сургалтын байгууллага, насан туршийн суралцахуйн төвд суралцаж байгаа хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын нөхцөл байдлын тандалт судалгааг гурван жил тутам боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага хийх зохицуулалтыг оруулсан болно.



БОЛОВСРОЛЫН ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХҮРЭЭГ ӨРГӨЖҮҮЛЖ,



slovenliness

ЭРСДЭЛТ
НӨХЦӨЛИЙН ҮНЭЛЭХ,
ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ



ignoring

СЭТГЭЛ ЗҮЙН
АСУУДЛЫГ ИЛРҮҮЛЭХ,
ТАНДАН СУДЛАХ



bullying

ДЭЭРЭЛХЭЛТЭД ӨРТСӨН
ХҮҮХДЭД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭ

МӨН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА, НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВД
СУРАЛЦАЖ БАЙГАА ХҮҮХДИЙН ЭРХ, ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАНДАЛТ
СУДАЛГААГ ГУРВАН ЖИЛ ТУТАМ БОЛОВСРОЛЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, АРГА ЗҮЙН
БАЙГУУЛЛАГА ХИЙХ ЗОХИЦУУЛАЛТЫГ ОРУУЛСАН

4) Хүүхдийн цахим орчин дахь зохистой хэрэглээг дэмжих, цахим орчинд хүүхдийг эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчны үйлчилгээ эрхлэгч өөрийн үйлчилгээнд хориотой агуулгыг түгээхгүй байх, хүүхдэд хортой агуулгыг хянах, хязгаарлах, хаах арга хэмжээ авахыг үүрэгжүүлэв.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч өөрийн сүлжээнд хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхүйц хориотой, хортой контентыг хязгаарлах, контентын ангиллын тэмдэглэгээг олон нийтэд түгээхийн өмнө байршуулах, насанд хүрэгчдэд зориулсан тохиргоог идэвхжүүлэх боломжоор хэрэглэгчийг хангасан байна.

Хүн, хуулийн этгээд хэвлэл мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчинд хориотой агуулга түгээснээс хүүхдийн эрх зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй гэж үзвэл гомдлоо хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн байгууллагад гаргаж, шийдвэрлүүлэх бөгөөд хүүхдийг цахимаар урхидах, дээрэлхэх, дарамталсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл ногдуулахаар хуульчилсан.



ХҮҮХДИЙН ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ,

ХҮҮХДИЙН ЦАХИМ ОРЧИН
ДАХЬ ЗОХИСТОЙ
ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ,

ЦАХИМ ОРЧИНД ХҮҮХДИЙГ
ЭРСДЭЛТ НӨХЦӨЛӨӨС
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,

ХОРИОТой АГУУЛГЫГ
ТҮГЭЭХГҮЙ БАЙХ,

ХҮҮХДЭД ХОРТОЙ
АГУУЛГЫГ ХЯНАХ,

ХҮҮХДИЙГ ЦАХИМААР
УРХИДАХ, ДЭЭРЭЛХЭХ,
ДАРАМТАЛСАН
ТОХИОЛДОЛД ЗӨРЧЛИЙН
ТУХАЙ ХУУЛИАР ТОРГОХ
ШИЙТГЭЛ НОГДУУЛАХААР
ХУУЛЬЧИЛСАН.



5) Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үед хүүхдийг насанд хүрсэн хүнд харгалзуулалгүйгээр орхих, хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахаас бусад тохиолдолд хүүхдийг байгаа газраас нь авч явах, тээвэрлэхийг хориглосон.

6) Хүүхдийн эсрэг болон хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээсэн хүнийг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байгууллагад ажиллуулах, хүүхэдтэй холбоотой ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглосон.

7) Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцох эрхийг баталгаажуулж өгсөн.

8) Засгийн газрын гишүүн бүр эрхлэх асуудлын хүрээнд салбарын хүүхэд хамгааллын үйлчилгээ, төрийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулах арга хэмжээ авахыг хуульчилсан болно.

9)



ХҮҮХДИЙН ЭРХ АШГИЙГ ЭРХЭМЛЭН ДЭЭДЭЛЖ, ЭРСДЭЛТ НӨХЦӨЛД БАЙГАА ХҮҮХДИЙГ НЭН ТЭРГҮҮНД ГЭР БҮЛИЙН ОРЧИНД БАЙЛГАХ, ХҮҮХДИЙГ ГЭР БҮЛЭЭС НЬ ТУСГААРЛАСАН ТОХИОЛДОЛД АЛЬ БОЛОХ АХ, ЭГЧ, ДҮҮТЭЙ НЬ ХАМТ, ТӨРӨЛ САДНЫ БОЛОН АСРАЛТ ГЭР БҮЛД АСРАН ХҮМҮҮЖҮҮЛЭХ ЗАРЧМЫГ БАРИМТЛАХААР ХУУЛЬД ТУСГАЛАА.

Хүүхэд хамгааллын тухай хууль батлагдсанаар дараах ач холбогдолтой. Үүнд:

1) Хүүхэд хамгааллын асуудлаарх төрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг тодорхой болж, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд бүрд хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.

2) Хуульд хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин, үйл явц, төрөл, хэлбэрийг тодорхойлж, хүүхэд хамгаалалд шаардагдах төсвийг тусгаснаар хүүхэд бүрд чанартай, хүртээмжтэй хүүхэд хамгааллын цогц үйлчилгээг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

3) Хүүхэд хамгааллын кейс менежментийн алхмыг тодорхойлж, мэргэжлийн удирдлагын чиг үүргийг хуульчилснаар хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг цаг алдалгүй, үр дүнтэй хүргэх, хүүхдийн сайн сайхан байдлыг дэмжих, үр дүнг үнэлэх, хянах механизм сайжирна.

4) Магадлан итгэмжлэгдсэн, мэргэшсэн төрийн бус байгууллагаар хүүхэд хамгааллын үйлчилгээг хүүхдэд хүргэх, сум, хороонд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтантай болсноор хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилт анхан болон дунд шатанд сайжирч, хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэнэ.

5) Салбар бүр хүүхэд хамгааллын бодлоготой байхыг хуульчилж өгснөөр хүүхдийн эсрэг хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлага, хариуцлага нэмэгдэж, Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажил олгогч бүр ажилтныхаа хүүхдэд ээлтэй хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхэд бүрд оруулах хөрөнгө оруулалт нэмэгдэж, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад бодит хувь нэмрээ оруулах болно.

2.1.6. ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/

<p>БАТАЛСАН ОГНОО</p> <p>2024.01.17</p>	<p>ТӨСӨЛ САНААЧИЛСАН</p> <p>Улсын Их Хурлын гишүүдээс 2023.03.16-ны өдөр өргөн мэдүүлсэн.</p>	<p>ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА</p> <p>2025.01.01</p>
---	--	---



5% - органик хүнс

Монгол Улс 2030 он гэхэд хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн **ТАВАН ХУВИЙГ** органик аргаар үйлдвэрлэх зорилт тавьсан.

Органик бүтээгдэхүүний тухай хуулиар органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, баталгаажуулах, бүртгэх, органик болохыг илэрхийлсэн тэмдэг хэрэглэх, сурталчлах, худалдаалах, органик үйлдвэрлэл эрхлэгчид төрөөс дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

Органик бүтээгдэхүүний тухай /шинэчилсэн найруулга/ хууль таван бүлэг, 19 зүйлтэй.

ОРГАНИК ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ОРГАНИК ҮЙЛДВЭРЛЭЛ ЭРХЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ, ОРГАНИК ҮЙЛДВЭРЛЭЛД ХОРИГЛОХ ЗҮЙЛ ЗЭРГИЙГ ТУСГАСАН.



бүтээгдэхүүн нийлүүлэгчээс түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авахдаа органик болохыг тодорхойлсон **баталгаа шаардах**,




баталгаажуулалтын байгууллагыг өөрөө сонгох, хамтын баталгаажуулалтын байгууллагын **гишүүнээр элсэх хүсэлт гаргах**

1) Нэр томьёо, органик үйлдвэрлэлд баримтлах зарчмыг тодорхой болгосноор органик бүтээгдэхүүн нь органик бус бүтээгдэхүүнтэй холилдохоос урьдчилан сэргийлэх, органик үйлдвэрлэлд хэрэглэхийг зөвшөөрсөн бодис хэрэглэх, органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээг хэрэглэх талаар тодорхой тусгасан.

2) Органик үйлдвэрлэл эрхлэгчид тавигдах шаардлага, органик үйлдвэрлэл эрхлэгчийн эрх, үүрэг, органик үйлдвэрлэлд хориглох зүйл зэргийг тусгасан. Тухайлбал, органик үйлдвэрлэл эрхлэгч нь бүтээгдэхүүн нийлүүлэгчээс түүхий эд, бүтээгдэхүүнийг худалдан авахдаа органик болохыг тодорхойлсон баталгаа шаардах, баталгаажуулалтын байгууллагыг өөрөө сонгох, хамтын баталгаажуулалтын байгууллагын гишүүнээр элсэх хүсэлт гаргах, шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнийг мэдээллийн санд бүртгүүлэх, мал, амьтан, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, түүхий эд, бүтээгдэхүүний байгалийн шинж чанарыг хадгалах үйлдвэрлэлийн арга технологи боловсруулж ажиллах зэрэг эрх үүргийг хуульчилсан.

3) Органик бүтээгдэхүүний баталгаажуулалт, баталгаажуулалтын байгууллагын эрх, үүрэг, органик бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн сан, органик бүтээгдэхүүн болохыг илэрхийлсэн гэрчлэх тэмдэг хэрэглэх зэргийг нарийвчилсан зохицуулсан.

4) Органик үйлдвэрлэлийн бодлого хэрэгжүүлэх төрийн байгууллагын бүтэц, чиг үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, батлагдах журам, стандарт, аргачлалын талаар, органик бүтээгдэхүүний худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчид төрөөс үзүүлэх дэмжлэг, урамшууллын талаар тусгалаа. Тухайлбал, Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдаалах импортын органик бүтээгдэхүүн нь экспортлогч улсын эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаас олгосон органик болохыг тодорхойлсон гэрчилгээтэй байх, импортын органик бүтээгдэхүүнийг жижиглэн савласан тохиолдолд шошго нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нийцсэн байх, органик бүтээгдэхүүнийг бөөнөөр нийлүүлсэн тохиолдолд шошгоны мэдээлэл жижиглэн савласан органик бүтээгдэхүүний шошгоны мэдээлэлтэй ижил байх зэрэг зохицуулалтыг тусгасан.



шилжилтийн үеийн болон органик бүтээгдэхүүнийг мэдээллийн санд бүртгүүлэх,



мал, амьтан, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, байгалийн шинж чанарыг хадгалж боловсруулах

МӨН ТҮҮНЧЛЭН ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭГЧИД ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ,
УРАМШУУЛАЛД ДАРААХ ЗҮЙЛИЙГ ТУСГАСАН. ҮҮНД:

БҮРТГЭЛТЭЙ ОРГАНИК БОРДООГ
ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙ, ХҮЛЭМЖИНДЭЭ
АШИГЛАСАН ТОХИОЛДОЛД

БОРДОО ХУДАЛДАН АВСАН
ЭХНИЙ ГУРВАН ЖИЛИЙН ЗАРДЛЫГ
ТӨРӨӨС ДЭМЖИХ

БАТАЛГААЖСАН, МЭДЭЭЛЛИЙН САНД
БҮРТГЭЛТЭЙ ОРГАНИК БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ
ЭКСПОРТОЛСОН ТОХИОЛДОЛД

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ЗОРИУЛАН
АРИЛЖААНЫ БАНКНААС АВСАН
ЗЭЭЛИЙН 50-ИААС ДООШГУЙ ХУВЬД
ХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

ШИНЭ НЭР ТӨРЛИЙН ОРГАНИК
БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЖ НИЙТИЙН
ХЭРЭГЦЭЭНД НИЙЛҮҮЛСЭН ТОХИОЛДОЛД

СУДАЛГАА, ХӨГЖИЛД ЗАРЦУУЛСАН
ЗАРДЛЫН 75 ХҮРТЭЛХ ХУВЬТАЙ ТЭНЦЭХ
ДЭМЖЛЭГИЙГ НЭГ УДАА УЛСЫН ТӨСВӨӨС ОЛГОХ

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОН БҮХ ШАТНЫ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭД ОРГАНИК ТУСЛАХ АЖ
АХУЙГ ХӨГЖҮҮЛЭХЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ АСУУДЛЫГ БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ХАРИУЦАЖ АЖИЛЛАНА.

Органик бүтээгдэхүүний тухай хууль батлагдсанаар байгаль орчин, эко систем, хүний эрүүл мэндэд ээлтэй органик үйлдвэрлэлийг дэмжин зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах, бүс, орон нутгийг хөгжүүлэх, ажлын байрыг бий болгох, органик хүнс, бүтээгдэхүүнээр иргэдээ хангах, экспортод гаргах эрх зүйн боломж бүрдэнэ.

Органик бүтээгдэхүүний тухай хуулийг 2025 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөнө.

2.2. Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль

2.2.1. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2025-2026 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

БАТАЛСАН ОГНОО 2023.11.10	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2023.09.29-ний өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2023.12.14
---	---	---

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг дор дурдсанаар баталлаа:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2024 он	2025 он	2026 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	7.0	6.5	5.4
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	8.5	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	25,855.1 34.9	27,757.3 33.4	29,155.8 32.4
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	27,360.5 37.0	29,417.3 35.4	30,955.8 34.4
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	4,989.2 6.7	2,056.7 2.5	1,538.5 1.7
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-1,505.4 -2.0	-1,660.0 -2.0	-1,800.0 -2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	6,273.3 8.5	6,620.8 8.0	6,971.7 7.7
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	44,400.0 60.0	49,800.0 60.0	54,000.0 60.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/ -Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2,351.9 3.2	2,437.7 2.9	2,461.8 2.7

Уг хууль нь Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийг батлах үндсэн баримт бичиг болсон юм.

2.2.2. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХАМТ БАТЛАГДСАН ХУУЛЬ, УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

БАТАЛСАН ОГНОО 2023.11.10	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2023.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.01.01
--	--	--

Улсын Их Хурал төрийн бүтээмж, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр долоон хууль, татварын бодлогын хүрээнд малчид, гадаадын хөрөнгө оруулагч, аж ахуй эрхлэгч болон хувиараа бизнес эрхлэгчдийг татварын бодлогоор дэмжих чиглэлээр таван хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хангах, стратегийн ач холбогдолтой төсөл хэрэгжүүлэх хүрээнд уул уурхайн бүтээгдэхүүн худалдах, худалдан авах зохицуулалттай гурван хууль, Газрын харилцаа, геодези зураг зүйн асуудлын чиг үүргийг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэхтэй холбоотой зургаан хууль, нэг тогтоол, 2024 оны төсөв баталсантай холбогдуулан иргэд, аж ахуй эрхлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, хөдөө орон нутагт орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төрийн албан хаагчдын цалин, нийгмийн баталгааг сайжруулах, боловсрол, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний талаарх долоон тогтоолыг баталсан.

Монгол Улсын 2024 оны төсөвтэй хамт батлагдсан хууль тогтоомжид дараах зохицуулалтыг тусгасан.

1) Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар:

Төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг үр ашигтай болгох зорилгоор ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг орон нутагт дахин хуваарилах хувь хэмжээг нэмэгдүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор боловсрол, эрүүл мэндийн салбарын жишгээр гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмыг төрийн бусад байгууллагуудад хамааруулах, жил бүрийн үндэсний их баяр наадам, бэлтгэл болон зохион байгуулалтын арга хэмжээнд зарцуулагдах төсвийг Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно гэсэн заалтад хамааруулахгүй болсон.

2) Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар:

Төрийн үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох зохицуулалтыг нэмж тусгаснаар төрийн албан хаагчийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах, нийгмийн баталгааг сайжруулах ач холбогдолтой.

3) Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар:

Улсын төсөвт төвлөрсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Ирээдүй өв санд хуваарилах хувийг 2024 онд 20 хувь, 2025 онд 40 хувь, 2026 оноос эхлэн 65 хувьд хүргэх өөрчлөлтийг тусгасан.

4) Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар:

Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг тухайн байгууллагаас олгох зохицуулалтыг нэмсэн.

Бараа бүтээгдэхүүний гарал үүслийн бүртгэл, хяналтын тогтолцоог сайжруулах, улмаар хүнс болон эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, гаалийн үйл ажиллагааг автоматжуулах зорилгоор олон улсын стандартыг хангасан зураасан кодыг ашиглах, татваргүй барааны дэлгүүр ажиллуулах тусгай зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар олгох зохицуулалтыг өөрчлөн тусгаснаар “Гадаад худалдааны цахим нэг цонх” мэдээллийн системийн үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагаанд эрх бүхий этгээд зөвшөөрөл олгохтой үйл ажиллагааг хялбаршуулах боломж бүрдэх юм.

5) Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар:

Малчин, мал бүхий этгээдийн борлуулсан анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноос, ноолуур, сарлагийн хөөврийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, далд эдийн засгийг бууруулах зорилгоор хувиараа бизнес эрхлэгч, татвар төлөгчдийг өөрийн хүсэлтээр нь орлогын босго хамаарахгүйгээр хялбаршуулсан горимыг сонгож үйл ажиллагааны орлогоо жилд нэг удаа тайлагнах боломжийг олгож, татварын хялбаршуулсан горимоор үйл ажиллагааны нийт орлогын 1.0 хувийн албан татвар төлөх, хөрөнгийн зах зээлийн таатай орчныг бүрдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, үнэт цаасны зах зээлийг нэмэгдүүлэх, түүнчлэн хөдөө орон нутаг дахь орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэхэд түр хугацааны татварын хөнгөлөлтийг түрээслэгчид олгох, малчин, мал бүхий этгээд малын тоо толгойн албан татварын тайлан гаргах шаардлагагүй, татварын албаны мэдээлэлд үндэслэн албан татварыг ногдуулах, уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ашигт малтмал баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн хүчин чадлаа нэмэгдүүлэх, үйлдвэрийн шинэчлэл хийхэд дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулах тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг дөрвөн

жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг дөрвөн жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргаж болох зохицуулалтыг тус тус тусгасан.

6) Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар:

Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч, Засгийн газар, аймаг, нийслэлийн дотоодын үнэт цаасны анхдагч ба хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалсан үнэт цаасыг борлуулсны орлогод ногдох хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 2024-2026 онд 90 хувь, 2027-2029 онд 50 хувь, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагчийн хувьцаа, үнэт цаас борлуулсан орлогод ногдох албан татварыг тухайн хувьцаа, үнэт цаасыг худалдан авахад гарсан холбогдох зардлыг хасаж тооцохоор орон нутагт шинээр орон сууц барьж борлуулсны орлогод ногдох аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг Багануур, Багахангай, Налайх дүүрэг, Дархан-Уул болон Орхон аймгийн төвийн сумын хилийн цэс дотор 2024-2026 онд 50 хувь, 2027-2029 онд 20 хувь, бусад аймаг, сумын хилийн цэс дотор 2024-2026 онд 90 хувь, 2027-2029 онд 50 хувь, нийтийн зориулалттай орон сууц түрээслэсний орлогод ногдох хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг Багануур, Багахангай, Налайх дүүрэг болон аймаг сумын хилийн цэс дотор 2024-2026 онд 90 хувь, 2027-2029 онд 50 хувиар тус тус хөнгөлөх зохицуулалтыг нэмж тусгасан.

7) Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар:

Стратегийн орд эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу уурхайн үйл ажиллагааны тасралтгүй, үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хайгуул-олборлолтын ажлыг хамтад нь гүйцэтгэх этгээдтэй 10 хүртэл жилийн хугацаатай гэрээ байгуулахаар тендер зарлаж болох зохицуулалтыг нэмсэн.

8) Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Геодези, зураг зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолоор:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрыг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлж, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолоор Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар болгон өөрчилсөн.

Газрын тухай хууль болон бусад хуульд орсон өөрчлөлтөөр Монгол Улсын иргэн гэр бүлийн хэрэгцээний газрыг эзэмших хүсэлтээ цахим системээр гаргаж, өмнө нь газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх авч байгаагүй иргэдэд эхний ээлжинд газар олгох боломжийг бүрдүүлсэн. Мөн иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар дээр нийтийн болон хувийн сервитут тогтоох, газар эзэмших эрх шилжих, хугацаа сунгах шийдвэрийг Нийслэл, дүүргийн Газрын алба гаргахаар болсон нь иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх боломж нээгдсэн. Улсын хэмжээнд тухайн жилд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтыг Засгийн газарт оруулан шийдвэрлүүлэх замаар салбар хоорондын уялдааг хангаж давхардуулан газар олгохгүй байх эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

9) Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар:

Авлигатай тэмцэх газарт гүйцэтгэх ажилтан, мөрдөгч, нууцалбал зохих албаны ажилтнаар ажилласан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд тооцох бөгөөд уг албан тушаалд ажилласан нэг жилийг нэг жил, гурван сараар дүйцүүлэн тооцох зохицуулалтыг тусгасан.

10) Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиар:

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд Түншлэлийн төвийг байгуулах хүртэл уг төвийн чиг үүргийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр нэмж тусгасан.

11) “Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолоор:

Засгийн газраас 2024 онд гадаад, дотоод үнэт цаас гаргах асуудлыг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг болон Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт нийцүүлэн шийдвэрлэх эрхийг Засгийн газарт олгосон.

12) “Засгийн газрын өрийн баталгаа гаргах зөвшөөрөл олгох тухай” Улсын Их Хурлын тогтоолоор:

“Чойбалсан Дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх” төслийг төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулахад, Газрын тосны бүтээгдэхүүний хомстол, үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэхэд импортлогч байгууллагуудад дэмжлэг үзүүлэх зорилгоор дутагдаж болзошгүй санхүүжилтийн нөөцийг бүрдүүлэхэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах зохицуулалтыг тусгасан.

13) “Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолоор дараах арга хэмжээ авч хэрэгжүүлийг Засгийн газарт даалгасан:

- Шинэ сэргэлтийн бодлогын хот, хөдөөгийн сэргэлтийг дэмжих зорилгоор иргэдийн орон нутагт шилжин, тогтвор сууршилтай ажиллах, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр иргэд, аж ахуй эрхлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, хөдөө орон нутагт орон сууцны нийлүүлэлтийг нэмэгдүүлж, шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэл, улс, орон нутгийн төсөв, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, тусламж, ногоон санхүүжилтээр шийдвэрлэх;

- Төрийн захиргаа, төрийн үйлчилгээний албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийг аймгийн төвийн сум болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэгт 20 хувиар, аймгийн төвөөс бусад суманд 40 хувиар, орон нутгийн тохижилт үйлчилгээний ажилчдын үндсэн цалинг 20 хувиар нэмэгдүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

- Мөн анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг бүс нутгийн онцлогийг харгалзан ялгаатай хуваарилах, иргэдийг тусламж үйлчилгээний шатлал хооронд хүнд суртал, чирэгдэлгүйгээр шуурхай шилжүүлдэг байх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог үргэлжлүүлэн эрчимжүүлж, хөдөөгийн хүн амын хамрагдалтыг нэмэгдүүлэх аян зохион байгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

- Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан болон тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ачаа тээврийн урсгалыг сайжруулах, төмөр зам, нисэх буудал, авто зам, замын байгууламжийн сүлжээг өргөтгөн шинэчлэх, боомтын хүчин чадлыг сайжруулах, эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх, нийслэл Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, шинэ суурьшлын бүс, хот байгуулах дэд бүтэц бий болгох болон төрийн үйлчилгээний салбарын төсөл, хөтөлбөрийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх;

- Мөн орон сууцны ипотекийн зээлийн эрэлт болон төвлөрлийг сааруулах бодлоготой уялдуулан ипотекийн хөтөлбөрийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, нийслэл, орон нутагт тэгш хүртээмжтэй хуваарилах, агаар, хөрс, орчны бохирдлыг бууруулах зорилгоор инженерийн дэд бүтцийн шийдэлтэй, нийт талбай нь 100 м²-аас ихгүй хэмжээтэй амины орон сууцыг орон сууцны ипотекийн зээлд хамруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар, Монголбанканд даалгасан болно.

2.2.3. ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

БАТАЛСАН ОГНОО 2023.12.07	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.01.01
--	--	--

Эрүүгийн хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:

- Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг /Хүчиндэх/, 12.3 дугаар зүйлийн 2.1, 3.2 дахь заалт /Бэлгийн мөлжлөг/, 13.1 дүгээр зүйлийн 2.1-д /Хүн худалдаалах/ заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоож, хохирогчийг арван найман насанд хүрсний дараа тоолж эхэлнэ.

- Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг /Хүнийг алах/, 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг /Хүчиндэх/, 12.3 дугаар зүйлийн 4.1 дэх заалт /Бэлгийн мөлжлөг/, 13.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг /Хүн худалдаалах/, 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг /Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/, 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг /Хахууль авах/, 22.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт /Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/ заасан гэмт хэрэг үйлдсэн ялтныг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоохгүй.

- Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг /Хүнийг алах/, 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг /Хүчиндэх/, 12.3 дугаар зүйлийн 4.1 дэх заалт /Бэлгийн мөлжлөг/, 13.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт /Хүн худалдаалах/ заасан гэмт хэрэгт өршөөл үзүүлэхгүй.

Эрүүгийн хуулийн 21.9 дүгээр зүйл /Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах/, 27.10 дугаар зүйл /Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтыг журам зөрчих/-ийг тус тус өөрчлөн найруулж, Бага насны хүүхдийг алсан бол арван хоёр жилээс хорин таван жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ялаар шийтгэнэ.

Хамт батлагдсан Зөрчлийн тухай хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг орууллаа. Үүнд:

- Зөрчил үйлдсэн хүнд нийтэд тустай ажил хийлгэх шийтгэл оногдуулах зохицуулалтыг шинээр тусгалаа.

- Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт зөрчсөнтэй холбогдуулан эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авах, сунгах, ангилал нэмэх, өөрчлөх, нөхөн авах, тээврийн хэрэгслийн эзэмшлийн шилжилт хөдөлгөөн хийх эрхийг хязгаарлана.

- Хүн, хуулийн этгээд эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хугацаандаа биелүүлээгүй нь цагдаагийн алба хаагч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг торгох шийтгэлийг биелүүлж дуусах хүртэл хугацаанд хязгаарлана. Энэ тохиолдолд тээврийн хэрэгслийг хуульд заасан журмын дагуу тусгай талбайд хүргэх, эсхүл бусад аргаар хөдөлгөөнийг нь хязгаарлана.

- Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий албан тушаалтан, шүүхээс оногдуулсан торгох шийтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд биелүүлэх бол шийтгэлийн хэмжээг 50 хувиар хөнгөрүүлж, энэ хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол шийтгэлийн хэмжээг 50 хүртэл хувиар нэмэгдүүлэхээр тусгалаа.

- Жолооч согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон; тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй, эсхүл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон; согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Хамт батлагдсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг орууллаа. Үүнд:

- Шийтгэлийн хуудсанд заасан торгох шийтгэлийг хэсэгчлэн төлүүлэх шийдвэр нь торгох шийтгэлийг хөнгөрүүлсэн нөхцөлд хамаарахгүй.

- Зөрчил үйлдсэн хүн торгох шийтгэлийг биелүүлээгүй бол эрх бүхий албан тушаалтан нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлээр солих саналаа оршин суугаа /оршин байгаа/ газар, эсхүл тухай зөрчил гаргасан харьяаллын шүүхэд хүргүүлнэ.

Хамт батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд Нийтэд тустай ажил хийлгэх шийтгэлийг гүйцэтгэх зохицуулалтыг нэмэлтээр орууллаа.

Хамт батлагдсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг орууллаа. Үүнд:

- Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн бага насны хүүхэд сураггүй алга болсон, олдсон тухай хойшлуулшгүй мэдээллийг харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч этгээд үнэ төлбөргүй, нийтэд мэдээлнэ.

- Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг /Хүнийг алах/, 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг /Хүчиндэх/, 12.3 дугаар зүйлийн 4.1 дэх заалт/ Бэлгийн мөлжлөг/, 13.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт /Хүн худалдаалах/ заасан гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлж дууссан, Эрүүгийн хуулийн 6.13 дугаар зүйлд заасны дагуу хорих ялаас өвчний учир чөлөөлөгдсөн болон Эрүүгийн хуулийн 6.14 дүгээр зүйлд заасны дагуу уучлалд хамрагдсан хүний зорчих хөдөлгөөнд тоног төхөөрөмж ашиглан хяналт тогтооно.

Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн гаралт буурах, бага насны хүүхдийг хүчиндэх болон алах гэмт хэргийн ялын бодлогыг чангатгах, гэмт хэрэгтнийг өршөөлд хамруулахгүй байх, хорих ялаас хугацаанаас өмнө суллахгүй байх зохицуулалтыг тусгаснаар бага насны хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тоо буурна гэж үзэж байна.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд оногдуулах ял, хариуцлагыг чангатгаснаар зам тээврийн ослын гаралт буурах, ослын улмаас амь нас, эд хөрөнгө хохирохоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг бий болголоо.

2.2.4. МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ХАМТ БАТЛАГДСАН ХУУЛИУД

<p>БАТАЛСАН ОГНОО</p> <p>2023.12.08</p>	<p>ТӨСӨЛ САНААЧИЛСАН</p> <p>Засгийн газраас 2023.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн.</p>	<p>ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА</p> <p>2024.02.23</p>
---	---	---

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд болон хамт батлагдсан Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудад дараах онцлог зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

1.Олон улсын худалдааны чөлөөт байдлыг дэмжих болон улс, бүс, нутагт тархсан өвчнөөс хамгаалах, тэмцэх зорилгоор хамгаалалттай аж ахуйд мөрдөх биохамгааллын нийтлэг зааврыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга өвчин тус бүрээр батлах, хамгаалалттай аж ахуй нь дээрх зааварт нийцүүлэн өөрийн үйл ажиллагаанд мөрдөх биохамгааллын зааврыг баталж мөрдүүлэхээр;

2.Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргаас бусад албан тушаалтан мал, амьтны гоц халдварт өвчний талаарх баталгаажаагүй мэдээллийг тараахыг хориглохоор;

3.Ургамлын хорио цээрийн гэрчилгээг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, олон улсын мал эмнэлгийн гэрчилгээг Мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тус тус олгохоор;

4.Эрсдэлийн үнэлгээ хийх журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн

Засгийн газрын гишүүн баталж, эрсдэлийн үнэлгээг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилогдсон эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэдэг байхаар;

5.Гаалийн байгууллага улсын хилээр нэвтрүүлсэн амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний талаарх мэдээллийг тогтоосон хугацаанд хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлдэг байхаар;

6.Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын жагсаалтад Мал эмнэлгийн албыг нэмж оруулахаар;

7.Малын генетик нөөцийг ашиглах тусгай зөвшөөрөл олгоход тавигдах тусгайлсан шаардлагыг тодорхой болгохоор;

8.Малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын болон хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны байгууллагын улсын байцаагчийг Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний болон Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хяналтын улсын байцаагч гэж ангилан хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхой тусгахаар;

9.Зөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар мал, малын үржүүлгийн бүтээгдэхүүнийг энгийн зөвшөөрөлгүйгээр гадаадад гаргасан болон гаргахыг завдсан, малыг сонгон үржүүлэхдээ ашиг шимийн чиглэлийг дур мэдэн өөрчилсөн, эрх бүхий байгууллагаас тогтоосноос өөр бүс нутагт үржүүлсэн, малын үүлдэр, омог шинээр бий болгох, үр, өндгөн эс, хөврөлийг үйлдвэрлэх, бичил биетнийг өсгөвөрлөх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол зөрчилд тооцож, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэлийн төрөл, хэмжээг тодорхойлохоор;

10.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар мал аж ахуйн үйлдвэрлэлийн хяналтын улсын байцаагчийн зөрчил шалган шийдвэрлэх харьяаллыг шинээр тогтоосон зэрэг болно.

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар гадаад орны мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтын байгууллагатай амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл мэнд, хорио цээрийн нөхцөлийг тохиролцох, гэрчилгээ олгох чиг үүргийг гаалийн байгууллагаас хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тус тус шилжүүлэхээр тусгасан.

Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл мэнд, хорио цээрийн нөхцөл, гэрчилгээний загварыг худалдааны түнш улс орнуудын эрх бүхий байгууллагатай шинэчлэн тохироход тодорхой хугацаа шаардлагатай бөгөөд ийнхүү тохирсны дараа хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны

төв байгууллага болон мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага гэрчилгээг олгох чиг үүргийг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн тул Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулан батлуулсан болно.

Хууль батлагдсанаар мал аж ахуйн салбарын хуулиудын давхардал, хийдэл, зөрчил арилж, худалдааны түнш орнуудаас тавьж байгаа шаардлага хангагдах нөхцөл бүрдэж, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспорт нэмэгдэх, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон бусад бодлогын баримт бичигт тусгагдсан хүнсний аюулгүй байдлыг хангах, мал, амьтны эрүүл мэнд, малын удмын санг хамгаалах, баталгаажуулах, улмаар нийтийн эрүүл мэндийг хамгаалах талаарх зорилтууд хэрэгжих боломж бүрдэнэ.

2.2.5. ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

БАТАЛСАН ОГНОО 2023.12.08	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2022.03.04-ний өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.02.23
--	---	--

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд дараах нэмэлт, өөрчлөлт тусгагдсан. Үүнд:

1) Цэргийн алба хаагч эмэгтэйн жирэмсний болон амаржсаны, хүүхэд асрах чөлөөтэй байсан хугацааг цэргийн алба хаасан хугацаанд оруулан тооцож, тухайн хугацааны эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс хариуцан цэргийн алба хаагчийн анги, байгууллага нийгмийн даатгалын байгууллагад тайлагнаж, шилжүүлэхээр тусгасан.

2) Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд цэргийн алба хаасны тэтгэврээ хувь тэнцүүлэн тогтоолгосон цэргийн алба хаагчид 18 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгох тухай заасан хэдий ч мөн хуулийн 8 дугаар зүйлийн 2-т заасан 10-аас доошгүй жил ажилласан гэсэн хугацаа заагаагүйгээс орон тоо, зохион байгуулалтын өөрчлөлт, биеийн эрүүл мэндийн байдлаар цөөхөн жил ажиллаад ажлаас чөлөөлөгдсөн цэргийн алба хаагч нэг удаагийн тэтгэмжид хамрагдах эрх зүйн зөрчлийг арилгаж хууль хоорондын уялдаа холбоог хангаж хуульчилсан.

3) Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахтай холбогдсон зааврыг батлан хамгаалахын болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран баталж байхаар тусгалаа.

Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар тус хуулийн зөрчил, хийдэл, давхардал арилж, эрх зүйн хувьд зөрчилгүй хэрэгжих боломж бүрдсэн.

2.2.6. ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

БАТАЛСАН ОГНОО 2023.12.08	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2023.10.24-ний өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.02.23
---	---	---

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэнд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаа, хүний эрүүл мэндэд нөлөөлж байгаа эрсдэлт хүчин зүйлийг тандах, судлах, эмийн зохистой хэрэглээг сурталчлан таниулах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх, зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлсэн өвчтөний эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх, тэтгэмжийн даатгалын шимтгэл төлбөл зохих хуульд заасан хугацааг хангаагүй амьгүй донорын оршуулгын зардалд түүний гэр бүлийн гишүүнд нэг удаагийн тэтгэмж олгох эрх зүйн зохицуулалтыг өөрчлөн тусгасан.

Хууль батлагдсанаар Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх нийгмийн эрүүл мэндийн цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи нэвтрүүлэх, төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарыг сурган чадавхжуулахад шаардагдах санхүүжилт шийдвэрлэгдэнэ. Мөн Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалтад орсон өвчний тоо болон иргэдийн зайлшгүй шаардлагаар гадаад улсад эмчлүүлэхэд хувиасаа төлөх төлбөрийн хэмжээ буурч, иргэдийн эрүүл мэндэд зарцуулагдах санхүүгийн зардал багасах эерэг нөлөөтэй.

2.2.7. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН БУСАД ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

БАТАЛСАН ОГНОО 2024.01.12	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.04.01
---	---	---

Дээрх хуулиудыг хэрэглэх явцад үүсч болзошгүй эрх зүйн үр дагаврыг тооцож төрийн байгууллага хооронд болон төрийн байгууллагаас хүн, хуулийн этгээдтэй, хүн, хуулийн этгээдээс төрийн байгууллагатай, иргэн хоорондын харилцааг тус бүрээр нь ангилж холбогдох өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:

Төрийн байгууллага, албан тушаалтан хоорондоо цахим хэлбэрээр мэдээлэл солилцох харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай нийцүүлэн, тус хуулийн 18.2-т заасан Нийтийн мэдээллийн систем болон албаны цахим шууданг ашиглахаар, харин хүн, хуулийн этгээдээс төрийн байгууллага албан тушаалтантай харилцах харилцаанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан системүүд болон эрх зүйн үр дагавраас хамаарч Иргэний хууль болон Цахим гарын үсгийн тухай хуульд заасан цахим гарын үсэг, тоон гарын үсгийг тус тус хэрэглэхээр, мөн түүнчлэн эрх зүйн үр дагавар багатай, эсхүл тухайн салбарын хууль тогтоомжоор баталгааждаг болон хуульд амаар гүйцэтгэж болохоор тусгасан харилцаанд аливаа хэлбэр заахгүй байхаар шийдвэрлэлээ.

Төр өөрт байгаа мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх зарчмыг тодорхой хуулиудад хангав. Тухайлбал: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тухай мэдээлэл зэргийг төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан олж авч болохоор, мөн хүн, хуулийн этгээдээс төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг цахим хэлбэрээр гаргах, ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэж, хариуг цахим хэлбэрээр хүргүүлж болохоор тусгалаа.

Тусгай зөвшөөрөл, энгийн зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, бүртгэл хийлгэхтэй холбоотой хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэж хариу хүргүүлэхэд зөвхөн цаасан хэлбэртэй байхаар заасан харилцааг өөрчилж цахим хэлбэртэй байх боломжийг нэмж тусган Зөвшөөрлийн тухай хуулийг практикт цахим хэлбэрээр хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэхээр тусгалаа.

Цахим баримт бичгийн албан ёсны хүчинтэй байдлыг цаасан баримт бичгийн нэгэн адил хүлээн зөвшөөрч хуульд заасны дагуу стандартаар тогтоосон баримт бичгийн бүрдлээр баталгаажсан тохиолдолд баримт бичгийн эх хувь гэж үзэхээр тусгалаа.

Хуульд зөвхөн бичмэл гарын үсгээр баталгаажуулж төрийн байгууллагаас үйлчилгээ авахаар заасан харилцаанд цахим гарын үсэг хэрэглэж болохоор зохицууллаа. Тухайлбал, хуулийн этгээдийг бүртгүүлэх, үүсгэн байгуулах баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, оюуны өмчийн эрхийг цахим хэлбэрээр бүртгүүлэх боломжийг бүрдүүлэх хүрээнд Компанийн тухай, Нөхөрлөлийн тухай, Патентын тухай, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай зэрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгалаа.

Хуульд зарим төрлийн гэрээг цаасан хэлбэрээр байгуулахаар заасныг Иргэний хуулийн зохицуулалтад нийцүүлж цахим хэлбэрээр байгуулж болохоор тусгалаа. Тухайлбал, Патентын тухай хуульд заасан патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг ашиглуулах лицензийн гэрээ, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан барьцааны гэрээ, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хөдөлмөрийн гэрээ,

Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан хөрөнгийн үнэлгээ хийх гэрээ, Өмгөөллийн тухай хуульд заасан хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлэх гэрээ, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд заасан гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах гэрээ, Аудитын тухай хуульд заасан аудитын үйлчилгээ үзүүлэх зэрэг гэрээнүүдийг зөвхөн цаасан хэлбэрээр байгуулахаар заасныг өөрчилж цахим хэлбэрээр байгуулж болохоор, байгуулахдаа цахим гарын үсэг хэрэглэхээр тусгалаа.

Дээрх хуулиуд батлагдсанаар төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, хүн, хуулийн этгээдийн төрийн байгууллагаас авах үйлчилгээг цахимжуулах, цахим баримт бичгийн хүчинтэй байдлыг хүлээн зөвшөөрөх, нотлох баримтын хэмжээнд үнэлдэг байх нөхцөл бүрдэж цаашид цахим шилжилт эрчимтэй хэрэгжих боломжтой болох юм.

2.2.8. ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

БАТАЛСАН ОГНОО 2024.01.17	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.02.15
---	---	---

Уг хуулийн зорилтыг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хэмнэлтийн горимыг баримталж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дагавар нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг бууруулахгүй байх, төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх зарчмыг хангах хүрээнд хэмнэлтийн зарим хязгаарлалтыг уян хатан болгох харилцааг зохицуулахаар тодорхойлсон бөгөөд хуульд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгав. Үүнд:

1) Төрийн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй нийслэлээс алслагдсан дүүрэг болон аймгийн Засаг даргын тамгын газар, тэдгээрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумын Засаг даргын тамгын газар, төрийн хяналт шалгалт хийх чиг үүрэгтэй аудитын байгууллагыг автомашин ашиглахаар зөвшөөрөв.

2) Дүрэмт хувцастай холбоотой хэсгийн ажил үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай зарим байгууллагын тусгай хувцастай холбоотой зохицуулалтыг тодорхой болгох үүднээс ажил олгогч нь ажилтныг түүний ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон ажлын тусгай хувцсаар хангах боломжтой болсон.

3) Төсвийн байгууллага, албан тушаалтны албан ажлын онцлогийг харгалзан шуурхай албаны болон бэлэн байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн албан хаагчийн гар утасны зардлыг санхүүжүүлэхээр тусгав.

4) Зайлшгүй биечлэн хийх бэлтгэл, галт зэвсэг, хэргийн газрын үзлэгийн

сургалт, гал түймэртэй тэмцэх зэрэг сургалтуудыг цахимаар зохион байгуулах боломжгүй хүндрэл учирч байгаа тул сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулахыг болон тээвэр шатахуун, дотоод албан томилолт түүнчлэн зарим зардлыг санхүүжүүлэхийг хориглосон байсан зохицуулалтыг хуулиас хаслаа.

Хууль батлагдсанаар байгаль, цаг уурын өөрчлөлт, өвөлжилт, хаваржилт хүндэрсэн нөхцөл байдлын үед орон нутаг дахь төсвийн байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах боломж бүрдэж, төрийн үйлчилгээ иргэдэд шуурхай, хүртээмжтэй болох юм.

2.2.9. ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

<p>БАТАЛСАН ОГНОО</p> <p>2024.01.17</p>	<p>ТӨСӨЛ САНААЧИЛСАН</p> <p>Засгийн газраас 2024.01.11-ний өдөр өргөн мэдүүлсэн.</p>	<p>ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА</p> <p>2024.02.15</p>
---	---	---

2022 оны байдлаар Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 64 хувийг нийслэл Улаанбаатар хот дангаар үйлдвэрлэж буй томоохон зах зээл болоод байна. Нийслэл Улаанбаатар хотын төсвийн 90.1 хувийг татварын орлогоор, 9.9 хувийг татварын бус орлогоор бүрдүүлж байна. Төсөв дагасан уг санхүүгийн схемийг шинэчлэн, олон улсын жишиг хотуудын эдийн засгийн хөгжилтэй ижил түвшинд хүрэх нэг чухал алхам бол хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгох, томоохон төслүүдийн санхүүжилтийг шийдвэрлэх механизм юм.

Дэлхийн томоохон хотууд эдийн засаг, дэд бүтцийн төслүүдийн санхүүжилтийг хөрөнгийн зах зээл дээр үнэт цаас гаргах замаар шийдвэрлэж байна. Нөгөө талаар олон улсын зах зээл дээр уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгах чиглэлээр дэлхийн улс орнууд далайцтай арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа бөгөөд үүний нэг нь ногоон санхүүжилтийг хөгжүүлэх явдал бөгөөд хөгжингүй улс орнууд ихээхэн хэмжээний хөрөнгийг энэ чиглэлийн хөрөнгө оруулалтад зориулах чиг хандлага дэлхий даяар эрчимжиж байна байна. Түүнчлэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн ногоон зээл болон бондын хүү бага бөгөөд 2023 оны дөрөвдүгээр сарын Олон Улсын Валютын Сангийн судалгаанаас үзэхэд хөгжиж буй орнуудын хувьд ногоон болон энгийн бондын хүүгийн түвшний зөрүү 2.0 хувь орчим байна.

Түүнчлэн бага өгөөжтэй ч нийгмийн болон байгаль орчны хувьд эерэг нөлөөлөл авчрах төсөл хөтөлбөрт хөрөнгө оруулах “үр нөлөөллийн хөрөнгө оруулалт” хийх хөрөнгө оруулагч, донор байгууллагуудын сонирхол их байна. Эдгээр хөрөнгө оруулагчид ашгийн төлөө гэхээс илүүтэйгээр эрсдэлгүй, нийгмийн ач холбогдол өндөртэй өрийн хэрэгслүүдийг хямд эх үүсвэрээр санхүүжүүлэх сонирхол өндөр байна.

Монгол Улсын хөрөнгийн зах зээл 10 их наяд төгрөгийн хэмжээнд хүрч сүүлийн жилүүдэд Улсын Их Хурал, Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлогын хүрээнд эрчимтэй өсч байна. Гэвч дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжил хангалттай бус байгаа шалтгааны улмаас дотоодын зах зээлд орон нутгийн бонд гаргахад түүнийг худалдаж авах мэргэжлийн хөрөнгө оруулагч, ялангуяа орон нутгийн болон ногоон бонд зэрэг нийгмийн, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх хариуцлагатай хөрөнгө оруулагчид хангалтгүй байгаа бөгөөд гол сонирхож буй субъект нь дотоодын арилжааны банкууд болж байна.

Арилжааны банкуудын хувьд аль болох өгөөж өндөр өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхолтой бөгөөд зах зээл дээр хэт давуу байдалтай байна. Улмаар зах зээл дээрх өгөөж өндөр, богино хугацаатай өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулах сонирхол хандлагатай байгаагаас дотоодын хөрөнгийн зах зээлд ногоон болон орон нутгийн бондыг гаргахад бусад өрийн хэрэгслүүдтэй өгөөж, хугацааны хувьд өрсөлдөх шаардлага үүсэж тухайн нэр төрлийн бондуудын хувьд зардал өндөртэй босох үндэслэл болж байна.

Мөн Банкны тухай хуулийн дагуу арилжааны банкны худалдан авах үнэт цаасны нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй бөгөөд улмаар нийслэлийн хэмжээний томоохон төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг дан дотоодын зах зээлээс босгох зах зээл хязгаарлагдмал байна.

Иймд дээрх хэрэгцээ, шаардлагыг үндэслэн нийслэл Улаанбаатар хот нь гадаад үнэт цаасыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, өмнө гаргасан үнэт цаасаа дахин санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын өрийн баталгаатайгаар гаргаж болохоор, мөн энэхүү гадаад үнэт цаас гаргах асуудал нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.3-т заасан "... бараа ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг зохицуулсан зохицуулалтад хамаарахгүй." байхаар, түүнчлэн Өрийн удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг хангасан тохиолдолд нийслэл Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хэрэгжих Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх зориулалтаар 2024 оны төсвийн жилд Засгийн газрын өрийн баталгаатайгаар гадаад үнэт цаас гаргах зэрэг асуудлыг холбогдох хууль, тогтоолд тусгалаа.

Хууль, тогтоол батлагдсанаар Нийслэлийн бонд олон улсын зах зээлд гаргах эрх зүйн орчныг нээж урт хугацаатай, зардал багатай өрийн хэрэгслийг зах зээлд гаргах, үүний үр дүнд төсөвт ирэх ачааллыг бууруулж, нийслэл хөгжлийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх боломжтой болох юм.

2.2.10. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ

БАТАЛСАН ОГНОО 2024.01.17	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.08.01
--	--	--

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1-4 дүгээр зүйлийг 2024 оны наймдугаар сарын 01-ний өдрөөс, 5 дугаар зүйлийг ердийн журмаар дагаж мөрдөхөөр баталсан бөгөөд дараах онцлог зохицуулалтыг тусгасан. Үүнд:

Нэг. Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах зохицуулалтын талаар:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах” гэсэн 31.5 дугаар зүйлийг “Сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах” болгон бүхэлд нь өөрчлөн найруулсан.

Энэ зүйл 12 хэсэгтэй байх бөгөөд 1 дэх хэсэгт Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах гурван үндэслэлийг тусгасан. Үүнд:

- гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь, эсхүл гэмт хэрэг үйлдсэн газраас зугтах үед барьсан;
- гэмт хэрэг үйлдсэн даруй гэрч, хохирогч шууд заасан;
- хэргийн газарт болон тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд ул мөр илэрсэн.

Харин 2 дахь хэсэгт Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэгт холбогдуулан сэжигтнийг дээр заасан гурван үндэслэлээс гадна дараах гурван үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол шүүхийн шийдвэргүй баривчилж болохоор өөрчилсөн. Үүнд:

- хэн болох нь тогтоогдоогүй;
- Монгол Улсад оршин суух газрын хаяг тодорхойгүй, эрхэлсэн ажилгүйн улмаас түүнийг мэдэгдэх хуудсаар дуудах боломжгүй;
- Монгол Улсад байнга оршин суудаггүй.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүнд гэмт хэрэг үйлдэгдсэн даруй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад үндэслэл бүхий сэжиг тогтоогдвол сэжигтнийг хуулийн 31.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан аль нэг үндэслэлээр хойшлуулшгүйгээр баривчлахаар зохицуулсан.

Ийнхүү сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах үндэслэлүүдийг нарийвчлан тодорхойлсноор практикт баривчлах үндэслэлийг субъектив

хандлагаас хамаарч харилцан адилгүй хэрэглэж байгаа асуудлыг нэг мөр зохицуулах ач холбогдолтой юм.

Мөн сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах ажиллагаанд прокурор хяналт тавих, мөрдөгчийн тогтоолыг батлах, шүүхэд даруй хүргүүлэх, эсхүл тогтоолыг үндэслэлгүй гэж үзвэл батлахаас татгалзах тухай шийдвэр гаргах, шүүх уг асуудлыг хянан шийдвэрлэхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгасан.

Ийнхүү хойшлуулшгүйгээр явагдсан баривчлах ажиллагааны үндэслэл, үр дүнг хянуулахаар холбогдох материалыг шүүхэд хүргүүлснээр баривчлах ажиллагаанд тавих шүүхийн хяналтыг сайжруулж, мөрдөн шалгах ажиллагаанд хүний эрхийн зөрчил гарахаас урьдчилсан сэргийлэх чухал механизм болно.

Хоёр. Баривчлах, цагдан хорих асуудлыг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллын талаар:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр сэжигтнийг баривчлах тохиолдолд прокурорын саналыг гэмт хэрэг гарсан газрын харьяалах шүүх, сэжигтнийг шүүхийн шийдвэргүй баривчилсан тохиолдолд саналыг тухайн баривчлах ажиллагаа явагдсан газрын харьяалах шүүх, хэрэв баривчлагдсан сэжигтнийг 24 цагийн дотор уг хэрэг гарсан газрын харьяалах шүүхэд хүргэх боломжгүй бол баривчлах ажиллагаа явагдсан газрын шүүх хянан шийдвэрлэнэ.

Ийнхүү сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих саналыг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг нарийвчлан тогтоосноор сэжигтэн, яллагдагчийн шүүхэд хандах эрхийг хамгийн богино хугацаанд, шуурхай хангах боломж бүрдэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цаашид хэвийн явагдах нөхцөл хангагдах юм.

Гурав. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаар:

Мөрдөгч яллагдагчийг үргэлжлүүлэн цагдан хорих тухай саналаа хугацаа дуусахаас 7-оос доошгүй хоногийн өмнө прокурорт хүргүүлэх, прокурор цагдан хорих хугацааг сунгах тухай саналаа даруй шүүхэд хүргүүлэх, шүүх прокурорын саналыг хугацаа дуусахаас 4-өөс доошгүй хоногийн өмнө хянан хэлэлцэж, цагдан хорих хугацааг сунгах, эсхүл сунгахыг татгалзах тухай шийдвэр гаргах зохицуулалтыг тусгалаа.

Ийнхүү цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах процессыг нарийвчлан тодорхойлсноор прокуророос яллагдагчид авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах саналаа “хугацаа дуусах өдөр, цагийг”-ийг тулгаж шүүхэд ирүүлснээс болж шүүхийн практикт хэлэлцүүлгийг товлон зарлах, бусад оролцогчийг дуудан ирүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэг явдлыг хязгаарлах ач холбогдолтой юм.

Шүүхийн шатанд яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, шүүх хуралдааныг хойшлуулах, түдгэлзүүлэх, хэргийг прокурорт буцаах, харьяалах шүүхэд

шилжүүлэх зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой шийдвэр гаргах тохиолдол бүрд шүүгдэгчид урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэрхэхийг давхар шийдвэрлэх шаардлага үүсдэг бөгөөд эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад прокурор, оролцогчийн гаргасан саналыг харгалзан шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн шүүгдэгчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болох зохицуулалтыг тусгалаа.

Ийнхүү яллагдагчийг цагдан хорих хугацааг тоолох хугацааг нарийвчлан тогтоож өгснөөр шүүхийн шатанд шүүгдэгчийг цагдан хорих хугацаа нь яллагдагчийг цагдан хорих нийт хугацаанд орох эсэх нь тодорхойгүй байсан асуудлыг нэг мөр шийдэх практик ач холбогдолтой юм.

Дөрөв. Бусад өөрчлөлтийн талаар:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар сэжигтэн гэм буруугаа хүлээхээсээ өмнө өмгөөлөгч авах эрхийг хүлээн зөвшөөрдөг бөгөөд баривчлах ажиллагаа явуулж буй албан тушаалтнууд баривчлагдсан этгээдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдлэх бүрэн эрхийг нь “Миранда эрх” мэдэгдэх хүрээнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Мөрдөгч сэжигтнийг баривчлах үед түүнийг ямар хэрэгт холбогдуулан баривчилж байгаа талаар мэдэгдэж, энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Хүнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулна” гэж өөрчиллөө.

Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Баривчлах хугацааг тоолох” 31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт сэжигтнийг мөрдөн шалгах байгууллагад хүргэх, зайлшгүй эмнэлгийн туслалцаа үзүүлэх, эрүүлжүүлэх, өмгөөлөгчтэй ганцаарчлан уулзахад зарцуулсан хугацааг “Шүүхийн зөвшөөрлөөр баривчилж саатуулах хугацаа 48 цагаас хэтэрч болохгүй” хугацаанд оруулан тооцохгүй байхаар тусгалаа.

Түүнчлэн “Хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсан.

Тав. Хамт өргөн мэдүүлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах талаар:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах хүрээнд хяналтын төхөөрөмж ашиглан хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд тавих хяналтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрэгжүүлэхээр тусгалаа.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль батлагдсанаар хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байсан хүндрэл бэрхшээл,

хэрэгжүүлэхэд нөлөөлөх сөрөг үр дагавар арилж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсэн эрхийг нөхөн сэргээн эдлүүлэх ажлын үр дүн дээшлэнэ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг 2025 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр баталсан.

2.2.11. ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

БАТАЛСАН ОГНОО 2024.01.17	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.10.01
--	--	--

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр баталсан бөгөөд дараах онцлог зохицуулалтыг тусгасан. Үүнд:

Нэхэмжлэлийн шаардлагын төрлийг нэмэгдүүллээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тусгайлсан журмаар шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарах нэхэмжлэлийг шаардлагын хэлбэрийг тодорхой болгох хүрээнд бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах, дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах, хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах зэрэг хэрэг маргааны төрлөөр нь ялган тодорхойлсон.

Түүнчлэн тусгайлсан журмаар шүүхэд хянан шийдвэрлэгдэх хэрэг маргаанд бусдын эд хөрөнгөд учруулсан гэм хороос гадна хүний эрүүл мэндэд учруулсан гэм хорын мөнгөн хөрөнгө гаргуулахыг тусгасан.

Тодорхой төрлийн иргэний хэргийг хялбар, хурдан шуурхай зардал багатай хянан шийдвэрлэх зорилгыг үндэслэн хуульд бага үнийн дүнтэйгээс үл хамааран дараах нэхэмжлэлийг шүүх тусгайлсан журмаар шийдвэрлэхээр тусгасан. Үүнд:

- шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол;
- бүх төрлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл;
- ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн дагуу ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлж буй өнөөгийн практикт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа буюу хөрөнгө битүүмжилсэн, хураах, хөрөнгийн үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдааг явуулах ажиллагаа тус бүрийг шүүхээр хянуулах нь түгээмэл байна. Энэ төрлийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцаас хамаарч шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дунджаар 1-4 жилийн хугацаанд түдгэлзэж, энэ хугацаанд төлбөрт хураагдсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээнд өөрчлөлт орох, чанар байдал дордох, төгрөгийн ханш сулрах зэргээр төлбөр авагч, төлбөр төлөгчийн аль аль нь нэмж хохирох сөрөг үр дагавар бий болж байна.

Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдол, нэхэмжлэл нь мөнгөн хөрөнгө гаргуулах тухай маргаан биш бөгөөд маргааны зүйл нь шийдвэр гүйцэтгэгчийн явуулсан тухайн төрлийн ажиллагаа хуульд нийцсэн эсэх тухай асуудал байдаг. Иймд энэ төрлийн нэхэмжлэлд үнийн дүнг тодорхойлох боломжгүй.

Үндсэн нэхэмжлэл буюу гэрээний үүрэг, гэм хор зэргээс шалтгаалсан хохирол, төлбөр гаргуулах гомдол, нэхэмжлэлийг шүүх өмнө нь ердийн журмаар хянан хэлэлцэж, зохигчид гурван шатны шүүхэд хандан, уг асуудал эцэслэн шийдвэрлэгдсэн байдаг. Иймд дээрх шаардлагын хүрээнд тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх маргааны төрөлд шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдлыг тусгасан.

Гэр бүл, өв залгамжлалтай холбоотой маргааныг үнийн дүнгээс үл хамааран ердийн журмаар хянан шийдвэрлэнэ.

Ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэлийн шаардлага нь нэхэмжлэгчийг урьд ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэртэй боловч уг шийдвэрийг биелүүлээгүйн улмаас ажилтан ажилдаа орж, хөдөлмөр эрхлэх, цалин хөлс олж авах эрх нь зөрчигдсөнтэй холбоотой үүсдэг маргаан байдаг.

Энэ төрлийн маргаан практикт ихэнхдээ шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байгаа боловч ажилтныг тодорхой бус зарим шалтгаанаар ажилд нь эгүүлэн авахаас ажил олгогч цааргалсан, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг удаашруулдагтай холбоотой байдаг.

Ажилтныг ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэртэй ажилд эгүүлэн томилох үр дагавар нэгэнт бий болсон маргаан байх тул энэ төрлийн маргааныг тусгайлсан журмаар хянан шийдвэрлэхээр тусгалаа.

Хугацааг тодорхой болгосон зохицуулалтыг тусгалаа.

Ердийн журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай харьцуулахад тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааны хувьд тодорхой, хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд шүүх хуралдааныг аль болох хойшлуулахгүйгээр нэг удаагийн шүүх хуралдаанаар шийдвэрлэх шаардлагатай.

Иймд дээрх шаардлагыг хангах зорилгоор хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэхээр хугацааг тодорхой зохицууллаа.

Түүнчлэн талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэнцвэртэй хангах зорилгоор дээрх хугацааг шүүгчдийн зөвлөгөөнөөр нэг удаа 14 хоногоор сунгах зохицуулалтыг тусгасан.

Хэрэг үүсгэх, нэхэмжлэл гардуулах журмыг нарийвчлан тодруулж өгсөн. Тухайлбал, шүүгч энэ хуулийн тусгайлсан журмаар хянан шийдвэрлэгдэх хэргийн хуульд заасан шаардлага хангагдсан бөгөөд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш таван хоногийн дотор иргэний хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.

Мөн хариуцагчид мэдэгдэх хуудсыг хүргүүлэхдээ нэхэмжлэлийн хувийг, хэргийн оролцогчийн эрх, үүргийн талаарх дэлгэрэнгүй тайлбарын хамт илгээнэ. Хэрэв мэдэгдэх хуудас, нэхэмжлэлийн хувь, тайлбарыг баталгаат шуудангаар илгээсэн, эсхүл шүүхийн ажилтнаар биечлэн хүргүүлснийг энэ хуулийн 77 дугаар зүйлд заасны дагуу хариуцагч хүлээн авсан бол ийнхүү хүлээн авсан өдрөөр, энэ хуулийн 754.4-т заасны дагуу хүргүүлсэн бол мөн зүйлд заасан мэдэгдэх хуудас хүлээн авсанд тооцох өдрийг нэхэмжлэлийн хувийг гардаж авсан өдөр гэж үзнэ.

Түүнчлэн ажлын хэсгээс тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх нэхэмжлэл, хариу тайлбар, хэргийн оролцогчийн эрх, үүргийг талаарх тайлбарын загварыг Улсын дээд шүүх батлах зохицуулалтыг тусгасан.

Ингэснээр бага үнийн дүнтэй тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх хэргийн нэхэмжлэлийг гаргах, хариу тайлбарыг хялбар байдлаар гаргах боломжтой болох юм.

Сөрөг нэхэмжлэл гаргах нөхцөлийг бүрдүүллээ.

Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тэгш зарчмыг баримтлах зорилгоор хариуцагч сөрөг нэхэмжлэл гаргах зохицуулалтыг тусгалаа. Ингэхдээ тодорхой шалгуур хугацааг тогтоолоо. Тухайлбал, хариуцагч нэхэмжлэлийг гардаж авснаас хойш долоон хоногийн дотор сөрөг нэхэмжлэл гаргах, зохигч үндсэн ба сөрөг нэхэмжлэлийг гардан авснаас хойш тав хүртэл хоногийн дотор нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох баримтаа шүүхэд ирүүлэх зэрэг процесс ажиллагааг хугацаатайгаар оруулсан. Түүнчлэн тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бусдын эрх хөндөгдсөн тохиолдолд бие даасан шаардлага хангаагүй гуравдагч этгээдийг оролцуулахаар зохицууллаа.

Гэрчийн мэдүүлгийн талаар.

Гэрч мэдүүлгээ үнэн зөв мэдүүлэхээ илэрхийлж, мэдүүлгээ нотариатаар баталгаажуулан мэдүүлсэн, мөн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийн тусламжтай мэдүүлгээ гаргасныг шүүх хангалттай гэж үзвэл нотлох баримтаар үнэлж болох зохицуулалтыг тусгасан.

Ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжих нөхцөлийг чангатгалаа.

Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад талууд хүсэлт гаргасан тохиолдолд ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шилжүүлэхээр тусгасан байсныг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах хийдэл үүсгэх магадлалтай тул дараах нөхцөлд шүүгч ердийн журмаар шийдвэрлэхээр шилжүүлэх захирамж гаргахаар тусгасан.

- тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөлд хамаарахгүй;
- тухайн хэрэг нь эрх зүйн, шинэ ойлголт, хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой байж болзошгүй гэж үзсэн.

Давж заалдах гомдол гаргах талаар.

Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг зохигчид эс зөвшөөрвөл шийдвэрийг гардуулснаас хойш долоон хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болох бөгөөд давж заалдах шатны шүүх эргийг эцэслэн шийдвэрлэнэ.

Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчсөн бол давж заалдах шатны шүүхээс хэргийг анхан шатны шүүхэд дахин хянан шийдвэрлүүлэхээр буцаана.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны удаашрал багасаж, иргэдэд хурдан шуурхай, хялбар байдлаар үр дүнтэй үйлчлэх шүүхийн хүртээмж дээшилнэ. Хэргийн онцлогт тохирсон, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны уян хатан зохицуулалт бий болно. Шаардсан мөнгөн дүнгээсээ их хэмжээний зардал үүсгэн хэт урт хугацаагаар шүүхээр маргахаас халширч, шүүхийн үйлчилгээг авахаас татгалзах явдлыг багасгахын зэрэгцээ нэгэнт шүүхэд хянан шийдвэрлэх процесс эхлүүлсэн иргэд, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг богино хугацаанд шударгаар сэргээх боломж нэмэгдэх юм.

Ингэснээр хэргийн оролцогчид үүсэх нийгмийн зардал багасаж, шүүхийн үйл ажиллагааны цахимжилттай уялдан шүүхээр үйлчлүүлэх иргэдэд таатай, тэдний хэрэгцээнд нийцсэн тав тухтай шүүхийн орчныг бий болгох эхний алхам бүрдэнэ. Үр дүнтэй, уян хатан шүүн таслах ажиллагаа нь шүүхийн цахимжилт, түүгээр дамжин хэрэгжих ил тод байдлын тусламжтайгаар нээлттэй шүүхийг бүтээж шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг дээшлүүлэхээс гадна Монгол Улсын Үндсэн хуулиар тодорхойлсон хүний зөрчигдсөн эрхийг сэргээхэд нэг чухал эрх зүйн орчин бүрдэнэ.

2.3. Олон улсын гэрээ, хэлэлцээр соёрхон батлах тухай хууль

2.3.1. ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

/Монгол Улс, Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай/

БАТАЛСАН ОГНОО 2023.12.15	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.01.12
--	---	--

Төслийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тус төслийн Зээлийн хэлэлцээрийг 2022 оны дөрөвдүгээр сарын 11-ний өдөр хийсэн. Зээлийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаан, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн, зөвшилцсөний үндсэн дээр Зээлийн хэлэлцээрийг байгуулсан.

Төслийг Зам, тээврийн хөгжлийн яам 2023 он–2026 он /дөрвөн жил/ хугацаанд хэрэгжүүлнэ. “Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл” нь нийт 110 сая ам.долларын төсөвт өртөгтэй бөгөөд Дэлхийн банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (ОУСБХБ)-аас олгох 100 сая ам. долларын зээл нь жилийн Баталгаат овернайт хүүгийн түвшин /SOFR/ дээр 1.30 хувийн нэмэгдэл бүхий хувьсах хүүтэй, таван жилийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 25 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтийг хийх нөхцөлтэй. Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-аас олгох 7.3 сая зээлжих тусгай эрх (10 сая орчим ам.доллар) нь ОУХА-аас олгох зээл нь жилийн 2.0 хувийн тогтмол хүүтэй, таван жилийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 25 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтийг хийх нөхцөлтэй болно.

“Монгол Улсын тээврийн холболт болон логистикийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд ээлжит болон их завсар хийх шаардлагатай авто замын чиглэлийг ачаа, тээврийн урсгал, төвийн тээвэрлэлтийн нэгдсэн сүлжээтэй холбогдох холболт болон Олон улсын хучилтын тэгш байдлын индекс /IRI /-ийн үзүүлэлттэй уялдуулах юм. Авто замын ээлжит болон их засварыг хийхээс гадна замын зорчих хэсгийг засварлах, шинэчлэх, ус зайлуулах сувгийг сайжруулах, авто замын тэмдэг, тэмдэглэгээ, зэрлэг ан амьтдын гарц зэрэг замын хөдөлгөөний аюулгүй байдлын байгууламжийг байгуулах юм. Түүнчлэн, төслийн хүрээнд ээлжит засвар хийгдэх авто замд зураг төсөв шаардлагагүй бөгөөд их засвар хийгдэх, зураг төсөвтэй авто замын барилгын ажлыг 2024 оны хавар эхлүүлэхээр төлөвлөөд байна. Дээрх авто зам засварын ээлжит болон их засварыг хийж, авто замын зорчих нөхцөл сайжирснаар тээврийн хэрэгслийн ашиглалтын зардал, зорчих цаг болон зам тээврийн ослыг бууруулах замаар

нөлөөлөлд өртөж буй зорчигчдод эдийн засгийн ихээхэн үр өгөөжтэй буюу уг төслийн эдийн засгийн дотоод өгөөж 18.7 хувь байна.

Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн саналыг үндэслэн тэргүүн ээлжид Улаанбаатар-Арвайхээр, Хархорин-Цэцэрлэг, Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн автозамуудын ээлжит болон их засварын ажил, Улаанбаатар-Өндөрхаан, Булган-Мөрөн, Арвайхээр-Баянхонгор, Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн автозамын их засварын ажил болон төмөр бетон гүүрийн их болон ээлжит засварын ажлыг тус төслийн хүрээнд хийхээр төлөвлөсөн болно.

Авто замын сүлжээний хөрөнгийн менежментийг боловсронгуй болгох, хууль, эрх зүйн орчныг сайжруулах, дэвшилтэт программ хангамж нэвтрүүлэх, боловсон хүчнийг чадавхжуулах стандарт, зах зээлийн судалгаа хийх, норм нормативыг сайжруулах, шинэчлэхэд чиглэгдэх юм.

2.3.2. КОНВЕНЦЫН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

**/Олон улсын хөдөлмөрийн байгууллагын
Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 онд
оруулсан нэмэлт, өөрчлөлт/**

<p>БАТАЛСАН ОГНОО</p> <p>2023.12.15</p>	<p>ТӨСӨЛ САНААЧИЛСАН</p> <p>Засгийн газраас 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн.</p>	<p>ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА</p> <p>Ердийн журмаар</p>
---	---	---

Манай улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын гишүүнээр 1968 онд элссэн бөгөөд тус байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2014 онд нэгдэн орсон. Мөн уг конвенцод 2014 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2019 онд соёрхон баталсан.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 2016, 2018 оны Бага хурлаар дээрх конвенцод оруулсан нэмэлт, өөрчлөлтийг одоогийн байдлаар 90 гаруй улс хүлээн зөвшөөрөөд байна.

Энэхүү конвенцод 2016 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр далайчдын эрхийг хамгаалах үүднээс Олон улсын далайн тээврийн танхим болон Олон улсын тээвэр эрхлэгчдийн холбооноос хамтран гаргасан хөлөг онгоцон дээрх ялгаварлан гадуурхалт болон дарамтыг багасгах тухай удирдамжийг баримтлах, мөн далайн хөдөлмөрийн гэрчилгээг сунгахтай холбогдох асуудлыг зохицуулсан.

Харин уг конвенцод 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд “далайн дээрэм” болон “хөлөг онгоцны эсрэг зэвсэглэсэн дээрэм тонуул” гэсэн нэр томъёог шинээр тусгаж, тус нөхцөл байдлын улмаас олзлогдсон үеийн далайчны хөдөлмөрийн гэрээний зохицуулалт тусгагдсан.

Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцод 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталснаар Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоц дээр ажиллаж буй далайчны хөдөлмөрлөх эрхийг хангах, хөлөг онгоц эзэмшигчийн зүгээс далайчинтай байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн хариуцлагыг өндөржүүлэх ач холбогдолтой.

Конвенцын нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хууль нь нэг зүйлтэй бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн болно.

2.3.3. САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

/"Агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"/

БАТАЛСАН ОГНОО 2024.01.11	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
--	--	--

Уг санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд онцгой байдлын нисгэгч, инженер техникийн ажилтнуудыг Бүгд Найрамдах Франц Улсын Иргэний аюулгүй байдлын газар, түүний харьяа агаарын ажиллагааны бааз болон ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг сургалтын төвд сургаж дадлагажуулах, сургагч, инженер ажилтнуудыг Монгол Улсад ажиллуулах, нисдэг тэрэгний сэлбэг хэрэгсэл нийлүүлэх, засвар үйлчилгээг хийх юм.

"Агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлснээр дараах дүнд хүрнэ:

- Өдөр, шөнийн нислэгийн эрхтэй нисэх багийн долоон дарга, таван хамтран нисгэгч тус тус бэлтгэгдэж, Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсээс эрх авах;

- Инженер техникийн бүрэлдэхүүний техник үйлчилгээ хийх чадвар дээшилж, их бие, хөдөлгүүрийн инженер, техникийн ажилтнууд II шатны сургалтад хамрагдан ур чадвар нэмэгдэх;

- Инженерийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн бэлтгэгдэж нисдэг тэрэгний ашиглалтын төлөвлөлтийг боловсруулах, сэлбэг хэрэгслийг захиалах, техник үйлчилгээний ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тусгай тоног төхөөрөмжийн ашиглалтад суралцаж, бие даан үүрэг гүйцэтгэх;

- Аврах ажиллагааны мэргэжилтэн, аврагч, эмч, сувилагч нарын мэргэжлийн ур чадвар нэмэгдэж, цаашид аврах ажиллагааны болон эмнэлгийн багаж хэрэгсэл, тусгай тоног төхөөрөмжүүдийг ашиглах мэдлэг, чадварыг бүрэн эзэмших зэрэг болно.

Санхүүгийн хэлэлцээрийг баталснаар Онцгой байдлын ерөнхий газрын аврах

ажиллагааны мэргэжилтний мэргэжлийн ур чадварыг сайжруулан, онцгой байдлын үеийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газраас олгох 24.7 сая еврогийн зээл нь жилийн 0.282 хувийн хүүтэй, таван жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 15 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтийг хийх нөхцөлтэйгөөр олгогдох юм.

Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль нэг зүйлтэй бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн болно.

2.3.4. САНХҮҮГИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

/"Гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл"/

<p>БАТАЛСАН ОГНОО</p> <p>2024.01.11</p>	<p>ТӨСӨЛ САНААЧИЛСАН</p> <p>Засгийн газраас 2023.10.20-ны өдөр өргөн мэдүүлсэн.</p>	<p>ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА</p> <p>Ердийн журмаар</p>
---	--	---

Уг санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд онцгой байдлын байгууллагын гал түймэр унтраах, аврах ангийн нэг аврагч, гал сөнөөгч дунджаар 32.1 км² талбайд байрлах эд хөрөнгө, иргэдийг хамгаалахаар үүргээ гүйцэтгэж байгаа бөгөөд гал түймэр унтраах ангийг зохих хэмжээнд хүчин чадал өндөртэй, шинэ үеийн тоног төхөөрөмж бүхий автомашинаар хангах юм.

"Гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

- Онцгой байдлын байгууллагад ашиглагдаж байгаа гал түймэр унтраах автомашин, техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал сайжирч, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах агуулах /2000м³, 5000м³ болон түүнээс дээш/, шатахуун түгээх станцууд, томоохон хэмжээний худалдааны төвүүдэд гарсан гал түймрийг унтраах чадавх сайжрах;

- Аюулт үзэгдэл, ослын голомтод түргэн шуурхай очих, цаг алдалгүй түргэн шуурхай аврах, гал түймэр унтраах үйл ажиллагаа сайжрах зэрэг болно.

Иймд Санхүүгийн хэлэлцээрийг баталснаар гал түймрийг хөөсөөр унтраах авто машин худалдан авч, аюулт үзэгдэл, гал түймэр унтраах үйл ажиллагааг сайжруулах ач холбогдолтой юм.

Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газраас олгох 24.7 сая еврогийн зээл нь жилийн 0.282 хувийн хүүтэй, таван жил үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх, 15 жилийн хугацаанд зээлийн эргэн төлөлтийг хийх нөхцөлтэйгөөр олгогдох юм.

Санхүүгийн хэлэлцээр соёрхон батлах тухай хууль нэг зүйлтэй бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Олон улсын гэрээний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцсэн болно.

2.4. Улсын Их Хурлын тогтоол

2.4.1. “ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2024 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ”

БАТАЛСАН ОГНОО 2023.11.23	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Монголбанкнаас 2023.09.25-ны өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.01.01
--	---	--

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаар хэлэлцэхдээ дэлхий нийтийг хамарсан цар тахал, олон улсын геополитикийн зөрчилдөөнөөс улбаатай хүндрэлүүдийг Монгол Улс амжилттай даван туулж эдийн засаг сүүлийн жил гаруй хугацаанд хурдацтай сэргэж байгаа ч дэлхийн эдийн засгийн орчны тодорхой бус байдал, түүхий эдийн үнийн гэнэтийн хэлбэлзэл өндөр байгаа хэвээр тул сэргэлтийг цаашид хадгалахын тулд эдийн засгийн гадаад, дотоод орчны тэнцвэрийг хангахад чиглэсэн бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эдийн засгийн өсөлтийн төлөв өндөр байгаа нь манай улс цар тахлын үеийн уналтаас сэргэлт рүү эрчимтэй шилжиж байгааг илтгэж байгаа бөгөөд гадаад орчны нөхцөл байдал амаргүй, бүс нутгийн болон голлох худалдааны түнш улсуудын эдийн засагт бий болж буй доргио шууд болон шууд бусаар нөлөөлж байгаа хэдий ч манай улсын эдийн засаг энэ оны эхний хагас жилд 6,4 хувиар өссөн нь уул уурхайн түүхий эдийн экспортын өсөлт, түүнийг дагасан тээвэр логистикийн салбар, мөн голлох ажлын байрыг бий болгодог үйлчилгээний салбарын үйлдвэрлэл нь энэхүү өсөлтийг голлон бий болгосон гэж үзэж болно.

Төсөв, мөнгө, санхүүгийн бодлого энэ оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг Төв банкнаас шинэчлэн 5,6 орчим хувьтай байх, дараа онд өсөлтийн эрч хадгалагдан 6.0 хувьтай, 2025 онд 5,9 хувьтай байхаар төсөөллийг шинэчилж инфляцыг Төв банкны зорилтот түвшинд хүргэж бууруулах нь эдийн засгийг тогтвортой, хүртээмжтэй өсгөх үндсэн суурь нөхцөл болох тул инфляцыг дунд хугацаанд 6 ± 2 нэгж бүрийн интервалд тогтворжуулах мөнгөний бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь Монгол Улсын эдийн засаг дунд хугацаандаа тогтвортой өсөх, эдийн засгийн өсөлтийг иргэн, аж ахуй нэгж, хувийн хэвшилд хөрөнгө оруулалтыг дэмжих үндсэн хөшүүрэг болох чухал ач холбогдолтой юм.

“Төрөөс мөнгөний бодлогын талаар 2024 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолд орон сууцны ипотекийн хөтөлбөрийг Засгийн газар шилжүүлэн авах хүртэлх хугацаанд хөтөлбөрийн тасралтгүй

байдлыг хангаж, зээлийн эргэн төлөлтөөс санхүүжүүлэх, орон сууцны ипотекийн хөтөлбөрийн хүрээнд олгох зээлийн нийт эх үүсвэрийг нийслэл, орон нутагт тэгш, хүртээмжтэй хуваарилахаар тусгасан.

Мөн тогтоолын хавсралтад Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор бизнесийн зээлийг нэмэгдүүлэх, хэрэглээний зээлийн хэт өсөлтөөс сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Банкнаас жижиг, дунд бизнест олгосон зээлийг ангилах, ангилал дээшлүүлэх, түүний бүтцийг өөрчилж, дахин санхүүжүүлэх зохицуулалтыг эрсдэлд суурилсан хяналт шалгалтын зарчимд тулгуурлан уян хатан болгох ажлыг судлан шийдвэрлэх, Тогтвортой хөгжлийн зорилтын таксономид органик хүнсний тариалалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тодорхой тусгаж, төрийн дэмжлэгтэй хэрэгжиж буй зээл, санхүүжилтийн хөтөлбөрүүдийн багцын тодорхой хэсгийг тухайн таксономитой уялдуулан ногоон, тогтвортой зээл гаргадаг болох чиглэлээр санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллахаар зохицуулалтыг тусгасан болно.

Тогтоол батлагдсанаар инфляцыг тогтворжуулах замаар дунд хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, гадаадын банкны бие даасан салбар нэгжийг дотоодын банк, санхүүгийн салбарт нэвтрүүлэх, ногоон зээлийн үр дүнг хэмжих, тайлагнах, баталгаажуулах нэгдсэн системийг хөгжүүлэх, хил дамнасан худалдааны цахим төлбөр тооцоо болон финтект суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжлийг дэмжих зэрэг чухал ач холбогдолтой юм.

2.4.2. “МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ТОЙРОГ БАЙГУУЛАХ, ТОЙРГИЙН МАНДАТЫН ТОО, ДУГААР, НУТАГ ДЭВСГЭР, ТӨВИЙГ ТОГТООХ ТУХАЙ”

<p>БАТАЛСАН ОГНОО</p> <p>2023.12.21</p>	<p>ТӨСӨЛ САНААЧИЛСАН</p> <p>Төрийн байгуулалтын байнгын хорооноос 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн.</p>	<p>ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА</p> <p>2024.01.01</p>
---	--	---


2023 оны тавдугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын 78 гишүүнийг олныг төлөөлөх, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно” гэж заасан бөгөөд үүнийг 2024 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг хуульчилсан. Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2023 оны зургадугаар сарын 16-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3, 12.4, 12.5 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.17 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын аймгийг 7, нийслэлийг зургаан

тойрог болгож, Улсын Их Хурлын сонгуулийн нийт 13 тойрог байгуулахаар, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн 2, 3 дугаар тойрогт баруун бүсийн Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгийг, 1, 4 дүгээр тойрогт хангайн бүсийн Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймгийг, 5, 7 дугаар тойрогт төвийн бүсийн Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгийг, 6 дугаар тойрогт зүүн бүсийн Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийг, 8, 9, 10, 11, 12, 13 дугаар тойрогт Улаанбаатарын бүсийн Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул, Багануур, Багахангай, Налайх дүүргийг хамруулан тогтоов.

Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төв, тойрогт ногдох мандатын тоо







5-р тойрог **Дархан-Уул, Сэлэнгэ, Төв**

Тойргийн төв

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум,
Аймгийн Засаг даргын Тамгын газар

10

Мандатын тоо

6-р тойрог **Дорнод, Сүхбаатар, Хэнтий**

7

Мандатын тоо

Тойргийн төв

Дорнод аймгийн Хэрлэн сум,
Аймгийн Засаг даргын
Тамгын газар



7

Мандатын тоо

7-р тойрог **Говьсүмбэр, Дорноговь
Дундговь, Өмнөговь**

Тойргийн төв

Өмнөговь аймгийн Даланзадгад сум,
Аймгийн Засаг даргын Тамгын газар



8-р тойрог **Баянзүрх дүүрэг**

Тойргийн төв

Баянзүрх дүүргийн
Засаг даргын Тамгын газар

5

Мандатын тоо



9-р тойрог **Баянгол дүүрэг**

Тойргийн төв Баянгол дүүргийн
Засаг даргын Тамгын газар

3

Мандатын тоо



10-р тойрог **Сүхбаатар, Чингэлтэй**

Тойргийн төв Чингэлтэй дүүргийн
Засаг даргын Тамгын газар

6

Мандатын тоо



11-р тойрог **Сонгинохайрхан дүүрэг**

Тойргийн төв Сонгинохайрхан дүүргийн
Засаг даргын Тамгын газар

5

Мандатын тоо



12-р тойрог **Хан-Уул дүүрэг**

Тойргийн төв Хан-Уул дүүргийн
Засаг даргын Тамгын газар

3

Мандатын тоо



13-р тойрог **Багануур, Багахангай, Налайх**

Тойргийн төв Налайх дүүргийн
Засаг даргын Тамгын газар

2

Мандатын тоо

2.4.3. “МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ ТОВЛОН ЗАРЛАХ, САНАЛ АВАХ ӨДРИЙГ ТОГТООХ ТУХАЙ”

БАТАЛСАН ОГНОО 2023.12.28	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Төрийн байгуулалтын байнгын хорооноос санаачлан, өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.01.01
--	---	--

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооноос “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэн 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Улсын Их Хурал ээлжит сонгуулийг сонгуулийн жилийн хоёрдугаар сарын 01-ний өдрөөс өмнө товлон зарлаж, санал авах өдрийг тогтооно.” гэж заасны дагуу ээлжит сонгуулийг 2024 оны нэгдүгээр сарын 31-ний өдрөөс эхлэхээр товлон зарлахаар, мөн зүйлийн 9.2-т “Ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн зургадугаар сарын сүүлийн хагасын аль нэг ажлын өдөр байна.” гэж заасны дагуу ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2024 оны зургадугаар сарын 28-ны өдөр байхаар Улсын Их Хурлаас тогтоолоо.

Мөн 2023 оны тавдугаар сарын 31-ний өдрийн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд Улсын Их Хурлын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулах бөгөөд Улсын Их Хурлын 78 гишүүнийг сонгуулийн тойргоос олныг төлөөлөх буюу мажоритар аргаар, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх буюу пропорционал аргаар сонгох, мөн хувь тэнцүүлэн төлөөлөх арга буюу жагсаалтаар сонгох сонгуульд Монгол Улсын нутаг дэвсгэр сонгуулийн нэг тойрог байхаар зохицуулсан.

Улсын Их Хурлын 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох зохицуулалттай холбогдуулан Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яам, Олон улсын байгууллагын дэргэд суугаа Монгол Улсын Байнгын Төлөөлөгчийн газар, Монгол Улсын Ерөнхий консулын газар, Консулын газар, Консулын төлөөлөгчийн газар байрладаг гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэн сонгуульд оролцож, санал өгөх эрхтэй байхаар тусгаж, гадаад улсад байгаа сонгогч санал өгөхтэй холбогдох журам, хугацааг хуульд тусгайлан зохицуулсан нь хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгогдох Улсын Их Хурлын 48 гишүүнийг сонгоход гадаад улсад байгаа санал өгөх эрх бүхий иргэд санал өгөх боломж бүрдсэн.

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдрийг сонгуулийн төв

байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтоох бөгөөд гадаадад санал авах өдөр нь дөрөв хүртэл өдөр байна.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдрийг 2024 оны зургадугаар сарын 20, 21, 22, 23-ны өдрүүд байхаар тогтоосон.

2.4.4. “ТОГТООЛЫН ХАВСРАЛТЫГ ӨӨРЧЛӨН БАТЛАХ ТУХАЙ”

БАТАЛСАН ОГНОО 2024.01.11	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Төсвийн байнгын хорооноос санаачлан, өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.01.01
--	--	--

Улсын Их Хурал 2023 оны долдугаар сарын 07-ны өдөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь долоон гишүүнээс бүрдэх бөгөөд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо нээлттэй сонгон шалгаруулалтаар хүн тус бүрээр шалгаруулж, Улсын Их Хурал томилж, чөлөөлөхөөр заасан.

Түүнчлэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Зөвлөлийн чиг үүргийг өргөжүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг тухайн хуульд нийцсэн эсэх, төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангасан эсэх, улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, ачааллын талаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах болон төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсруулах үүрэгтэйгээр Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дэргэд ажиллахаар заасан.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэмд өөрчлөлт оруулах шаардлагатай тул Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо “Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, 2024 оны нэгдүгээр сарын 11-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсан. Үүнд:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 161.1-д заасан чиг үүргийн хүрээнд эдийн засгийн төсөөлөл, таамаглал хийх, төсвийн болон хөгжлийн бодлогын тогтвортой байдалд шинжилгээ хийх, төсөвт учрах эрсдэлийн шинжилгээ хийх гэсэн гурван чиглэлээр Зөвлөлийн хийх ажлын чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон;

- Зөвлөл хамтын удирдлагын зарчимд үндэслэн үйл ажиллагаагаа явуулна;

- Зөвлөл эдийн засгийн таамаглалын, төсвийн эрсдэлийн болон төсвийн тогтвортой байдлын, бодлогын нөлөөллийн шинжилгээний гэсэн гурван тайланг сар, улирал бүрээр гарган, хуралдаанаараа хэлэлцэж, Төсвийн байнгын хороонд танилцуулж, олон нийтэд мэдээлэх, хагас жил тутам олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахаар тусгасан;

- Зөвлөл чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, судалгааг холбогдох төрийн байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаас гаргуулан авахаар тусгасан;

- Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэмд тусгагдсан Зөвлөлийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэлийг Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан тул дүрмээс хассан;

- Зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлж ажиллах Төсвийн судалгааны нэгжтэй байх бөгөөд тус нэгж нь Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэнэ.

Тогтоол батлагдсанаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Төсвийн тогтвортой байдлын орон тооны зөвлөл хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх чиглэлээр гүйцэтгэх ажил, үүрэг тодорхой болж, Зөвлөлөөс гаргасан таамаглалын болон бодлогын нөлөөллийн тайлантай Төсвийн байнгын хороо болон олон нийт сар, улирал бүр танилцах боломж бүрдэж байна.

2.4.5. “БҮГД НАЙРАМДАХ УЗБЕКИСТАН УЛСЫН НИЙСЛЭЛ ТАШКЕНТ ХОТОД МОНГОЛ УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ НЭЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ”

БАТАЛСАН ОГНОО 2024.01.12	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2024.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.02.02
---	---	---

Монгол Улс Бүгд Найрамдах Узбекистан Улстай 1992 онд дипломат харилцаа тогтоосон бөгөөд уламжлалт найрсаг харилцаатай. Тус улс нь 35 сая гаруй хүн амтай, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн хөгжлөөрөө бүс нутагтаа тэргүүлдэг төдийгүй улс төр болон эдийн засгийн хувьд нөлөө бүхий улс төрийн хувьд төвийг сахисан улс юм.

Манай хоёр улсын худалдааны эргэлт сүүлийн жилүүдэд аажмаар өсөж, 2022 онд 10,4 сая ам.долларт хүрсэн. Тухайлбал, экспорт 4.2 сая орчим ам.доллар, импорт 6.2 сая гаруй ам.доллар болж өссөн үзүүлэлттэй байна.

Узбекистан Улстай Монгол Улсын хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгод нийцсэн эрүүл хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх чиглэлээр хамтран ажиллах, манай үндэсний үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг

Монгол Улсын эдийн засгийн бүсчлэлийн бүс нутаг, хот, хөдөөгийн хөгжлийн нэгдмэл болон бүсүүдийн харьцангуй бие даасан, харилцан уялдаатай тогтолцоог бүрдүүлж, бүс нутаг, хот, хөдөөг тэнцвэртэй хөгжүүлэх, хүн амын нутагшилт, суурьшлын олон төвтэй тогтолцоог бий болгох, нийслэл Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, иргэдийн орон нутагт шилжин суурьших таатай нөхцөлийг хангах зорилгоор Улсын Их Хурлаас баталсан зарим бодлого, хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд тайлбарлан таниулах, иргэдээс санал авах, байр суурийг нь сонсох ажлыг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы завсарлагааны хугацаанд зохион байгуулахыг Улсын Их Хурлын гишүүдэд даалгасан болно.

Улсын Их Хурлын гишүүд Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явц, үр дүн, шинэчлэн боловсруулахтай холбогдох асуудал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан бүс, орон нутаг, нийслэл Улаанбаатар болон дагуул хотыг хөгжүүлэх зорилт, Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан боомтын болон хот, хөдөөгийн сэргэлтийн зорилт, хэрэгжилтийн явцыг иргэд, олон нийтэд танилцуулж, саналыг нь сонсох юм.

Тогтоолд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх тайлан, лавлагаа, бусад шаардлагатай мэдээлэл бүхий гарын авлагыг бэлтгэх болон бүсчилсэн хөгжлийн бодлогыг боловсронгуй болгох, Монгол Улсын эдийн засгийн бүсчлэлийг тогтоох асуудлаар эдийн засгийн форумыг бүсчлэн зохион байгуулах арга хэмжээг авч, хамтран зохион байгуулах, холбогдох зардлыг шийдвэрлэхийг Засгийн газарт даалгасан болно.

Тогтоол батлагдсанаар Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогын зорилтууд, хэрэгжилтийг олон нийтэд тайлбарлан таниулж, иргэдийн саналыг авах хэлэлцүүлгийг зохион байгуулах ба Улсын Их Хурлын гишүүдийн хийсэн уулзалт, хэлэлцүүлэг, тайлбарлан таниулах ажлын дүн, саналыг нэгтгэн Улсын Их Хуралд 2024 оны гуравдугаар сард багтаан танилцуулах юм.

2.4.7. “ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЗЭВСЭГ, ТЕХНИКИЙГ ШИНЭЧЛЭХ, СЭРГЭЭН САЙЖРУУЛАХ БОДЛОГО БАТЛАХ ТУХАЙ”

**БАТАЛСАН
ОГНОО**

2024.01.16

ТӨСӨЛ САНААЧИЛСАН

Засгийн газраас 2023.10.23-ны өдөр өргөн мэдүүлсэн.

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

Ердийн журмаар

Тогтоолд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд заасан холбогдох хуулийн төслийг боловсруулан өргөн мэдүүлэх, Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах, бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах

зардлыг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний болон жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж, өргөн мэдүүлэх, түүнчлэн энэ бодлогын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Улсын Их Хуралд танилцуулахыг Засгийн газарт үүрэг болгосон.

Тогтоолын хавсралтаар батлагдсан Зэвсэгт хүчний зэвсэг, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах бодлогод тухайн бодлогын зорилго, үндэслэл, зарчмыг тусгаснаас гадна дараах зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

- зэвсэг, техникийн ашиглалт, хадгалалтыг технологийн горимын дагуу зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлж хэрэгжүүлэх хүрээнд техникийн ашиглалтыг нэмэгдүүлэх, хадгалалтыг сайжруулах, техникийн үйлчилгээний хүчин чадлыг нэмэгдүүлэх, материаллаг нөөцийг бүрдүүлэхтэй холбогдох зорилт;

- зэвсэг, техникт төлөвлөгөөний дагуу сэргээн сайжруулах засвар, техникийн үйлчилгээ хийх хүрээнд засвар, техникийн үйлчилгээг жил бүр төлөвлөгөөтэйгөөр хэрэгжүүлэх, зардлыг улсын төсөвт тусгах, засвар хийх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилт;

- зэвсэг, техникийг худалдан авах, зээл, тусламжаар шинэчлэх зорилтын хүрээнд цэрэг-техникийн хамтын ажиллагаатай гадаадын улс орнуудын зээл, тусламжаар болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэх зэвсэг, техникийг;

- орчин үеийн техник, технологи, инновацыг нутагшуулах, цэргийн зарим төрлийн техник, хэрэгслийг эх орондоо үйлдвэрлэх зорилтын хүрээнд үндэсний батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх, зарим зэвсэг, техникийн эд ангийг зохион бүтээж, туршин, үйлдвэрлэж, зэвсэглэлд нэвтрүүлэх зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан болно.

Түүнчлэн бодлогыг хэрэгжүүлэх санхүү, хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлсноос гадна Улсын Их Хурал, Засгийн газар, батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагаас энэ бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан тусгалаа.

Энэхүү тогтоол нь Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах талаар төрөөс баримтлах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл, удирдлага, зохицуулалтыг тодорхойлж байгаагаас гадна Зэвсэгт хүчний хуулиар хүлээсэн үүрэгт нийцсэн, шинжлэх ухаан, техник, технологийн ололт, инновацид суурилсан өндөр бүтээмжтэй зэвсэглэл, цэргийн техникээр нөхөн хангагдах эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн бодлогын баримт бичиг юм.

2.4.8. “МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНООС “ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК, “ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН НҮҮРС ОЛБОРЛОЛТ, БОРЛУУЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТ, ЭКСПОРТ, БУСАД БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ”

**БАТАЛСАН
ОГНОО**

2024.01.16

ТӨСӨЛ САНААЧИЛСАН

Төрийн байгуулалтын байнгын хорооноос санаачлан, өргөн мэдүүлсэн.

**ДАГАЖ МӨРДӨХ
ХУГАЦАА**

2024.01.16

Улсын Их Хурлын 2023 оны 63 дугаар тогтоолоор байгуулагдсан Хянан шалгах түр хороо нь бүрэн эрхийнхээ хүрээнд стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын томоохон ордод үйл ажиллагаа явуулж буй “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаатай холбоотой 3.1 сая гаруй хуудас баримт материалыг хамруулсан хяналт шалгалтыг 72 хоногийн хугацаанд хийж, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсголыг хоёр үе шаттай зохион байгуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой зарим компанийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах үүрэг бүхий Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны тайлан, санал, дүгнэлт болон Хянан шалгах түр хорооноос боловсруулсан “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэн 2024 оны нэгдүгээр сарын 16-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан.

Уг тогтоолоор Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК-ийн нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт болон бусад бараа, ажил, үйлчилгээний худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан. Үүнд:

1) Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хууль зөрчиж гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар эзэмшүүлсэн асуудлыг шуурхай шалгаж, холбогдох шийдвэрийг хүчингүй болгох арга хэмжээг авч, хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх;

2) Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд улс төрийн нөлөө бүхий этгээд, тэдгээрийн хамаарал бүхий этгээд ажиллах, аж ахуй, бизнесийн үйл ажиллагаанд улс төрийн нам, улс төрчид оролцохыг таслан зогсоох, хязгаарлах арга хэмжээг авах;

3) “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК болон төрийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээдээс цаашид төсвийн шинжтэй, компанийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө оруулалт, төслийг санхүүжүүлэхгүй байх, хориглох арга хэмжээ авахыг;

4) Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн аж ахуй, бизнесийн үйл ажиллагаанд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс нөлөөлөхийг хязгаарлах, тэдгээрийн компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5) “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК болон төрийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, нээлттэй зохион байгуулах чиглэлээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

6) “Тавантолгой” ХК-ийн төрийн эзэмшлийн 51 хувийн хувьцааг орон нутгийн өмчлөлд шилжүүлсэн “Аймаг, нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын 1999 оны тавдугаар сарын 13-ны өдрийн 29 дүгээр тогтоолын холбогдох заалтыг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээг авах;

7) Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт орших Тавантолгойн чулуун нүүрсний бүлэг ордын Бортээгийн уурхайн гэрээт олборлогчийг сонгон шалгаруулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн “МТАС” түншлэлтэй 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр байгуулсан “Тавантолгойн ордын Бортээгийн уурхайн хөрс хуулалт, өрөмдлөг, тэсэлгээ, нүүрс олборлолт, нүүрс баяжуулалтын ажил гүйцэтгэх гэрээ”-г холбогдох хуульд заасан журмын дагуу хүчингүй болгох арга хэмжээг авах;

8) Татварын хяналт шалгалтыг хуульд заасан журмын дагуу зохион байгуулаагүйгээс зарим хуулийн этгээдийн татвараас зайлсхийх нөхцөлийг бүрдүүлж, татварын нөхөн ногдуулалт болон алданги, торгууль ногдуулах боломжийг алдагдуулсан албан тушаалтанд хариуцлага хүлээлгэж, цаашид дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр татварын хууль тогтоомжийг боловсронгуй болгох хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

9) Монгол Улсын хилээр гаалийн бүрдүүлэлтгүй нүүрс тээвэрлэх, экспортлох, татвараас зайлсхийх нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, гааль болон хилийн хяналт шалгалтын хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

10) Хянан шалгах түр хорооны хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг авч, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, Түр хорооны үйл ажиллагаанд саад учруулсан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын асуудлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх;

11) Хяналт шалгалтаар илэрсэн гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг холбогдох хуулийн дагуу шалгаж, шийдвэрлүүлэхийг Ерөнхий прокурор Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газарт тус тус зөвлөхийг Засгийн газарт даалгасан.

Энэ тогтоолыг 2024 оны нэгдүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөх бөгөөд тогтоолын биелэлтэд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Хууль зүйн байнгын хороо хяналт тавьж ажиллана.

2.4.9. “ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫГ БҮСЧЛЭН БАЙРШУУЛАХ ТУХАЙ”

БАТАЛСАН ОГНОО 2024.01.17	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2024.01.05-ны өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА Ердийн журмаар
--	--	--

Тус тогтоолоор Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн дараах арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасан болно. Үүнд:

1) төрийн байгууллагуудыг эрхлэх асуудал, чиг үүрэг, үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хамрах хүрээг нь харгалзан нийслэл Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн, бүсчлэн байршуулах талаар бодлого боловсруулах;

2) Улаанбаатар хотоос орон нутагт шилжин ажиллах төрийн албан хаагчид дэмжлэг үзүүлэх, нийгмийн баталгааг хангах асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авах, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

3) төрийн байгууллага, албан хаагчдыг орон нутагт бүсчилсэн байдлаар шилжүүлэн байршуулахад шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг тооцон тухайн жилийн улсын төсвийн төсөлд тусган шийдвэрлэж байх.

Тогтоол батлагдсанаар төрийн байгууллагуудыг Улаанбаатар хотоос үе шаттайгаар нүүлгэн, бүсчлэн байршуулах талаар бодлого боловсруулж, түүнд холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийн саналыг боловсруулан шийдвэрлүүлж, хэрэгжүүлэх ба ингэснээр хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж, хөгжлийн түвшнийг ойртуулж, бүсүүдийн хөгжлийн түвшнийг эрэмбэ дараатай дээшлүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах боломж бүрдэнэ.

2.4.10. “ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ”

/Нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийх/

БАТАЛСАН ОГНОО 2024.01.17	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Улсын Их Хурлын гишүүдээс 2023.11.27-ны өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.01.17
---	---	---

Уг тогтоолоор Нийслэлийн нийтийн тээврийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, парк шинэчлэх шаардлагын дагуу 2023 онд худалдан авсан автобусны худалдан авах ажиллагаанд хяналт шалгалт хийх асуудлаар Улсын Их Хурлын хянан шалгах түр хороог олонхыг төлөөлөн Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Д.Батлут, Ж.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Г.Тэмүүлэн, Ж.Чинбүрэн, цөөнхийг төлөөлөн Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Н.Ганибал, С.Одонтуяа, Т.Доржханд нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Хянан шалгах түр хороо бүрэн эрхийн хүрээнд 2024 оны нэгдүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн зургаан сарын хугацаанд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, тайланг санал, дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд танилцуулна.

Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тусгай шалгалтын сэдэв, хүрээ хязгаарын хүрээнд Нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд 2023 онд хийсэн автобус худалдан авах ажиллагааг Төрийн болон албаны нууцад хамааруулан гэрээ шууд байгуулсан үндэслэл, шалтгаан, нөхцөлийг шалган тогтоосноор цаашид төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулахгүй байх, худалдан авах үйл ажиллагаа нээлттэй ил тод болох, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг сайжруулахад эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

2.4.11. ““ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ” ХК-ИЙН ХУВЬЦААНЫ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ”

БАТАЛСАН ОГНОО 2024.01.17	ТӨСӨЛ САНААЧИЛСАН Засгийн газраас 2023.12.20-ны өдөр өргөн мэдүүлсэн.	ДАГАЖ МӨРДӨХ ХУГАЦАА 2024.01.17
---	---	---

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг

ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэж заасан.



2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд төрсөн болон Монгол Улсын харьяат болсон иргэн бүрд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг энгийн хувьцааг эзэмшүүлэхээр зохицуулсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн дээр дурдсан тогтоолоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Монгол Улсын нийт иргэдэд адил тэнцүү хэмжээгээр эзэмшүүлэх, “ингэхдээ 2012 оны дөрөвдүгээр сарын 11-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд төрсөн болон Монгол Улсын харьяат болсон иргэн бүрд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг энгийн хувьцааг эзэмшүүлэхээр, мөн Монгол Улсын иргэдэд үнэ төлбөргүйгээр олгосон “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг тус компанийн энгийн хувьцаанд бүртгэх, түүнчлэн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн эрх бүхий этгээд ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогоос “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Эрдэнэс Монгол” ХХК, түүний нэгдлийн болон бусад төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд хооронд үүссэн өр авлагад суутган тооцох зэрэг асуудлуудыг зохицуулахаар тусгалаа.

Тогтоол батлагдсанаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын иргэд эзэмшсэнээр байгалийн баялгийн үр өгөөжөөс иргэн бүр тэгш хүртэх боломжтой болоод зогсохгүй тус компанийн үйл ажиллагаанд тавих иргэдийн хяналт оролцоо дээшилж, ил тод, нээлттэй компанийн засаглал хөгжихөд чухал ач холбогдол үзүүлэх болно гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАРЫН 2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫГ ХААЖ ХЭЛСЭН ҮГ

2024.01.17



Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хатагтай ноёд оо,

Улсын Их Хурлын найм дахь удаагийн сонгуулиар бүрдсэн парламент намрын “отгон” чуулганаа өндөрлүүлж байна. Энэ удаагийн чуулган Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу ажлын 75 хоног хуралдаж, 224 хууль, Улсын Их Хурлын 62 тогтоол баталлаа. Бүхэлдээ энэ удаагийн чуулганыг шинэтгэлийн чуулган болсон хэмээн дүгнэж болно. Ард түмний төлөөллийн байгууллага Улсын Их Хурал ард түмний засаглах эрхийг хангах, төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх, “ЗД” парламент буюу ардчилсан, ард иргэдтэйгээ зөвлөлдөг, цахим парламент байх зорилтоо хэрэгжүүлж ажилласан. 2023 онд Монгол Улсын хүн ам албан ёсоор 3 сая 500 мянга болсон сайхан мэдээгээр үгээ эхэлье. Монголчууд ийнхүү олуулаа болохын хэрээр “их нүүдлийн зүг хөдөлж”, цэгцрэх хөдөлгөөний эхлэл тавигдаж байгааг онцолмоор байна. Монголчууд цагийн аясаар өвсний шим, усны тунгалгийг дагаж нүүдэллэсээр ирсэн нүүдэлчдийн үр удам. Энэ нүүдэл энэ цагт эрүүл, шударга нийгмийг цогцлоохын төлөөх ИХ НҮҮДЭЛ болон өрнөж байна.

Уламжлал, шинэчлэл хоёрын тэнцвэрийг олох, буруу зөвийн ялгааг таних, тогтолцоо, засаглалын гажуудлыг арилгах, хулгайч, хууль зөрчигчдөө илрүүлэн, шүүн шийтгэх зэргээр товчхондоо их өөрчлөлтөд тэмүүлсэн нүсэр хөдөлгөөн идэвхжсэн цаг үеийг бид туулж байна. Эмх цэгцгүй, бужигнаан түжигнээнтэй ч юм шиг санагдах энэ хөдөлгөөн бол эмх цэгцээ олж цэгцрэх ИХ ТОМ ЭЕРЭГ ҮЙЛ ЯВЦ гэдгийг бид ойлгох ёстой. Жам ёсны энэ үйл явц улмаар манай улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь багана нь болно гэдэгт итгэлтэй байна. Ардчилал улам хэрсүүжиж төлөвшиж, төгөлдөршинө. Үр дүнд нь Монгол Улс хүчирхэгжиж, Монгол хүн бүр жаргалтай амьдрах нөхцөл бүрдэнэ. Саяхан бидний хүсэл зорилго төдий байсан олон зүйлс өнөөдөр бодит үр дүн болж хувирч байна. Экспорт түүхэндээ анх удаа 15.2 тэрбум ам.долларт хүрч, төлбөрийн тэнцэл 1.4 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Гадаад валютын нөөц 5.0 тэрбум ам.долларт хүрлээ. Монгол Улсын төсвийн орлого 35.6 хувь буюу 6.0 их наяд төгрөгөөр өслөө. Эдийн засгийн өсөлт 6.9 хувьд, нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 5800 ам.долларт хүрлээ. Макро эдийн засгийн эдгээр үзүүлэлт бол өнөөдөр өрнөж буй өөрчлөлт шинэчлэлтийн үгүйсгэшгүй үр дүн, бодит үзүүлэлт мөн. Гэхдээ амжилт, өсөлтийн тоон үзүүлэлтээр ард түмнээ цатгаж бид чадахгүй ээ.

Энэ өсөлт айлын хаалгаар орох ёстой. “Нийгэмд бухимдал маш их байна” гэсэн дүгнэлт саяхан хийсэн судалгааны дүнгээр гарсан. Бухимдлын шалтгаан гурван гол хүчин зүйлээс хамаарч байгаагийн хамгийнэхэнд “Шударгабусбайдал”, хоёрдугаарт “Эдийн засгийн өсөлтийн хүртээмжгүй байдал” нэрлэгдсэн байна. Судалгаанд оролцсон 10 хүн тутмын найм нь амьдрал доройтсон, инфляц буурч байгаа ч цалин, тэтгэвэр, орлогын нэмэгдэл нь үнийн өсөлтийг давж чадахгүй байна гэж үзжээ.



Амжилт, өсөлтийн тоон үзүүлэлтээр ард түмнээ цатгаж бид чадахгүй ээ. Энэ өсөлт айлын хаалгаар орох ёстой...

Нэг үе 16.9 хувьд хүрээд байсан инфляц буурч, 7.9 хувь болсон нь бодит үзүүлэлт мөн. Гэвч иргэд “Бодитоор амьдрал, амьжиргаа сайжраагүй байхад эдийн засаг өсөж байна, инфляц нэг оронтой тоонд байна гэж ярих нь бухимдлыг улам нэмэгдүүлж байна” гэж үзсэн байна. Ард түмнийхээ боломжийг хулгайлдаг авлига, албан тушаалын гэмт хэрэг, баялгийн хулгайн бусармаг үйлдлүүд алхам тутамдаа илчлэгдэж байгаа ч хариуцлага тооцохгүй байна гэж ард түмэн бухимдаж байна.

Улсын Их Хурлаас байгуулагдсан Хянан шалгах түр хороо намрын чуулганы хугацаанд “Нүүрсний” хулгайн асуудлаар нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг хоёр үе шаттай явуулж, 412 гэрчийг дуудан оролцуулж, энэ хэргийн талаар ард түмний мэдэх эрхийг хангасан. Өмнө нь өндөр түвшний улстөрчид,



эрх мэдэл бүхий хууль сахиулагчид, шударга бус замаар бизнес эрхлэгч гурав эрх ашгаараа нийлэхэд, энэ улсад хуулиас дээгүүр давхарга үүсгэдэг байсан бол парламентын шинэтгэл, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үр дүнд 10, 20 жилээр далд бугшиж байсан хулгай, дээрэм ил гарч байна. Гэм буруутай нь баримтаар нотлогдсон хэн бүхэн парламентын нээлттэй хяналтын сонсголд дуудагдан оролцдог боллоо. Тэр хэрээр ард түмэн төрөөсөө шударга ёсыг тасралтгүй шаардаж, тэр шаардлага нь энэ танхимд хууль болон батлагдаж, хулгай луйвар тав алхахгүй баригдах ил тод нийгмийн хариуцлагатай засаглал бүрдэж байна. Гэвч тэдэнд хариуцлага тооцох асуудал маш муу байна. Дээр дурдсан судалгаагаар “олон нийтэд ил болсон авлига, хулгайн хэргүүдэд хэн ч хариуцлага хүлээхгүй, нэг хэргийн дуулианаар өмнөх хэргүүд бүдгэрсээр байгаад олон нийт туйлын бухимдалтай байна” гэсэн дүгнэлт гарсан. Гэм буруутанд хариуцлага тооцох, ял шийтгэл оноох, эсхүл цагаатгах боломж Улсын Их Хурал, Хянан шалгах түр хороонд байхгүй. Хуулиар тогтоосон ийм эрх зөвхөн шүүх, хуулийн байгууллагад бий бөгөөд энэхүү үйл ажиллагаагаа шүүхийн байгууллага шударга ёсны зарчимд нийцүүлэн, бие даан хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй гэдгийг сануулж, ард түмнийхээ шаардлагад хариулт өгөхийг хүсч байна. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо ч энэ асуудалд анхаарлаа хандуулах шаардлагатай.

Эрхэм гишүүд ээ,

Монгол Улс бол хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн Үндсэн хуультай, Ардчилсан улс. Хэлэлцэж, зөвлөлдөж, маргалдаж, мэтгэлцэх зарчмаар хуулиа тогтоодог Парламентын засаглал, хэнээс ч хараат бус ажиллах шүүх засаглал, хэн нэгний нөлөөнд үл автах хэвлэл мэдээлэл бол Ардчиллын дархлаа гэдгийг бид мартаж болохгүй. Ардчиллын дархлаагаа ард түмнээрээ хамгаалж байж бид Ардчилсан улс хэвээр үлдэнэ. Хэн нэгэн буюу хэсэг бүлэг хүмүүс явцуу сонирхлоороо Ардчиллын үнэт зүйлс рүү халддаг байхыг хэрхэвч хүлээн зөвшөөрөх ёсгүй. Ард

түмний мэдэх эрх, хууль тогтоогчдын хууль батлах үйл явц, шүүх засаглалын хараат бус байдал руу техник, технологийн дэвшлийг ашиглан, олон нийтийг хамарсан тархи угаалт явуулах замаар халддаг байдал хэрээс хэтэрч байна. Хэвлэлийн эрх чөлөө, нийгмийн сүлжээний нээлттэй бүтцийн ард нуугдсан асар их хар хүч, бохир мөнгө, нарийн зохион байгуулалт бүхий бүлэглэлүүд эрс идэвхжиж, ил цагаандаа гарч байгааг олон нийт анзаарч буй байх аа. Энэ мэт бохир технологи ганц манай улсад биш, дэлхий дахинд халдвар мэт тархаж буй нь ардчилалд учирч буй томоохон эрсдэлт үзэгдэл мөн гэж нийтээрээ үзэж, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх олон төрлийн арга хэмжээ авсаар байна. Хиймэл оюун ухаан бол хоёр үзүүртэй илд гэж үздэг болсон.

Гэхдээ үүнээс сэргийлэх цорын ганц найдвартай, үр дүнтэй арга бол хэрсүү няхуур, мэдээлэлд шүүлтүүртэй хандах чадвартай ард иргэд юм. Нуран унаж буй хуучин, бохир хүсэл шинэ аргаар хэлбэржсээр байгаад иргэн бүр соргог мэдрэмжтэй хандаж, үүний эсрэг шийдвэртэй тэмцэхийг уриалж байна. Иргэний мэдэх эрхийг санаатай зөрчиж, ард түмнээ хагаралдуулан талцуулах нь гэмт хэрэг, хүний эрхийн ноцтой зөрчил мөн. Хүний эрх бол хүн биш хууль засаглах ёс, ардчиллыг бэхжүүлэх үнэт зүйл мөн тул ард түмний төлөөллийн байгууллага болох парламент түүнийг хамгаалагч, манлайлагч, хүний эрхийг хангах үндэсний тогтолцооны гол оролцогч байх ёстой гэж бид үздэг. Намрын чуулганы хугацаанд Улсын Их Хурал Олон улсын Парламентын холбоотой хамтран хүний эрхийн өөрийн үнэлгээг дэлхийн парламентуудын дотроос анх удаа хийсэн нь дэлхий нийт, олон улсын байгууллагууд бидний хүчин чармайлтад чухал ач холбогдол өгч байгаагийн бодит илэрхийлэл мөн.

Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын найм дахь удаагийн сонгуулиар бүрдсэн парламент бүхэлдээ улс төрийн тогтвортой байдлыг эрхэмлэж, Засгийн газрын ажиллах таатай боломж нөхцөлүүдийг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлсэн.



Таатай үр дүн олон гарсан ч анхаарах ёстой зарим асуудлууд байна. Авлигын эсрэг тэмцэл, тогтолцооны суурь шинэчлэлүүд, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх Засгийн газрын шийдвэр, шийдэл бүхнийг Улсын Их Хурал гацаа саадгүй, яаралтай горимоор хэлэлцэн баталсан. Гэвч Засгийн газар танхимын зарчмаар ажиллаж чадаагүй, байр сууриа нэгтгээгүй, тооцоо судалгаа дутуу хийсэн зэрэг олон алдаа дутагдлын буруутан нь Улсын Их Хурал болдог жишиг тогтож, парламентын нэр хүндэд сөргөөр нөлөөлж байна. Улсын төсөв батлахаас эхлээд томоохон төслүүд гацах хүртэлх асуудал бүрийн алдааг Улсын Их Хуралд тохдог арга барилаа өөрчлөх нь шударга ёсны зарчим, засаглалын тэнцвэрт харилцаанд нийцнэ. Нийгмийн бухимдлыг дэвэргэж, түүн дээрээс “ардын баатар” болж тодорно, улс төрийн ашиг хонжоо олно гэж тооцдог улигт аргаа орхих цаг болсныг сануулъя. “Жоомоо алах гээд гэрээ шатаав” гэдэг шиг өөрөөсөө бурууг зайлуулах бүтэлгүй оролдлогоороо Парламентын дархлааг сулруулж болохгүй гэдгийг төр, засгийн байгууллагын албан тушаалтан бүр бодолцох ёстой.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амилуулах, тогтолцооны томоохон өөрчлөлтүүдийг хөрсөнд буулгахад маш чухал Сонгуулийн жил эхэлж байна. 126 гишүүн, бүсчилсэн найман тойрог шинэ Монголын шинэ түүхийг бичнэ гэсэн хүлээлт байгаа. Монгол хүн бүр энэ өөрчлөлтийн үр шимийг хүртэх ёстой. Тиймээс улс орныхоо урт хугацааны, тогтвортой хөгжлийн суурийг хариуцлагатай сонголтоор баталгаажуулах үйл хэрэгт нэн хариуцлагатай хандахыг улс төрийн намууд, нийт иргэддээ уриалж байна.



Шинэчлэгч парламент байж, Эрх зүйн шинэчлэлээ бүрэн үр дүнд хүргэхийн тулд үлдэж буй хугацаанд Эдийн засгийн реформд онцгой анхаарах шаардлага байна...

Энэ удаагийн сонгуульд намууд бодлогоор өрсөлдөх, нэр цэвэр, мэдлэг боловсролтой, ёс зүйтэй хүмүүсээ нэр дэвшүүлэх шинэ жишиг тогтоох ёстой. Сонгогчдын саналыг авахын тулд намууд үзэл баримтлалаа хаяж гээдэг, элдэв амлалтаар ирээдүйгээ балладаг өмнөх жишиг давтагдах ёсгүй. Энэ сонгууль нэг тойрог, нэг аймгийг “услах” биш, бүс нутгийн хөгжил дэвшлийн төлөө бодлого дэвшүүлж, бодлогоор өрсөлдөх сонгууль болох ёстой. Бүсчилсэн хөгжил нь хөгжил дэвшлийн нэг чухал хөшүүрэг гарцаагүй мөн. Шинэ сэргэлтийн бодлогод туссан Хот, хөдөөгийн сэргэлтийн зорилтууд амжилттай хэрэгжихэд бүсчилсэн хөгжлийн бодлого чухал түлхэц болох болно. Чуулганаар “Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталсан. Тогтоолд заасны дагуу Эрхэм гишүүд завсарлагааны хугацаанд ард иргэдтэйгээ уулзаж, бүсчилсэн хөгжлийн бодлогын ач холбогдлыг тайлбарлаж, үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулах асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, санал бодлыг нэгтгэн Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлэх чиглэлийг өгч байна. Мөн өвөлжилтийн нөхцөл, байдлыг газар дээр

нь үзэж танилцан, цас зудын гамшгаас малчдаа сэргийлэн хамгаалах арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран авах нь зүйтэй. 2023 оны мал тооллогын дүнгээр малын тоо 6.4 саяар буурч, 64.7 сая болсон байна. Энэ бол мал хорогдсон гэхээсээ илүүтэй манай малчид “Мянгат малчин” болохын төлөө биш, малынхаа чанар, ашиг шимийг сайжруулахад, тоог биш чанарыг чухалчилж байгаагийн илрэл юм.

Тиймээс хөдөө ажахуйд шинэчлэлхийх, малчин-мал-бэлчээр гурвын харилцан шүтэлцээг хангаж, малчин өрхүүдийн хамтын ажиллагааг дэмжих, нийтлэг ашиг сонирхлыг хангах чиглэлээр санал бодлыг нь сонсож, Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхийг Эрхэм гишүүддээ үүрэг болгоё. Та бидний бүрэн эрхийн хугацаа өндөрлөхөд ганцхан чуулган үлдээд байна. Шинэчлэгч парламент байж, Эрх зүйн шинэчлэлээ бүрэн үр дүнд хүргэхийн тулд үлдэж буй хугацаанд Эдийн засгийн реформд онцгой анхаарах шаардлага байна. Нийтийн буюу төрийн санхүүгийн шинэчлэл зайлшгүй болсныг Засгийн газрын сангуудын үйл ажиллагаа, төсвийн үрэлгэн байдал, татварын үр ашиггүй тогтолцоо харуулж байна. “D-өргөдөл” цахим системээр дамжуулан иргэдээс ирүүлж буй өргөдөл, санал хүсэлт ч энэ асуудалд чиглэж байгаа. Улсын эдийн засаг өссөн ч тэр нь иргэдийн амьжиргаанд бодит нөлөө үзүүлж чадахгүй байгаа нь манай төрийн санхүү, татварын тогтолцоо гажуудалтай байгаагийн илрэл юм. Эдийн засгийн бодлого маань дундаж, чинээлэг давхаргыг дэмжих биш, уул уурхайгаас хамааралтай хэт цөөнхийг дэмжсэн урвуу хамааралтай байгааг засахгүйгээр бид цааш явах аргагүй. Үүнийг засаж чадвал хэрэглэгч биш бүтээгч, импортлогч биш экспортлогч болж, өрөөс хуримтлалд, халамжаас хөдөлмөрт шилжих, баялаг бүтээгчдээ дэмжих, олон гэсэн ганц тулгуурт эдийн засгаа олон тулгууртай болгох боломж бүрдэнэ.

Эрхэм гишүүд ээ,

Дэлхий дахинд үүсээд буй шинэ эрсдэлүүд, улс орны маань хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлсүүд биднээс дотоодын эв нэгдлээ бэхжүүлэхийг шаардсаар байна. Миний бие хэдхэн хоногийн өмнө “Ойрын нөхөд хэрэлдэхэд холын дайсан баярладаг” гэж хэлсний учир энэ юм. Нийгмийн ухамсар нягтарч, ёс зүйн өндөр хэм хэмжээ тогтож, улс төрийн ёс суртахуун, хариуцлагын босго өндөрссөөр буй энэ цаг үетэй хөл нийлэх нь улс төрчдийн хувьд нэг ёсны сорилт юм. Тиймээс нийгэм, цаг үеийн сорилтод тэнцэж, үйлдэл, үйл хэрэг бүрээрээ манлайлагч байгаарай.

“

Нуран унаж буй хуучин, бохир хүсэл шинэ аргаар хэлбэржсээр байгаад иргэн бүр соргог мэдрэмжтэй хандаж, үүний эсрэг шийдвэртэй тэмцэхийг уриалж байна..

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулган хаасныг мэдэгдье.



МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРАЛ

ЦАХИМ ХУУДАС
www.parliament.mn

ЦАХИМ ПАРЛАМЕНТ
d.parliament.mn

ЦАХИМ ӨРГӨДӨЛ
petition.parliament.mn